



ХУУЛЬ САХИУЛАХЫН  
ИХ СУРГУУЛЬ



МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН  
ХОЛБОО

# ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН  
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2016 №2 (56) 14 дэх жилдээ



## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

### ЭРХЛЭГЧ

#### **Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ**

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

### ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

#### **Б.БАТ-ЭРДЭНЭ**

Монгол Улсын дээд шүүхийн шүүгч, доктор (Ph.D), профессор

#### **Б.БАТЗОРИГ**

Тахарын ерөнхий газрын дэд дарга, доктор (Ph.D), дэд профессор

#### **Б.БОЛДБААТАР**

Монголын Криминологичдын холбооны гүйцэтгэх зөвлөлийн гишүүн, доктор (Ph.D), профессор

#### **Н.ГАНБАДРАЛ**

Доктор (Ph.D), дэд профессор

#### **Ж.ДОЛГОРСҮРЭН**

Доктор (Sc.D), профессор

#### **Н.ЖАНЦАН**

Монгол Улсын гавъяат хуульч, доктор (Ph.D), профессор

#### **А.ЛХАГВА**

Монгол Улсын гавъяат хуульч, доктор (Ph.D), профессор

#### **Г.ЭРДЭНЭБАТ**

Улсын Ерөнхий Прокурорын орлогч

### НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

#### **С.ГАНТУЛГА**

Доктор (Ph.D)

#### **Б.ЭНХБОЛД**

Доктор (Ph.D)

### ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

#### **С.ГАНТУЛГА**

Доктор (Ph.D)

### ЭХ БЭЛТГЭГЧ ДИЗАЙНЕР

#### **Х.БАДНААЖОНОН**



## Гарчиг

### КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Нуугдмал гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зам **Ц.Цэлмэг** 4
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хөршийн хяналтын ач холбогдол  
**Б.Баянмөнх, Д.Сумъяацэрэн** 10
- Хариуцсан нутаг дэвсгэрийн сум, баг, хорооны зураглал, түүнийг сайжруулах зарим асуудал **Г.Бямбадорж** 13
- Пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэгч субъект **Г.Баттулга** 17

### ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Уголовно-правовая защита половой неприкосновенности и половой свободы личности: сравнительно-правовой анализ российской и зарубежных систем уголовного права **В.А. Авдеев, Е.В.Адеев** 21
- Бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодуулах эрхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах гэмт хэрэгтэй тэмцэж ирсэн уламжлал, шинэчлэл **Б.Баттүвшин** 27

### ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Үйл явдлыг тогтооход чиглэсэн эрүүгийн процессийн зарим асууда **.Б.Намсрай** 32
- Гэмт хэрэг мөрдөх орчин үеийн чиг хандлагын зарим асуудал **Я.Цэлмэн** 36

### КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Хэргийн материалаар шүүх эмнэлгийн шинжилгээ хийхэд анхаарах асуудал **С.Аюушбаатар** 39
- Авто техникийн шинжилгээ хийхэд тулгамдаж буй зарим асуудал **Ж.Ялалтбаяр** 42

### ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Цагдаагийн байгууллагын аюулгүй байдлын зарим асуудал **Ю.Бадамханд, Ж.Жанболат** 48
- Цагдаагийн албан хаагчдын нийгмийн хамгааллын зарим асуудал **Л.Нямдаваа** 53

### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Особенности индивидуальной воспитательной работы с осужденными **Мазалева Людмила Валерьевна** 63

### ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Хуулийн хэллэгт таслал хэрэглэхтэй холбогдсон зарим логик асуудалд (монгол улсын үндсэн хуулийн жишээн дээр) **Х.Оюунбаатар** 65
- Монгол Улсын шүүхийн тогтолцоотой холбоотой үүссэн Үндсэн хуулийн маргаанд хийсэн дүн шинжилгээ **Т.Азжаргал** 69
- Харьяалалгүй иргэний эрх зүйн байдлыг боловсронгуй болгох зарим асуудал **О.Хишигмөнх** 78
- Нэмэгдсэн өртгийн албан татварын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал **Э.Мөнхжаргал** 83
- Монгол Улсын харьяат үрчлэгдсэн хүүхдийн иргэний харьяаллын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга зам **Ц.Ундрах** 87

### ТАНИН МЭДЭХҮЙ

- Олон улсын террорист бүлэглэл “исламын улс /isis/-ын тухай” **Д.Нямбат** 90



## НУУГДМАЛ ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

**Ц.Цэлмэг**

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, доктор (Ph.D)

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, гэмт явдалтай тэмцэх, гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэгт хяналт тавих зэрэг олон нэр томъёог судлаачид хэрэглэж байгаа ч эцсийн дүндээ эдгээр нь гэмт явдлын гаралтыг багасгах, нийгмийн хор аюулыг бууруулах, шалтгаан, нөхцлийг арилгах буюу саармагжуулах зорилго бүхий системтэй үйл ажиллагаануудын цогц байдаг.

Монгол Улсад гэмт явдлын гаралт жил ирэх тусам өсөн нэмэгдэж, ЦЕГ-ын албан ёсны тоон мэдээгээр 2006 он хүртэл жилд дунджаар 18.000 гэмт хэрэг, 2006-2010 онд жилд дунджаар 20.000 гэмт хэрэг, харин 2015 оноос жилд дунджаар 27.000 орчим гэмт хэрэг бүртгэгдэж байгаа<sup>1</sup> нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил үр дүнгээ өгөхгүй байгаад дүгнэлт хийж, гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг тодорхойлох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх уламжлалт онолыг шинэчлэх, нуугдмал гэмт явдлын түвшинг тодорхойлсны үндсэн дээр гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга замыг боловсронгуй болгох үр дүнтэй арга зам тодорхойлоход хувь нэмрээ оруулах шаардлагатай байна.

Хүн төрөлхтөн эрт үеэс гэмт этгээдийг цээрлүүлэхээс гадна гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, ялтан этгээдийг ухамсарлуулан ойлгуулж, хүмүүжүүлэх арга замыг эрэлхийлж, олон талт үзэл баримтлалыг боловсруулж ирсэн нь гэмт явдлаас урьдчилан сэргийлэх орчин үеийн онол, сургаалийн эх үндсийг тавьжээ.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх

арга хэмжээг өргөн утгаар нь авч үзвэл нийгмийн бүхий л хөгжил дэвшил, түүний эдийн засаг, үзэл суртал, соёл, техникийн цогц арга хэмжээний үр дүнд нийгмийн харилцааг боловсронгуй болгож, аж төрөх ёсыг хэвшүүлэн тогтоосноор хангагдах үйл ажиллагаа байдаг бол явцуу утгаараа гэмт хэргийн тухай мэдээ, мэдээллийг судалсаны үндсэн дээр гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан, нөхцлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн.

Гэмт явдал /преступность/ болон гэмт хэрэг /преступление/ гэсэн ялгаатай ойлголтуудыг тодотгох шаардлагатай бөгөөд гэмт явдал нь тодорхой нутаг дэвсгэрт, тодорхой цаг хугацааны туршид үйлдэгдсэн бүх гэмт хэргүүдийн нийлбэр цогц байдаг бол гэмт хэрэг нь бие хүний ухамсарт үйл ажиллагаа, гэмт зан төлвийн үр дагавар бүхий тохиолдлын чанартай үзэгдэл байдаг.

Гэмт явдал нь зайлшгүй шинжтэй нийгмийн үзэгдэл болохын хувьд нийгмийн амьдралын янз бүрийн хүрээ түвшинд оршиж байгаа өөртөө нөлөөлөх шалтгаан, нөхцөлүүдтэй нягт холбоотой байдаг тул гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд нь эдгээр шалтгаан, нөхцөл бүрт нөлөөлж чадахуйцаар зохион байгуулагдах учиртай.

Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилт аяндаа хэрэгжихгүй, урт удаан хугацаанд нөр их хүч, хамтын ажиллагаа, хөдөлмөр шаарддаг үйл явц бөгөөд нийгэм, төрийн зүгээс чиглэсэн зорилготой, системтэй, байнгын тасралтгүй иж бүрэн арга хэмжээ авч байхыг шаарддаг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд ялгамжтай хандаж системтэй дүн шинжилгээ хийх, төрөлжүүлэн ангилах явдал түүний дэс дараалал, баримтлах журам, үндсэн чиг шугамыг тогтоон бэхжүүлэх үйл ажиллагаанд оролцогч субъектуудын гүйцэтгэх үүрэг, эрх хэмжээг тодорхойлон оновчтой болгох, бодит байдлаар хандах, бүрэн дүүрэн цогцолбор шинжтэй явуулах зорилтыг хангахад чиглэгддэг.

Нуугдмал гэмт явдлын түвшинг тооцохгүйгээр зөвхөн бүртгэгдсэн гэмт хэргийн хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна гэдэг нь бодитой үр дүнд хүрэхгүй.

Далайн усанд хөвж яваа мөсөн уултай гэмт явдлыг зүйрлэж болох бөгөөд усны мандал

<sup>1</sup> [www.police.gov.mn](http://www.police.gov.mn)



дээр харагдаж байгаа багахан хэсэг нь бүртгэгдсэн гэмт хэргийг төлөөлөх бол усан доор далд байгаа ихэнх хэсэг нь нуугдмал гэмт явдал гэсэн үг. Гол жин дарж буй нуугдмал гэмт явдлын түвшинг тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлохгүйгээр гэмт явдалтай тэмцэнэ гэдэг нь нүд хуурсан, хий хоосон зүйл гэдэг нь гэмт явдалтай тэмцэж буй ажлын дүнгээс харагдана.

Тухайн улсад үйлдэгдсэн гэмт явдлын түвшинг бодитой тогтоохын тулд нуугдмал гэмт явдлын түвшинг тогтоох зайлшгүй шаардлагатай нь тодорхой. Гэтэл Монголын шүүх, хууль сахиулах байгууллагууд, тэдгээрийн албан тушаалтнууд зөвхөн цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тоон мэдээллийн талаар ярьж, гэмт хэргийн гаралт ингэж буурлаа, илрүүлэлт өссөн зэргээр ярьж бичих нь бодит байдлаас их зөрүүтэй буюу товчхондоо гэмт явдлын бодит түвшинг тогтоож чадахгүй байгаа хэрэг юм.

Нуугдмал гэмт явдал /латентная преступность, latent crime/ гэж бодитойгоор үйлдэгдсэн боловч хуулийн байгууллагад бүртгэгдээгүй, шалгагдаагүй, илрээгүй байгаа гэмт хэргүүдийн нийлбэр цогц юм. Өөрөөр хэлбэл, ямар ч тоон мэдээнд ороогүй, мөрдөн шалгах ажиллагаа хийгдээгүй, хуулийн байгууллагад мэдэгдээгүй нууц, далд байгаа гэмт хэргүүдийн нийлбэр цогцсыг ойлгоно. Харин илрээгүй гэмт хэрэг /скрытой преступление/ гэдэг нь хууль сахиулах байгууллагад бүртгэгдсэн, шалгагдаж байгаа буюу түдгэлзүүлсэн, хэрэгсэхгүй болсон зэрэг гэмт хэрэг үйлдсэн этгээд нь хараахан тогтоогдоогүй байгаа гэмт хэргүүдийг ойлгодог.

Нуугдмал болон илрээгүй гэмт явдлын ялгаа нь хуулийн байгууллагад бүртгэгдсэн болон бүртгэгдээгүйгээс гадна илрээгүй гэмт хэргүүдийн талаар тодорхой тоо баримт, хавтаст хэргүүд /материал/ байдаг бол нуугдмал гэмт явдлын түвшинг тодорхойлох боломжгүй, зөвхөн магадлалын онолын үндсэн дээр баримжаалдагт оршино.

Нуугдмал гэмт явдлын түвшинг илэрсэн гэмт явдалтай харьцуулахад ямагт өндөр байдаг бөгөөд бүртгэгдсэн гэмт хэргийн тооноос нуугдмал гэмт явдлын түвшин даруй 3-10 дахин их байдаг<sup>2</sup> гэж барууны судлаачид олон жилийн судалгааны үндсэн дээр тодорхойлсныг дараах хэдхэн

<sup>2</sup> В.Н. Кудрявцева, В.Е. Эминова. Криминология. М, 2004, с 58

жишээгээр батлах боломжтой. Хулгайд эд хөрөнгөө алдсан хүмүүсээс хэд нь цагдаагийн байгууллагад хандсан болон хандалгүй өнгөрсөн талаар 2005 онд “Шихихутуг” ХЗДС-д багшаар ажиллах хугацаандаа оюутнуудын хамтаар 1000 хүнээс асуулгын аргаар судалгаа авахад, оролцогчдын 85 хувь нь хулгайд эд зүйлсээ алдаж байсан ч 70 хувь нь цагдаагийн байгууллагад хандаагүй бөгөөд шалтгаанаа “явдлын гарз, цагдаа олж чадахгүй, адгийн зарга 10 хоног гээд хаясан” зэргээр хариулсан.<sup>3</sup> Энэ судалгааны дүнгээс үзэхэд, хулгайчид эд зүйлсээ алдсан хүмүүсийн 70 орчим хувь нь цагдаад хандаагүй өнгөрч байгаа нь тэдгээр бодитой үйлдэгдсэн гэмт хэргүүдийг нуугдмал үлдэхэд хүргэж байна.

Манай улсад үйлдэгдэж байгаа гэмт явдлын 40 гаруй хувийг эзэлдэг бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэг нь жилд дунджаар 10.000 орчим бүртгэгддэг бөгөөд нуугдмал гэмт явдлын түвшинг тооцвол жилд дунджаар 50.000 орчим хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэж байх магадлалтай.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 203 дугаар зүйл буюу “Ан агнуурын хууль тогтоомж зөрчих” гэмт хэрэг жилд 20 орчим бүртгэгддэг бөгөөд эд зүйл хууль бусаар улсын хил нэвтрүүлэхийг завдаж хураагдсан нэн ховор, ховор амьтны арьс, эд эрхтэн жилд дунджаар 80-120 мянгаас буурахгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн нуугдмал шинж ямар өндөр түвшинд байгааг харуулна.

Тодорхой гэмт хэргийг өөр хуулиас иш татах замаар объектив талыг нь тодорхойлох нь Эрүүгийн хуулийн тогтвортой байдлыг алдагдуулдаг бөгөөд үүний нэг жишээ нь 2012 онд Ан агнуурын тухай хуулийг хүчингүй болгож, “Амьтны тухай” хуулийг шинэчлэн найруулж, одоо хүчин төгөлдөр үйлчилж байхад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 203 дугаар зүйлд “Ан агнуурын хууль тогтоомж зөрчих” гэмт хэрэг гэсэн нэртэйгээр үйлчилж жилд 10 гаруй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа нь Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглосон “Хууль ёсны зарчим” зөрчигдөж байгаа гэж үзэхээс өөр аргагүй.

Улаанбаатар хот руу жилд гарал үүслийн гэрчилгээгүй, хууль бусаар бэлтгэсэн мод ачсан 10.000 орчим автомашин нэвтэрч<sup>4</sup> байгаа бол Эрүүгийн хуулийн тусгай

<sup>3</sup> Ц.Цэлмэг. Криминологи. УБ хот, 2005 он, 256 дахь талд

<sup>4</sup> Ц.Цэлмэг. Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн Эрүүгийн эрх зүйн болон криминологийн асуудал сэдэвт Докторын бүтээл. 2012 он, УБ хот. 155 дахь талд



ангийн 211 дүгээр зүйл буюу “Ойн тухай хууль тогтоомж зөрчих” гэмт хэрэг жилд 200 орчим бүртгэгддэг, аймаг болон сум хооронд зөөгдөж байгаа хууль бусаар бэлтгэсэн модны сүлжээг хянаж чадахгүй байгаа зэрэг цөөхөн хэдэн жишээгээр манай улсад жилд дунджаар 27.000 гэмт хэрэг бүртгэгддэг бол нуугдмал гэмт явдлын түвшинг тооцвол үүнээс 5-6 дахин их буюу жилд дунджаар 130.000-150.000 гэмт хэрэг бодитойгоор үйлдэгддэг гэж дүгнэж болохоор байна. Мөсөн уулын орой болох бүртгэгдсэн гэмт хэрэг 20-25 хувийг эзэлдэг бол гол хэсэг нь далд буюу нуугдмал байдгийг олон орны эрдэмтэд хэдийнэ хүлээн зөвшөөрсөн бөгөөд ОХУ-ын криминологийн эрдэмтэд өөрсдийн орны нуугдмал гэмт явдлын түвшинг бүртгэгдсэн гэмт хэргээс даруй 5-6 дахин өндөр<sup>5</sup> гэж тодорхойлжээ.

Хамгийн их гэмт хэрэг үйлдэгддэг, тэр хирээрээ нуугдмал гэмт явдлын түвшин өндөр байдаг орнуудад АНУ, ОХУ, Канад, Испани, Баруун европ болон манай улс ордог бөгөөд 100.000 хүнд оногдох гэмт явдлын коэффициентээр хэмжихэд баруун Европод дунджаар 5000 гэмт хэрэг, Канадад 8000, Швецэд 13000, АНУ-д 5700, ОХУ-д 2800, Японд 1500, Энэтхэгт 650, Мусульманы эрх зүйн тогтолцоот орнуудад 150-2000 орчим, БНХАУ-д 235 гэмт хэрэг ногдож байх жишээтэй.<sup>6</sup> Тухайлбал, 100.000 хүнд ногдох санаатай аллага болон хүч хэрэглэсэн гэмт хэргийн коэффициент нь ОХУ-д 17.6 гэмт хэрэг, Энэтхэгт 3.1, БНХАУ-д 2.3, Колумбид 61.2, Өмнөд африкт 49.3, Албанид 36.9, Ямайкад 33.2, Монголд 25.7, Венесуэлд 23.6 гэмт хэрэг ногдож байгаа нь дэлхийд хамгийн өндөрт тооцогдож байна. Манай иргэд, хуульчдын олонх нь нуугдмал гэмт явдлын талаар тодорхой ойлголтгүй, илрээгүй гэмт хэрэгтэй хольж хутгадаг бөгөөд гагцхүү нуугдмал гэмт явдлын түвшинг бодитой тогтоосон нөхцөлд л гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд бодит үр дүн гарах учиртай. Өөрөөр хэлбэл, зөвхөн бүртгэгдсэн гэмт хэргийн хүрээнд асуудалд хандаж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна гэвэл тэр нь бодит байдалд нийцэхгүй төдийгүй тодорхой үр дүнд хүрэхгүй гэдэг нь тодорхой юм. Тухайлбал, жилд байгаль орчны эсрэг 300 орчим гэмт хэрэг бүртгэгддэг бөгөөд ийм цөөхөн гэмт хэрэг бүртгэгддэг тул манай улсын байгаль орчинд ноцтой заналхийлэл байхгүй, УМБГ-ын “Байгаль орчны эсрэг

гэмт хэрэгтэй тэмцэх” тасагт 8 мөрдөн байцаагч хангалттай гэж үзээд ажиллуулж байгаа нөхцөлд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд ахиц гарахгүй нь ойлгомжтой. Миний судалгаагаар зөвхөн байгаль орчны эсрэг нуугдмал гэмт хэргийн түвшин гэхэд жилд 10.000-с буурахгүй байгаа бөгөөд бид гэмт хэрэгтэй тэмцэх тэмцлийн хараагаа зөв тодорхойлж, энэ төрлийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажил тодорхой амжилтад хүрнэ гэдгийг ямагт санах учиртай.

Гэмт явдал нуугдмал байх шалтгаан, нөхцлийг дараах байдлаар ангилах санал дэвшүүлж байна. Үүнд:

**Нэгдүгээрт:** Гэмт хэргийн хохирогчтой холбоотой хүчин зүйлсийн улмаас гэмт хэрэг нуугдмал үлдэх тохиолдол их байна. Тухайлбал, гэмт хэргийн улмаас хохирсон этгээд хууль сахиулах байгууллагад гомдол гаргахгүй байх явдал. Олон хүмүүс хулгайд эд зүйлээ алдах, бусдад зодуулах, эмэгтэйчүүд хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон үедээ нэр төрөө алдахаас айх, эсвэл хохирогчийн зан байдал гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан болсон тохиолдолд хохирсон этгээд хуулийн байгууллагад хандахгүй өнгөрөөх нь цөөнгүй. Гэмт хэрэг бодитойгоор үйлдэгдсэн, хохирол учирсан байхад хуулийн байгууллагад хохирогч хандахгүй байгаа нь төвөгшөөх, хуулийн байгууллагын үйл ажиллагаанд итгэхгүй байх, айх, ичих зэргээс болж гэмт хэрэг нуугдмал үлддэг.

Түүнчлэн, хохирогч нь гэмт этгээдийн дарамт, эрхшээлд байгаагаас хуулийн байгууллагад хандахгүй эрх нь зөрчигддөг, хохирогч хууль, эрх зүйн мэдлэг дутмагаас хаана хэнд хандахаа мэдэхгүй, зарим тохиолдолд эрх нь зөрчигдсэн эсхийг ч мэдэхгүй байх нь гэмт хэрэг нуугдмал байхад хүргэдэг. Дээрх хүчин зүйлсийг багцлаад гэмт явдал нуугдмал байхад хохирогчийн үзүүлэх хүчин зүйлийн нөлөөлөл гэж болох бөгөөд эдгээр нь гэмт явдал нуугдмал байх үндсэн шалтгаан гэж үзэж болно.

**Хоёрдугаарт:** хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны доголдол, ажилтнуудын ёс зүйгүй, дээрэнгүй зан авир нь иргэдээс тэдэнд итгэх итгэлийг сулруулж маргаанаа шүүх, хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэхийн оронд хоорондоо зохицох, тохиролцохыг эрмэлзэх нь гэмт явдал нуугдмал байх дараагийн шалтгаан болж байна. Хууль сахиулах байгууллагууд үйлдэгдсэн гэмт хэргүүдийг тэр бүр илрүүлж чаддаггүй<sup>7</sup>, шийдвэрлэхгүй хугацаа

<sup>5</sup> Криминология. М.П.Клейменов. М., 2011 г, с-61

<sup>6</sup> Мөн тэнд үзэх

<sup>7</sup> Авлига, албан тушаалын гэмт хэрэг. АНУ-ын Азийн



алддаг явдал нь иргэдийг шүүх, хуулийн байгууллагад итгэх итгэлийг бууруулж их хэмжээний хохирол учраагүй, амь нас, эрүүл мэндээрээ хохироогүй л бол цагдаад хандахгүй өнгөрөхөд хүргэдэг. Зарим албан тушаалтнууд хохирогчийг залхтал явуулах, хэрэгтэн мэт харьцах, хохирлыг барагдуулах тал дээр анхаардаггүй зэрэг нь хохирогч иргэнийг гэмт этгээдтэй тохиролцоход хүргэж, эцэстээ гэмт хэрэг нуугдмал үлдэж байна.

**Гуравдугаарт:** Эрүүгийн хууль болон бусад хууль тогтоомжийн хийдэл, тодорхой зүйл заалтын боловсронгуй бус байдал нь гэмт хэрэг нуугдмал байх нэгэн шалтгаан болж байна. Тухайлбал, Эрүүгийн хуульд хээл хахууль авсан, өгсөн, зуучилсан бүх этгээдийг шийтгэхээр зааж өөрийгөө илчлэн ирсэн этгээдэд урамшууллын механизм хэрэглэхгүй байгаа өнөөгийн нөхцөлд авлигын гэмт хэргийг хүссэн хүсээгүй нуугдмал шинжтэй болгодог.

“Transparency international” олон улсын байгууллагын жил бүрийн судалгаагаар<sup>8</sup> Монгол Улс нь авлигад автсан орны тоонд багтдаг, харин шүүхээр шийдвэрлэгдсэн хээл хахуулийн гэмт хэрэг гарын арван хуруунд багтааар цөөн байгаа нь өнгөц харахад манай улсад хээл хахууль байхгүй шахам дүр зураг харагдаж байгаа нь олон улсын байгууллагын судалгааны дүнд итгэх үү, Монгол Улсын шүүхийн албан ёсны тоон мэдээнд итгэх үү гэсэн асуулт тавигдахад хүргэнэ.

**Дөрөвдүгээрт:** Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг, ухамсар дутмаг, хуулийн байгууллагатай хамтран ажиллах, туслах сэтгэхүй бүрдээгүй байгаа нь гэмт хэрэг нуугдмал байхад тодорхой хэмжээнд нөлөөлдөг.

Хөгжингүй орнуудын иргэдийн эрх зүйн ухамсар хөгжсөн, иргэд нь хуулийн байгууллагынхаа ажилд туслах эрмэлзэлтэй бөгөөд гэмт хэрэг үйлдэгдэж байгаа болон үйлдэгдсэн талаарх мэдээллийг цаг тухайд нь мэдээлдэг, хуулийн байгууллага болон иргэдийн хамтын ажиллагаа хөгжсөн, урамшууллын механизмудыг хууль тогтоомждоо хангалттай суулгасан байдаг. Тухайлбал, гэрчээр дуудагдсан этгээдэд ажлаас нь чөлөө олгох, аюулгүй байдлыг нь хангах, байр, хоолны болон замын зардал олгох, цалинг хасахгүй байх, гарсан бусад зардлаа төрийн зардлаар гаргуулах

сангийн захиалгаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргасан гарын авлага. УБ хот, 2014 он, 55 дахь талд.

<sup>8</sup> www. Transparency.org

эрхийг хангадаг байхад манай улсад байдал ямар байгааг бид мэднэ, хэдийгээр гэрч хохирогчийн аюулгүй байдлыг хангах хууль батлагдсан нь сайн хэрэг ч зардал гаргуулах болон бусад асуудал одоо ч тунхагийн шинжтэй байгаа учир иргэд дахин дахин гэрчээр дуудагдах явдлаас залхах нь аргагүй. Түүнчлэн, манай олонхи иргэд хар амиа бодсон, хууль эрх зүйн мэдлэг, ухамсар муутай, хуулийг сахин биелүүлэхдээ хойрго, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээс цааргалдаг, “амьд хүний гэрч болохоор үхсэн хүний дэр бол” маягийн сэтгэхүйтэй, эд мөнгөнд автаж мэдүүлгээсээ буцах зан байдал гаргадаг нь гэмт хэрэг нуугдмал байх нэгэн шалтгаан болдог.

Гэмт хэргийн үндсэн шалтгаан бол хувь хүний хүсэл шунал, уур хилэн, атаа хорсол, би-д хүлэгдсэн үзэлтэй /эго/ холбоотой учир гэмт хэрэг нь гагцхүү хүн төрөлхтөнтэй л хамт устаж алга болох мөнхийн үзэгдэл юм. Олон сая хүний эрх ашгийг нэгтгэх боломжгүй учир хүн бүрийн нийгэмд биеэ хэрхэн авч явбал зохих боловсронгуй дүрмийг зохиож мөрдүүлэх нь төрийн гол чиг үүрэг.

өрөл бүрийн шашны сургаал нь хувь хүний хүмүүжилд анхаарч гэмт хэргийг нүгэлд тооцож үйлдэхгүй байхыг сургаж байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлж байгаа нэг хэлбэр учир хүндэтгэлтэй хандах нь зүй ёсны хэрэг. Энэ мэтчилэн далд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь зөвхөн төрийн байгууллагуудын үүрэг төдийгүй, төрийн бус байгууллага, сүм хийд, аж ахуйн нэгж, иргэдийн тал бүрийн оролцоотойгоор үр дүнд хүрэх нарийн төвөгтэй үйл ажиллагаа бөгөөд дээр хэлсэнчлэн гэмт хэргийн гаралтыг бууруулах, хянах тухай л ярихаас гэмт хэрэг гэдэг үзэгдлийг бүрмөсөн байхгүй болгох боломжгүй гэдэг нь тодорхой юм. Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг агуулга, шинж байдлаар нь эдийн засгийн, улс төр, үзэл суртлын, удирдлага, зохион байгуулалтын, эрх зүйн болон техникийн шинжтэй арга хэмжээ гэж ангилна.

Эдийн засгийн арга хэмжээ нь нэг хүнд ногдох үндэсний орлого, амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, иргэдийн хөдөлмөрлөх нөхцөл, орон сууцны болон ахуйн үйлчилгээний нөхцлийг сайжруулах, татварын дарамтыг бууруулах зэрэг нийгэм, эдийн засгийн арга хэрэгслийг ашиглах замаар хэрэгжин биелэх асуудлууд хамаарна.





Улс төр, үзэл суртлын арга хэмжээ нь хүмүүнлэг, ардчилсан, эрх зүйт нийгэм байгуулах, нийгмийн харилцааг улам боловсронгуй болгох, нийгмийн ухамсарт нөлөөлж дээшлүүлэх, иргэдийн ухамсар, боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх зэрэг хэлбэрээр илэрнэ.

Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ нь гэмт явдалтай тэмцэхэд төр, нийгэм, аж ахуйн болон олон нийтийн байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг уялдуулах, мэдээлэл цуглуулах, шалтгаан нөхцөлийг илрүүлэн арилгах, иргэдийн гэмт хэрэгтэй тэмцэх идэвхижилийг дээшлүүлэх зэрэг болно.

Эрх зүйн арга хэмжээ нь Эрүүгийн хууль тогтоомж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, боловсронгуй болгох замаар хэрэгжин биелэх үйл ажиллагаа мөн.

Техникийн арга хэмжээ нь гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд орчин үеийн техник хэрэгсэл, компьютерийн тусламжтайгаар гүйцэтгэгдэх арга хэмжээнүүд хамаарна. Гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник, компьютерийг өргөнөөр ашиглах, нийт иргэдийн гар, хурууны хээг авч компьютерт хадгалах, банк, үнэт цаас, татварын тооцоо, нийтийн тээвэр зэрэг бүхий л салбарыг цахим төлбөр тооцооны системд оруулах, гудамж, нийтийн тээврийн хэрэгслүүдийг нэг бүрчлэн камержуулах зэрэг техникийн шинжтэй арга хэмжээнүүд нь гэмт хэргийг илрүүлэх, нотлох ажиллагаанд чухал үүрэгтэй.

Нуугдмал гэмт явдалтай тэмцэх, илрүүлэх арга зам:

Нуугдмал гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил нь юуны өмнө далд байгаа зүйлийг илрүүлэх, тодорхой болгоход чиглэх ёстой бөгөөд үүний тулд шалтгаан, нөхцөлд нь анхаарал хандуулах шаардлага урган гарна.

Гэмт хэрэг нуугдмал байх шалтгаан нь иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэг дорой байгаатай холбоотойг дээр өгүүлсэн бөгөөд ард иргэдэд хууль сурталчлах, тэдэнд эрх зүйн боловсрол олгох ажлыг өргөн цар хүрээтэй зохион явуулах, хууль эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, туслалцаа үзүүлэх тогтолцоог бий болгож дэмжлэг үзүүлэх зэргээр иргэдийг эрх ашиг зөрчигдсөн үед хаана, ямар байгууллагад хэрхэн хандахаа

мэддэг болгох нь наад захын шаардлага юм.

Гэрч, хохирогчоор дуудагдсан этгээдэд ажлаас нь чөлөө олгох, аюулгүй байдлыг нь хангах, байр, хоолны болон замын зардал олгох, цалинг хасахгүй байх, гарсан бусад зардлаа төрийн зардлаар гаргуулах эрхийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 99-101 дүгээр зүйлүүдэд тодорхойлсон боловч харамсалтай нь хуулийн заалт өнөөдрийг хүртэл амьдралд хэрэгждэггүй, нэг ч гэрчид зардал гэж нэг ч төгрөг олгодоггүй практик тогтсон нь иргэд хуулийн байгууллагын хамтын үйл ажиллагаанд тодорхой ахиц гарахгүй байгааг анхаарч төрөөс дээрх зардлын санхүүжилтийг жил бүр төсөвт суулгаж албан тушаалтнууд мөнгө хүсэж зохих ёсоор баримтжуулсан хүсэлт бүрийг хүлээн авч шуурхай шийдвэрлэж байх нь тогтсон практикийг өөрчилж иргэд хуулийн байгууллагын хамтын үйл ажиллагааг сайжруулах эхний чухал алхам болох нь гарцаагүй.

Шүүх, хуулийн байгууллагын шинэчлэл хүний нөөцийн буюу ажилтан, албан тушаалтнуудын мэдлэг, ур чадвар, хандлага, харьцааны соёлыг өөрчлөх, дээшлүүлэхэд орших бөгөөд чадахгүй бол зорьж буй шинэчлэл утга учиргүй болж үр дүнд хүрэхгүй. Өөрөөр хэлбэл ямар ч сайн хууль эрх зүйн орчин бүрдүүлээд, ажиллах нөхцлийг нь сайжрууллаа ч гэсэн нөгөө л бусдыг үл тоомсорлодог, бүдүүлэг, дээрэнгүй, ёс зүйгүй, чадвар муутай, ажлын бүтээмж муутай ажилтан байгаа цагт шүүх, хуулийн байгууллагад итгэх иргэдийн итгэл сэргэхгүй. Хамгийн сайныг нь шилж сонгох шударга тогтолцоог бүрдүүлж байж л төрийн алба тунгалаг болно гэдгийг анхаарах учиртай.

Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэл, өөрчлөлттэй зэрэгцээд нуугдмал гэмт явдлын түвшин өсөх буюу буурах үзэгдэл тохиолддог. Тухайлбал, шинээр баталсан Эрүүгийн хуульд өмчийн эсрэг болон экологийн эсрэг гэмт хэргүүдийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар заасан нь нуугдмал гэмт хэргийг ил гаргах чухал хүчин зүйл болно.

Өнөөдөр ашигт малтмалыг зөвшөөрөлгүй олборлож байгаа 90.000 хүнийг эрүүгийн хариуцлагад татах, түлээний мод зөвшөөрөлгүй бэлтгэсэн, жижиг хулгай зэрэг хохирлын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхгүйн улмаас зөрчилд тооцдог 150.000 хүний асуудал





хурцаар хөндөгдөх бөгөөд дээрх тооны хүмүүсийг эрүүгийн хариуцлагад татахад хууль хяналтын байгууллагын хүч, орон тоо, чадавхи хүрэлцэх эсэх, эсвэл Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэхгүй зөнд нь орхих асуудал үүснэ.

Материаллаг бүрэлдэхүүнтэй байхаар гэмт хэргийг хуульчлах нь хоцрогдсон арга биш бөгөөд цаашид Эрүүгийн хуулийг боловсронгуй болгохдоо гэмт хэрэг бүрийн онцлогийг харгалзан улс орны хөгжил дэвшилд саад болохооргүй, нийгмийг гэмт халдлагаас хамгаалж чадахуйц, уян хатан заалт бүхий хуулийг батлах шаардлага тулгарч байна. Түүнчлэн, Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлагад хүлээлгэхээр заасан нь Үндсэн хуультай зөрчилдөх эсэх, Эх газрын эрх зүйн тогтолцоо буюу Германы сонгодог эрх зүйн уламжлалтай нийцэх эсэх, бизнесийн үйл ажиллагааг боомилж эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг онцгой анхаарах шаардлагатай.

Нуугдмал гэмт явдалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, илрүүлэхийн тулд зарим тодорхой төрлийн гэмт хэргүүд дээр жишээ авъя. Юуны өмнө хээл хахууль авах, өгөх, зуучлах гэмт хэргийн нуугдмал байх шинж хамгийн өндөр буюу бүртгэгдсэн 1 хэргийн цаана 100-200 гэмт хэрэг байх магадлалтай гэж үздэг. Манай улсад жилд 10 гаруй хээл хахуулийн гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэгддэг бол далд 1000-2000 орчим гэмт хэрэг нуугдаж байх магадлалтай.

Манай улсад бизнесийн бараг бүхий л үйл ажиллагаа төрөөс хамааралтай байж, тусгай зөвшөөрөл шаарддаг нь шат шатандаа авлига авах нөхцлийг бүрдүүлж байгаа учир шилэн дансны тогтолцоо цахим төрийн үйлчилгээг нэвтрүүлэх шаардлагатай бөгөөд эхний алхмууд хийгдэж эхэлсэн нь сайшаалтай.

Төрийн албан хаагчдын цалин хангамжийг зохих түвшинд нэмэгдүүлэх, нэмэгдүүлэх эх үүсвэр олохын тулд цомхон чадварлаг төрийн аппаратыг бүрдүүлэх шаардлагатай. Төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулах журмыг хатуу хяналттай, уралдаант шалгалтын журмаар, олон нийтийн хяналтан дор явуулах цаг нь болсон.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажил бол хангалттай санхүүгийн эх үүсвэртэй байж амжилтад хүрнэ. Торгуулийн болон эд хөрөнгө хураах ял, захиргааны арга хэмжээ ногдуулсанаас цугларсан

хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах, төрийн байгууллагын албан хаагчдын орон тоог үндэслэлгүйгээр хасахгүй байх, бусад арга хэмжээнд хөрөнгө зарцуулах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гол арга зам болно.



## ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ХӨРШИЙН ХЯНАЛТЫН АЧ ХОЛБОГДОЛ

**Б.Баянмөнх** – ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, цагдаагийн хошууч

**Д.Сумьяацэрэн** – ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, цагдаагийн ахлах дэслэгч

**Товч агуулга:** Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх дэлхийн улс орнуудад үр дүнтэй хэрэгжиж буй “Хөршийн холбоо” хөтөлбөрийн талаар болон манай улсад хэрэгжээд эхэлсэн уг хөтөлбөрийн үр дүн, ач холбогдлын талаар энэхүү өгүүлэлд бичжээ.

**Түлхүүр үгс:** Хөршийн холбоо, хөршийн хяналт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх.

Гэмт хэрэг, зөрчил нь нийгмийн сөрөг үзэгдэл бөгөөд устаж үгүй болохгүй, аль ч нийгэмд байсаар ирсэн түүхтэй. Түүний гаралтыг зөнд нь орхих бус, харин түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй, үр дүнтэй зохион байгуулж явуулах нь өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлага болсоор байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн арга бол урьдчилан сэргийлэх ажлыг чанартай зохион байгуулах явдал юм. Өнөөдөр гэмт хэргийг гарсан хойно нь хөрөнгө мөнгө, хүч хэрэгсэл, цаг заваа зарцуулан байж илрүүлэх, шийдвэрлэхдээ биш, харин гарахаас нь өмнө аль болох урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гарах нөхцөл, байдлуудыг арилгахад чиглэгдсэн арга хэмжээг иж бүрэн цогцоор нь явуулах нь чухал юм.

Энэ асуудлыг цагдаагийн байгууллага дангаараа өөртөө хүлээгээд амжилт олохгүй бөгөөд үүнд, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааны оролцоог жигд хангах, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийг төрийн албадлага, итгэлцэл дээр тулгуурлан, үүрэг ролийг нэмэгдүүлэх, энэ ажилд идэвхитэй оролцсон

аж ахуйн нэгж, байгууллагуудыг урамшуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төрөл бүрийн төслийг санхүүжүүлж байх нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой.

Өнөөдөр Улаанбаатар хотод гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа нэг томоохон төсөл ажил бол “Хөршийн хяналт” хөтөлбөр билээ.

Хөршийн хяналт нь манай улсад 1990 оноос өмнө “хөршийн холбоо” нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд үйл ажиллагааны хамрах хүрээ, чиглэл нь харьцангуй хязгаарлагдмал шинжтэй байжээ.

Статистик мэдээнээс үзвэл, гэр, орон сууцанд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн 50-60 хувийг иргэдийн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 30-40 хувийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг эзэлж байна. Ялангуяа гэр хороолол, орон сууцны орчимд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад иргэдийн үүрэг оролцоо чухал гэдэг нь гадаадын улс орнуудад хэрэгжиж байгаа “Хөршийн хяналт”-ын нэгдлүүдийн практик туршлагаас илхэн харагдаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах ажлыг дэлхийн олон улс орон янз бүрийн нэршилтэйгээр хэрэгжүүлж ирсэн бөгөөд түүхчлэн авч үзвэл:

АНУ: Хөршийн хяналтын систем нь Хойд Америкийн нутаг дэвсгэр дэх хамгийн эртний бөгөөд тэргүүн туршлага нэвтрүүлсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга тактик юм.

Анх 1960-аад оны сүүлчээр гэмт хэргийн гаралт маш ихээр нэмэгдэж байсан учраас урьдчилан сэргийлэх ажлыг иргэд, оршин суугчдад түшиглэн зохион байгуулах шаардлагатай болж, 1972 онд Үндэсний шерифийн холбооноос иргэд, хууль сахиулах байгууллагын хоорондын уялдаа холбоог сайжруулах, тэдэнд туслах зорилгоор “Хөршийн хяналт” Үндэсний хөтөлбөрийг бий болгож хэрэгжүүлж эхэлсэн байна.

Улмаар 2001 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн террорист халдлагын хор уршгийн дараагаар аюулгүй байдлыг хангах нэгдлүүдийн үйл ажиллагаа нь урьд өмнө байгаагүйгээр эрчимжиж ирсэн бөгөөд Хөршийн хяналт хөтөлбөр нь террорист халдлагаас сэрэмжлэх, байгалийн гамшигт үзэгдлийн бэлэн байдлыг хангах, яаралтай тусламж үйлчилгээг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг хамрах болсон байна.<sup>1</sup>

**Англи улс:** Гэмт хэргээс урьдчилан

<sup>1</sup>“АНУ-ын үндэсний хөршийн хяналт”. АНУ-ын Хууль зүйн туслалцааны товчоо., 8 дахь тал. /[https://www.bja.gov/Publications/NSA\\_NW\\_Manual.pdf/](https://www.bja.gov/Publications/NSA_NW_Manual.pdf/)



сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулахдаа итгэлцэл бий болгох “Хөрш болон айл өрхийн хяналтын сүлжээ” гэсэн нэршилтэй холбооны үйл ажиллагаагаар дамжуулан оролцуулсан байна.

Уг холбоо нь гэмт хэргийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог хангах, сайн дурын нэгдлүүдийн үйл ажиллагаанд тулгуурласан аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дэмжих, дээрх чиглэлээр иргэдийн ухамсрыг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэнд, өмч хөрөнгийг хамгаалах үйл ажиллагаанд цагдаагийн байгууллага болон бусад хамтран ажиллагч байгууллагуудад туслалцаа үзүүлэн, олон нийтийн оролцоог хангах үндсэн зорилготой ажилладаг байна.<sup>2</sup>

**Япон:** Хөршийн холбоо<sup>3</sup> нь дэлхийн хоёрдугаар дайны үед Япон Улсын засгийн газраас үүсгэн байгуулсан үндэсний хөтөлбөр бөгөөд аюулгүй байдлыг хангах хамгийн анхан шатны нэгж юм.

Энэ нэгж нь дотоодын аюулгүй байдлыг хангах, иргэний хамгааллыг хэрэгжүүлэх, гал түймэртэй тэмцэх үүрэгтэй бөгөөд 10-15 айл өрхийг багтаасан байдаг байна.

Япон Улс дахь хөршийн холбоонд тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг хамтын нэгдлүүд нь Эдогийн эрин үеэс үүдэлтэй бөгөөд тухайн тогтолцоо нь Япон Улсын ерөнхий сайд байсан Фумимаро Коноёогийн харьяанд багтдаг Дотоод хэргийн яамны 1940 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн тушаалаар анх байгуулагдаж байжээ.

Тухайн үйл ажиллагаанд оролцох нь хүн бүрийн үүрэг байсан бөгөөд нэгдэл бүр нь хэмжиж өгсөн бараа материалыг хуваарилах, засгийн газраас гаргасан бондыг тараах, гал түймэртэй тэмцэх, нийтийн эрүүл мэндийг хамгаалах болон иргэний хамгааллын үйл ажиллагааг шуурхай хэрэгжүүлэх зорилготойгоос гадна тухайн нэгдлүүд нь Үндэсний шашны хөдөлгөөнийг дэмжих, Засгийн газраас баримталж байгаа бодлогыг олон нийтэд түгээх, эх оронч үзлийг бий болгох зэрэг үүрэг хариуцлагыг хүлээж байсан байна.

Энэхүү холбоо нь 1947 онд Америкийн эрх мэдэлтнүүдийн нөлөөллөөр татан буугдсан бөгөөд тухайн систем нь өнөөдрийн хувьд сайн дурын үүсгэл санаачлагын бие даасан холбоо болох “*chonaikai*” эсвэл “*jichikai*” гэсэн нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Дээрх улсуудаас гадна Швед улсад “Хөршийн харуул хамгаалалт” нэртэйгээр

<sup>2</sup> The effectiveness of neighborhood watch” The Campbell collaboration. 10 дахь тал. [file:///C:/Users/admin/Downloads/1049\\_R.pdf/](file:///C:/Users/admin/Downloads/1049_R.pdf/)

<sup>3</sup> (隣組 Tonarigumi?)

хэрэгжиж байгаа бөгөөд эдгээр төсөл хөтөлбөрүүд нь гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад ихээхэн тус дэмжлэг болж, өнөөг хүртэл үр дүнтэй зохион байгуулагдсаар байгаа нь иргэдийнхээ итгэлцэл, нийгмийн идэвхи, санаачлага дээр тулгуурлан зохион байгуулсантай салшгүй холбоотой юм.

Манай улсын хувьд 1990-ээд оноос өмнө энэхүү ажил нь хөршийн холбоо нэртэйгээр орон сууцанд амьдардаг иргэдийн дунд хэрэгжиж байжээ.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.3-т заасан гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн идэвхи, санаачлагад суурилсан “хөршийн хамгаалалт” төсөлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг 2014 оноос эхлэн эрчимжүүлж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 126 дугаар тогтоолоор “Хөршийн хяналт” хөтөлбөр, “Хөршийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг баталсан байна.

Хөршийн хяналт гэдэг нь өөрсдийн амьдарч буй нутаг дэвсгэрийг аюулгүй амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдэж, энэ чиглэлээр орон нутгийнхаа хууль сахиулах байгууллага болон захиргааны байгууллагуудтай хамтран ажилладаг тодорхой нэг нутаг дэвсгэрт оршин суудаг хүмүүсийн /иргэдийн/ нэгдэл юм.

Өөрөөр хэлбэл, Хөршийн хяналт нь нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах иргэдийн сайн дурын нэгдэл, анхдагч нэгж юм. Хөршийн хяналтыг бүрэн утгаар хэрэгжүүлж чадах аваас иргэд, оршин суугчид болон тодорхой нэгдлүүдийг яаралтай түргэн тусламжийн үйлчилгээнд бэлэн байлгахад гадна, гэмт хэрэгтэй тэмцэх, байгалийн гамшигт үзэгдлүүдэд ч бэлэн байлгах боломжийг бий болгож өгдөг үр дүнтэй ажил билээ.

Хөршийн хяналтыг хэрэгжүүлсний давуу тал нь:

-Иргэн бүрийн нийгмийн хариуцлага нэмэгдэнэ.

-Айл хөршийн хүчирхэг нэгдлийг бий болгож тэдэнд өөрсдөөрөө бахархах сэтгэл төрүүлнэ.

-Амар тайван, аюулгүй амьдрах таатай орчин нөхцөл бүрдэнэ.

-Хөрш айлуудынхаа талаар тодорхой мэдээлэлтэй болно.

-Хууль, хяналтын байгууллагуудыг мэдээ, мэдээллээр хангах боломж бүрдэнэ.

-Иргэд, хууль сахиулах байгууллагуудын



хамтын ажиллагаа өргөжнө.

-Гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурна.

Нийслэл хотод гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр амжилттай, үр дүнтэй зохион байгуулагдсан туршлагаадаас авч үзвэл:

Баянзүрх дүүргийн “Хөгжлийн төв”-ийн санхүүжилтээр 2014 оны 09 дүгээр сараас 2014 оны 12 дугаар сарын хооронд “Камержуулсан гэрэлт гудамж” төсөл хэрэгжүүлж, 2 гудамжинд нийт 5 камер, 12 гэрэлтүүлэг тавьж, камерыг бүлгийн ахлагч нар гэртээ хянаж, Цагдаагийн хэлтэстэйгээ хамтран ажилласан нь ихээхэн үр дүн өгч, гэмт хэрэг, зөрчил буурсан байна.

Түүнчлэн Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн 5 дугаар хороонд “Аюулгүй орц” төсөл хэрэгжүүлж тус хорооны 23 байрны 53 орцонд 2014.01.03-наас эхлэн хяналтын камерыг байрлуулан хяналтанд авч, “Нью фалкон” ХХК-ны гэрээт харуул хамгаалалтын албатай хамтран ажилласан нь зохих үр дүнгээ өгч гэмт хэрэг, зөрчлийн гаралт 66,6 хувиар буурсан байна.

Мөн 5 дугаар хороонд 9, 15 дугаар хороонд 70 хөршийн хяналтын бүлэг байгуулагдан үйл ажиллагаа нь идэвхжин “Хөршийн хяналтын бүлэг” гэсэн тэмдэглэгээг 100 цэгт байрлуулан ажилласан нь олон нийтэд энэ үйл ажиллагааг сурталчилсан, иргэдийн идэвхи санаачлагыг өрнүүлсэн үр дүнтэй ажил болсон байна.<sup>4</sup>

Энэ арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хамгийн гол хүчин зүйл бол оршин суугч иргэдийн бие биендээ итгэх итгэлцэлийг бий болгох, дээрээс нь идэвхи, санаачлагыг өрнүүлэх явдал юм. Энэ нь дараагийн хөршийн хяналтын бүлэг үүсэн байгуулагдах, үүндээ шинэ гишүүдийг элсүүлэхэд чухал нөлөө үзүүлэх ач холбогдолтой билээ.

Хөршийн хяналтын бүлэг өөрсдийнхөө оршин суугаа газар орчин дээрээ болж байгаа зүйлсийн талаарх мэдээлэлтэй байна гэдэг нь тухайн бүлгийн гишүүний өөрийнх нь үүрэг, хариуцлага байдаг. Энэхүү мэдээлэл нь бусад гишүүдэд хүргэгдэж байх ёстой бөгөөд тэднийг идэвхжүүлэх нь бүлгийн ахлагчийн үүрэг байна.

Эцэст нь иргэд оршин суугчид хөршийн хяналтын бүлэг байгуулах, үйл ажиллагааг нь эхлүүлэхэд дараах зүйлсийг сайтар анхаарах шаардлагатай.

Үүнд:

-Санаачлагч нь өөрийн зэргэлдээ хөршүүдтэй уулзалт зохион байгуулах;

-Хөршүүд өөрсдийн амьдарч байгаа нутаг дэвсгэр, орчинд ямар зүйл тулгамдаад

байгаа талаар ярилцаж, хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцох;

-Хөршүүддээ “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагааны зорилго, ач холбогдол, хүрэх үр дүнг тайлбарлан таниулах;

-Уг уулзалт ярилцлагадаа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын холбогдох албан тушаалтныг урин оролцуулах;

Хөршийн хяналтын үйл ажиллагаа нь иргэд хоорондын харилцан итгэлцэл, идэвхи санаачлага дээр түшиглэж, амжилтанд хүрдэг онцлог бүхий сайн дурын үйл ажиллагаа юм.

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт “Хөршийн хяналт”-ыг нэгдсэн нэг арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар ханган хэрэгжүүлж чадвал гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, гаралт буурах боломжтой үр дүнтэй арга юм гэдгийг олон нийтэд тайлбарлан таниулж, сурталчлах явдал чухал гэж үзэж байна.

<sup>4</sup> Улаанбаатар хотын Цагдаагийн газрын “Хөршийн хяналт, хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаарх тайлан. 2016.02.23



**ХАРИУЦСАН НУТАГ ДЭВСГЭРИЙН СУМ,  
БАГ, ХОРООНЫ ЗУРАГЛАЛ, ТҮҮНИЙГ  
САЙЖРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛ**

**Г.Бямбадорж**

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн багш, докторант

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үндсэн үүргийг гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, зарим үйл ажиллагаанд зөвшөөрөл олгож, хяналт тавих чиг үүрэгтэй болохыг шинэчлэн найруулсан цагдаагийн албаны тухай хууль заасан байна. Энэхүү үүргийг хэрэгжүүлэх гол нөхцөл нь хариуцсан нутаг дэвсгэрт байрлаж байгаа объектуудын байрлаж буй байршил, тэдгээрийн онцлог шинж, тэдгээр объектуудын хоорондын зай, тухайн объектод хүрч очих зам, жим, гүүр, зарим анхаарал татсан субъектүүдийн байршил зэргийг нарийн судлаж сум баг хорооны зураглалд тусгах нь чухал.

Хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгчийн хариуцсан нутаг дэвсгэрийн зураглал хийх ажлын эрх зүйн үндэсийг шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, ЦЕГ-ын даргын 2009 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 613 дугаар тушаалаар батлагдсан ЦБҮАЖ-ийн код-702 цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн заавруудад тусгасан юм.

Гэхдээ дээрх хууль тогтоомж эрх зүйн актуудад сум баг хорооны зураглал хийх талаар нарийн тодорхой зааж өгөөгүй боловч, энэхүү ажлын эрх зүйн үндэс нь цагдаагийн байгууллагын үндсэн үүрэгтэй шууд холбоотойгоор хуульчлагдсан байдаг.

Өнөөдөр хэсгийн байцаагч, төлөөлөгч нар нь Цагдаагийн байгууллагын объектын судалгааны бүрэлдэхүүн хэсэг болсон сум баг хорооны зураглалыг үйлдэж объектын судалгаандаа авч байгаа боловч уг зураглалд агуулагдаж буй мэдээлэл нь ерөнхий, гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаанд ашиглагдах мэдээлэл хомс, анхаарал татаж буй объект, субъектүүдийн байршил тодорхой бус, сум

баг хорооны зураглалыг тогтмол баяжуулж сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Гадаадын зарим орны цагдаагийн байгууллага тухайлбал баруун европын орнуудын цагдаагийн байгууллага нь манай орны цагдаагийн байгууллагын объектын судалгааны бүрэлдэхүүн хэсэг болсон сум баг хорооны зураглалтай ижил төстэй Crime mapping” буюу гэмт хэргийн зураглал үйлдэх системийг бүрэн ашиглаж байна.

“Crime mapping” буюу гэмт хэргийн зураглал үйлдэх систем нь: Гэмт хэрэг, гэмт явдлын гаралт, тэдгээрийн төрөл, ангилалтыг газрын зурагт харах болон гэмт явдлыг шинжлэхийн тулд хууль сахиулах байгууллага ашигладаг систем юм.

Энэ нь гэмт хэрэгт дүн шинжилгээ хийх, цагдаагийн стратегийн Comp.Stat загварын нэг гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд “Crime mapping” буюу гэмт хэргийн зураглал үйлдэх системийг газар зүйн мэдээллийн систем (GIS)-ыг ашиглан гэмт явдлын төлөв байдлыг шинжээчийн тусламжтайгаар тодорхойлж гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй цэгүүдийг тодорхойлох боломжийг олгодог систем юм. Ингэснээр гэмт явдлыг прогноз гарган гэмт хэргийг урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах нөхцөл бүрддэг.

Объектын судалгаа гэдэг нь: Цагдаагийн алба хаагчдаас өөрийн хариуцсан нутаг дэвсгэрийн газар орны онцлогийг тусгасан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ашиглах зорилгоор хийсэн иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагын талаар цуглуулж боловсруулсан мэдээллийн цогцийг хэлнэ. Бид объектын судалгааг дор дурьдснаар ангилж авч үзсэн билээ. Үүнд:

Сум баг хорооны зураглал гэдэг нь:

Объектын судалгаа	
Объектын судалгаа	Субъектын судалгаа
Сум баг, хорооны зураглал	Гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй хүмүүсийн судалгаа
Тухайн нутаг дэвсгэрт байрлах албан газар, байгууллага, аж ахуйн нэгжийн судалгаа	Гэмт хэрэг, зөрчилд холбогдогчдын судалгаа
Мал, малын гаралтай түүхий эд авдаг цэг	Гэмт хэрэг үйлдээд даалтанд байгаа сажигтэй этгээдийн судалгаа
Тамга тэмдэг олшруулагчийн судалгаа	Эрэн сурвалжлагдаж буй оргодол, этгээдүүдийн
Гарсан гэмт хэрэг зөрчил, түүний шалтгаан, нөхцлийн талаарх судалгаа	Хорих ял эдлээд суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн, ял хойшлогдсон хүмүүсийн судалгаа
Саун, массажны газрын бүртгэл судалгаа	Гадаадын болон харьяалалгүй иргэдийн судалгаа
Автомашини эхсвэр, салбиг хэргээс Борлуулдаг газрын бүртгэл гэх мэт	Насанд хүрээгүй хүмүүсийг уруу татагчдын судалгаа





Хариуцсан нутаг дэвсгэрийн хүрээ, хэмжээ хязгаарыг тодорхойлсон хэсэг зурвас газар ба түүн дотор байрлах объектуудын бүдүүвч зураглалыг хэлнэ хэмээн тодорхойлж болох юм<sup>1</sup>.

Сум баг хорооны зураглалыг хийхийн тулд хэсгийн байцаагч, төлөөлөгч нь объектуудын газар зүйн байршилыг сайн мэдэж судалсан байх шаардлагатай бөгөөд зураглалыг гаргахдаа өөрийн судалгаанд тулгуурлан гаргаж болохоос гадна техник технологи ашиглаж эсвэл тухайн засаг захиргааны газрын албанаас тодорхой мэдээлэл авч болох юм.

Сум баг хорооны зураглалд тухайн нутаг дэвсгэрт байрлаж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн объектуудын хоорондын зай, хэмжээ, гудамж талбай, булан тохой, айлын өвөлжөө, хаваржаа, зуслангийн газар, баталгаат зам, баталгаат бус зам, малын жим, мал тууврийн зам, хууль бусаар мод бэлтгэгч нарын явдаг зам, мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгч нарын явдаг нууц зам жим зэргийг нарийн судлаж сум баг хорооны зураглалд тусгана.

Ингэж тусгах нь олон талын ач холбогдолтой тухайлбал: Тухайн нутаг дэвсгэрт байрлаж байгаа объектуудын хоорондын зайг тодорхойлсноор зам харгуй хаагдсан тохиолдолд объектуудын зайгаар тээврийн хэрэгсэл өнгөрч болох эсэх, галын аюул гарсан тохиолдолд уг гал нь хажуугийн объектууд дамжих эсэхийг тогтоох, хэрэв дамжих боломжтой бол галын аюулд өртөж болзошгүй хүн, объект, эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах зэргээр олон нийтийн аюулгүй байдлыг хангах боломжийг бий болгоно.

Хариуцсан нутаг дэвсгэрийн гудамж талбай түүний онцлог мухар гудамж, захдуу гудамж, нарийн гудамжтай газар зэрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй газрыг нарийн судлаж сум баг хорооны зураглалд тусган тэдгээрийг хяналтандаа авч, хэв журмын эргүүлийн чиглэл, олон нийтийн цагдаагийн ажилтан, урамшилт эргүүл жижүүрийг ажлуулан тухайн эмзэг цэгт ажилуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллана.

Айлын өвөлжөө, хаваржаа, зуслангийн газар зэргийн байршилыг сум баг хорооны зураглалд тусган ажилласнаар эзэнгүй өвөлжөө хаваржааг зураглалд тэмдэглэн мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй цэг газруудыг хяналтандаа авч уг өвөлжөө хаваржаа зуслангийн газарт мал хаших, мал муулах зэргээр мал хулгайлах гэмт хэрэг

үйлдэгдэх нөхцөл бололцоог хааж сайн дурын иргэд, малчин холбоог ажилуулан тэднийг мэргэжлийн удирдлагаар хангаж мал хулгайлах гэмт хэргийг урьдчилан сэргийлж ажиллана.

Баталгаат зам /төв зам/, баталгаат бус зам, малын жим, мал тууврийн зам, хууль бусаар мод бэлтгэгч нарын явдаг зам, мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгч нарын явдаг нууц зам жимийг гэмт хэрэг үйлдэгч нарын хэргийг мөрдөн байцаах ажиллагаа явуулах, гүйцэтгэх ажлын арга болон бусад арга хэрэгслээр мэдээ мэдээлэл цуглуулах, мэдээ мэдээлэл олзлох зэргээр сум баг хорооны зураглалдаа тусгаж ажиллана.

Ингэснээр малын хулгайн гэмт хэрэг үйлдэгч нарын нууц зам жим, мал тууврийн зам, хууль бусаар мод бэлтгэгч нарын явдаг замыг мэдэж, мал хулгайлах болон хууль бусаар хэрэглээний мод бэлтгэх, хууль бусаар ан агнах зэрэг гэмт хэргийг шуурхай илрүүлэх гэмт этгээдийг отолт хийж баривчлах, энэ төрлийн гэмт хэргийг урьдчилан сэргийлэх ач холбогдолтой болно.

Түүнээс гадна тухайн нутаг дэвсгэрт байгаа зам жимийг тусгаснаар хэсгийн байцаагч, төлөөлөгч нь тухайн газар орон нутгаа сайн мэдэж, гэмт халдлагад өртөж болзошгүй хяналтанд байх объект, хөрөнгө мөнгө ихээр төвлөрсөн газар объектод хүрч очих зам жим зэргийг нарийвчилан гаргаж хяналт тавьж ажиллах бололцоо нөхцлийг бүрдүүлнэ.

Гэмт халдлагад өртөж болзошгүй хяналтанд байх объект, хөрөнгө мөнгө ихээр төвлөрсөн газруудыг хариуцсан нутаг дэвсгэрт байгаа объектуудын зураглалыг үйлдэж тусгахдаа цагдаагийн тасаг, хэсгийн байрнаас хяналтанд байх объект, хөрөнгө мөнгө ихээр төвлөрсөн газар хүртэл явганаар болон тээврийн хэрэгсэлтэй гэмт хэрэг, зөрчлийн дуудлагаар хүрэлцэн очих цаг хугацааг тодорхойлж, уг тогтоосон хугацаагаар хүрэлцэн очих замаар очих боломжгүй өөр бусад зам болон замгүй газраар хүрч очих боломжийг тодорхойлон зураглалд тусгаж, гэмт этгээдийг отолт хаалт хийж баривчилж болох цэг газар, тухайн газар орны онцлогоос хамааран ажиглалт явуулах цэг газар зэргийг нарийвчилан тусгана.<sup>2</sup>

Түүнчлэн хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч нар нь хариуцсан нутаг дэвсгэртэй байрлах аж ахуйн нэгжийг судлаж мэдэх нь нэн тэргүүний хийж гүйцэтгэх ажлын нэг бөгөөд хариуцсан нутаг дэвсгэрт нь ямар байгууллага, аж ахуйн нэгж ямар төрлийн үйл ажиллагаа явуулдаг, хаана

<sup>1</sup> Г.Бямбадорж. Архидан согтуурах явдалтай тэмцэх үйл ажиллагаа, УБ 2013. 106-р тал

<sup>2</sup> Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл. 2015 оны №1 дугаар, 16 дахь тал



байрладаг зэргийг мэдэж сум баг хорооны зураглалд тусгаснаараа дуудлага мэдээлэлд шуурхай очих, хорооны нутаг дэвсгэрт байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоог гаргах тэдний зорилго үүрэг чиглэлийг мэдэх ач холбогдолтой төдийгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, уг ажилд тэдний үүрэг оролцоог дээшлүүлэх, хамтран ажиллах ач холбогдолтой юм.

Албан газар, байгууллага аж ахуйн нэгжийн судалгааг авахдаа хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч нар өөрийн биеэр биечлэн явж, үзэж шалган тухайн объектуу нэвтэрч болох нуугдмал зам, гэмт этгээд халдаж болзошгүй цонх, хаалга, дээвэр, тагт, халдаж болзошгүй эмзэг цэг, гарах гарц, галын шат, аврах үйл ажиллагаа явуулах цонх, хаалгыг нарийн тодорхой тусгахын зэрэгцээ тухайн объектод камерын болон дохиололын систем байгаа эсэх, хэдий хир хугацаанд тухайн аж ахуйн нэгжид дуудлагаар очих, хэрэв очих зам машинтай очих боломжгүй бол хоёр дахь зам хаагуур явж хүрэх, харуул хамгаалалтын албатай эсэх, харуулын албадын болон харуулуудын баталгаа зэргийг заавал гаргаж өөрийн үйл ажиллагаандаа ашиглана.

Мөн тухайн аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг илэрхийлэх бичиг баримтын бүрдэл түүний хуулбар, тухайн байгууллагын удирдах албан тушаалтаны бүртгэл судалгаа алба хаагч, ажилтнуудын бүртгэл цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ гамшиг осолын үед дайчилан ажиллуулж болох техник, хүн хүч, гэмт хэрэг зөрчил үйлдэгдсэн тохиолдолд холбогдох албан тушаалтаны утас, гэрийн хаягыг объектын судалгаанд заавал тусгана.

Албан газар, байгууллага аж ахуйн нэгж зохих хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан холбогдох байгууллагад бүртгүүлсэн үйл ажиллагааны тодорхой чиглэл, бүтэц зохион байгуулалт бүхий хуулийн этгээд байх ба улсын бүртгэлийн гэрчилгээ, үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг судалснаар тухайн аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа хуульд хэрхэн нийцэж буй эсэхийг судлах ач холбогдолтойг дурьдах нь зүйтэй.

Сум баг хорооны зураглалыг сайжруулах, түүнийг ашиглан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд хэсгийн байцаагч, төлөөлөгч нар сум баг хорооны зураглалд дор дурдсан зүйлийг заавал судлах шаардлагатай гэж бид үзэж байна. Үүнд:

- Гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй хүмүүсийн байршил;
- Гэмт хэрэг, зөрчилд холбогдогчдын нарын

байршил;

• Гэмт хэрэг үйлдээд даалтанд байгаа сэжигтэй этгээдийн байршил;

• Хорих ял эдлээд суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн, ял хойшлогдсон хүмүүсийн байршил;

• Гэр бүл орчиндоо байнга тааламжгүй байдал гаргадаг хүмүүсийн байршил;

• Тухайн нутаг дэвсгэрт түр оршин суух, гадаадын болон харьяалалгүй иргэдийн байршил;

• Гэмт хэрэг үйлдэж хяналтанд байгаа насанд хүрээгүй хүмүүсийн байршил;

• Мал бүхий иргэд, малын гаралтай түүхий эд авдаг газруудын байршил;

• Алт, үнэт эдлэлийн ченжүүд болон ломбардуудын байршил;

• Гэмт хэрэг зөрчил үйлдэгдэж болзошгүй цэг газрын байршил;

• Тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн байршил, ангилал, цаг хугацаа /хулгайлах, булаах, дээрэмдэх, танхайрах, хүчиндэх, зам тээврийн хэрэг осол үйлдэгдсэн газар, цаг хугацаа г.м/

• Авто машин, галт зэвсэг эзэмшдэг иргэдийн байршил;

• Нуугдмал зам жим;

• Тэнэмэл хүмүүсийн байршил;

• Зочид буудлын байршил;

• Интернет, РС тоглоомын газрын байршил;

• Сэтгэцийн өвчтэй хүмүүсийн байршил зэргийг сум баг хорооны зураглалд заавал тусгана.

Дээр дурдсан зүйлүүдийг сум баг хорооны зураглалд тусгаснаар үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх /эзэн холбогдогч нь тогтоогдоогүй/ хэргийг бие даан болон бусад албадын хүч тусалцаатайгаар түргэн шуурхай илрүүлж, сэжигтнийг цаг алдалгүй баривчлах боломж бүрдэх юм.<sup>3</sup>

Хариуцсан нутаг дэвсгэрийн сум баг хорооны зураглалд үйлдэгдсэн гэмт хэргийн байршилийг хэргийн ангилал зүйлээр нь ялган тэмдэглэж дээр дурдсан зүйлүүдийг нэмж тусган тухайн хэргийн нөхцөл байдал, халдлагын зүйл, үйлдэгдсэн цаг хугацаа, өссөн буурсан гэмт хэргийн ангилал төрөл, аль баг хэсэгт хэд хэчнээн гэмт хэрэг үйлдэгдсэн, ямар төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байгааг аль ч үед (шаардлагатай үед) харж болох боломжтойгоос гадна дээрх зүйлийг судлан зураглалд тусгагдсан гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй хүмүүсийн байршил, гэмт хэрэг, зөрчилд холбогдогч нарын байршил, гэмт хэрэг үйлдээд батлан даалтанд байгаа сэжигтэй этгээдийн байршил, хорих ял эдлээд суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн, ял

<sup>3</sup> Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл. 2015 оны №1 дугаар, 17 дахь тал





хойшлогдсон хүмүүсийн байршил, гэмт хэрэг үйлдэж болзошгүй хяналтанд байдаг насанд хүрээгүй хүмүүсийн байршил, мал бүхий иргэд, малын гаралтай түүхий эд авдаг газруудын байршил, алт үнэт эдлэлийн ченжүүд болон ломбардуудын байршил, галт зэвсэг эзэмшдэг иргэдийн байршил, зэргийг түүвэрлэн авч үйлдэгдсэн гэмт хэргийн шалгах хүрээг тогтоон, хэрэгт холбоотой байж болох дээрхи субъектүүдыг шалгаснаар тухайн хэргийг илрүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Мөн тухайн сум, хорооны баг хэсэгт хяналтын системийг нэвтрүүлж ашиглах, иргэд олон нийтийн хүч дэмжлэгийг авч өсөж байгаа газарт эргүүлийн чиглэлийг түлхүү ажиллуулах, өссөн гэмт хэргийн төрлөөс шалтгаалан уг төрлийн гэмт хэргийг урьдчилан сэргийлэх тусгай ба нэг бүрчилсэн арга хэмжээг зохион байгуулж үр дүнтэй ажиллах боломж бүрдэх юм.

### **ДҮГНЭЛТ**

Хэсгийн байцаагч, төлөөлөгчийн объектын судалгааны төрөл болох сум баг хорооны зураглалд авагдсан мэдээлэл нь хэт ерөнхий, гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаанд ашиглагдах мэдээлэл хомс, анхаарал татаж буй объект, субъектүүдын байршилийг зөв тодорхойлон гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй хүмүүсийн байршил, гэмт хэрэг үйлдээд батлан даалтанд байгаа сэжигтэй этгээдийн байршил зэргийг зураглалд тусган гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, үйлдэгдсэн гэмт хэргийг шуурхай илрүүлэхэд чиглэгдсэн нарийвчилсан сум баг хорооны зураглалыг хийж, гэмт явдлыг шинжлэн судлан зураглалд тусган түүнийг ашиглаж гэмт хэрэг илрүүлэх арга зүйг сайжруулж, гэмт хэргийн илрүүлэлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэх, гэмт явдлын прогноз гарган гэмт хэргийг урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

### **САНАЛ**

•Гэмт хэрэг илрүүлэх тогтоолцоонд сум баг хорооны зураглалыг сайжруулах, баяжуулах, судалгаа хийх арга зүй болон гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд хэрхэн ашиглах талаар цагдаагийн алба хаагчдад сургалт явуулж тэдний үр чадварыг нэмэгдүүлэх талаар үр дүнтэй ажил зохион байгуулах;

•Сум баг хорооны зураглалыг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд түлхүү ашиглаж гэмт хэргийг илрүүлэх арга тактикийг боловсронгуй болгож гэмт хэрэг илрүүлэлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэх;

•Хэсгийн байцаагч, төлөөлөгч нарыг зарим үүргээс /хөнгөн гэмт хэрэгт бүртгэх ажиллагаа явуулах/ чөлөөлж сум баг хорооны зураглал

үйлдэх, түүнийг сайжруулах, баяжуулах нөхцөл бололцоогоор хангах;

•Сум баг хорооны зураглалын хоцрогдсон хэлбэр загварыг өөрчилж, хариуцсан нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон анхаарал татсан объект, субъектуудын байршилийг тусгасан гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд ашиглаж болох үр дүнтэй шинэ загвар бий болгож ашиглах зэрэг болно.



## ПЕНИТЕНЦИАР<sup>1</sup> ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУБЬЕКТ

**Г.Баттулга**

ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн  
Харуул хамгаалалтын тэнхимийн ахлах багш, хошууч

Хорих ял нь Монгол Улсын эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд Шүүхийн шийтгэх тогтоолоор ногдуулдаг шүүхийн практикт өргөн хэрэглэгддэг ял бөгөөд “үндсэн агууллага нь ялтныг олон нийтээс тусгаарлаж, харуул хамгаалалт, хяналт бүхий нөхцөлд хорих тусгай байгууллагад байлгахад”<sup>2</sup> оршдог. Хорих ялыг гэмт этгээдийг цээрлүүлэх, иргэдийн гэмт хэргийн улмаас хөндөгдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин нийгэмшүүлэх<sup>3</sup> зорилгоор хэрэглэнэ.

Хорих байгууллага нь хорих ялын зорилгыг хэрэгжүүлэх үүднээс ялтныг гэмт хэрэг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, хүмүүжүүлэх, тэднийг нийгэмшүүлэх ажлыг оновчтой, үр нөлөөтэй зохион байгуулах үндсэн үүргийг нийгмийн өмнө хүлээдэг. Харин 2011-2015 онд хорих анги, цагдан хорих байранд гарсан гэмт хэрэг, зөрчлийн судалгаанаас харвал 2011-2015 оны хооронд нийт 91 гэмт хэрэг гарсан бөгөөд үүнээс хорих ангид 78, цагдан хорих байранд 13 гэмт хэрэг гарчээ. Мөн 2011-2015 онд хорих анги, цагдан хорих байранд нийт 9577 зөрчил бүртгэгдэж, он тус бүрээр авч үзвэл зөрчлийн тоо жил дараалан өссөн

үзүүлэлтэй байна.<sup>4</sup>

Тэгвэл хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад ялтны зүгээс үйлдэгдэж буй гэмт хэрэг буюу “Пенитенциар”<sup>5</sup> гэмт хэргийг хэрхэн бууруулах вэ? Түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? гэсэн асуултууд урган гарна. Энэхүү асуудлын хүрээнд хорих байгууллага ялтан, хоригдогчдын зүгээс гэмт хэрэг, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх үр ашигтай арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар авч үзэхийн өмнө “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” гэсэн ойлголтыг тодорхойлох нь зүйтэй юм. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэдгийг “гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ”<sup>6</sup> гэж тодорхойлсон байна.

Харин доктор, профессор Н.Жанцан “Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь уг үзэгдэлд нөлөөлөх хүчин зүйлсийн хүч, үйлчлэлийг сулруулах аажмаар арилгах... бүхэл бүтэн шаталсан систем бөгөөд түүнийг хэрэгжүүлэх ажиллагааг нэгж салбар бүр дээр ялгамжтай зохион байгуулана”<sup>7</sup> гэж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн арга зүй ойлголтыг тодорхойлсон байна.

Нийгэмд үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь өргөн хүрээтэй нэгдсэн, арга хэмжээг ойлгох бол хорих байгууллагад үйлдэгддэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа нь “пенитенциар” орчинд буюу хорих байгууллагад явагддагаараа онцлог юм. Пенитенциар орчинд явагдаж буй урьдчилан сэргийлэх ажиллагаа нь криминологийн шинжлэх ухааны ололтод тулгуулан явуулдаг практик ажиллагааны, төрөл, хэлбэр, хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн бодит шийдлүүд, арга ажиллагааны иж бүрдэл байдаг.

Хорих байгууллагад үйлдэгддэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг

<sup>1</sup>Анх 1786 онд Филадельфи, Пенсильвани мужид ганцаар хорих шоронг байгуулж “Пенитенциар” буюу Penitentiary /paenitentia - гэмшил гэсэн латин үгнээс гарвалтай/ гэж нэрлэх болсон бөгөөд Penitentiary нь англиар засан хүмүүжүүлэх газар, хорих байгууллага гэсэн утгатай.

<sup>2</sup> Нарангэрэл.С Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2007. 517 дах тал

<sup>3</sup> Монгол улсын эрүүгийн хууль /Шинэчлэсэн найруулга/ 5дугаар зүйлийн 5.1 –д <http://legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>

<sup>4</sup> ШШГБ-ын удирдах албан тушаалтанд зориулсан товхимол. 2016 он. 13-15 дахь тал

<sup>5</sup> “Пенитенциарное преступление” “Crimes in the Prison/ Penitentiary” гэдэг нь хорих ял эдлүүлэх явцад үйлдэгддэг гэмт хэргийн олон улсын нэршил юм. Манай оронд ч “Пенитенциар криминологи” “Пенитенциар гэмт явдал, гэмт хэрэг” гэсэн нэр томъёо хэрэглэгдэх болжээ.

<sup>6</sup>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. УБ. 1997. 3-р зүйл

<sup>7</sup>Н.Жанцан ., Криминологи. УБ.2000. 64 дэх тал



үе шаттайгаар, ялгамжтай, төрөлжүүлэн явуулах, уг ажиллагаанд оролцогч субъектуудын үүргийг тодорхой болгох, тэдгээрийн ажлын уялдаа холбоог оновчтой зохион байгуулах нь чухал юм<sup>8</sup>. Хорих ангийн харуул хамгаалалтын, нийгмийн ажлын, сэтгэл зүйн алба, эмч болон бусад албадын хоорондын ажлын уялдаа холбоо муу байгаа нь хорих байгууллагад гэмт хэрэг, зөрчил гарах нэгэн нөхцөл болоод зогсохгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж буйг үгүйсгэх аргагүй билээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг онолын болон хууль эрх зүйн түвшинд а/ Ерөнхий урьдчилан сэргийлэх арга хэмжээ; б/ Тусгай урьдчилан сэргийлэх арга хэмжээ; в/ Нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ<sup>9</sup> гэсэн үндсэн гурван төрөлд хуваан авч үздэг. Эхнийх нь гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртахуун, хүмүүжлийн болон зохион байгуулалтын шинж чанартай нийтлэг арга хэмжээг ойлгох бол удаах нь тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн арга хэмжээг хэлнэ. Харин нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэдэг нь тодорхой этгээд гэмт хэрэг үйлдэхээс болон давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ юм.

Харин Оросын холбооны улсын криминологид пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг дараах гурван түвшинд<sup>10</sup> хуваан авч үзжээ.

1. Ерөнхий буюу нийтлэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Үүнд хорих байгууллагын зүгээс хорих ялтнуудын бие авч явах байдал, ялтан болон албан хаагчидтай хэрхэн харьцах, тэднийг хорих ангийн дотоод дүрэм журамд захирагдаж, хууль тогтоомж, дэглэм журмын эсрэг харш үйлдэл гаргахгүй байлгахад чиглэсэн хорих байгууллагаас авч буй цогц үйл ажиллагаа юм.

Тухайлбал гэмт зан төлөв төдийлөн тогтоогүй ёс суртахууны хүрээнд алдаа гарган тэр нь гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн зан байдлын гажуудлыг засах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ үүнд багтана. Мөн бусдын нөлөөнд автагдаж гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд эерэг зан байдлыг төлөвшүүлэх, тэдний гэмт санаа бодлыг эерэг зүйлд хандуулахад чиглэгдсэн арга хэмжээ, олон талт үйл ажиллагааг ойлгоно.

<sup>8</sup>Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал /Онол арга зүйн сэтгүүл/. 2015 №02,03 (14,15). 76 дахь тал.

<sup>9</sup> Г.Эрдэнэбат, Б.Батзориг, Г.Туяа. Криминологи. УБ. 2013 он. 39 дэх тал; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль.1997 он. 6 дугаар зүйл

<sup>10</sup> Пенитенциарная криминология. Рязань. 2009 г. 183 ст

2. Шууд урьдчилан сэргийлэлт  
Энэ нь тодорхой ялтнуудад чиглэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ бөгөөд уг арга хэмжээнд хамрагдаж байгаа ялтнууд давтан гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүд байна. Эдгээр болзошгүй гэмт хэрэгтнүүдийг /potential offender/ дахин гэмт хэрэг өдүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд тэдэнтэй тодорхой төлөвлөгөө боловсруулан ажиллана. Мөн тухайн ялтны үйлдсэн гэмт хэрэг, зан төлөв болон анх удаа, давтан, удаа дараа гэмт хэрэг үйлдсэн эсэхээс шалтгаалан тэдэнд тохирсон урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

3. Нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэлт  
Энэ нь нэг этгээдрүү чиглэсэн нэг бүрчилсэн арга хэмжээ бөгөөд тухайн ялтныг тусгайлан авч үзэж зан байдлын онцлог, шинж чанар, түвшин буюу мэргэжил, боловсрол, нийгмийн гарал, яс үндэс шашин шүтлэг гэх мэт уг этгээдийн талаар нарийвчлан тодорхойлсны үндсэн дээр явуулах урьдчилан сэргийлэх ажиллагааг ойлгоно. Нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх ажлыг эрт үеийн болон тухайн үеийн гэж ангилдаг. Пенитенциар гэмт хэргээс эрт үед нь урьдчилан сэргийлэх гэдгийг хорих байгууллагын эрх бүхий субъектүүдээс ялтан хорих ангид хүлээн авах, тэдний хорих ангийн нөхцөл байдалд дасан зохицох зэрэг эхний үе шатанд нь явуулдаг зорилго чиглэл бүхий хүмүүжлийн ажил<sup>11</sup> гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл ялтныг хорих байгууллагад хүлээн авч бүртгэл явуулахаас эхлэн урьдчилан сэргийлэх шинжтэй хүмүүжлийн болон бусад ажил хамт явагдаж байх ёстой юм. Харин сүүлийн тохиолдолд нь ихэвчлэн гэмт хэргийг таслан зогсоох ажиллагаатай зэрэгцэн явагдана.

Нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэлтийн үндсэн нь а) Ялтныг хорих байгууллагад хүлээн авснаас хойш нарийн судлах үүний үндсэн дээр давтан гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүсийг илрүүлэх, тодорхойлох б) Гэмт хэрэг үйлдэх магадлалтай этгээдийг тодорхойлсны үндсэн дээр ямар аргаар урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулах талаар төлөвлөлт гаргах. в) Нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээний хүрэх үр дүнг тодорхойлох. Тухайлбал, шинээр ирж буй ялтнуудын хорих байгууллага хүлээн авч хорих байгууллагын үйл ажиллагаанд дасгахаас эхлэн тухайн ялтантай тогтмол, тасралтгүй ажилласнаар түүнийг гэмт хэрэг, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх бодит үр дүнд хүрэх боломжтой гэж үздэг. г) Гэмт хэрэг үйлдэх үр үндэс болсон бодит шалтгааныг тодорхойлж,

<sup>11</sup> Мөн тэнд 184 ст



мөн чанарыг таньж мэдсэнээр гэмт үйлдлээс урьдчилан сэргийлж, таслан зогсоох, тухайн ялтны онцлог, үйлдэж болзошгүй гэмт үйлдэлд нь тохирсон урьдчилан сэргийлэх арга, арга замыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх чухал ач холбогдолтой.

Урьдчилан сэргийлэх ажлын түвшинг оновчтой тодорхойлох нь гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлөх учир шалтгааныг олж тогтоон, шатлан эрэмблэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тохиромжтой арга, арга хэмжээг боловсруулах, тогтолцоог бүрдүүлэх хүч, хэрэгслээ зохистой хуваарьлах зэрэг практик чухал ач холбогдолтой.

Харин пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дээрх түвшингийн арга хэмжээнүүдийг ямар субъект хэрхэн хэрэгжүүлэх, ямар зохион байгуулалттай ажиллах талаар авч үзэх нь чухал юм. Аливаа үйл ажиллагаанд оролцож, түүнийг хэрэгжүүлж буй субъект гэдэг нь тухайн үйл ажиллагаанд оролцох тодорхой чадамж бүхий эрх үүрэгтэн юм. Өргөн утгаараа пенитенциар гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх субъект гэдэгт хууль тогтоомжид заасан эрх эдэлж, үүрэг хүлээсэн хорих байгууллагын тогтолцоон дахь бүх алба, нэгж, албан хаагчид багтана.

Эдгээр субъектууд хэд хэдэн үндэслэлээр ангилан авч үзсэн байдаг. Хамгийн түгээмэл байдлаар дараах гурван бүлэгт<sup>12</sup> хувааж болно. Үүнд: 1/ нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх ажил явуулдаг; 2/ хууль сахиулах болон хяналтын ажил үүрэг гүйцэтгэх явцдаа урьдчилан сэргийлэх ажил явуулдаг; 3/ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдах, зохицуулах чиг үүрэг бүхий субъектууд тус тус хамаарна.

Мэдээж урьдчилан сэргийлэх ажлын үр дүн нь субъектууд саланги бус, бие биетэйгээ харилцан уялдаатай ажиллаж буй эсэхээс ихээхэн шалтгаална. Эдгээр субъектүүдийг шийдвэрлэж буй асуудлын түвшин буюу эрх хэмжээний цар хүрээнээс нь хамаарч хэвтээ ба босоо тогтолцоо бүхий харилцан хамааралтай байдаг.

Пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын агуулга, субъектүүдийн чадамж, чиг үүргээс хамаарч мэргэшээгүй, хагас мэргэшсэн, мэргэшсэн гэж ангилж болно.

Пенитенциар урьдчилан сэргийлэх ажлын мэргэшээгүй субъектууд гэдэгт хорих байгууллагын аж ахуйн алба буюу хөдөлмөр зохион байгуулалт, ахуй хангалтын алба, хорих байгууллагын ажилтнаас гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 124 дүгээр зүйлд зааснаар шашны, буяны

болон бусад байгууллагуудыг хамааруулна. Эдгээр байгууллагуудын гүйцэтгэх үүрэг нь ялтныг хөдөлмөр эрхлүүлэх, тэднийг ажлын байраар хангах, шашин шүтлэгээр дамжуулан энэрэнгүй үзлийг төлөвшүүлэх, албан болон албан бус боловсрол олгох замаар ялтны дундаас гэмт хэрэг гаргахаас урьдчилан сэргийлэх ажилд тодорхой хувь нэмэр оруулж байдаг.

Өөрийн үндсэн зорилгодоо урьдчилан сэргийлэх чиг үүргийг агуулдаг хорих байгууллагын бүтцийн алба нэгжүүд, алба хаагчид нь пенитенциар урьдчилан сэргийлэх ажлын хагас мэргэшсэн субъектэд хамаарна. Хорих байгууллагын олон талт үйл ажиллагаанд оролцох эрх мэдлээсээ хамаарч эдгээр нэгжүүд нь пенитенциар гэмт хэрэгт нөлөөлөх нөхцөл шалтгааныг илрүүлэх, тодорхой арга, үйл ажиллагааны тусламжтайгаар түүнийг арилгах арга хэмжээ авдаг. Тухайлбал:

\*Урьдчилан сэргийлэх ажилд хамрагдах шаардлага бүхий ялтанд нэг бүрчилсэн хүмүүжлийн ажил явуулах, ялтныг нийгэмшүүлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа хэв журам зөрчдөг ялтнуудыг илрүүлж, тэдэнтэй ажиллах нэг бүрчилсэн хүмүүжлийн ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг нийгмийн ажилтнуудаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа.

\*Хорих байгууллагын сэтгэл зүйн алба нь ялтнуудын сэтгэл зүйн оношлогоо хийж, зарим ялтныг урьдчилан сэргийлэх ажилд хамруулах, эрсдэлтэй бүлгийн ялтнуудыг илүү гүнзгий судалж, тэдэнд хяналт тавьж ялангуяа амиа хорлох хандлагатай эсвэл сэтгэл зүйн эмгэгтэй ялтнуудад урьдчилан сэргийлэх болон сэтгэл заслын ажил явуулах.

\*Хорих байгууллагын эрүүл мэндийн албанаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд мансууруулах бодис, согтууруулах ундаа хэрэглэх хандлагатай ялтнууд, бие эрхтнээ гэмтээсэн эсхүл гэмтэл учирсан ямар нэг шарх, ул мөр, шивээс зэргийг илрүүлэх үзлэг хийж, энэ талаар аюулгүй байдлын болон бусад албанд мэдэгдэх.

Пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэшсэн субъектүүд нь урьдчилсан сэргийлэх гол зорилт, чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгжүүд юм. Энэхүү үндсэн нэгж нь одоогийн томъёоллоор хорих анги бүрт байх дотоод ажлын хэлтэс /аюулгүй байдал, харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил хариуцсан алба/ бөгөөд хорих байгууллагын өдөр тутмын харуул хамгаалалтыг зохион байгуулж, хяналт тавьж, цагийн хуваарь, дэглэм журмыг сахиулах, үзлэг нэгжлэг хийх хамгаалалтын техник хэрэгслийн тусламжтай хорих ангид орж гарч буй хөдөлгөөн, хамгаалалтын

<sup>12</sup> Пенитенциарная криминология. Рязань. 2009 г. 189 ст



бүс, объектын бүрэн бүтэн байдлыг ханган ажилладаг.

Ялтны дунд байдаг албан бус бүлэглэлүүдийн<sup>13</sup> харилцаа, ялтны доторх уур амьсгал, нууц далд аргаар үйлдэгддэг хорих ангийн дэглэм журам зөрчиж буй аливаа үйлдлийг цаг алдалгүй илрүүлж, таслан зогсоож, гэмт хэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлж ажилладаг чухал субъект нь хорих байгууллагын гүйцэтгэх алба юм. Гүйцэтгэх ажлыг үр нөлөөтэй явуулснаар зөрчил гаргагч ялтнуудыг гэм буруугаа сайн дураар хүлээх, төлөвлөж буй гэмт хэрэг зөрчлөөс татгалзах, илрээгүй гэмт хэрэг, зөрчил болон түүнийг үйлдсэн этгээдийг олж, илрүүлэх зэрэг үйл ажиллагааг явуулдаг.

Мөн хорих ял эдлүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих чиг үүрэг бүхий прокурорын байгууллага нь хэдийгээр хорих байгууллагын бүтэцэд орохгүй ч пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бие даасан субъект болдог<sup>14</sup>. Өөрөөр хэлбэл хууль тогтоожийн хэрэгжилтэнд хяналт тавьснаар түүнийг зөрчигчидөд хариуцлага тооцон хууль тогтоомжийг дахин зөрчих ялдлыг таслан зогсоож, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг субъект юм.

Дээрхээс дүгнэн үзвэл пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг тодорхой үе шаттайгаар үр нөлөөтэй зохион байгуулах, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг олж илрүүлэхэд Пенитенциар криминологийн шинжлэх ухааны байр суурьнаас хандах, хорих анги, албад өөрсдийн онцлогт тохирсон пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулж үе шаттай, тасралтгүй явуулах нэн шаардлагатай байна. Ингэхдээ тодорхой судалгааны арга зүйд үндэслэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүйн зөвлөмжийг криминологид, судлаачдын дэмжлэгтэй боловсруулж энэхүү үйл ажиллагаандаа хорих ангийн практик ажилтнуудын татан оролцуулж тэднийг уг арга ажиллагаанд сургаж бэлтгэх нь зүйтэй юм.

<sup>13</sup>ОХУ-н зарим эрдэмтэд ялтны дунд албан болон албан бус бүлэг үргэлж үүсэж байдаг гэж үздэг бөгөөд энэ манай практикт байдаг "гал хам" бүлэг гэсэн нэршилтэй дүйх ойлголт юм. Энэ нь өөрийн гэсэн "өвөрмөц соёл" буюу "prison subculture" дунд оршин тогтнож байдаг.

<sup>14</sup> Пенитенциарная криминология. Рязань. 2009 г. 190 ст



## УГОЛОВНО-ПРАВОВАЯ ЗАЩИТА ПОЛОВОЙ НЕПРИКОСНОВЕННОСТИ И ПОЛОВОЙ СВОБОДЫ ЛИЧНОСТИ: СРАВНИТЕЛЬНО-ПРАВОВОЙ АНАЛИЗ РОССИЙСКОЙ И ЗАРУБЕЖНЫХ СИСТЕМ УГОЛОВНОГО ПРАВА<sup>1</sup>

**В.А. АВДЕЕВ**

доктор юридических наук, профессор кафедры  
уголовного права, криминологии и уголовного  
процесса Байкальского государственного университета

**Е.В. АВДЕЕВА**

кандидат юридических наук, старший преподаватель  
кафедры уголовного права, криминологии и уголовного  
процесса Байкальского государственного университета

Аннотация. В статье раскрываются актуальные проблемы уголовно-правовой защиты половой неприкосновенности и половой свободы личности. Дан сравнительно-правовой анализ уголовного законодательства Российской Федерации, Монголии, Китайской Народной Республики, Японии в сфере обеспечения уголовно-правового регулирования половой неприкосновенности и половой свободы личности.

Ключевые слова: уголовно-правовая политика, уголовное законодательство, свобода личности, преступления против половой неприкосновенности и половой свободы личности.

Глобализация международной жизни обуславливает необходимость гармонизации национальных правовых систем, в том числе в сфере обеспечения неприкосновенности основных прав и свобод человека. Институционализация общепризнанных принципов предполагает стандартизацию уголовного законодательства с учетом ратифицированных норм международного права<sup>2</sup>. Государства обязуются гарантировать безопасность естественных и неотъемлемых прав человека, включая право на жизнь, здоровье, свободу, честь и достоинство и т.д. Пристального внимания среди объектов уголовно-правовой охраны на современном этапе заслуживают общественные отношения в сфере защиты

половой неприкосновенности и половой свободы личности.

В этой связи особое значение приобретает межгосударственный уровень гармонизации норм, обеспечивающих уголовно-правовую охрану половой неприкосновенности и половой свободы личности. Повышенный научный интерес к проблеме оптимизации уголовно-правовых средств в области обеспечения половой неприкосновенности и половой свободы личности сопряжен с решением вопросов стандартизации международно-правовых норм и национального уголовного законодательства<sup>3</sup>.

Неизменным в оптимизации уголовно-правовой политики в сфере противодействия преступлениям насильственного характера следует признать гарантированность национальным законодательством незыблемости общепризнанных принципов международного права, предусмотренных Всеобщей декларацией прав человека (ст. 3), Международным пактом о гражданских и политических правах (ст. 9), Конвенцией Содружества Независимых Государств о правах и основных свободах человека (ст. 6) и иными нормативно-правовыми актами универсального и регионального характера, предусматривающими использование в целях обеспечения права человека на личную неприкосновенность совокупности как внутригосударственных, так и транснациональных средств внесудебной и судебной защиты<sup>4</sup>.

Между тем определенные трудности имеют место вследствие неразрешенности вопросов гендерного неравенства, обусловливаемого разноразличностью социально-экономических и политико-правовых национальных систем. Более того, различный подход к механизму противодействия посягательствам на половую неприкосновенность и половую свободу личности детерминирована плюралистичностью правовых, религиозных и культурных ценностей.

Согласно показателям официальной статистики в 2015 году на территории Российской Федерации количество **зарегистрированных** фактов изнасилований<sup>3</sup> Авдеев В.А., Авдеева О.А. Условное осуждение в контексте современной уголовно-правовой политики РФ // Российская юстиция. 2014. № 5. С. 2-6.  
<sup>4</sup>Сергеев В.А. Гармонизация уголовно-правовой политики в сфере назначения и исполнения наказания / В.А. Сергеев, В.А. Авдеев, О.А. Авдеева // Криминологический журнал Байкальского государственного университета экономики и права. – 2015. - №1. – С. 78-93.

<sup>1</sup>Статья выполнена при финансовой поддержке государственного задания № 2014/52 на выполнение государственных работ в сфере научной деятельности в рамках базовой части проекта № 2706 «Уголовно-правовые и криминологические аспекты противодействия преступности».

<sup>2</sup>Авдеев В.А., Авдеева О.А. Правовое воздействие и правовая политика: вопросы институционализации и инструментальной сущности // Юридический мир. 2015. № 11. С. 19-23.



в структуре преступлений против личности составило 1% (3 936 преступлений). За изнасилование на территории РФ в 2015 г. было осуждено 2 888 человек. Удельный вес данного состава преступления в общей структуре преступлений составил 0,4%. Наибольшие показатели количества осужденных лиц приходятся на Приволжский, Сибирский и Центральный федеральные округа - 22,7% (656), 19,9% (575), и 18% (519). Далее по количеству осужденных следует Уральский федеральный округ, доля осужденных в котором за изнасилование составил 11,4% (327 лиц). Наименьшие показатели по количеству осужденных приходятся на Южный, Дальневосточный, Северо-Западный и Северо-Кавказский федеральные округа - 9,5% (275), 6,4% (184), 5,5% (157) и 5,3% (151). Незначительные показатели количества осужденных лиц выявлены в Крымском федеральном округе - 1,1% (30 человек).

В соответствии с главой 18 УК РФ уголовно-правовыми средствами обеспечения охраны половой свободы и половой неприкосновенности личности является законодательная регламентация таких составов преступлений как изнасилование, насильственные действия сексуального характера, понуждение к действиям сексуального характера, половое сношение и иные действия сексуального характера с лицом, не достигшим шестнадцатилетнего возраста, развратные действия (ст. 131-135 УК РФ). Повышенная общественная опасность изнасилования и насильственных действий сексуального характера отражается на категоризации указанных составов преступлений. Основные составы исследуемых преступлений и квалифицированные виды, предусмотренные соответственно частями первой и второй ст. 131, 132 УК РФ, являются тяжкими, особо квалифицированные виды - особо тяжкими преступлениями. В качестве меры уголовной ответственности за изнасилование или насильственные действия сексуального характера, совершенные в отношении лица, не достигшего четырнадцатилетнего возраста, субъектом, имеющим судимость за ранее совершенное преступление против половой неприкосновенности несовершеннолетнего, предусматриваются наказания от пятнадцати до двадцати лет лишения свободы либо пожизненное лишение свободы (ч. 5 ст. 131, ч. 5 ст. 132 УК РФ).

Необходимо отметить, что оформление в Особой части УК РФ самостоятельной главы - «Преступления против половой

неприкосновенности и половой свободы личности» создает предпосылки для последовательной оптимизации средств уголовно-правовой охраны свободы личности. Однако на современном этапе в условиях глобализации актуализируется разработка законодательных гарантий противодействия насильственным и ненасильственным преступлениям против половой неприкосновенности и половой свободы на межгосударственном уровне. Развитие международного сотрудничества стран Азиатско-Тихоокеанского региона в обеспечении права человека на свободу предполагает целенаправленную унификацию технико-юридического понятийно-категориального аппарата. Актуальным представляется разработка унифицированного подхода к таким юридическим категориям, как «изнасилование», «мужеложство», «лесбиянство», «иные насильственные действия сексуального характера», «развратные действия» и т.п. Отсутствие в международных нормативно-правовых актах унифицированных дефиниций обусловило многообразие подходов к структурированию Особой части в рамках национального уголовного законодательства стран Азиатско-Тихоокеанского региона<sup>5</sup>.

Наметившийся плюрализм в правовой оценке половой неприкосновенности половой свободы человека предопределил многообразие составов преступлений, предусматривающих ответственность за посягательства на указанные объекты уголовно-правовой охраны. Сложившееся многообразие подходов к определению видового и родового объектов посягательства позволило осуществить в странах Азиатско-Тихоокеанского региона законодательную регламентацию составов преступлений против половой неприкосновенности и половой свободы личности в пределах таких глав как «Преступления против детей, семьи и общественной морали» (Монголия), «Преступления против личности, демократических прав граждан» (КНР), «Преступления, состоящие в безнравственности, совращении и двоебрачии» (Япония) и т.д. Отмеченная тенденция в законодательной регламентации преступлений против половой неприкосновенности и половой свободы личности осложняет на правоприменительном уровне реализацию согласованной политики по

<sup>5</sup>He Binsung. Essentials of the Missions of Criminal Law (Theory) in the Age of Globalization. Beijing, 2015. -59 p.





обеспечению эффективности мер уголовно-правовой охраны. Функционирование разнородных программ, рассогласованность норм уголовного законодательства различных национальных правовых систем затрудняет взаимосвязь и взаимодействие правоохранительных и правоприменительных органов в сфере противодействия посягательствам на половую неприкосновенность и половую свободу личности.

Сравнительный анализ норм Уголовного кодекса РФ, Уголовного кодекса Монголии, Уголовного кодекса КНР и Уголовного кодекса Японии показывает неоднозначный подход законодателей указанных государств к регламентации данных составов преступлений. Многообразное толкование норм российского, монгольского, китайского и японского уголовного законодательства, ориентированного на защиту половой неприкосновенности и половой свободы, отражается в наименовании статей, содержании диспозиций и санкций норм.

Так, например, Уголовный кодекс Китайской Народной Республики ограничивается двумя статьями, направленными на охрану половой неприкосновенности и половой свободы человека (ст. 236, 237 УК КНР). Согласно ст. 236 УК КНР, законодательному оформлению подлежит изнасилование, совершенное с применением по отношению к женщине угроз и насилия. Одним из ключевых элементов изнасилования признается не половое сношение, а применение «к женщине угроз и насилия». В этой связи возникает закономерный вопрос относительно специфики объективной стороны преступления и установления точного момента его окончания. Дискуссионной представляется позиция китайского законодателя, идентифицирующего изнасилование с «развратными действиями по отношению к девушке, не достигшей 14 лет». Развратные действия с учетом их юридической природы исключают применение насилия. Отсутствие как физического, так и психического насилия по отношению к потерпевшей ставит под сомнение возможность законодательного отождествления развратных действий с изнасилованием.

С определенной долей условности к преступлениям против половой неприкосновенности и половой свободы личности может быть отнесено принуждение женщины к совершению унижающих ее достоинство действий и совершение надругательства над ней путем насилия, угроз или иными методами (ст. 237 УК

КНР)<sup>6</sup>. В качестве непосредственного объекта посягательства, исходя из содержания диспозиции анализируемой нормы, выступают, прежде всего, общественные отношения в сфере охраны достоинства потерпевшей. Кроме того, унижающие достоинство женщины действия вполне могут быть не связаны с гендерным неравенством. Что касается надругательства над потерпевшей, то в законе указываются своеобразные способы совершения преступления – «путем насилия, угроз или иными методами», которые также могут быть не связаны с областью взаимоотношения полов.

Уголовный кодекс Монголии к преступлениям против детей, семьи и общественной морали относит, в том числе преступления, посягающие на половую неприкосновенность и половую свободу личности. Таковыми являются половое сношение с лицом, не достигшим 16-летнего возраста, удовлетворение полового влечения в неестественной манере, изнасилование. Учитывая сложность разграничения видового и непосредственного объектов посягательства, думается, на правоприменительном уровне возникают проблемы правильной квалификации указанных преступлений.

Плюралистические подходы национальных правовых систем к оформлению запретов на данные деяния демонстрирует сопоставление российского и японского уголовного законодательства<sup>7</sup>. Уголовный кодекс Японии регламентирует два состава преступлений против половой свободы и половой неприкосновенности личности. На основании ст. 176-178 УК Японии уголовной ответственности подлежат: 1) развратные действия с применением насилия; 2) изнасилование; 3) преступные деяния, приравняемые к развратным действиям с применением насилия и к изнасилованию. Раскрывая специфику объективной стороны преступления, предусмотренного ст. 176 УК Японии, законодатель акцентирует внимание на: 1) возрасте потерпевшего (потерпевшей) как достигшей, так и не достигшей тринадцати лет; 2) применении насилия или угроз.

Между тем затруднения на правоприменительном уровне как раз могут быть связаны с установлением критериев отграничения насильственных развратных

<sup>6</sup>Issue Brief . The Global Regime for Transnational Crime // Council on Foreign Relations June. - 25, 2013.

<sup>7</sup>Albanese J. S. Deciphering the linkages between organized crime and transnational crime // Journal of International Affairs, Vol. 66 No. 1 Fall/Winter 2012. - P. 1-17.



действий от изнасилования. Вызывает закономерный вопрос законодательная формула изнасилования, понимаемого как «совращение лица женского пола путем применения насилия или угроз» (ст. 177 УК Японии). Проблематичными при квалификации являются преступные деяния, приравняемые к развратным действиям с применением насилия и к изнасилованию. Согласно диспозиции нормы статьи 178 УК Японии во внимание при юридической оценке указанных деяний следует принимать беспомощное состояние потерпевших. Однако критерии разграничения данных противоправных действий не указаны в норме уголовного закона.

Сравнительно-правовой оценки заслуживает дифференциация в российском, монгольском, китайском и японском законодательстве уголовной ответственности за преступление против половой неприкосновенности и половой свободы человека. Характерной особенностью правовой системы РФ является реализация целей наказания, а именно, восстановление социальной справедливости, исправление осужденного, предупреждение совершения новых преступлений через законодательную формулу и содержание санкций уголовно-правовых норм, предусмотренных ст. 131-135 УК РФ. Так, например, изнасилование, реализованное без отягчающих обстоятельств, наказывается на срок от трех до шести лет лишения свободы (ч. 1 ст. 131 УК РФ). Изнасилование по УК Монголии наказывается лишением свободы на срок до пяти лет (ст. 126). Изнасилование, совершенное с применением по отношению к женщине угроз и насилия, при отсутствии отягчающих обстоятельств карается по китайскому уголовному законодательству более строго вследствие увеличения верхнего предела наказания до десяти лет лишения свободы (ч. 1 ст. 236 УК КНР). Изнасилование в соответствии со ст. 177 УК Японии влечет наказание в виде лишения свободы с принудительным физическим трудом на срок не ниже двух лет.

При установлении квалифицирующих и особо квалифицирующих признаков изнасилования максимальный срок наказания, предусмотренного ст. 131 УК РФ, составляет: по части второй - до десяти лет, по части третьей - до пятнадцати лет, по части четвертой - до двадцати лет, по части пятой - до пожизненного лишения свободы. Установление квалифицированных и особо квалифицированных видов изнасилования влечет, согласно ст. 236 УК КНР, по части второй - назначение «максимально строгого

наказания из предусмотренных», по части третьей - вплоть до назначения смертной казни. Изнасилование при отягчающих обстоятельствах по УК Монголии предусматривает назначение наказания от пяти до десяти лет лишения свободы, при особо отягчающих обстоятельствах - влечет наказание свыше 15 до 25 лет лишения свободы или смертную казнь. Между тем ст. 177 УК Японии не предусматривает как квалифицированных видов изнасилования, так и более строгих видов наказаний.

Сопоставление иных норм российского, китайского и японского уголовного законодательства свидетельствует о смешении признаков составов преступлений, обусловившем недостаточную законодательную оформленность насильственных действий сексуального характера, предусмотренных ст. 132 УК РФ. Национальная специфика проявляется в процессе регламентации в России уголовной ответственности за понуждение к действиям сексуального характера, половое сношение и иные действия сексуального характера с лицом, не достигшим шестнадцатилетнего возраста, развратные действия (ст. 133-135 УК РФ). Так, понуждение к действиям сексуального характера без отягчающих обстоятельств влечет ответственность до одного года лишения свободы, при наличии квалифицированного вида, сопряженного с совершением указанного деяния в отношении несовершеннолетнего (несовершеннолетней), - до пяти лет лишения свободы (ч. 1-2 ст. 133 УК РФ)<sup>8</sup>. Основной состав понуждения к действиям сексуального характера регламентирует ответственность до четырех лет лишения свободы, по части второй - до шести лет лишения свободы, по части третьей - до десяти лет лишения свободы, по части четвертой - до пятнадцати лет лишения свободы, по части пятой - до двадцати лет лишения свободы, по части шестой - вплоть до пожизненного лишения свободы (ст. 134 УК РФ)<sup>9</sup>. Оценивая санкции норм, предусмотренные за развратные действия, необходимо отметить, что основной состав преступления влечет наказание до трех лет лишения свободы, квалифицированный вид

<sup>8</sup>Авдеева Е.В. Актуальные вопросы назначения наказания в виде ограничения свободы за преступления против свободы личности / Е.В. Авдеева // Российская юстиция. - 2014. - № 10. - С.14-18.

<sup>9</sup>Маслак С.Н. Насильственные преступления против половой неприкосновенности и половой свободы личности: проблемы уголовно-правового регулирования и квалификации: автореф. дис. ... канд. юрид. наук : 12.00.08 / Маслак Сергей Николаевич. - Краснодар, 2013. - 27 с.



— до восьми лет лишения свободы, особо квалифицированные виды (ч. 3-5 ст. 135 УК РФ), соответственно, - до двенадцати и пятнадцати лет лишения свободы<sup>10</sup>.

В рамках уголовного законодательства КНР предусматривается ответственность до пяти лет лишения свободы за принуждение женщины к совершению унижающих ее достоинство действий и совершение надругательства над ней путем насилия, угроз или иными методами (ч. 1ст. 237 УК КНР). Совершение указанного преступления публично или в общественном месте влечет наказание свыше пяти лет лишения свободы (ч. 2 ст. 237 УК КНР). Надругательство над ребенком наказывается «самым суровым из предусмотренных в частях первой и второй настоящей статьи наказанием» (ч. 3 ст. 237 УК КНР).

Уголовный кодекс Монголии регламентирует наказание до трех лет лишения свободы за половое сношение с лицом, не достигшим 16-летнего возраста (ст. 122). Удовлетворение полового влечения в неестественной манере обуславливает назначение более строго размера наказания в виде лишения свободы, варьирующегося от двух до пяти лет лишения свободы (ст. 125). Во внимание в данном случае принимается способ совершения преступления - путем насилия или угрозы его применения, а также посредством использования беспомощного состояния потерпевшего.

Что касается уголовного законодательства Японии, то ст. 176 УК устанавливает наказание за развратные действия с применением насилия в виде лишения свободы с принудительным физическим трудом на срок от шести месяцев до семи лет, в то время как уголовная ответственность, предусмотренная ст. 177 УК Японии, регламентирует наказание за изнасилование в виде лишения свободы с принудительным физическим трудом на срок не ниже двух лет.

Резюмируя вышесказанное, следует отметить, что проведение сравнительно-правового исследования норм российского, монгольского, китайского и японского уголовного законодательства, обеспечивающего охрану половой неприкосновенности и половой свободы человека, позволило раскрыть ряд проблем, осложняющих реализацию межгосударственных

<sup>10</sup>Авдеева Е.В. Уголовно-правовое обеспечение права человека на личную свободу в национальном праве / Е.В. Авдеева // Криминологический журнал Байкальского государственного университета экономики и права. - 2014. - № 1. - С. 162-171.

средств противодействия указанным посягательствам. Ключевым направлением уголовно-правовой политики в контексте глобализации, повлекшей значительные миграционные процессы, является унификация уголовно-правовых институтов, регламентирующих организационно-практические меры противодействия насильственным и ненасильственным преступлениям, посягающим на половую неприкосновенность и половую свободу личности. Особое значение приобретает консолидация мер социально-экономического, политико-правового, информационного и иного характера. Эффективное обеспечение безопасности личности предполагает модернизацию правовой политики на транснациональном уровне путем разработки согласованной стратегии и комплекса мер, направленных на ликвидацию причин и условий, способствующих совершению насильственных преступлений, обеспечению защиты потерпевших и их полноценной реабилитации.

#### Литература:

- 1.Авдеев В.А., Авдеева О.А. Правовое воздействие и правовая политика: вопросы институционализации и инструментальной сущности // Юридический мир. 2015. № 11. С. 19-23.
- 2.Авдеев В.А., Авдеева О.А. Условное осуждение в контексте современной уголовно-правовой политики РФ // Российская юстиция. 2014. № 5. С. 2-6.
- 3.Авдеева Е.В. Уголовно-правовое обеспечение права человека на личную свободу в национальном праве / Е.В. Авдеева // Криминологический журнал Байкальского государственного университета экономики и права. - 2014. - № 1. - С. 162-171.
- 4.Авдеева Е.В. Актуальные вопросы назначения наказания в виде ограничения свободы за преступления против свободы личности / Е.В. Авдеева // Российская юстиция. - 2014. - № 10. - С.14-18.
- 5.Albanese J. S. Deciphering the linkages between organized crime and transnational crime // Journal of International Affairs, Vol. 66 No. 1 Fall/Winter 2012. - P. 1-17.
6. Issue Brief . The Global Regime for Transnational Crime // Council on Foreign Relations June. - 25, 2013.
- 7.He Binsung. Essentials of the Missions of Criminal Law (Theory) in the Age of Globalization. Beijing, 2015. —59 p.
- 8.Маслак С.Н. Насильственные преступления против половой неприкосновенности и половой свободы



личности: проблемы уголовно-правового регулирования и квалификации: автореф. дис. ... канд. юрид. наук : 12.00.08 / Маслак Сергей Николаевич. — Краснодар, 2013. — 27 с.

9.Оберемченко А.Д. Развратные действия: уголовно-правовая характеристика и проблемы квалификации: автореф. дис. ... канд. юрид. наук : 12.00.08 / Оберемченко Александр Дмитриевич. — Краснодар, 2014. — 26 с.

10.Сергевнин В.А. Гармонизация уголовно-правовой политики в сфере назначения и исполнения наказания / В.А. Сергевнин, В.А. Авдеев, О.А. Авдеева // Криминологический журнал Байкальского государственного университета экономики и права. — 2015. - №1. — С. 78-93.



**БҮРЭН БИШ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ  
АЖИЛД ГАРГАХ, ЖОЛООДУУЛАХ  
ЭРХГҮЙ ХҮНЭЭР ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ  
ЖОЛООДУУЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ  
ТЭМЦЭЖ ИРСЭН УЛАМЖЛАЛ,  
ШИНЭЧЛЭЛ**

**Б.Баттүвшин**

Хууль сахиулахын их сургуулийн магистрант

**Түлхүүр үг:** Бүрэн биш тээврийн хэрэгсэл, жолоодох эрхгүй хүн, гэмт хэрэг, Монгол хууль цаазын түүхэн эх сурвалж, уламжлал, шинэчлэл

Монгол Улсын хүн ам жилээс жилд өсч байгаатай холбоотойгоор хүний хэрэглээ болсон авто машины тоо ихсэж байна. Үүнтэй уялдан зам тээврийн осол, хэрэг жилээс жилд нэмэгдэх хандлагатай байна. Манай оронд төдийгүй дэлхий дахинд зам тээврийн ослын улмаас жил бүр 1.2 сая хүн буюу өдөрт 3242 хүн нас бардаг бөгөөд үүний 90%-ийг хөгжиж буй, буурай хөгжилтэй, бага, дунд орлоготой улс орнууд эзэлж байна. Эдгээр орнуудад дэлхийн хүн амын 81% нь амьдардаг бөгөөд нийт авто машины зөвхөн 20% нь байдаг.

Дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа хүн амын эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг нь зам тээврийн осол, гэмтэл юм. Зам тээврийн осол, хэрэг нэмэгдэж, түүнээс учрах хохирол, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл өсч буй энэ үед замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах явдал дэлхий нийтийн үйл хэрэг болж байна. Иймд НҮБ-ийн Ерөнхий Ассемблейн 2010 оны 64/225 дугаар тогтоолоор 2011-2020 оныг Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 10 жил болгохоор зарласан билээ.

Манай улсад зах зээлийн харилцаа өргөжиж, улс орны хөгжил, хүн ам өсч, хот суурин газруудад үйлдвэр, аж ахуйн болон орон сууцны барилга байгууламж, зам, дэд бүтэц шинээр байгуулагдан өргөжин тэлж байгаатай холбоотойгоор тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсад хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрх зүйт төрийг төлөвшүүлэн бэржүүлэх зорилго бүхий шилжилтийн үед хууль зүйн шинжлэх

ухааны суурь асуудлын нэг болсон монголын эрх зүйн түүхэн уламжлалыг судлах нь нэн чухал юм.

Монголын эрх зүйн түүхэн уламжлалыг судалснаар монголчуудын төр ёс, хууль цааз, зан заншил, хэм хэмжээ, хууль дээдлэх үзлийн түүхэн уламжлалыг өөрийн орны өвөрмөц нөхцөл байдалд тулгуурлан хөгжүүлэх хууль зүйн шинжлэх ухааны нэг гол зорилгыг хэрэгжүүлэхэд үүрэг гүйцэтгэдэг билээ.

Монгол төр ёсны үзэл хууль цаазын сэтгэлгээ нь 2200 гаруй жилийн түүхэн уламжлалтай бөгөөд Монгол Улсын түүхэн дэвшил хөгжил, мандал буурлын үр дагавар мөн. Төрт ёсны энэхүү түүхийн урт хугацаанд монголчууд нийгэм, эдийн засаг, улс төрийн онцлог байдалтай уялдан өөр өөрсдийн амьдралын явцад бий болсон нийгмийн харилцааг зохицуулах хууль цаазыг түүний дотор эрүүгийн хууль тогтоомжийг боловсруулан гаргаж, нийтээр мөрдөж байжээ.

Эдгээр хууль цаазыг судлан Монгол Улсын Эрүүгийн хуулийн “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг” гэсэн 24 дүгээр бүлэгт заасан “Бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах” гэмт хэргийн уламжлалын асуудлыг онол, арга зүйн үүднээс судалж, улмаар практикт шударгаар биелүүлж ирсэн уламжлал шинжийг нь өвлөн хэрэгжүүлэх нь ач холбогдолтой юм.

Монголын эртний хууль цаазууд болон тэдгээрийн үйлчилж байсан орон зай, цаг хугацааны зэрэг асуудлыг харгалзан дараах хуулийн заалтуудыг хооронд нь харьцуулах, системчлэх байдлаар авч үзлээ.

1921 оноос өмнөх хууль цаазын бичгүүдэд бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах гэмт хэргийн талаар тусгасан нь:

XIII зууны эхээр Монгол туургатан нэгдэж, нэгдсэн төр улсаа байгуулсан билээ. Монголын тулгар улс баруун зүгт Эрчис гол, өмнө зүгт Цагаан хэрэм, умардад Байгаль нуур хүртэлх нутаг дэвсгэрт тогтнож, өөрийн орны болон хүн төрөлхтний соёл иргэншлийн өв уламжлал, туршлагад тулгуурласан нийгэм, төрийн шинэ тогтолцоог бүрдүүлэн бий болгон хүчирхэгжин мандсан байна.<sup>1</sup>

Иймд Төв Азид үүсэн байгуулагдсан Монгол туургатны тулгар улсад хүчтэй төвлөрсөн төр, цэрэг армиас гадна нэгдмэл хууль цааз зайлшгүй шаардлагатай байсан зүй тогтлыг харгалзан бүх нийтээр дагаж шийтгэх нэгдмэл цааз болох “Их засаг” хуулийг шийтгэн гаргасан ба энэ нь монголын эрх зүйн хөгжлийн шинэ үеийг нээсэн анхны хууль юм.

Монголын их хаан Чингисийн Их Засаг хэмээсэн яруу сайхан нэр, өвөрмөц гүн агуулгатай хууль цааз манай ард түмний



соёл иргэншлийн бүхий л түүхийн туршид монголчууд болон монгол судлаач, сонирхогчдын анхаарлыг үргэлж татаж ирсэн.

Чингис хаан зөвхөн хурдан хүлэг, хурдан зэвсэг, эр зоригоор улс гүрнийг нэгтгэн захирч, төрийг засан тохинуулж үл болно гэдгийг сайтар ухаж, засаг цааз, хэв ёс журам дүрмийг цэгцлэн тогтоож, иргэн бүхэнд даган мөрдүүлжээ. Чингис хааны хууль цаазыг зөрчсөн хэн боловч алагчлалгүй шийтгэгддэг байжээ. Өөрөөр хэлбэл, хууль цааз нь Их эзэн хаанаас эхлээд иргэн бүрд тэгш үйлчилдэг байсан. Ийнхүү шударга ёсыг өөрөөсөө буюу дээрээсээ тэгш хэрэгжүүлсэн нь Чингис хааны Их Монгол улс байгуулж чадсаны нэгэн нууц юм. Дэлхийн олон улсад ихэд алдаршсан Их засаг цааз бол Их Монгол Улсын хууль цаазын эмхтгэл, үндсэн хууль бөгөөд уламжлал шинжлэлийг үнэн мөнөөр, монгол ухаанаар эргэн харах болсон өнөө үед олон талаас нь шинжлэн үзвээс зохих монголын эртний хууль цаазын дурсгал бичиг юм.

Их засаг цаазын тунхагласан өдрөөс эхлэн эзэн Чингисийг насан хутга болох хүртэлх хугацаанд хэдэнтээ сайжруулан төгөлдөржүүлж 1211, 1219, 1225 онд нэмэлт, өөрчлөлт оруулж байжээ.

Ийнхүү Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн хамгийн эртний дурсгалт бичиг болох Их засаг цаазын тусгай хуулиуд гэсэн тав дугаар бүлгийн 35 дугаар зурваст: "Дайн байлдаан дуусмагц унааны сайн морийг ус бэлчээрт тавих хэрэгтэй, унах ба гүйлгэхийг хориглоно. Агт морио сүйтгэгчдийг яллатугай. Ялангуяа, морины толгой нүдийг занчигчдыг ална." гэж заасан нь агт морьд бол монголчуудын нүүдлийн аж ахуйн чухал бүрэлдэхүүн хэсэг, зам харилцааны гол хэрэгсэл, дайн байлдааны хосгүй зэвсэг, хань нөхөр учир дээдлэн үзэж, хайрлан хамгаалах хэрэгтэй байсныг харж болохоор байна. Мөн эл хуулийн 41 дүгээр зурваст: "Өртөө бүрд байх ёстой унаа морьдын тоо, хоол хүнсний зүйл, бусад зардлыг дааж, тэр бүхнийг мянгат түмэтүүдээс гаргуулж байхаар тогтоосон байна. Нэг замын өртөөг хоёр түмт хариуцаж хангах агаад түмтүүд нь өрх бүрдээ хуваарилан татварладаг байлаа. 42 дугаар зурваст: "Өртөө бүрийг сар тутам түшмэл ирж шалган бүхий л асуудлыг байцааж буруутныг шийтгэнэ"<sup>2</sup> гэсэн нь "Сар бүр шалгана" гэдэг уг асуудлыг хичнээн их анхаарч байсны илэрхийлэл ба хязгааргүй уудам монголын их гүрэнд зам харилцаа өртөө улаа үнэхээр чухал байсан нь харагдаж байна.

Халх журам хуульд: Монгол Улс Манж Чин улсын эрхшээлд 200 орчим жил дарлагдсаны дараа эзэнт гүрний эсрэг нэг санаа нэгдмэл хүчээр босч, төрийн голомтоо дахин бадрааж, улс гэрээ төвхнүүлэхдээ төр иргэний хамаг хэргийг зохицуулан захирах хууль цааз боловсруулан дагаж шийтгүүлэхээр шимтсэн байна. Иймээс

Монгол Улсын

1 Ш.Нацагдорж. "Чингис хааны кадиг" УБ.,1995. 17 дахь тал

2 Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997. 75 дахь тал

хаан Жавзандамбын зарлигаар төр, шашны зүтгэлтэн эрдэм төгс, ухаант мэргэд 1913 оны сүүлчээр 1918 оны эх хүртэлх хугацаанд боловсруулан дагаж шийтгүүлсэн 65 дэвтэр бүхий Монгол Улсын хууль зүйлийн бичиг бол Чингисийн Их засаг, Монгол-Ойрадын Их цааз, Халх журам зэрэг хуулийн үргэлжлэл, үнэт дурсгал төдийгүй төр ёсны өнийн

уламжлалтай Монголчуудаас дэлхий дахины цааз эрхэмжийн сан хөмрөгт оруулсан хувь юм.<sup>3</sup>

Зарлигаар тогтоосон Манж Чин улсын бүгд хууль, Халх журам, Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг хэмээх хууль цаазын дурсгалт бичгүүд нь манжийн ноёрхлын үеийн монголын төр, захиргаа эрх зүйг судлахад гол үндсэн эх сурвалж болдог юм. Уг хууль зүйлийн бичгийн 44 дүгээр дэвтэрт "Өртөөний засаг доод" хэргийг болон түүнийг үйлдсэн этгээдэд оногдуулах ялыг "Өртөөний морийг илүү унах нь" гэсэн гэмт хэргийн нэгэн зүйлд: "Аливаа зарсан түшмэл хүн унах морийг тооноос гадна илүү нэг морь унах болвоос наян ташуур занч. Нэг морь тутам нэг зэрэг нэм. Хэрэв алшаа морь унаваас зохих бөгөөд албанд гоц морь авцгаах болбоос далан ташуур занч. Түүнийг учирт өртөөний түшмэл хуягийг занчиж, хор хийвээс алтваад нэгэн зэрэг нэм. Шат хугарснаас хэрэлдэн занчсан тэгш болбоос ёсоор хэлэлц. Хэрэв гоц морь унаваас зохиход нь өртөөний түшмэл, хуяг, алшаа морь өгвөөс ялыг өртөөний түшмэл, хуяг оноогтун. Хэрэв зарсан түшмэл ард зам мурийж өртөөлөх, жутич өртөөг өнгөрсөн морийг халахгүй болвоос жаран ташуур занч. Түүнийг учирт өртөөний морь үхвээс нэгэн зэрэг нэм. Морийг авч албанд төлүүл. Түүнээс яарах түргэн хэрэг оноогтун. Хэрэв яарах түргэн цэргийн хэрэг болох жич, өмнөх өртөөнд халах морьгүй болбоос оноохгүй төлүүлэхгүй. Мөн халсангүй учрыг шүүгтүн." Мөн хуулийн 44 дүгээр дэвтрийн "Өртөөний морийг зоригоор хэрэглэх нь" гэмт хэргийн нэгэн зүйлд: "Аливаа өртөөний түшмэл, өртөөний морийг зоригоор түр хэрэглэх эсвээс уламжлан хүнд түр өгөх, жич, түр гуйх болбоос аливааг наян ташуур занчигтун"<sup>4</sup> гэсэн байгаа нь өмнөх Их засаг хуулиас Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичиг хүртэл бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолооооуулах гэмт хэрэгтэй тэмцэх зорилготой хэм хэмжээ байгаагүй ч Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичигт орсон нь Эрүүгийн хууль тогтоомжид гэмт хэргийн шинжтэй анхны зохицуулалт болсон байна.





Тухайлбал, 1921 оноос өмнөх хууль цаазын бичгүүдэд энэ талаар бараг тусгагдаагүй байгаа нь учир дутагдалтай боловч өнөөгийн эрүүгийн хууль тогтоомжийн үндэс суурь болж өгчээ.

1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжид бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах гэмт хэргийг хуульчилсан нь:

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн хөгжилд 1921 оны Ардын хувьсгал шинэ үеийг нээж, хуучин төрийн аппаратыг устгаж, түүний хууль цааз, ёс суртахуунд халдахгүйгээр ардчилсан өөрчлөлтийг гүнзгийрүүлж болохгүй байсан.

Монгол Улсын анхны Эрүүгийн хууль нь “БНМАУ-ын шүүх цаазын бичиг” нэртэйгээр ерөнхий ангийг нь Засгийн газрын 1926 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн нэгдүгээр хурлаар, тусгай ангийг нь 1926 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Улсын 3 дугаар Их хурлаас тус тус батлан гаргажээ.

1926 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын нэгдүгээр хурлаар баталсан “Шүүх цаазын бичиг” нь ерөнхий анги 7 бүлэг, 40 зүйлтэй, тусгай анги 8-31 бүлэг, 41-227 зүйлтэй хууль билээ. Энэ хуулийн арван зургаадугаар бүлэгт “Аливаа зам ба харилцан нэвтрэлцэх зүйлүүд жич: улсын хязгаарын овоо, тэмдэг зэргийг хамгаалах нь”, хорингуравдугаар бүлэг “Улсын ба ард олны хөрөнгийг сүйтгэх нь”, гучдугаар бүлэг 3 О.Батсайхан, З.Лонжид. “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” УБ., 1995. 3 дахь тал

4 Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал УБ., 2011 он 195 дахь тал

“Хулгайлах, булаах ба дэрэмдэх зэргээр бусдын эд хөрөнгийг сүйтгэх нь” гэсэн бүлгүүд хуульчлагдсан боловч бидний судалж буй бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй этгээдээр тээврийн хэрэгсэл жолоодуулах гэмт хэрэг нь хараахан хуульчлагдаагүй байна.

1929 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр баталсан БНМАУ-ын Шүүх цаазын бичиг нь 227 зүйлтэй бөгөөд өмнөх хуулийн арван зургаадугаар бүлэг “Аливаа зам ба харилцан нэвтрэлцэх зүйлүүд жич: улсын хязгаарын овоо, тэмдэг зэргийг хамгаалах нь” гэмт хэрэг нь энэ хуулийн арван тавдугаар бүлэгт төрлийн объектын нэр болон гэмт хэргүүд хэвээр хуульчлагдсан байна.

1934 оны 5 дугаар сарын 14-ний өдөр хуралдсан Ардын сайд нарын Зөвлөлийн 13 дугаар хурлын тогтоолоор баталсан БНМАУ-ын Шүүх цаазны бичиг, 1942 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн БНМАУ-ын 25 дугаар бага хурлаас гаргасан тогтоолоор БНМАУ-ын Эрүүгийн хуульд бүрэн биш тээврийн

хэрэгслийн ажилд гаргах, жолоодох эрхгүй этгээдээр тээврийн хэрэгсэл жолоодуулах гэмт хэргийн талаар тусгагдаагүй байна.

1961 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр баталсан БНМАУ-ын Эрүүгийн хууль:

Энэ хууль нь 11 бүлэг, 221 зүйлтэй бөгөөд тогтолцооны хувьд Эрүүгийн хуулийн ерөнхий, тусгай анги гэж ангилсан байдаг. Тус хуулийн “Нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, ард иргэдийн эрүүл мэндийн эсрэг гэмт хэргүүд” гэсэн 10 дугаар бүлгийн 172 дугаар зүйлд “Зам тээврийн ажилтан хөдөлгөөнийг аюулгүй байлгах ба тээвэр ашиглалтын дүрэм зөрчих” гэмт хэргийг:

“А.Төмөр зам, усан агаарын тээврийн ажилтан хөдөлгөөнийг аюулгүй байлгах ба тээвэр ашиглалтын дүрэм зөрчиж, хүмүүст аюул учруулсан, онхолдуулж, мөргөлдүүлсэн буюу бусад ноцтой хор хохирол учруулсан, эсхүл тээврийн хэрэгсэл, зам, дохио, холбооны хэрэгслийг чанаргүй муу зассанаас дээр дурдсан хор аюулд хүргэвэл хоёроос арван жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ.

Б.Энэ гэмт явдлууд нь энэ зүйлийн а-д дурдсан хор аюулд учруулаагүй боловч тийм байдалд хүргэх нь гарцаагүй байсан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар хүмүүжүүлэх ажил хийлгэнэ”<sup>5</sup> гэж хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан нь шинэ үеийн Эрүүгийн хуульд бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй этгээдээр тээврийн хэрэгсэл жолоодуулах гэмт хэрэг анх удаа гэмт хэргийн шинжтэй хуульчлагдсан боловч, төрлийн объектын хувьд “Нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, ард иргэдийн эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт хуульчлагдаж, мөн бүрэн биш тээврийн хэрэгсэл ажилд гаргах, эрхгүй этгээдээр жолоодуулах гэсэн диспозиц бүрэн утгаараа хуульчлагдаагүй юм. Харин өмнөх хуультай харьцуулахад гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын хувьд “Төмөр зам, усан агаарын тээврийн ажилтан” гэж тусгай субьекттэй зааснаараа давуу тал болсон.

1986 оны 12 дугаар сарын 5-ны өдөр баталсан БНМАУ-ын Эрүүгийн хууль:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн хууль нь 13 бүлэг, 301 зүйлтэй ба “Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” гэсэн 12 дугаар бүлгийн 262 дугаар зүйлд “Бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах буюу согтуу жолоочоор тээврийн хэрэгсэл жолоодуулах” гэмт хэргийг:

“Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих буюу





ашиглалт хариуцсан этгээд техникийн хувьд илт бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргасан буюу согтуу жолоочоор тээврийн хэрэгсэл жолоодуулсан түүнчлэн, хөдөлгөөний аюулгүй байдлын болон тээврийн хэрэгслийн ашиглалтын журам бусад хэлбэрээр зөрчсөнөөс энэ хуулийн 260 дугаар зүйлд заасан хор уршиг /хөнгөн, хүндэвтэр гэмтэл/ бий болсон бол тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг мянга таван зуу хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ” гэж үндсэн

<sup>5</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал УБ., 2011. 465 дахь тал

бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан байна. Өмнөх 1961 оны Эрүүгийн хуулиас төрлийн объектын хувьд шинээр “Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” бүлэг нэмж, үүнд “Бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах буюу согтуу жолоочоор тээврийн хэрэгсэл жолоодуулах” гэмт хэрэг шинээр хуульчилж, гэмт хэргийн шинжийг бүрэн агуулж, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхгүйг тодорхойлж өгсөн дэвшилттэй байна.

2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр баталсан Монгол Улсын Эрүүгийн хууль: Монгол Улсын Эрүүгийн хууль нь 31 бүлэг, 305 зүйлтэй ба бидний судалж буй “Бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах” гэмт хэргийг одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуулийн 220 дугаар зүйлд байдлаар хуульчилсан байна. Үүнд:

220.1.Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын аюулгүй ажиллагааг албаны хувьд хариуцсан ажилтан илт бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргасан, жолоодох эрхийн үнэмлэхгүй этгээдээр машин жолоодуулсны улмаас хүний бие махбодид хүндэвтэр гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

220.2.Энэ хэргийн улмаас хүний бие махбодид хүнд гэмтэл учирсан, хүний амь нас хохирсон түүнчлэн онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх үйл хжиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэсэн ба

хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хуульчилж, практикт хэрэглэж байна.

Өмнөх оны хуультай харьцуулахад төрлийн объектын хувьд ижил боловч гэмт хэргийн хувьд хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хуульчлагдсан байна. Мөн “... илт бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргасан, жолоодох эрхийн үнэмлэхгүй этгээдээр машин жолоодуулсны улмаас...” гэсэн нь өмнөх оны хуульд заасан “...согтуу жолоочоор тээврийн хэрэгсэл жолоодуулах...” гэсэн диспозицтой харьцуулахад өргөн хүрээтэй болсон байна. Мөн гэмт хэргийн хор уршгийн хувьд өмнөх оны Эрүүгийн хуультай харьцуулахад “... хүний бие махбодид хөнгөн гэмтэл...” учирсан байхаар заасан хор уршиг хасагдаж, үндсэн бүрэлдэхүүнд “...хүний бие махбодид хүндэвтэр гэмтэл учирсан...” байхаар хуульчилсан байна.

2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан Монгол Улсын Эрүүгийн хууль:

Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг” гэсэн 27 дугаар бүлэгт “Бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах” гэмт хэрэг тусгагдаагүй байна.

Харин 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр УИХ-аас баталсан Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 14 дүгээр бүлэг “Тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчил” гэсэн 14 дүгээр бүлгийн 14.4 дүгээр зүйлд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих”-ийн 1 дүгээр хэсэгт “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”, 2 дугаар хэсэгт “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл эрх нь дуусгавар болсон хүнд тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”, 54 дүгээр хэсэгт “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон, эсхүл согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн этгээдээр тээврийн хэрэгсэл жолоодохыг шаардсан, эсхүл нөлөөлсөн бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх



хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж хуульчилсан байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэг, 220 дугаар зүйлд заасан “Бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах” гэмт хэрэг нь учирч буй хор аюул, түүний ирээдүйд бий болох сөрөг үр дагаврын хувьд хүндэвтэр гэмт хэрэгт тооцогдох хэрэг юм.

Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 1-д гэмт хэргийг тодорхойлохдоо “Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.” гэж заасан ба тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын аюулгүй ажиллагааг албаны хувьд хариуцсан ажилтан илт бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргасан, жолоодох эрхийн үнэмлэхгүй этгээдээр машин жолоодуулсан үйлдлээр бусад хүний эрх, ашиг сонирхол, бие махбодид хүндэвтэр гэмтэл, эсхүл бусдын эд хөрөнгөд их хэмжээний хохирол учирсан сөрөг үр дагавар үзүүлж, түүнийг гэмт хэрэгтэн болгож, байгаа учир гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжийг хангаж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн амьд явах эрхтэй” 2 дах хэсэгт “...эрүүл, аюулгүй орчинд амьдрах” эрхтэй гэж заасан. Энэ нь хүний нийгмийн баталгааг бүрдүүлэх төдийгүй, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхгүй байх, түүнийг зөрчихтэй тэмцэх хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх хууль зүйн баталгааг бүрдүүлж, хүний эрх ашигт гэмт халдлага, эрх зүйн бусад зөрчлөөс ангид байлгах үүргийг төр өөртөө үүрэг болгож хариуцсан хэрэг юм. Иймд эрх зүйн шинэчлэлийн хүрээнд боловсруулагдаж, УИХ-аас баталсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчлэсэн найруулгад “Бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах” гэмт хэргийг тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын аюулгүй ажиллагааг албаны хувьд хариуцсан ажилтан илт бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргасан, жолоодох эрхийн үнэмлэхгүй этгээдээр машин жолоодуулсны улмаас хүний бие махбодид хүндэвтэр гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан үйлдлийг субъектив, объектив талын шинжтэйгээр

хуульчлах нь зүйтэй гэж үзэж байна.



## ҮЙЛ ЯВДЛЫГ ТОГТООХОД ЧИГЛЭСЭН ЭРҮҮГИЙН ПРОЦЕССИЙН ЗАРИМ АСУУДАЛ

**Б.Намсрай**

ЦЕГ-ын Судалгаа, дүн шинжилгээний төвийн ахлах  
мэргэжилтэн, цагдаагийн хошууч

### Оршил:

Күнзийн сургаальд: “Жилийн ургацыг авъя гэвэл үрийг нь тарь, арван жилийн ургацаа бэлдье гэвэл модыг нь тарь, харин 100 жилийн ургацаа хураа я гэвэл бусдад зааж өг” гэсэн байдаг.

Үнэнийг тогтоохын тулд гэмт хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь судалж, яллах, цагаатгах эсхийг дэнслэх нь эрүүгийн процессийн зорилго гэж үздэг.

Харин өнөө цагт гэмт хэргийн “субъектив” талыг тогтооход чиглэсэн эрүүгийн процесс давамгайлж, хэргийн учир шалтгааныг танин мэдэхээс илүүтэй хохирогч, гэрчийн мэдүүлэгт тулгуурлан сэжигтнийг яллах төлөв байдал ажиглагдаж байгаа гэж шүүмжлэх болсон.

Иймд дараах агуулга бүхий нийтлэлийг бичлээ:

Буруутныг тогтооход яаравчилах нь эрүүгийн процессийн үндсэн зорилго биш. Харин хэргийн үнэн бодит байдлыг тогтоож тал бүрээс нь судлан шинжлэх бүтээлч, үр ашигтай арга барилыг нэвтрүүлэх хэрэгтэй байна. Тухайлбал: Байцаалт, тайлбар авах зэрэг мэдээлэл олж авах, бэхжүүлэх аргуудыг үйл явдлыг тогтооход чиглүүлж өгөх.

Буруутныг тогтоож яллахад хэт төвлөрвөл хүний эрхийг зөрчин, хувийн арга барил давамгайлсан ажлын практикийг бий болгоно. Үр дагавар нь “мэдлэггүй шүүгч”, “ноён прокурор”, “арга барилгүй мөрдөгч”, “залт өмгөөлөгч” юм.

Үйл явдлын үнэнийг эрэлхийлэхгүй буруутныг хайх нь хэргийг нотлох хүрээг хумьж, хяналтгүй болгох, объектив үнэнээс холдох, мөрдөн шалгах, шүүх ажиллагаанд хөндлөнгөөс саад учруулах эрсдэл дагуулна.

Буруутныг тогтоож, яллахад чиглэсэн

эрүүгийн процесс нь хохирогч, гэмт үйлдлийн арга хэрэгсэл, шалтгаант холбоог анхаарлын гадуур үлдээх эсхүл хүнийг эрх зөрчигдөх байдлыг бий болгох эрсдэлтэй.

### Үйл явдлыг тогтоох ажиллагаа:

Гэмт хэрэг гарсан цагаас эхлэн гэм буруутныг яллах хүртэл болсон үйл явдлын шалтгаан мөн чанар, нотлох баримтыг олон талаас нь дүн шинжлэх, эдгээрээс ял хүлээвэл зохих буруутныг гарцаагүй тогтоох ажиллагаа нь “үйл явдлыг тогтоох эрүүгийн процесс” юм.<sup>1</sup>

Шүүгч, прокурор, мөрдөгч нь эрүүгийн процессийг явуулахдаа хавтаст хэрэгтэй бус нийгэмтэй харилцдаг. Энэ процесс нь харилцан танин мэдэх шинж чанартай хууль зүйн харилцаа, эсрэг тэсрэг ашиг сонирхолын дунд оршино.<sup>1</sup>

Үйл явдлыг тогтоох ажиллагааны философи нь хэргийн объектив үнэнийг олж мэдэхэд чиглэсэн эрүүгийн процесс явуулахад чиглэнэ. Энэ нь хэргийн шалтгаан нөхцөл, зөрчигдсөн эрх, хор уршиг, зүйлчлэл, нотлох баримтын чанар зэрэг өргөн хүрээтэй ойлголтыг судалсаны эцэст гарцаагүй нотлох баримтыг бүрдүүлж, буруутныг яллах зарчмаар илэрхийлэгдэнэ.<sup>2</sup>

Хэрвээ хэргийг бүхэлд нь судлахаас төвөгшөөж буруутныг хайхад чиглэсэн мөрдөх ажиллагааг эрчимжүүлэн, яллах арга барилыг голчлон баримталвал “Үйл явдлын үнэн”-ийг тогтоож чадахгүй.

Иймд “үйл явдал”-ыг тал бүрээс нь тогтоох үүргийг шүүгч, прокурор, мөрдөгчид үүрэг болгосон дараах зохицуулалт 2002 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгагдсан:

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авна.

“Аль нэг баримтыг туйлшран үнэлэхээс зайлсхийж яллах, цагаатгах баримт, тодорхой төрлийн эрүүгийн процессийн ажиллагааг бүтээлчээр хэрэгжүүлэх нь чухал байна. Жишээ нь: Шүүгчдэгч найз бүсгүйгээ 48 цагийн турш зодож улмаар амийг нь хөнөөсөн гэх хэрэг олон нийтийн анхаарлын төвд байсан. Энэ хэргийн хохирогчид хийсэн шүүх шинжилгээний дүгнэлт хуурамч гарснаас ял завших эрсдэл үүслээ гэж дүгнэсэн.”<sup>3</sup>

Энэ хэргийн нотлох баримт шүүх эмнэлгийн дүгнэлтийн хүрээнд хумигдсан нь харамсалтай бөгөөд хохирогчийн үхлийн шалтгааныг зөвхөн шүүх эмнэлгийн

<sup>1</sup> Keith N.Haley, Criminal justice, fourth edition, 2005, p 14

<sup>2</sup> С.Нарангэрэл, Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, 2001 он, 47 дахь тал

<sup>3</sup> Б.Намсрай, Гэмт хэргийн аналитик, Гэмт явдалтай тэмцэх асуудал онол-арга зүйн сэтгүүл, 2004 он, №24



дүгнэлтээр хязгаарлах нь учир дутагдалтай юм. Үүнээс гадна шүүх эмнэлгийн дүгнэлтийг баримтлах эсэх нь шүүхийн эрх хэмжээний асуудал болно”

Шүүх хэргийг бүх талаас нь бүрэн, бодитойгоор шинжлэн судалж, үнэн байдлыг тогтоохын тулд шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн эсэх, уг хэрэгт гэмт хэргийн бүрэлдэхүүн байсан эсэх, шүүгдэгч гэм буруутай эсэх, хариуцлагыг хөнгөрүүлэх буюу хүндрүүлэх нөхцөл байдал байгаа эсэхийг заавал шийдвэрлэсэн байна.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас шилжүүлсэн хэргийн талаар прокурор нь дараах зүйлийг нягтална: гэмт хэргийн бүрэлдэхүүн байгаа эсэх, хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл байгаа эсэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг бүрэн, бодитой явуулсан эсэх, Эрүүгийн хуулийн зүйл, хэсгийг зөв хэрэглэсэн эсэх, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг тодруулж чадсан эсэх, түүнийг арилгах талаар арга хэмжээ авсан эсэхийг шалгана.

“2014 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй өргөдөл, гомдлын 67 хувь нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болсон байна”

2014 оны эхний хагас жилд Улсын Дээд шүүхийн хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн эрүүгийн 251 хэргээс: 52 хэргийн тогтоол, магадлал өөрчлөгдөж, 57 хэргийн тогтоол, магадлал хүчингүй болсон байна.

Шүүхийн тогтоол, магадлал өөрчлөгдсөн үндэслэлийн хувьд нийт 52 хэргээс: 19 хэргийн тогтоол “эрүүгийн хууль буруу хэрэглэсэн”, 6 хэргийн тогтоол “шүүх хэрэглэвэл зохих хууль хэрэглээгүй”, 3 хэргийн тогтоол “хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн”, 4 хэргийн тогтоол “хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн”,

Шүүхийн тогтоол, магадлал хүчингүй болсон шалтгаан, үндэслэлийн хувьд нийт 57 хэргээс: 24 хэргийн тогтоол “Эрүүгийн байцаан шийтгэх хууль ноцтойгоор зөрчсөн”, эрүүгийн 33 хэргийн тогтоол нь “тогтоол, магадлалд дурдсан дүгнэлт нь жинхэнэ байдалтай нийцээгүй” үндэслэлээр хүчингүй болсон бөгөөд 4 хэрэг нь цагаатгалын хэрэг байна.<sup>5</sup>

Эд мөрийн баримтад гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэргийн ул мөр үлдсэн зүйл, түүнчлэн гэмт үйлдлийн замаар олсон мөнгө, үнэ бүхий зүйл, бусад зүйлс, баримт бичиг болон гэмт хэргийг илрүүлэх, хэргийн бодит байдлыг тогтоох,

гэмт этгээдийг олох, эсхүл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм бурууг үгүйсгэх буюу хөнгөрүүлэхэд ач холбогдол бүхий бусад эд зүйлийг тооцно.<sup>6</sup>

Үнэн хэрэгтээ, манай эрүүгийн процесст эд мөрийн баримт, нотлох баримт, баримт сэлт, нотолгооны зүйлийн талаарх ойлголт нэг мөр болоогүй байна. Объектив үнэний зарчим нь нотлох баримт, нотлох ажиллагааны амин чухал асуудал тул нотлох баримт, түүнийг цуглуулах аргыг боловсронгуй болгож, мэдүүлэгт түшиглэсэн процессоос татгалзах хэрэгтэй байна.

Эрүүгийн процесст объектив үнэнийг тогтоох шалгуур, шалтгаан нь:

Шалгуур	Яагаад?
Гэмт хэрэг, түүний шалтгаан, нөхцөл, хүчин зүйлийг судлах. “Гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан нь үнэн байх ёстой. Шалтгаан нь үнэн бол гэмт хэрэг ч үнэн байна”	Энэ нь тухайн үйлдэл, эс үйлдэхүй гэмт хэрэг мөн эсэх, хэрэгтний гэм бурууг тодорхойлно. Жнь: шунахайн шалтгаантай, өс хонзонгийн гэм буруу сэдэлтэй гм.
Объектив үнэний гэрч нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх, эх сурвалжийг нууцлан хамгаалах.	Нотлох баримтын эх сурвалж, төрлийг процессийн ажиллагаа явуулж байгаа албан тушаалтан урьдчилан дүгнэлт гарган хайрцаглаж болохгүй. Зөвхөн хуульд заасан арга хэрэгслээр олж авах, хамгаалах стандарт хангагдсан эсэхэд үнэлэлт өгөх эрхтэй.
Х о х и р с о н , холбогдсон аль ч тал үнэнийг нотлох, өөрсдийн эрхээ хамгаалах боломжоор хангах.	Талууд үнэнийг нотлохын тулд адил тэгш эрх хуулиар олгогдсон байх хэрэгтэй болно. Аль нэг талын давуу эрх нь “объектив үнэн”-ийг тогтоох боломжийг алдагдуулна.
Я л л а г д а г ч а а р татахаас өмнө хэргийг бүхэлд нь баримтжуулж процессийн аль ч шатанд хүний эрх зөрчихөөс у р ь д ч и л а н сэргийлэх.	С э ж и г т н и й г яллагдагчаар татахаас өмнө урьдчилан хорьж мөрдөн шалгах ажиллагаа явуулах, таслан сэргийлэх арга хэмжээ авах нь эрүүгийн процесс болон хүний эрхийг зөрчих шалтгаан болно. <sup>1</sup>

<sup>4</sup><http://www.eagle.mn/content/read/25858.htm>

<sup>5</sup>Үндэсний статистикийн хороо, 2014 оны нийгэм, эдийн засгийн статистик

<sup>6</sup>Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар 2014 оны эхний хагас жилд хянагдсан эрүүгийн хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон тогтоол, магадлалыг судалсан тухай (тойм)



### Буруутныг тогтоохоор туйлширсан ажиллагааны алдаа дутагдал

Буруутныг олоход чиглэсэн эрүүгийн процесс нь хүний эрхийн томоохон зөрчил бий болгоно. Учир нь процесс хэрэгжүүлэгч сэжигтэн, яллагдагчийн гараас атгасан бол тавихыг хүсэхгүй. Хэргийн бусад баримтаас илүү түүнийг хэрэг хүлээлгэхэд чиглэсэн мэдүүлгийг авна, гэрч хохирогчийн мэдүүлгээс улбаалан мөрдлөгийг явуулна.

Харин хуулийн дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардах эрхгүй.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлд дурьдсанаар өнөөдрийн практикт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэх үүрэг бүхий гүйцэтгэх ажилтан, шүүх хуралдаанд улсын яллагчийн чиг үүргийг хэрэгжүүлэгч прокурор, баривчлах, цагдан хорих байр, хорих ангийн ажилтнууд өөрсдөө болон бусдаар дамжуулан эрүү шүүлт тулгасан тохиолдол гарч байна.<sup>7</sup>

Улсын хэмжээнд 2014 онд Шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр сэжигтнийг баривчлах тухай 869 санал хүлээн авснаас 814 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 55 сэжигтэнд зөвшөөрөл олгохоос татгалзаж шийдвэрлэсэн байна.

Буруутныг тогтоохоор туйлширсан ажиллагаа нь тухайн сэжигтнийг хорьж, баривчлах арга тактикийг практикт бий болгодог. Жишээ нь: Улсын хэмжээнд 2014 онд Шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр сэжигтнийг баривчлах тухай 869 санал хүлээн авснаас 814 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 55 сэжигтэнд зөвшөөрөл олгохоос татгалзаж шийдвэрлэсэн байна.<sup>8</sup>

Шүүхээс баривчлахаас татгалзсан нийт 55 сэжигтнээс 14.5 хувийг гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай баримтгүй, 47.2 хувийг баривчлах үндэслэлгүй, 25.4 хувийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58 дугаар зүйлийг зөрчсөн гэсэн үндэслэлээр тус тус татгалзжээ.

Буруутныг тогтоохоор туйлширсан ажиллагаа нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан яллах болон цагаатгах нотлох баримтыг цуглуулах замаар хэргийг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар шаардлагатай бүх арга хэмжээ авах, ял оногдуулах зарчимд үл нийцдэг.

Учир нь энэ ажиллагааны явцад хэрэгт <sup>7</sup> Хүний эрхийн Үндэсний комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын 14 дэх илтгэл, 2014, 6 дахь тал

<sup>8</sup> Шүүн таслах ажиллагааны 2014 оны тайлан

ач холбогдол бүхий цагаатгах баримтууд цугларах боломжгүй. Тухайлбал, манай улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар нотлох баримт цуглуулах, үнэлэх эрх гагцхүү мөрдөгч, шүүгч, прокурорт төвлөрч, талууд эрх тэгш байх зарчим хангагдахад нэн хүндрэл үүссээр байна.

Үйл явдлыг тогтоох арга	Буруутныг тогтоох арга
Цогцос, тээврийн хэрэгсэл, орон байр, эд зүйлд үзлэг, нэгжлэг хийх	Тайлбар мэдүүлэг авах, байцаах
Шүүхийн шинжилгээ, туршилт	Таньж олуулах
Эд зүйл, баримт бичгийг хураан авах, битүүмжлэх	Н ү ү р э л д ү ү л ж байцаах
Бичиг баримт, мэдээлэл гаргуулан авах	Мэдүүлгийг газар дээр нь шалгах
Гүйцэтгэх ажлын хяналт, нууц мөрдөн шалгах ажиллагаа	Баривчлах, хорих
Үйл явдлыг баримтжуулсны эцэст буруутныг тогтоох эрүүгийн процесс	Буруутныг мөрдөх замаар үйл явдлыг тогтоох эрүүгийн процесс

Орчин үеийн чиг хандлагыг судалж үзвэл үйл явдлыг тогтоох аргыг чухалчилсан эрүүгийн процессийн арга нь буруутныг тогтоох аргаас ялгаатай төдийгүй, нотлох баримт цуглуулах, хадгалах ажиллагаа техник, тоног төхөөрөмжийн хөгжилд тулгуурласан, түүнийг нь шүүх үнэлж шийдвэр гаргах практик тогтсон байна.

Жишээ нь японы цагдаагийн мөрдөгчид авто ослын гэмт хэргийн газар rison 50 аппарат ашиглан 3 хэмжээст зураг авч дүн шинжилгээ хийснийг прокурор хэрэгт авч, шүүгч тухайн баримтад үндэслэн шийдвэрээ гаргаж байна.<sup>9</sup> Энэ бол үйл явдлыг тогтоох зорилготой нягт уялдсан эрүүгийн процессийн арга, түүний үнэлэмжийн тод жишээ юм.

Манайд нотлох баримт цуглуулах, шинжлэх лаборатори, тоног төхөөрөмж хангалтгүй байгаа явдал нь үйл явдлыг тогтооход чиглэсэн мөрдөх ажиллагааг хөгжүүлэх боломжийг алдагдуулж байна.

#### Үйл явдлыг тогтоох аргыг хуульчилах:

Эрүүгийн процесст шаардлагатай мэдээллийг цуглуулах зорилгоор тайлбар авах, үзлэг, нэгжлэг хийх, бичиг баримт гаргуулан авах, шинжилгээ хийлгэх, эд хөрөнгө битүүмжлэх, харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах аргуудыг шинээр боловсруулах Эрүүгийн процессийн хуулийн төсөлд дараах байдлаар тусгах нь

<sup>9</sup> Япон Улсын Чича Мужийн цагдаагийн байгууллагын зам тээврийн хэрэг мөрдөн шалгах багийн туршлагыг судалсан тэмдэглэл, 2013 он



ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

“Мөрдөгч, прокурор, шүүгч нь хэргийг тал бүрээс нь бүрэн шалгах шалгаж шийдвэрлэхийн тулд дараах үндэслэл бүхий тодорхой ажиллагааг явуулсан байна:

1.Хэрэг гарсан нөхцөл байдлыг тодруулах, эд мөрийн баримтыг олох, хэрэгт ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулах зорилгоор тайлбар гаргагчийн зөвшөөрлөөр түүнээс тайлбар авна.

2.Хэрэг гарсан нөхцөл байдал, хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг тогтоох, тодруулах зорилгоор хүний бие, эд зүйл, бичиг баримт, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, мал, амьтан, хэрэг гарсан газарт үзлэг хийнэ. Үзлэг хийх үед хуульд заасан үндэслэл илэрвэл хэв загвар, дээж авах, битүүмжлэх, хураан авах ажиллагааг явуулна. Үзлэгийг нууцаар явуулж болно.

3.Эд мөрийн баримт, эсхүл сэжигтэн шүүгдэгч нуугдаж байна гэх хангалттай үндэслэл байвал тэдгээрийг олж илрүүлэхээр хүний бие, орон байр, бусад газарт нэгжлэг хийнэ.

4.Хэрэг үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон байж болох, эсхүл мөрдөн шалгах ажиллагаанд ач холбогдолтой эд зүйл, бичиг баримтыг гаргуулах эсхүл хураан авч судална, шаардлагатай бол битүүмжилнэ.

5.Хэрэг үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон байж болох, эсхүл процессийн ажиллагаанд ач холбогдолтой хөрөнгийг нуух, устгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө, санхүүгийн хэрэгсэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэл, банк болон бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлана.

6.Процессийн ажиллагаанд ач холбогдол бүхий мэдээ, баримт байгаа гэх хангалттай үндэслэлтэй бол сүлжээний хэрэглэгч, эзэмшигч хэн болох, байршил, цаг хугацаа, төхөөрөмж болон хандалт зэрэг мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийг гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах, утсан харилцааны сүлжээнд нэвтрэх хяналт тогтооно.<sup>10</sup>

7.Хэрэгт ач холбогдолтой тодорхой нөхцөл байдал, үйл явдлыг сэргээн дүрслэх шаардлагатай бол туршилт хийнэ.

8.Мэдүүлэг авах, нүүрэлдүүлэн мэдүүлэг авах, мэдүүлгийг газар дээр нь шалгах, таньж олуулах ажиллагаа болон баривчлах,

цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг дээр дурьдсан тодорхой ажиллагааны явцад цугларсан нотлох баримтыг үндэслэн явуулна.

#### **Дүгнэлт**

Хуульчдын ур чадвар, процессийн эрх зүй, тактик арга зүйн дутагдлаас шалтгаалж эрүүгийн процесс явуулж нотлох баримт цуглуулах арга “мэдүүлэг”-т суурилсан хэлбэрт шилжлээ. Мэдүүлэг нь хэргийн талаар мэдээлэл олж авах, нуун далдалсан эд зүйлийг газар дээр нь олж авах зэрэг олон талын ач холбогдолтой байдаг боловч мэдүүлгийг хангалттай сайн хийгээгүй тохиолдолд ач холбогдол нь буурдаг.

Прокурорын хяналтад байгаа, шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдийн шийтгэх тогтоолыг түүвэрлэн үзэхэд дийлэнх хувь нь гэрч, хохирогчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, тэмдэглэлээр бэхжүүлэх ажиллагааны явцад цугларсан баримтууд байна.

Эдгээр баримт нь бодит үнэнийг тогтооход ач холбогдолтой боловч хэргийг тал бүрээс нь тогтоож шийдвэрлэх зарчмыг бүрэн дүүрэн хангаж, олон төрлийн нотолгооны аргад суурилсан байна гэж үзэхэд учир дутагдалтай.

Түүнчлэн, мэдүүлэгт хэт төвлөрөн, сэжигтнийг тойрсон мөрдөн шалгах, яллах ажиллагаа эрүүгийн процессийн сайнгүй практик юм. Иймд хэргийн бодит байдлыг таньж мэдэх, улмаар нотлохоос өмнө сэжигтэн, яллагдагчийг тогтоохыг даалгах, шүүгч, прокурор, мөрдөгчийн ажлын үзүүлэлт, амжилтыг хэргийг шийдвэрлэсэн байдлаар үнэлэхээс илүүтэй хэрхэн баримтжуулсан, тал бүрээс нь судалж үзсэн эсэхээр нь дүгнэх хэрэгтэй байна.

Түүнчлэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулж гэмт хэрэгт заавал явуулах тодорхой төрлийн үйл ажиллагааг тухайлан хуульчилж эрүүгийн процессийн хэрэгжилтийг хангах хэрэгтэй байна.

(Footnotes)

<sup>10</sup>Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг, 2014 он

<sup>10</sup>Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийн төсөл, Хууль зүйн яам, 2015 он





## ГЭМТ ХЭРЭГ МӨРДӨХ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГЫН ЗАРИМ АСУУДАЛ

**Я.Цэлмэн**

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх ажиллагааны онол, тактикийн тэнхимийн ахлах багш, докторант, цагдаагийн ахмад

**Товчлол:** Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг зөв тогтоож, нотолж, нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь эрх зүйн шинэчлэлийн хүрээнд заавал хийх ажил юм.

Монгол Улсын тухайд гэмт хэрэг мөрдөх нь хуучин ЗСБНХУ-ын арга зүй, арга тактик, номлолоор хийгдэж ирсэн бөгөөд одоо ч ул мөр нь арилаагүй байна. Дэлхий нийтийн гэмт хэрэгт мөрдөх, түүнтэй тэмцэх чиг хандлага улам шинжлэх ухаанлаг болж байна. Судалгаанаас үзэхэд, Монгол Улсад гэмт хэрэг илрүүлэх үндсэн арга нь байцаалт байгаа нь орчин үеийн чиг хандлагад нийцэхгүй болсон. Гэмт хэрэг мөрдөх талаар бид хүний хүчинд суурилсан чиг хандлагаа өөрчилж шинжлэх ухаан, техникийн дэвшлийг нэвтрүүлж, хэрэглэж хэвших шаардлагатай байна. Өндөр хөгжсөн орнуудад хүний эрхийн баримжаатай мөрдлөг явуулахыг шаардаж хууль тогтоомж, эрх зүйн тогтолцоондоо суулгаж байгаа нь үр дүнд хүрсээр байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Солонгос Улс гэмт хэрэг мөрдөх үйл ажиллагаандаа нэвтрүүлж, тодорхой үр дүнд хүрч буй зарим чиг хандлага, үйл ажиллагааны талаар авч үзсэн. Үүнд:

- 1.Хэргийн газрын үзлэг;
- 2.ДНК /DNA/ гэмт хэрэг илрүүлэх, мөрдөхөд ашиглах;
- 3.Дижитал шинжилгээ, мөрдөн шалгах ажиллагаа.

### 1.Хэргийн газрын үзлэг

Манай улсад хэргийн газрын үзлэгийг мөрдөн байцаагч удирдан явуулахаар холбогдох хуульд заасан бөгөөд цаг хугацаа ихээр зарцуулан хэргийн газрын үзлэгийг тоочин бичих аргаар явуулдаг. Бид хэргийн газрын үзлэг гэдгийг мөрдөн байцаагчийн

хийх ёстой тоочин бичих ажил гэж эндүү ташаа ойлгон ирсэнд асуудал нь байгаа юм. Орчин үед хэргийн газрын үзлэг нь цэвэр мэргэжлийн шинжээч нарын ажлын талбар болсон бөгөөд мөрдөгчийн үүрэг нь хэргийн газрын үзлэгийг тоочин бичих аргаар хийх биш, нотлох баримтыг цуглуулж бэхжүүлэх биш, харин хэргийн газрын нөхцөл байдалтай биечлэн танилцаж, гэмт хэрэг хэрхэн үйлдэгдсэн байж болох төсөөлөлтэй болж, үүн дээрээ үндэслэн мөрдөн байцаалтын дараагийн шатны ажиллагааг хэрхэн явуулах вэ гэдгийг зохион байгуулах үйл ажиллагаа юм. Тэгвэл хэргийн газар хэн ажиллах ёстой вэ гэсэн асуулт урган гарч байна. Хэргийн газар тал бүрийн мэргэжлийн шинжээчдийн баг ажиллах ёстой. Хэргийн газар нь гэмт хэрэгтний ул мөр үлдсэн байж болох хамгийн өндөр магадлалтай орчин юм. Гар хурууны хээ, хөлийн мөр, биологийн мөр зэргээс гадна хүний нүдэнд харагдахгүй бичил мөрүүд хүртэл үлдсэн байдаг тул үүнийг илрүүлэх, цуглуулах, бэхжүүлэх, шалгах ажиллагаа бол цэвэр шинжээчдийн ажил юм.

Шинжээчдийн баг нь дараах төрөлтэй байж болно. Үүнд:

- 1.Хэргийн газрын үзлэг хийх баг
- 2.Хэргийн газрыг нөхөн сэргээх баг
- 3.Туршилт хийх баг
- 4.Илэрсэн мөр бүр дээр ажиллах, шинжилгээ хийх мэргэжлийн шинжээч.

Манай мөрдөн байцаалтын практикт хэргийн газарт зөвхөн криминалистикийн шинжээч ажиллаж байгаа нь туйлын учир дутагдалтай. Тэд ил харагдах мөр дээр ажиллах бөгөөд, хэргийн газрын зураг авахаар үйл ажиллагаа, техник технологийн боломж нь хязгаарлагддаг. Энэ нь гэмт хэрэгтний бусад олон төрлийн мөрийг бэхжүүлэн авч чадахгүй байдалд хүргэдэг. Хүний амь нас хохирсон хэрэгт криминалистикийн шинжээчээс гадна шинжээч эмч оролцож байна. Энэ хоёр хүнээр шинжээчдийн баг хязгаарлагдаж байна.

Тэгвэл БНСУ-д гэмт хэргийн газрын үзлэг хийж байгаа шинжээчдийн баг нь дүрс бичлэгийн шинжээч, бичиг баримтын шинжээч, ДНК шинжээч, шүүх эмнэлгийн шинжээч, сэтгэл зүйн шинжээч, дижитал нотлох баримтын шинжээч, биологийн, химийн, физикийн шинжээч гэх мэт бүрэлдэхүүнтэй ажиллаж байх бөгөөд хэрвээ хэргийн газрыг зориудаар балласан, нотлох баримтыг устгасан бол хэргийн газрыг нөхөн сэргээх шинжээчдийн баг эхэлж ажилладаг байна.

### 2.ДНК шинжилгээ.

Манай улсад “Генетикийн мэдээллийн”





буюу ДНК шинжилгээ нь харьцангуй шинэ төрлийн шинжилгээ юм. Бидэнд ДНК мэдээллийн сан байгуулах эрх зүйн орчин өнөөдөр дутмаг байгаа нь энэ төрлийн шинжилгээгээр гэмт хэргийг илрүүлэх мөрдөхөд саад болж байна.

Шүүхийн шинжилгээний практикт дэлхийн улс орнуудын ашиглаж байгаа “Генетикийн мэдээллийн сан” /ДНХ мэдээллийн сан ч гэдэг/ гэдэг нь хүний эс дэх 23 хос хромсом дээр байрладаг 13-15 локусын аллелийг бүрдүүлэгч нуклеотидийн дарааллыг тогтоосон үр дүнг хэлдэг. Хувь хүнийг ДНХ-ийн шинжилгээгээр адилтган харьцуулах шинжлэх ухааны энэ ололт амжилт, арга технологийг АНУ, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн вант улс, ХБНГУ, Франц, Канад зэрэг өндөр хөгжилтэй улсууд шүүхийн шинжилгээний практикт гэмт хэргийг илрүүлэхэд ашиглаад 15 гаруй жил болж байна.<sup>1</sup>

Хүний бие 60 орчим их наяд эсээс бүрддэг бөгөөд бүх эсэд ДНК агуулагддаг ба бүгд ижил байдаг. ДНК нь нүдэнд харагдахгүй хэдий ч хэргийн газар ихэвчлэн үлддэг онцлогтой. Нэг эсийн хоёр ихэрээс бусад хүний ДНК өөр байдаг.

ДНК шинжилгээ нь дараах үе шаттай. Үүнд:  
1.Эзэн холбогдогч нь тогтоогдоогийн хэргийн газраас ДНК илрүүлэх

2.2 дахь шатны ДНК тогтоох шинжилгээ  
ДНК шинжилгээг хийхэд: а. ДНК илрүүлэх, б. ДНК дээжийг ялгаж авах, в. PCR<sup>2</sup> ашиглан томруулах, г. ДНК мэдээллийг шинжлэх гэсэн дарааллаар явагддаг. Эцэст нь шинжилгээний нэр болон генетикийн үзүүлэлтийг тоогоор илэрхийлнэ.

ДНК шинжилгээ нь дараах ач холбогдолтой. Үүнд:

-ДНК мэдээллийн санг бүрдүүлэх  
-Илрээгүй гэмт хэрэгтнийг илрүүлэх. / Жишээ: БНСУ-ын ДНК шинжээч нь онц хүнд хүн амины гэмт хэргийг сэжигтний идсэн жимсний хальснаас илрүүлсэн ДНК шинжлэн илрүүлсэн байна. Үүнээс энэ төрлийн шинжилгээ нь гэмт хэргийг илрүүлэхэд ихээхэн түлхэц өгнө гэдэг нь харагдана./

-Цуврал аллагыг илрүүлэх  
-Томоохон ослоос хохирогч нарыг тогтоох  
-Төрөл төрөгсдийг тогтоох  
-Зам тээврийн гэмт хэрэг мөрдөх

БНСУ-д ДНК мэдээллийн санг ашиглан гэмт хэргийн үзүүлэлтийг 2010.7.26-2015.3

<sup>1</sup>Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс. Шүүхийн шинжилгээний практикт “Генийн мэдээллийн санг” ашиглаж гэмт хэргийг илрүүлж буй гадаадын зарим улс орны туршлага, эрх зүйн орчин (Харьцуулсан судалгаа), 2013. УБ

<sup>2</sup>PCR-Polymerase Chain Reaction гэсэн үг. Полимеразын гинжин урвал гэсэн утгатай бөгөөд ДНК-ийн жижиг хэсгийг судалгааны материал дотроос илрүүлэх техник.

дугаар сар хүртэлх хугацаанд авч үзвэл<sup>3</sup>:

-Хулгайлах: 1003

-Хүчиндэх: 248

-Дээрэмдэх, танхайрах: 53

-Хүнийг санаатай алах: 5

-Бусад: 203

Энэ үзүүлэлт нь Монгол шиг цөөхөн хүн амтай улсад бол ДНК шинжилгээг хийх, ДНК мэдээллийн сантай болох нь гэмт хэргийн илрүүлэлтийг даруй олон хувь өсгөх боломжтойг харуулж байна.

Дэлхий дээр өнөөдрийн байдлаар 50 гаруй улсад 5 сая орчим гэмт хэрэгтний ДНК мэдээллийн санд төвлөрүүлсэн байна<sup>4</sup>.

### 3. Дижитал шинжилгээ, мөрдөн шалгах ажиллагаа

Шинжлэх ухаан хөгжихийн хэрээр гэмт хэрэгтэй тэмцэх арга, технологи ч хөгжиж байна. Үүний нэг нь дижитал шүүхийн шинжилгээ, дижитал мөрдөх ажиллагаа юм. Орчин цагт дижитал төхөөрөмж, технологийг ашигладаггүй хүн бараг үгүй болсон байна. Дижитал тоног төхөөрөмжинд хувийн суурин цахим тооцоолуураас гадна, зөөврийн нөүтбүүк, гар утас, зөөврийн хатуу диск, флаш зэрэг бүх төрлийн мэдээлэл агуулагч орчин үеийн техник технологиуд ордог.

БНСУ-д дижитал шинжилгээний хэлтэс нь 2015 онд байгуулагдсан бөгөөд 1995 оноос суурь нь тавигдсан байна.

Дижитал шинжилгээ гэдэг нь компьютер болон бусад төрлийн дижитал тоног төхөөрөмжөөс өндөр технологийн тусламжтайгаар дижитал мэдээллийг цуглуулан шинжилгээ хийснээр эд мөрийн баримт олдог бүх төрлийн ажиллагааг хэлдэг<sup>5</sup>.

Дижитал эд мөрийн баримт нь дараах онцлогтой:

1.Нууц, далд байдалтай оршдог.

2.Их хэмжээтэй.

3.Өөрчлөгдөж хувирах сул талтай.

4.Сүлжээний орчинд ажиллаж болох тул байр зүйн бэрхшээлгүй.

Дижитал шинжилгээ, мөрдөн шаогах ажиллагаа нь БНСУ-д 2010-2014 онд нийт мөрдөн шалгах ажиллагааны 34 хувийг

<sup>3</sup>Joo, Mhen-Chel, Prosecutor, Korean Institute of Justice / Capacity Building For Managerial Level Officers of Law Enforcement University, Mongolia/

<sup>4</sup>Lee, Seung hwang, Chief of DNA analysis lab, DNA forensic div, Korean Institute of Justice /Capacity Building For Managerial Level Officers of Law Enforcement University, Mongolia/

<sup>5</sup>Ян, Сог Жу, БНСУ-ын ПЕГ-ын дижитал мөрдөн шалгах хэлтсийн дарга, “Дижитал мөрдөн шалгах ажиллагааны өнөөгийн байдал ба алсын хараа” Korean Institute of Justice /Capacity Building For Managerial Level Officers of Law Enforcement University, Mongolia/



эзлэх хүртэл өссөн байна. Мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлж дижитал нотлох баримтыг шилжүүлэх, цагдаа, прокурор зэргийг холбосон "DFIS" системийг нэвтрүүлсэн бөгөөд дижитал эд мөрийн баримтад цогц дүн шинжилгээ хийх "DFAS v2.0" системийг ашиглаж байна.

Эд мөрийн баримтын өргөтгөлөөс нь хамааран дараах шинжилгээг хийж байна.

-Файл

-Имэйл

-Цахим шийдвэр

-Санхүү, дансны бүртгэл

-Мобайл-ярианы жагсаалт гэх мэт.

Дижитал шинжилгээ нь эд мөрийн баримтыг илрүүлэх, хураах, хадгалах, мэдээллийг шинжлэх, сэргээх, дүн шинжилгээ хийх гэсэн үндсэн үүрэгтэй. Үүнээс онцолвол ярианы шинжилгээ хийгч, дансны шинжилгээ хийгч программ хангамжууд нь гэмт хэргийн бүлгийг болон түүний зохион байгуулагчийг олж тогтоох, сүлжээний болон бусад дансны аргаар үйлдэгддэг банк санхүүгийн болон, аж ахуйн нэгж байгууллагын татвараас зугтах хэрүүдийг илрүүлэхэд өндөр үр нөлөөтэй ажилладаг байна.

Энэ нь манай улсад ашиглахад өндөр үр дүнтэй шинжилгээ байх бөгөөд олон улсыг дамнасан гэмт хэргийг илрүүлэхэд мөн үр нөлөөтэй гэж хэлж болно.

### **Дүгнэлт**

Дэлхий нийтээр гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, нотлох үйл ажиллагаанд хүний эрхийн чиг баримжаатай, орчин үеийн шинжлэх ухаан, техник технологийн олтыг түлхүү нэвтрүүлж ашиглах чиг хандлагатай болсон байна.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлаас шалтгаалан жил ирэх гэмт хэргийн гаралт өсөж, түүний илрүүлэлт буурсаар байна. Бид олон жил эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэж ирсэн боловч энэ нь хүний хүчинд суурилсаар ирсэнийг үгүйсгэх аргагүй. Одоогийн эрх зүйн орчин ч цаг үеэсээ хоцроод байгаа болох нь эрдэмтэн, судлаачдын бүтээлээс харагддаг.

Өндөр хөгжилтэй улс орнуудын тэргүүн туршлагаас шууд нэврүүлэх боломж бидэнд байгаа ч улс орны эдийн засгийн байдлаас шалтгаалж бидэнд хөрөнгө мөнгөний хүндрэл үргэлж учирч байгааг ч нуух аргагүй. Гэхдээ хийх хүн арга олдог гэдэг шиг бид дотоод зохион байгуулалтаа өөрчилж, ойрын сайн хөршүүдийнхээ тэргүүн туршлагаас тэдний тусламжтайгаар нэвтрүүлж хэрэгжүүлэх боломж байна.

### **Санал**

1.Хэргийн газрын үзлэгийн үр нөлөөг

дээшлүүлэхийн тулд шинжилгээний багийг хэргийн газарт ажиллуулдаг болох;

2.Мөрдөгч, шинжээч нараа мэргэшүүлэн сургах;

3.ДНК шинжилгээг явуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинжээч нарыг орчин үеийн техник технологиор хангах;

4.Мөрдөх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх дижитал шинжилгээний хэлтсийг байгуулах;

5.Мөрдөх ажиллагаанд орчин үеийн шинжлэх ухаан, техник технологийн ололтыг түлхүү ашиглах ажлыг эрчимжүүлэх;

6.Мөрдөх чиг үүрэг бүхий албан хаагчдын ажлын ачааллыг зөв тооцоолох.



## ХЭРГИЙН МАТЕРИАЛААР ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХЭД АНХААРАХ АСУУДАЛ

**С.Аюушбаатар**

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Шинжлэн  
магадлахуйн тэнхимийн ахлах багш

**Товч агуулга:** Хэргийн материалаар шүүх эмнэлгийн шинжилгээ хийж, шийдвэрлэх асуудал олон байдаг. Үүний тулд шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулахаар ирүүлж буй хэргийн материалд ямар баримт бичгүүдийг бүрдүүлж хавсаргах, шинжилгээ хэрхэн явагддаг талаар мэдээлэл өгөх зорьсон.

**Түлхүүр үг:** Эмнэлгийн баримт бичиг, шүүх шинжилгээ, хэргийн материал

Шинээр нөхцөл байдал илэрсэн, иргэдийн өргөдөл, гомдол ихэссэн зэрэг шалтгаанаар шүүх эмнэлэгт хэргийн материалаар шинжилгээ хийлгэх нь жилээс жилд өссөөр байгаа нь Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлгийн улсын хэмжээний статистик тоо баримтаас харагдаж байна.

Цогцсыг чандарласан, хэргийн нотлох баримт устсан, сэжигтэн холбогдогч этгээд алга болсноор цогцос, амьд хүн, эд мөрийн баримтыг шинжлэх боломжгүй болсон, урьд гаргасан гаргасан дүгнэлт эргэлзээтэй байх, эмч, эмнэлгийн ажилчдын үйл ажиллагаатай холбоотой хэрэг зэрэг тохиолдолд хэргийн материалаар шүүх эмнэлгийн шинжилгээ хийдэг.

Хэргийн материалаар шүүх эмнэлгийн шинжилгээ хийх арга нь цогцос шинжлэх, хүн үзэж шинжлэх, эд мөрийн баримт шинжлэх аргуудаас зарчмын хувьд ялгаа байдаггүй.

Шинжилгээгээр ихэвчлэн үхэлд хүргэсэн шалтгаан /гэмтлийн болон бусад шалтгаант эсэх/, талийгаач нас барахын өмнө үйлдэл хөдөлгөөн хийж чадах эсэх, эрүүл мэндийн хохирлын зэрэг буюу гэмтлийн зэрэг тогтоох, талийгаач амь насаа алдах, эрүүл мэндийн хохиролд хүрэхэд эмч, эмнэлгийн ажилчдын мэргэжлийн үйл

ажиллагааны алдаа дутагдал байгаа эсэх зэргийг тогтооно.

Хэргийн материалаар шүүх эмнэлгийн шинжилгээг анхдагч, нэмэлт, давтан хэлбэрээр шинжээч дангаар буюу хамтарсан, хавсарсан бүрэлдэхүүнтэйгээр шинжээчид тавигдсан асуултад хариулах байдлаар хийнэ.

Шинжилгээ хийлгэхэд хэргийн материалд зайлшгүй хавсаргах баримтууд:

- Хэргийн газрын үзлэг, хэргийн газарт цогцост үзлэг хийсэн тэмдэглэл;
- Өмнө нь хийгдсэн бүх шүүх эмнэлгийн шинжилгээний дүгнэлт;
- Эмгэг анатомийн шинжилгээний протокол;
- Өвчний түүх, амбулаториор эмчлүүлэгчийн карт;

- Клиник конференцийн протокол;
- Мэргэжлийн салбар зөвлөлийн дүгнэлт;
- Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт;

- Шинжээчийг гэрчээр байцаасан тэмдэглэл;
- Холбогдох мөрдөн байцаалтын туршилт, судалгааны үр дүн, бусад мөрдөн байцаалтын мэдээллээс багтаана.

Шүүх эмнэлгийн шинжилгээг хэргийн материалаар хийхдээ тухайн хэрэгт хавсаргасан эмнэлгийн бичиг баримтуудыг шинжлэх үйл явцаар эхэлдэг.

Эмнэлгийн бичиг баримтад: Өвчний түүх, амбулаториор эмчлүүлэгчийн карт, эмнэлгийн магадлагаа, эмнэл зүйн онош тодруулахаар хийгдсэн шинжилгээний хариу бичиг дүгнэлт, нас барсан тохиолдолд цогцос шинжилсэн эмгэг анатомийн протокол, шүүх эмнэлгийн шинжилгээ хийсэн бол цогцос анх шинжилсэн бичиг баримт зэрэг хамаарна. Дараа нь мөрдөн байцаалтын ажиллагааны явцад цуглуулсан баримтыг шинжилнэ. Үүнд: Хэргийн газар цогцост үзлэг хийсэн тэмдэглэл, мөн тээврийн хэрэгсэлд үзлэг хийсэн тэмдэглэл, хэргийн газраас биологийн гаралтай эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлж авсан тухай тэмдэглэл, гэрч, хохирогч, холбогдогч нарыг байцаасан тэмдэглэл, бусад криминалистик, инженер-техник, хими, биологийн шинжээчдийн гаргасан дүгнэлт зэрэг орно.

Шинжилгээ хийх бүрэлдэхүүнд орсон бүх шинжээчид нь хэргийн материалтай сайтар танилцан мөрдөн судлах ажиллагаа явуулна гэсэн ойлголт юм. Нөгөөтэйгүүр шинжээчийн тодорхой бус асуудлыг дэвшүүлэн, амьд хүн, цогцос, эд мөрийн баримтад чиглэсэн үйл ажиллагаа юм.

Шинжээч аль болох анхны бичиг баримтын эх хувьтай танилцаж судлах ёстой. Хэрэв дээрх баримтууд хэрэгт хавсрагдаагүй бол шинжээч нь шинжээч томилсон этгээдээс албан ёсоор шаардах эрхтэй. Мөрдөн



байцаагч болон бусад шинжээч томилсон этгээд нь шаардсан баримтыг эхээр нь аль эсвэл албан ёсны баталгаат хуулбар хэлбэрээр шинжээчдэд өгнө. Уг шаардсан баримт нь байхгүй тохиолдолд албан ёсоор байхгүй талаар хариу мэдэгдэнэ.

Хэргийн материалаар шүүх эмнэлгийн шинжилгээг хийхдээ зөвхөн бичиг баримтад тулгуурлахаас гадна, эд эсийн шинжилгээний материал, хувцас хэрэглэл, гэмтэл үүсгэсэн гэх багаж, зэвсэг зэрэг бусад эд мөрийн баримтыг судалснаар хийнэ.

Хэргийн материалаар шүүх эмнэлгийн шинжилгээ хийх шинжээчид тавигдсан асуултууд нь шүүх эмнэлгийн шинжээчдийн тусгай мэдлэгийн хүрээнд тохирсон байх ёстой. Шинжилгээ явуулах хугацаа нь түүнтэй холбоотой эрх зүйн актанд тусгагдсан хугацаагаар зохицуулагдана. Шинжилгээнд судлан шинжлүүлэхээр ирүүлсэн хэргийн материал, эд мөрийн баримтын тоо хэмжээ, хийгдэх лаборатори шинжилгээний явц хамрах хүрээнээс хамаарч, шинжилгээний хугацаа удаашрахаар болбол энэ тухайгаа шинжээч томилсон этгээдэд мэдэгдэх хэрэгтэй. Мөн шинжилгээний явцад нэмэлт материал шаардагдах, шинжээчийн хяналтан дор эмнэлгийн нөхцөлд байлгаж ажиглаж шинжлэх, шарил шинжлэх шаардлага гарвал энэ тухайгаа цаг алдалгүй нэн даруй шинжээч томилсон этгээдэд мэдэгдэх.

Хууль сахиулагч, болон хууль хяналтын байгууллагын албан хаагчид нь хэргийн материалаар шүүх эмнэлгийн шинжилгээ хийх ерөнхий арга, техникийг мэддэг байх шаардлагатай.

•Хамтарсан болон хавсарсан /комисс/ шинжилгээний бүрэлдэхүүнд гурваас доошгүй мэдлэг, дадлага туршлагатай шинжээч эмчийг томилно. Хэрэв анагаах ухааны бусад салбар шинжлэх ухаанаас шинжээч томилох тохиолдолд тэр салбартаа тэргүүлэх мэргэжилтнийг сонгох нь шинжилгээний үр дүнд эерэгээр нөлөөлөх хүчин зүйл болдог.

•Комиссын гишүүдээс нэг нь ахлаж, шинжилгээнийхээ явцыг төлөвлөж, бусад шинжээчдийнхээ үйл ажиллагааг зохицуулж ажиллана.

•Комиссын гишүүн бүр шинжээчид тавигдсан асуултуудтай танилцаж, хэргийн материал түүнийг дагалдаж ирсэн эд мөрийн баримтуудтай биечлэн танилцсан байна.

Ахлаж байгаа шинжээч нь шинжилгээг хэрхэн явуулах төлөвлөгөө гарган, түүндээ хугацааг нарийвчлан тусгаж, бусад шинжээч нарынхаа ажлыг зохицуулан шинжилгээг хийх, тэдгээрээс шинжилгээтэй холбоотой санал дүгнэлтийг цуглуулж авж нэгтгэн шүүх эмнэлгийн акт, дүгнэлтийн ерөнхий загвар

төслийг бэлтгэж ажиллана.

Шүүх эмнэлгийн шинжээч нь шинжилгээг эхлэхдээ хэргийн материал болон түүнийг дагалдаж ирсэн эд мөрийн баримтуудыг хүлээн авч шинжээч томилсон тогтоол дээрх илгээсэн баримтуудтай тулгаж бүртгэх, битүүмжилсэн зүйлийг ахалж байгаа шинжээчийн зөвшөөрөлтэйгээр эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу нээж хүлээж авна.

Шаардлагатай тохиолдолд шинжилгээ хийлгэхээр томилсон этгээдэд хандаж дутуу болон нэмэлт эд мөрийн баримт гаргуулах, зарим нэгэн мөрдөн байцаах ажиллагаа явуулж өгөхийг хүсэх /шарил шинжлэх-эксгумац хийх, хохирогчийг эмнэлэгт хэвтүүлж шинжлэх, давтан буюу оношийг баталгаажуулах эмнэл зүйн шинжилгээнүүд хийх, хохирогч болон урьд нь шинжилгээ хийсэн шинжээчийг асуулгаж зарим нэгэн зүйлийг тодруулах ажиллагаа явуулах/, шинжилгээний хугацааг сунгуулах, зарим нэг шинжлэх ухааны туршилт судалгаа хийхэд шинжилгээнд ирүүлсэн материал устаж үгүй болох эсвэл анхны шинж чанараа алдахаар бол энэ тухайгаа шинжээч томилсон этгээдэд мэдэгдэж зөвшөөрөл авна.

Шинжилгээний байгууллагаас томилогдсон шинжээчид нь шинжилгээ томилсон хугацаанд нь дүгнэлтийг бэлэн болгож, шинжлүүлэхээр ирүүлсэн эд мөрийн баримт, хэргийн материалыг тоо ёсоор нь дагалдах бичгийн хамт шинжээч томилсон этгээдэд хүлээлгэж өгнө.

Хэрвээ шинжилгээнд нэмж ирүүлсэн материал нь дахин шинжилгээнд хүрэлцэхгүй буюу шаардлага хангахгүй бол энэ тухайгаа даруй хүсэлт гаргаж, хохирогч амьд байгаа бол шинжээч томилсон этгээдээр дамжуулан дуудан ирүүлж, эмнэлгийн нөхцөлд шинжлэх, нас барсан тохиолдолд шарил шинжлэх боломжтой эсэх зэрэг асуудлыг шийдэх шаардлагатай.

Шинжээчийн гаргасан хүсэлтийн дагуу нэмэлт материал цуглуулах, мөрдөн байцаалтын туршилт явуулахаар бол шинжээч томилсон этгээд шинжээчдийг татан оролцуулж болно. Хэрэв шинжээч энэ үйл ажиллагаанд оролцсон бол туршилт судалгааны талаар шинжилгээний явц, "дүгнэлт"-д тусгаж өгнө.

Хэргийн материалаар шинжилгээ хийж байгаа шинжээч нь өөрийн санаачилгаар шинжилгээний харьцуулах материал цуглуулах, хохирогч холбогдогчтой биечлэн уулзаж ярилцаж цуглуулсан материал зэрэг нь хууль бус аргаар олсон эд мөрийн баримт гэж үздэг.

Шүүх эмнэлгийн шинжилгээний явцад шинжээч нь хэргийн материал,



шинжилгээний объектийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалтыг бүрэн хариуцах үүрэгтэй. Эд мөрийн баримт объектыг шинжлэх явцад, түүний бүрэн бүтэн байдал алдагдах, анхны шинж байдлаа алдахаар бол энэ талаар шинжээч томилсон этгээдэд мэдэгдэж, зөвшөөрөл авснаар шинжлэн судална. Шинжилгээ хийхийн өмнө фото зураг авах, хэв цутгаж загвар авах, зэрэг бусад аргаар баримтжуулж авна. Цаашид шинжилгээний явц, шинжилгээ хийсэн арга техникийн талаар нэг бүрчлэн бичиж тэмдэглэл хөтөлж фото зураг, бичлэг хийх зэрэг аргаар бэхжүүлнэ. Энэ тухайгаа шинжилгээ хийсэн баримт, дүгнэлтэд тусгаж өгнө.

Шинжилгээ хийгдсний дараа зохих шаардлагын дагуу дүгнэлтийг бичгээр гаргана. Хэргийн материалд хавсаргасан эд мөрийн баримтуудыг судлан шинжилсэн тухай шинжилгээний хэсэгт товч тодорхой бичиж тэмдэглэсэн байх хэрэгтэй. Ишлэл авсан хэсгийнхээ тодорхой нэр, он сар огноо, мөрдөн байцаалт болон шүүх хурлын тэмдэглэл зэргийн хавтас хэрэг дэх хуудас зэргийг тодорхой зааж тэмдэглэл хийнэ. Энэ нь шинжээчид тавигдсан асуултад хариулж, дүгнэлт гаргах чухал үндэслэл нь байдаг.

Дүгнэлт нь бүх асуултад хариулсан, хоорондоо уялдаа холбоотой байхыг шаардана. Энэ нь шинжээч эмч, шинжээчдээс нарийн ур чадварыг шаарддаг. Шинжилгээний явцад асуулт тавигдаагүй, хэрэгт ач холбогдолтой зүйл илэрвэл үндэслэлийг дурдаж, дүгнэлтэнд тусгаж өгч болно.

Хэргийн материалаар шинжилгээ хийлгэх шийдвэр гарган цогцсыг чандарласан, хэргийн нотлох баримт устсан, сэжигтэн холбогдогч этгээд алга болсноор цогцос, амьд хүн, эд мөрийн баримтыг шинжлэх боломжгүй болсон урьд гаргасан дүгнэлт эргэлзээтэй байх, эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнуудтай холбоотой хэрэг зэрэг тохиолдолд хэргийн мөн чанарт тохирсон үндэслэл бүхий асуултуудыг оновчтой сонгож шүүх эмнэлгийн шинжилгээ хийлгэх явдал юм. Шинжилгээг үр дүнтэй явуулж, гарсан дүгнэлт нь үндэслэл бүхий нотлох баримтын хэмжээнд үнэлүүлж, эргэлзээгүй байлгахын тулд холбогдох баримт бичгийг шинжилгээ томилох эрх бүхий этгээд цаг алдалгүй бүрдүүлж өгөх шаардлагатай.



## АВТО ТЕХНИКИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХЭД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

**Ж.Ялалтбаяр**  
ХСИС-ийн докторант

“Гэмт хэрэгтэй тэмцэхэд шүүхийн шинжилгээний байгууллагын үүрэг, хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд илтгэл хэлэлцүүлэх гэж буй зорилго нь: манай улсад тээврийн хэрэгслийн тоо өсч байгаатай уялдан замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг өдрөөс өдөрт нэмэгдэж, хувь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө болон улс нийгэмд учрах хохирол нэмэгдсээр байна. Иймд замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, гэмт хэрэг болон ослын шалтгаан нөхцлийг тогтооход тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлуудыг хөндөж, шийдвэрлэх гарцыг та бүхнээр хэлэлцүүлэхэд оршино.

Шүүхийн шинжилгээний байгуулагад криминалистикийн олон төрлийн шинжилгээнүүдийг хийж, хэргийн учир шалтгаан, эзэн холбогдогчийг тогтоож ирсэн.

1.Криминалистикийн шинжилгээний төрлүүдийг

- Гарын мөр
- Мөр судлал
- Галт зэвсэг
- Бичиг судлал, бичиг техник
- Дүр зургийн
- Дүрс бичлэгийн
- Дуу авиа
- Компьютерийн шинжилгээ
- Авто техник-н гэж ангилна.

Криминалистик шинжилгээ судлал гэдэг нь хүн, байгаль, юмсын аливаа зүй тогтолын сургаалд үндэслэн гэмт үйдлийн мөрөнд оношлогооны ба адилтгалын шинжилгээ хийх онолын үндэс, зарчим хэл, нийтлэг аргачлалыг боловсруулдаг мэдлэгийн цогц<sup>1</sup>. Криминалистикийн шинжилгээ судлалын зүйл нь шинжилгээ хийхэд танин мэдэх зайлшгүй шаардлагатай бодит үнэний зүй тогтол болон гаж тогтолын цогц юм<sup>2</sup>.

•Шинжилгээний онолын үндэс /хүн, байгаль, юмсын аливаа зүй тогтол/

<sup>1</sup> Б.Лхагвасүрэн., Криминалистикийн шинжилгээ судлал, 2010 он., 19 дэх тал

<sup>2</sup>Б.Лхагвасүрэн., Криминалистикийн шинжилгээ судлал.,2010он., 20 дэх тал

- Шинжилгээний зарчим
- Шинжилгээний хэл
- Шинжилгээний нийтлэг аргачлал
- Шинжилгээний субъект
- Шинжилгээний нийтлэг болон тусгай аргачлалд тулгамдаж буй асуудал
- Шинжлэх ухааны ололт амжилт, түүнийг криминалистикийн шинжилгээнд ашиглах боломж.Тэгвэл авто-техникийн шинжилгээ нь криминалистик шинжилгээний 1 төрөл учир дээрх мэдлэгийн цогцыг мөрдлөгөө болгодог.

Криминалистикийн хэл арга зүйн тухай сургаал, криминалистикийн систем түүний ерөнхий онолын элемент болгохыг бид мэдсэн.

Ойлголт ба тодорхойлолт, тэдгээрийн илэрхийлдэг нэр томъёо, тэмдгийн системийг криминалистикийн хэл<sup>3</sup> гэнэ.

Криминалистикийн хэлийг шинжлээд Р.С. Белкин криминалистикийн шинжлэх ухаанд хэрэглэж байгаа тодорхойлолтыг хүрээ өргөжих тутам энэ хэл өөрчлөгдөж буйг тэмдэглээд “криминалистикийн хэл ямар нэгэн онцгой, зөвхөн явцуу хүрээний мэргэжилтнүүд ойлгомжтой, ойлголт нэр томъёоны аппарат биш. Ийм хэл байхгүй байж ч болохгүй. Энд нэгдүгээрт, ахуйн ба бүх шинжлэх ухааны шинжтэй, хоёрдугаарт, криминалистикийн хэлний бүтцэд үйлчилж байгаа ойлголтын системийн тухай өгүүлж байна.

Тэгвэл техникийн шинжлэх ухаан нь үндэс болж байдаг нотлох баримт цуглуулах, шинжлэх, ашиглах болон гэмт хэрэг илрүүлэх урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулагдсан авто техникийн хэрэгсэл, арга барил, арга зүйн системийг авто техник<sup>4</sup> гэж нэрлэж болно..

Өнөө үед бидний өмнө боловсронгуй болгож, сайжруулах шинжилгээнүүдийн 1 нь авто техникийн шинжилгээ юм.

Урьд өмнө авто техникийн шинжилгээг тусгай мэдлэг эзэмшсэн мэргэжилтнүүд буюу ЗЦГ, Механик инженерийн сургууль, ТИС, БХДС, ХААИС-н инженер техникчид хийдэг байсан. Шүүхийн шинжилгээний байгууллагад авто техникийн шинжилгээг ул мөр илрүүлэх, бэхжүүлэх, шинжлэх зорилгоор мөр судлалын лабораторид хийж ирсэн. Энэ шинжилгээг хийхэд криминалистикийн шинжээчдээс гадна авто-техникийн инженерүүд, мэргэжилтэнүүдийн тусгай мэдлэг шаардагддаг.

2013 оны 8-р сард ШШҮХ-нд бусад шинжилгээ, судалгаа хийдэг лабораторуудын

<sup>3</sup> Р.С.Белкин., Курс советской криминалистики.,Б. И.М.,1978.,178 дахь тал

<sup>4</sup> Ж.Хурцгэрэл., Криминалистик I., 2002 он., 28 дах тал





нэгэн адил авто-техникийн шинжилгээний лаборатори байгуулснаар дараахь асуудлуудыг шийдвэрлэх шинжилгээнүүд хийж байна.

-Зам тээврийн осол гарах үеийн нөхцөл байдалд дүгнэлт хийх,

-Тээврийн хэрэгслийн болон эд ангийн эвдрэл, бүрэн бүтэн байдал, оношлогооны шинжилгээ хийх

-Авто замын болон техник хэрэгсэл дэх мөр судлалын шинжилгээнүүд хийгдэж байна.

Одоогоор авто техникийн шинжилгээний лаборатори нь лабораторийн эрхлэгч 1, ахлах шинжээч 1, автын инженер буюу техникийн шинжээч 2 гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Шүүхийн шинжилгээний тухай хуулинд "шүүхийн шинжилгээ" гэж эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид заасан тусгай мэдлэг шаардсан асуудал /шинжлэх ухаан, техник, урлаг, соёл, нягтлан бодох бүртгэл зэрэг/-ыг шийдвэрлэхийн тулд шинжилгээний объектод шинжилгээ хийж дүгнэлт гаргах ажиллагаа гэж заасан.

Авто техникийн шинжилгээ нь хавсарсан буюу иж бүрэн шинжилгээний ойлголт юм.

-Ослын үед авто замын нөхцөл байдал, техник , эд ангийн эвдрэлээс үүдсэн шалтгааныг тогтоох

-Ослын явцад эдгээр объектын гадаргууд шинээр бий болсон мөрний шинж чанар, гарал үүсэл, чиглэл гэх мэтийг тогтоох гэсэн 2 өөр тусгай мэдлэгийг ашиглан шинжээчийн дүгнэлт гаргадаг.

Комплексная экспертиза буюу иж бүрэн /цогц/ шинжилгээ нь өөр өөр төрлийн тусгай мэдлэг эзэмшсэн шинжээчдийн гаргасан,эцсийн үр дүн нь нэгдмэл нэг зорилгод чиглэгдсэн шинжилгээ юм.<sup>5</sup>

Авто техникийн иж бүрэн шинжилгээнд мөн мөр судлал /үүссэн мөрүүдийн гадаад шинж чанар/, биологи /хохирогч, холбогдогчийн цусны бүлэг тогтоох/, химийн /согтолтын зэрэг тогтоох/, физик /автомашинь будгийн найрлага тогтоох/, шүүх эмнэлгийн /хохирогч холбогдогчийн гэмтлийн зэрэг тогтоох, задлан шинжилгээ/ гэх мэт хавсарсан шинжилгээнүүдийг хийж хэргийн хувь заяа шийдэх ажиллагаа мөн.

Криминалистикийн хэлтэст зам тээврийн осол-хэргийн, мөр судлалын гэсэн хавсарсан шинжилгээ хийгддэг.

Тээврийн хэрэгслийн мөр судлалын шинжилгээ:

- Явагч хэсгийн мөрний
- Түрж байрласан хэсгийн мөрний
- Мөр эд зүйлийн
- Мөр бодисын

Тээврийн трасологи буюу транспортоскопи Төрөл бүрийн тээврийн хэрэгсэл, түүний эд ангиудаас үүссэн мөр судалдаг криминалистикийн хэсэг.

Явагч хэсэгтэй бүх төрлийн тээвэрлэгч механизмыг криминалистикт тээврийн хэрэгсэл гэж ойлгоно. Агаарын, төмөр замын, усан замын тээврийн хэрэгсэл, криминалистикийн шинжилгээний объект болох явдал байдаг ч газраар явагч тээврийн хэрэгслийн мөрөнд тээврийн трасологи голлон анхаарал хандуулдаг.

Тээврийн хэрэгслийн мөр – Гэмт үйлдлийн улмаас тээврийн хэрэгслийн явагч, явагч бус эд ангиас үүссэн, эсвэл харилцан үйлчлэлийн нөлөөгөөр тухайн тээврийн хэрэгсэл дээр үүссэн мөр дүрс , мөр эд зүйл, мөр бодис.

Тээврийн хэрэгсэл нь гэмт халдлагын зүйл байх, гэмт хэрэг үйлдэх хэрэгсэл болох явдал бий. Тээврийн хэрэгслийн мөр судлал нь зам тээврийн гэмт хэрэг илрүүлэхэд чухал нөлөөтэй.

Тээврийн хэрэгслийн мөрний ангилал

Явагч хэсгийн мөр дүрс: Дугуйт, гинжит, тээврийн хэрэгсэл, ердийн хөсөг, чарганы явагч хэсгээс дүрслэгдэж бий болох бөгөөд энэ мөр нь хөдөлгөөн дунд, эсвэл зогсож байхад үүсэж болно.

Түрж байрласан хэсгийн мөр дүрс: тээврийн хэрэгслийн нүүрвэч, хаалт, тэвш, зэрэг харьцангуй илүү түрж байрласан эд ангиаудаас мөргөлт, шүргэлтийн үйлчлэлээр хохирогчийн биед болон бусад объектод үүсэх мөр.

Мөр эд зүйл: зам тээврийн гэмт хэргийн үед тээврийн хэрэглээс салж унасан эд анги, түүний хэсэг.

Мөр бодис: Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дунд, эсвэл зогсож байхад асгарч, дууссан, арчигдсан шатах, тослох, хөргөөх, шахах, материалын үлдэц.

Харилцан үйлчлэлийн мөр: Замын байгууламж, бусад объектыг мөргөж, шүргэсэний улмаас тээврийн хэрэгслийн эд ангийн гадаргуйд үүссэн мөр дүрс, мөр бодис<sup>6</sup>.

Доктор, профессор Р.С.Белкин: "Шүүхийн шинжилгээний зүйл нь биет зүйл, бодит үйлдэл юм. Эдгээр баримт бичиг, хүн, амьтан, цогцос, тээврийн хэрэгсэл тэдгээрийн үйлдлийн улмаас үүссэн мөр хамаарна"<sup>7</sup> гэжээ.

Монгол улсад 2013 оны байдлаар 6 Б.Батэрдэнэ., Криминалистик 2003 он., 60 дахь тал

7 Р.С.Белкин., Курс советской криминалистики.,Б.И.М.,2001.,459 дахь тал

<sup>5</sup> Ст 81 УПК



автомашин болон тээврийн хэрэгслийн тоо, гарч байгаа ослын шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйл, хохирлыг статистик үзүүлэлтээр үзүүлбэл:

Улсын хэмжээнд тээврийн хэрэгслийн ослын өсөлт

Манай улсад тээврийн хэрэгслийн тоо жилээс жилд өсч байна. 2013 оны байдлаар 620661 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна. Тээврийн хэрэгслийн өсөлтийг сүүлийн 10 жилийн байдлаар харьцуулбал:



	2012	2013	ӨСӨЛТ БУУРАЛТ
Суудлын	354383	433382	↑ 22.2%
Ачааны	106711	151530	↑ 42.0%
Автобус	9285	5992	↓ -35.4%
Механизм	6654	8468	↑ 24.3%
Тусгай	18416	18726	↑ 1.6%
Мотоцикл	24339	25571	↑ 5.0%
Чиргүүл	19105	20385	↑ 6.6%
Бусад	15528	11010	↓ -29.0%
<b>БҮГД</b>	<b>554577</b>	<b>675064</b>	<b>↑ 21.7%</b>


2012 оны тээврийн хэрэгслийг 2013 оныхтой харьцуулж үзэхэд 21,7%-иар өссөн байна.

“Зам тээврийн осол- зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие,эрүүл мэнд хохирох,тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх,ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдал»<sup>8</sup> гэж Монгол улсын замын хөдөлгөөний дүрэмд тодорхойлсон байдаг. Улсын хэмжээнд 2013 онд тээврийн ослын холбогдолтой 90721 дуудлага хүлээн авч,18367 зам тээврийн ослыг бүртгэн авсан байна.Зам тээврийн ослыг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзэхэд 2012 оныхоос 94,6 %-иар өссөн байна.

8 Ц.Эрдэнэчимэг, Монгол улс дахь зам гээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлэлт. УБ., 2014 он., 11 дахь тал




**Зам тээврийн ослын дуудлага /сүүлийн 3 жилээр/**



Зам тээврийн ослыг эд материалын хохиролтой, хүн нас барсан, гэмтсэн осол гэж ангилна. Нийслэлд бүртгэгдсэн 15110 зам тээврийн ослын 9570 буюу 63,3 хувь нь эд материалын хохиролтой осол байхад үлдсэн 5540 буюу 36,7 хувь нь хүн гэмтсэн, хүний амь нас тодорхой хэмжээгээр хохирсон зам тээврийн осол эзэлсэн байна.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн хүмүүсийн гэмтлийн зэргээс харахад нийт гэмтэл авсан хүний 23,4 хувь нь хөнгөн, 50,2 хувь нь хүндэвтэр, 26,4 хувь нь хүнд гэмтэл авсан байна.







2013 онд Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2114 гарч, гэмт нэргийн улмаас 423 хүн нас барсныг 2012 онтой харьцуулахад гэмт хэрэг 7,2 нувйар гэмтсэн хүн 18,9 хувиар, нас барсан хүн 14,6 хувиар тус тус өссөн байна.

Зам тээврийн осол гарч буй шалтгааныг хөдөлгөөнд оролцож байгаа байдлаар нь авч үзвэл:



Услын хэмжээнд бүртгэж, шалгасан 18367 зам тээврийн ослын 17848 буюу 97,2 хувь нь жолоочийн буруутай үйлдлээс, 475 буюу 2,6 хувь нь зорчигчийн буруутай үйлдлээс, 44 буюу 0,2 хувь нь замын нөхцлөөс шалтгаалан гарсан байна.



Ослын улмаас учирсан хохирлын хэмжээ жилээс жилд өсч байгаа нь хүмүүсийн автомашины хэрэглээ, автомашины парк шинэчлэгдэж, автомашины сэлбэг, хэрэгслийн өртөг өндөр үнэтэй машин их болж байгаатай холбоотой юм.

д/д	Он	Учирсан хохирол	
		Улс	Хот
1	2012	8,118,960.00	4,937,533.00
2	2013	8,497,978.52	6,827,190.17

Эдгээр үзүүлэлтээс дүгнэлт хийхэд Авто-техникийн шинжилгээ нь криминалистик



шинжилгээний чухал нэг хэсэг бөгөөд хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэргийг илрүүлэх, таслан зогсоох ажлыг сайжруулах шаардлага гарч байна.

## **ДҮГНЭЛТ**

Шүүхийн шинжилгээний тухай хууль нь 2009 онд батлагдсан. Авто техникийн шинжилгээний лаборатори нь 2010 оны 1 дүгээр сарын Хууль зүйн сайдын бүтэц зохион байгуулалтын б/1 тушаалаар байгуулагдсан. Эдийн засгийн шинжилгээ хийх журам, шүүх эмнэлгийн шинжилгээ хийх зааврыг Шүүхийн шинжилгээний тухай хуулинд тусгасан байдаг. Харин авто техникийн шинжилгээ хийх журам, заавар, авто техникийн шинжээчдийн эрх, үүрэг хариуцлага, эрх зүйн актуудад тусгагдаагүй байдаг ба Шүүхийн шинжилгээний тухай хуулинд заасан криминалистикийн шинжилгээ хийх журам, шинжээчдийн үйл ажиллагаа эрх зүйн зохицуулалтыг дагаж мөрдөж байна. Авто техникийн шинжилгээ хийхэд нөлөөлөх, ач холбогдол өгөх орчин үеийн тусгай техник хэрэгслээр тоноглогдсон лаборатори байхгүй байна. Шинжилгээний судалгаа хийж, дүгнэлт гаргах нарийн мэргэжил эзэмшсэн боловсон хүчин дутагдалтай байна.

### **САНАЛ**

Дээрх дүгнэлтээс үзэхэд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Одоогийн байдлаар авто техникийн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байгаа шинжилгээний төрөлд тусгай буюу нарийн мэргэжил эзэмшсэн боловсон хүчин бэлтгэх.

2. Тусгай мэргэжлийн шинжээчдэд олгох урамшууллыг төсөвт тусгуулах.

3. Тусгай мэдлэг эзэмшсэн мэргэжилтэн, инженер-техникийн шинжээчийг сонгон шалгаруулах замаар томилох.

4. Шаардлагатай тохиолдолт техникийн мэргэжилтэнг томилон ажилуулахаар мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, гэрээ, санамж бичгийг боловсруулах.

5. Шинжилгээ судалгаа хийх ая тухтай орчин бүрдүүлэх, шинжээчийн ахуйн нөхцөл болон эд материалаар хангамжийг нэмэгдүүлэх, шинээчийн дүгнэлт гаргахад ашиглагдах, ач холбогдлоо өгөх орчин үеийн техник хэрэгсэл, лабораторийг сайжруулах саналтай байна.



## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

**Ю.Бадамханд**

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, цагдаагийн хурандаа

**Ж.Жанболат**

Хууль сахиулахын их сургуулийн магистрант

Түүхэн замналын хувьд авч үзвэл хүй нэгдлийн нийгмээс эхлэн хүний үүсэл, төлөвшил, хөгжлийн бүх үе шатанд аюулгүй амьдрах асуудал тавигдаж ирсэн. Түүхчид эртний хүмүүсийн нэг дор цуглаж, хамтдаа амьдрах болсны үндсэн шалтгааныг аюулгүй байдлын хэрэгцээтэй нь холбон тайлбарладаг.

Хувь хүн, нийгэм, иргэншлийн асуудал хурцдаж ялангуяа дэлхийн II дугаар дайны дараа хувьсал өөрчлөлт хурдацтай явагдаж эхэлснээс үүдэн хувь хүн, нийгэм, байгууллагын аюулгүй байдал анхаарал татан XX зууны сүүлчээс дэлхий нийтийн шинжтэй болсон. Улмаар хөдөлмөрийн хуваарь хөгжиж, аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй хүмүүс бий болсон нь орчин үеийн цэрэг, цагдаагийн байгууллагын анхдагчид юм.

Аливаа улс үндэстний аюулгүй байдлын үндсэн хэсэгт: тухайн улсын оршин тогтнохуйн, нийгэм төрийн байгууллын, иргэдийн эрх, эрх чөлөөний, эдийн засгийн, шинжлэх ухаан, технологийн, мэдээллийн, соёл иргэншлийн, хүн ам, удмын сангийн, экологийн аюулгүй байдлын асуудал хамаарна.

Хүний амьдралын чухал асуудал болох аюулгүй байдлын асуудалд системтэйгээр хандах, хүн, нийгэм, төр, хүн төрөлхтөний амьдрах, хөгжих нэн чухал нөхцөл болох аюулгүй байдлын цогц, баяжуулсан мэдлэгийг бүтээх үүднээс олон талт, олон хүчин зүйл, шинжлэх ухааны олон салбараас хамааралтай аюулгүй байдлын тухай шинжлэх ухааныг аюул судлалын ухаан буюу секьюритологи (лат. securitas

– аюулгүй байдал, «логия» (грек. logos – сургаал, шинжлэх ухаан)) гэж нэрлэхийг эрдэмтэд санал болгосон байна.

Аюулгүй байдлын тухай ойлголт нь ихээхэн цогц шинжтэй үзэгдлийн мөн чанарыг тайлж, тодорхойлохоос эхлэх учиртай бөгөөд тухайлбал аюулгүй байдал нь эдийн засаг, цэрэг, улс төр, мэдээлэл, боловсрол, генетикийн гэх мэт олон талтай. Т.Гоббс, Д.Локк, Ж.Ж. Руссо, Б.Спиноза болон XVII - XVIII зууны бусад гүн сэтгэгчдийн философийн үзэл баримтлалын үрээр баруун Европын орнуудад “*аюулгүй байдал*” хэмээх ойлголт илүү өргөн хүрээнд тархсан бөгөөд аливаа бодит аюул занал арилсан нөхцөлд бүрэлдэн тогтсон амар амгалан байдал (энх тайван), энэхүү байдал бүрэлдэн тогтоход түлхэц болсон улс төр, эдийн засгийн болон материаллаг нөхцөл гэж үзэх болжээ.<sup>1</sup>

Аюулгүй байдлын талаарх энэхүү ойлголтыг С.И.Ожеговийн тайлбар тольд<sup>2</sup>: “аюул заналхийлээгүй нөхцөл байдал, аюулаас хамгаалах хамгаалалт буй” гэсэн бол, Я.Цэвэлийн тайлбар тольд<sup>3</sup>: “Аймаар жигшмээр юмгүй, айх болгоомжлохыг мэдэхгүй” гэж, академич С.Нарангэрэл: «Аюулгүй байдал гэдэг нь тухайн улсад улс төрийн, эдийн засгийн ба нийгэмшлийн тогтвортой байдлыг тогтоон хангах, хуулиудыг чанд сахин биелүүлэх ба эрх зүйн дэг журмыг хангуулах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх үндэс болсон улс төрийн, эдийн засгийн, нийгэмшлийн, цэргийн, экологийн, мэдээллийн ба бусад шинжтэй дотоод ба гадаад шинж чанартай аюул заналхийллээс бие хүн, нийгэм, төрийн амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байдал юм»<sup>4</sup> гэсэн байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалын<sup>5</sup> 1 дүгээр зүйлийн 1.1.1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ” гэж онцгойлон тодорхойлсон бөгөөд аюулгүй байдлыг дараах төрөлд авч үзсэн байна.

1. Оршин тогтнохуйн аюулгүй байдал
2. Эдийн засгийн аюулгүй байдал
3. Дотоод ба гадаад аюулгүй байдал
4. Хүний аюулгүй байдал
5. Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал

<sup>1</sup>Үндэсний тагнуулын академи. УБ. 2012. х.51

<sup>2</sup>Словарь С.И.Ожегова. //http://enc-dic.com/ozhegov/Bezопасnost-1370/

<sup>3</sup>Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966. 60 дахь тал

<sup>4</sup>Нарангэрэл. С. Эрх зүйн толь бичиг. УБ. 2007. х.54

<sup>5</sup>Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлал.





6. Мэдээллийн аюулгүй байдал Аюулгүй байдлын салбарын “гадаад аюулгүй байдал” буюу “хамгаалалт” / defence/ хэмээн нэрлэгдэж буй хэсэгт үүрэг гүйцэтгэдэг байгууллагууд “зэвсэгт хүчин” (armed forces) хэмээгддэг бол “дотоод аюулгүй байдал”-ын салбарт үүрэг гүйцэтгэдэг байгууллагууд “аюулгүй байдлын үйлчилгээ” (police services-law enforcement agencies) гэгддэг байна.

Аюулгүй байдлыг хангах нь учирч болзошгүй аюул, заналыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, няцаах, устгах талаар хувь хүн, нийгэм, улс орон, дэлхийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд тулгуурласан шинжлэх ухааны олон салбарыг хамарсан асуудал юм.

Улс нийгмийн аюулгүй байдлын баталгааг хамтын хүчээр аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, оролцох замаар хангана. Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо гэж «Үндэсний аюулгүй байдлыг хангах (Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий субъектүүдийн тогтолцоо) зорилтуудыг шийдвэрлэхэд шаардагдах, байгууллага, газар, хүч хэрэгсэл, эрх зүйн орчин бүхий зохион байгуулалтын тогтолцоог ойлгоно. Үндэсний аюулгүй байдлыг хангах үүргийг Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, хууль сахиулах болон төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд гүйцэтгэнэ.

Монгол Улсын цагдаагийн байгууллага байгуулагдсанаас хойш цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байсан дүрмүүдэд (1923, 1926, 1928, 1934, 1936, 1942, 1955, 1963, 1985) цагдан сэргийлэх байгууллагын аюулгүй байдлыг хангах талаар тодорхой заалт байхгүй боловч заримерөнхий ойлголтуудыг оруулж өгсөн байдаг. Тухайлбал:

- 1955 оны “Улсын цагдан сэргийлэх дүрэм<sup>6</sup>”-ийн 16 дугаар зүйлд “Улсын цагдан сэргийлэхийг зэвсэг, хувцас, эд хэрэглэгдэхүүн, шинжлэх ухаан техникийн хэрэгсэл, тээврийн ба холбооны хэрэгсэл зэрэг бусад эд хогшлоор хангах явдлыг ДЯЯ-наас төвлөрсөн журмаар гүйцэтгэнэ. Морь ба албаны нохойн тоо, тээврийн хэрэгсэл, мөн зэвсэг, техник болон бусад эд хогшлын жагсаалтыг ДЯЯ-ны сайдаас тогтооно.

- 1963 оны БНМАУ-ын “Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм<sup>7</sup>”-ийн 4 дүгээр бүлгийн

<sup>6</sup>БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1955 оны 129 дүгээр тогтоолоор баталсан БНМАУ-ын Дотоод явдлын яамны харьяа Улсын цагдан сэргийлэх дүрэм.

<sup>7</sup>БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1963 оны 499 дүгээр тогтоолоор баталсан БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм.

10 дугаар зүйлд: “Цагдан сэргийлэх байгууллагын ажилд улс төр, зан суртахууны талаар тогтвортой, ерөнхий боловсролын талаар зохих бэлтгэлтэй, үнэнч шударга хүмүүсийг авч байна”, 15 дугаар зүйлд: “Цагдан сэргийлэх байгууллагын ажилтан нарын албан үүргээ гүйцэтгэж байгаа үед нь бусдаас бүлэглэх буюу буу зэвсэг, бусад хэрэгслийг ашиглах, илтээр халдан довтолж, амь насанд аюул учруулахад хүрвэл” зэвсэг хэрэглэж болно.

- 1985 оны БНМАУ-ын “Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм<sup>8</sup>”-ийн 1 дүгээр бүлгийн 3, 4 дүгээр зүйлд: “Цагдан сэргийлэх байгууллагын бүх үйл ажиллагаа нь социалист хууль ёсыг нарийн чанд сахих, өндөр сонор сэрэмжтэй байх зарчимд үндэслэнэ”, “Цагдан сэргийлэх байгууллага хөдөлмөрчин олон түмэнтэй тогтоосон нягт холбоогоо бүх талаар хөгжүүлэх, үйл ажиллагаандаа тэдний тусламж, дэмжлэгт тшишглэнэ. Цагдан сэргийлэх байгууллагын бүх үйл ажиллагаа цэрэгжүүлсэн өндөр зохион байгуулалттай, шуурхай, байнгын бэлэн байдалд байна”; 2 дугаар бүлгийн 9 дүгээр зүйлд: “Улсын цагдан сэргийлэх газрын дэргэд зөвлөх эрхтэй зөвлөл байгуулна. ...Зөвлөлийн хуралдаанаар нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хяналт шалгалтын асуудал болон зарим чухал тушаал, зааврын төслийг хэлэлцэнэ” гэж тус тус заасан байна.

Дээрх дүүрмүүдээс харахад тухайн түүхэн цаг хугацаанд цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах албан ёсны хариуцсан нэгжгүй, цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт хангалтгүй, цаашид сайжруулах, боловронгуй болгох хэрэгцээ шаардлага байсныг харуулж байна.

“Тос дотроосоо өтнө” гэж өвөг дээдэс маань дотоод аюулгүй байдлын мөн чанарыг товч бөгөөд тодорхой сургамжлан хэлж ирсэн түүхтэй.

Монгол Улсын Их хурлаас 1993 онд баталсан цагдаагийн байгууллагын анхны бие даасан хууль болох “Цагдаагийн байгууллагын тухай хууль”-ийн 51 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Цагдаагийн төв байгууллага нь цагдаагийн нийт байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд, цагдаагийн байгууллагын дарга, захирагч нар тухайн байгууллагын өдөр тутмын ажилд дотоод хяналт тавьж, хууль тогтоомж, цагдаагийн алба хаагчийн ёс зүйн шаардлага, хүний

<sup>8</sup>БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1985 оны 95 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм.



эрх, эрх чөлөөг тэмцэх явдалтай тэмцэх, шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авна” гэж зааж дотоод хяналт аюулгүй байдлын албаны үйл ажиллагааны эрх зүйн үндсийг анх тодорхойлсон.

Үүний дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 1993 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 05 дугаар тушаалаар “Цагдаагийн анги, байгууллагын ажилд туслах шалган зааварчлах үүрэг бүхий тусгай тасаг”-ийг байгуулж, улмаар 1993 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 35 дугаар тушаалаар “Тусгай тасаг”-ийн дүрмийг баталж Цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлыг хариуцсан албан ёсны нэгж, эрх зүйн зохицуулалтыгбий болгосон байна.

Цагдаагийн байгууллагын шинэчлэлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлж байгаа томоохон ажлын нэг нь байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг улам боловсронгуй болгох, шинэ шатанд гаргах явдал бөгөөд “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт “Цагдаагийн төв байгууллага нь ... дотоод хяналт-аюулгүй байдлын нэгж байгуулна” гэж заасан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалд “Дотоод аюулгүй байдал”-ын хэсгийг боловсруулахдаа Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэх, хууль ёс, үндэсний эв нэгдлийг сахин дээдлэх, Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс болох агуулгад тулгуурласан.

Монгол Улс нь хүн ам цөөтэй боловч газар нутаг уудам, байгалийн нөөц арвин бусад улс орнуудын сонирхол татсан улсын хувьд дотоод аюулгүй байдлын асуудлаа онцгойлон анхаарахыг дэлхийд өрнөж буй үйл явц, манай орны улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд сүүлийн жилүүдэд гарч буй өөрчлөлт, сорилт бэрхшээл бэлхнээ харуулж байна.

Аюулгүй байдлыг хангах нь учирч болзошгүй аюул, заналийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, няцаах, устгах талаар улс орон, хувь хүн, нийгэм, дэлхийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд тулгуурлан шинжлэх ухааны олон салбарыг хамарсан асуудал болж байгаа тул Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ хэрэгжүүлж байгаа үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг

үүргийн байгууллагын хувьд дотоод аюулгүй байдлыг хангах болон түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохын тулд гадаад улс орны цагдаагийн байгууллага дотоод аюулгүй байдлаа хэрхэн хангаж байгаа байдал болон олон улсын чиг хандлагыг судалж, Монгол Улсын Цагдаагийн албаны онцлогт тохирсон эрх зүйн зохицуулалтыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх шаардлагатай байна гэж үзэж болохоор байна.

ОХУ-д 2009 оноос “Барилга байгууламжийн аюулгүй байдлын тухай техникийн журам”<sup>9</sup> хууль (2014 онд нэмэлт өөрчлөлт орсон), 2010 оноостөр, олон нийтийн, хүрээлэн буй орчны, хувь хүний болон хуульд заасан бусад аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, зарчим, төрийн, засгийн газрын, нутгийн өөрөө удирдлагын, ОХУ-ын Аюулгүйн зөвлөлийн бүрэн эрх, чиг үүргийг тусгасан “Аюулгүй байдлын тухай” хууль<sup>10</sup> (2015 онд нэмэлт өөрчлөлт орсон) хэрэгжиж байна.

Цагдаагийн байгууллагын чадавх суларвал нийгэмд хууль зөрчих нь ердийн үзэгдэл болох, гэмт хэргийн гаралт өсч, хүмүүс зохион байгуулалтад орж өөрсдийн зөв гэж үзсэн үйлдлийг хүч түрэмгийлэн хэрэгжүүлэх, нийгмийн дэг журмыг бүлэглэн зохион байгуулалттайгаар зөрчих хандлагага, нөхцөл байдал үүсэж болзошгүй байдаг.

Цагдаагийн байгууллага нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж иргэний дэмжлэгийг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах, шинжлэх ухаан, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ололтыг ашиглах, аливаа гэмт халдлагаас төр, олон нийтийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дотоод аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нэн чухал.

“Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”<sup>11</sup>-ын /код/ 113.2 дахь хэсэгт:

Цагдаагийн байгууллагын дотоодын аюулгүй байдал - хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бусад чиг үүргийг гадаад, дотоод орчны нөлөөлөх хүчин зүйлээс үл хамааран

<sup>9</sup>Федеральный закон от 30 декабря 2009 г. N 384-ФЗ. «Технический регламент о безопасности зданий и сооружений». //Система ГАРАНТ: [http://base.garant.ru/12172032/1/#block\\_100#ixzz3zDKC6R3h](http://base.garant.ru/12172032/1/#block_100#ixzz3zDKC6R3h)

<sup>10</sup>“Аюулгүй байдал” гэдэг нь хувь хүн, нийгэм, төрийн амин чухал ашиг сонирхол гадаад, дотоодын аюул заналаас хамгаалагдсан байдал юм. Ст.1 Закона РФ от 5 марта 1992 г. №2446-1 “О безопасности”.

<sup>11</sup>Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. /код-113.2/.



үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангагдсан байдлыг;

Цагдаагийн байгууллагын дотоодын аюулгүй байдлыг хангах - цагдаагийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны сөрөг хүчин зүйлс нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, учруулж буй хор уршгийг саармагжуулахад чиглэсэн удирдлага, зохион байгуулалт, биет болон инженер техникийн арга хэмжээний цогцыг хэлнэ

“Алба хаагчийн аюулгүй байдлыг хангах” – Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4-т заасны дагуу хойшлуулшгүй арга хэмжээг авах үйл ажиллагааг;

“Барилга, байгууламж /объект/-ийн аюулгүй байдлыг хангах” – байгууллагын барилга, байгууламжийг гадны гэмт халдлага болон гэнэтийн аюул, осол /байгалийн аюултай үзэгдэл/, алба хаагчдын болгоомжгүй байдлаас үүсэж бий болох хор уршгаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нэгэнт бий болсон аюул заналхийллээс хохирол багатай даван туулахад чиглэсэн нэгдсэн бодлоготой, харилцан уялдаатай үйл ажиллагааны нийлбэр цогц гэж тус тус тодорхойлсон байна.

Монгол Улсын Засгийн газраас баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр<sup>12</sup>”-ийн хэрэгжүүлэх арга хэмжээний 5.3.10-т: Алба хаагч, ажилтны хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцлийг дээшлүүлэх, 5.5.2-т: Иргэд үйлчилгээ авах орон зай бий болгох, үйлчилгээний нэгдсэн стандартыг хэрэгжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор албаны нэг загварын барилга байгууламж<sup>13</sup>(ажлын байр)-тай болгож, орчин үеийн машин техник хэрэгслээр хангах арга хэмжээ авч, гадаад өнгө төрхийг шинээр бий болгох гэж тус тус заасан байна.

Цагдаагийн албаны дотоод аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, аюулгүй байдлыг хангах алба хаагчдыг бэлтгэх, сургах, давтан сургах, үйл ажиллагааны

чиглэл, эрх, үүргийг тодорхойлсон харилцааг хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангахад орчин үеийн дэвшилтэд техник технологийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, гадаад улс орны аюулгүй байдлыг хангаж байгаа тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, чиг хандлагыг тодорхойлсноор хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх, байгууллагын аюулгүй байдал алдагдах, аливаа эрсдэлтэй нөхцөл байдалд үүсэх, алба хаагч нарын албанд хандах хандлага буурах, алба хаагчдад хууль бус шийдвэр гаргахад нөлөөлөх, боловсон хүчний тогтвортой ажиллах хэмжүүр алдагдах зэрэг нөхцөл байдлаас ангижрахаас гадна хуулиар хүлээсэн үүргээ тогтвортой, иргэдэд жигд хүртээмжтэй хүргэх, дотоодын болон гадаадын аливаа эрсдэлтэй үйлдлээс бүрэн хамгаалах, цагдаагийн байгууллагын боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэх, хууль сахиулах үйл ажиллагааг нэг мөр хэрэгжүүлэх, албан хаагчдад тавигдах ёс зүй, мэргэжлийн ур чадвар, хариуцлага, хууль сахин биелүүлэх шаардлагыг өндөржүүлэх, эрх зүй, нийгмийн хамгааллын баталгаагаар хангахад чухал ач холбогдолтой. Тиймээс мэргэшсэн, чадварлаг алба хаагчдын тоог нэмэгдүүлэх, алба хаагчдын ёс зүй, ажил гүйцэтгэх чадамж, байгууллагын дотоод хяналт болон хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, аюултай нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд цагдаагийн байгууллагын, тэр дундаа цагдаагийн байгууллагын барилга байгууламжийн, цагдаагийн алба хаагчдын хувийн аюулгүй байдлын асуудлыг хөндөн авч үзэх шаардлагатай.

Цагдаагийн байгууллагын аюулгүй байдлын тухай ойлголтыг түүний хуулиар хүлээсэн үүрэгтэй нь холбон үзвэл гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй хэрэгжүүлэх гадаад дотоод орчин бүрдсэн байдлыг Цагдаагийн байгууллагын аюулгүй байдал хэмээн тодорхойлж болно<sup>14</sup>.

Иймд Цагдаагийн байгууллагын аюулгүй байдалд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны аюулгүй байдал, цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдал, цагдаагийн барилга байгууламжийн /байр/ аюулгүй байдал гэх мэт асуудлуудыг хамааруулан ойлгож болох юм.

Гадаадын зарим улс орнуудад гарч байгаа гэмт үйлдэл, нөхцөл байдлуудаас харахад цагдаагийн байгууллагын объект руу халдах; цагдаагийн байгууллагад хууль бусаар

<sup>12</sup>Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”. //http://songino-3.police.gov.mn/news/content/type/70

<sup>13</sup>**Барилга хот байгуулалтын яамны “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо” баримт бичгийн 4.3.-т:** Онцгой болон гамшгийн нөхцөл байдал гэнэт үүсэх шалтгааныг урьдчилан тооцох замаар барилгын бүтээгдэхүүн болон хүн амыг эрсдэлээс хамгаалах; 4.4.-т: Барилга байгууламжийн инженерийн тоног төхөөрөмж, барилгын бүтэц, буурь хөрсний чанар, найдвартай байдлыг хангахаар тусгасан.

//http://barilga.gov.mn/?page=custom&module=news&id=ef4a53d6-fcc0-4fd2-8a21-d88b45a44974

<sup>14</sup>Цагдаагийн ерөнхий газар. Цагдаагийн байгууллагын дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдал 2012., УБ. 2013. 21 дэх тал.



нэвтэрч нотлох баримтыг устгах, хулгайлах; гэмт этгээдүүд оргон зайлах, суллан авах зэрэг хэрэг гарч байгаа нь цагдаагийн байгууллагын барилга байгууламж /байр/, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах нь анхаарах асуудлын нэг болж байгааг харуулж байна.

Цаашид цагдаагийн барилга байгууламж /байр/, түүний эрх зүйн зохицуулалт, аюулгүй байдлын асуудлыг шинээр үнэлэн тодорхойлж, ач холбогдол бүхий арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.



## ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Л.Нямдаваа

ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга,  
цагдаагийн дэд хурандаа

Цагдаагийн алба хаагчдын нийгмийн хамгааллын тухай гэдэг бодлогын цаана халамжийн бодлого биш, харин тэдний хөгжлийн асуудал, хууль зүйн баталгааны асуудал түлхүү яригдах ёстой. Энэ нь цаг үетэйгээ нийлсэн, тэдний нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх учиртай.

Мөн бусад салбарын нийгмийн хамгаалал, хөгжлийн асуудлаас ялгарах өвөрмөц онцлогтой, хууль сахиулах салбарын хүний нөөцийн удирдлагын урт хугацааны бодлоготой уялдуулах ёстой.

Хамгийн наад зах нь цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүний тогтвортой ажиллах, өөрийгөө хөгжүүлэх орчин бий болгох, цагдаагийн алба хаагчдаас албаа сэтгэл хоёрдохгүй хаах нөхцөл, боломжийг бүрдүүлэх ёстой юм.

Өнөөдөр цагдаагийн алба хаагчдын хувьд тулгамдаж байгаа нийгмийн асуудлуудаас эн тэргүүнд албан үүргээ биелүүлэх баталгааг хууль тогтоомжид тусгаж баталгаажуулах, алба хаагчдын орон сууцны хангамжийг сайжруулах, цалин хөлс, нэмэгдэл, нөхөн олговрын тогтолцоог шинэчлэх, гэр бүлийн гишүүдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, байгууллагын тохижилтыг шинэ шатанд гаргах, эмнэлгийн үйлчилгээний нэр төрөл, чанарыг дээшлүүлэх, эрх зүйн хамгааллыг бэхжүүлэх гэсэн үндсэн чиглэлд анхаарлаа хандуулж байна.

Цагдаагийн албан хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгаа гэдэг нь хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ гүйцэтгэх боломжийг хуульчлан тогтоож өгсөн бодит нөхцөл хэмээн тодорхойлж байна.

Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааг 1916 оны “Нийслэл хүрээний тойрон газруудыг цагдан сэргийлүүлэх дүрэм, хэмжээ тогтоохуй”-ээс эхлээд 2013 оны “Цагдаагийн албаны тухай хууль” хүртэл 12 хууль, дүрэмд их, бага хэмжээгээр тусган зохицуулж иржээ.

Харин “БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын үндсэн үүрэг, эрхийн тухай” Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1985 оны зарлиг нь цагдаагийн байгууллагын тухай

анхны хууль гэж үзэх бүрэн үндэслэлтэй”<sup>1</sup> гэж доктор Ж.Долгорсүрэн өөрийн бүтээлдээ бичсэн байна.

Цаашилбал, Монголын байнгын ажиллагаатай Улсын бага хурал 11 дүгээр зүйл заалт бүхий “Цагдан сэргийлэх, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын ажилтнаас үүргээ биелүүлэх баталгааны тухай” хуулийг баталж, хуулийн 3 дугаар зүйлд цагдан сэргийлэх байгууллагын ажилтан гэмт хэргийг зогсоох, иргэдийн болон өөрийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалахын тулд бороохой, гав хүлэг, усан хөөрөг, нулимс асгаруулагч зэрэг тусгай хэрэгсэл, түүнчлэн зэвсэггүйгээр бие хамгаалах эрхтэй хэмээн зааж байв.<sup>2</sup>

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна,<sup>3</sup> Монгол Улсын Засгийн газрын тухай 14 дүгээр зүйл /Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах/-д заасан нийгмийн хэв журмыг бэхжүүлэх талаархи Засгийн газрын бүрэн эрхийн 1-д “Хүний эрх, эрх чөлөө, жэндэрийн эрх тэгш байдлыг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон шаардлагатай бусад баталгааг бүрдүүлэх, бэхжүүлэх арга хэмжээ авна”<sup>4</sup> хэмээн манай хууль тогтоомжид баталгааг хангах чиглэлээрх эрх зүйн үндсийг тусгайлан тусгаж өгсөн байна.

Мөн 1993 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуульд цагдаагийн албан хаагчийн эрх зүйн байдлыг тусгаснаар уг албан хаагчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг анхлан бүрдүүлж өгчээ.

Хууль зүйн салбарт сүүлийн жилүүдэд хийгдэж буй шинэчлэлд “хууль сахиулагч” гэх нэр томъёо хэрэглэгдэх болсон бөгөөд цагдаагийн алба хаагч нь хууль сахиулах албаны гол төлөөлөгч гэж тодорхойлох болсон.

Учир нь цагдаагийн байгууллага, алба хаагч Монгол Улсын 90 гаруй хуулиар эрх үүрэг хүлээж ажилладаг бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хуулиар

<sup>1</sup>Ж.Долгорсүрэн. Монгол Улсын Цагдаагийн эрх зүйн курс. УБ. 2015. 14 дэх тал

<sup>2</sup>Ж.Долгорсүрэн. Монгол Улсын Цагдаагийн эрх зүйн курс. УБ. 2015. 14 дэх тал

<sup>3</sup>Төрийн мэдээлэл. 1992. №1

<sup>4</sup>Төрийн мэдээлэл. 1993. №3



хүлээлгэсэн захиргааны үүргийн биелүүлэх үүргийг хүлээдэг.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Цагдаагийн албаны тухай хуульд “цагдаагийн алба хаагч” үүргээ гүйцэтгэхийн тулд ямар төрлийн хойшлуулшгүй ажиллагаа явуулах, эрх, үүрэг нь ямар байх талаар тодорхой зохицуулалтгүй, үндсэндээ үйл ажиллагааны баталгаа нь хангагдаагүй гэхэд болно.

Энэ бүхэн нь Цагдаагийн албаны тухай хуульд хууль зүйн баталгааг бүрэн тусган зохицуулагдаж чадаагүй байгаатай салшгүй холбоотой гэж үзэж болно.

Цагдаагийн албаны тухай хуулиар цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааны талаар зохицуулалт байхгүй, харин нийгмийн баталгааны чиглэлээр хэдхэн заалт оруулсан байдлаас харж болно.

Учир нь тухайн цаг үед Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулан өргөн барьсан боловч батлагдаагүй орхигдож улмаар нэр, агуулга нь өөрчлөгдөж Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон боловсруулагдаж, өргөн барих явцад засгийн бодлого солигдож, улмаар бодлого өөрчлөгдсөний улмаас уг хуулийн төсөл батлагдан хэрэгжих боломжгүй болсон. Уг хуулийн төслөөр цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, хууль зүйн баталгааны талаар тусгайлан оруулж өгөхөөр төсөлд тусгагдсан байсан боловч батлагдаагүй улмаас алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгаа алга болсон гэж үзэж болно.

Цагдаагийн албан хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааны нэр томъёоны тодорхойлолтыг эрдэмтэн судлаачдын бүтээл болон хууль тогтоомжуудын нэр томъёоны тодорхойлолтод өнөөг хүртэл нарийвчлан тусгаж өгөөгүй, тодорхойлоогүй байгаа нь онолын тулгамдсан асуудал гэж судлаачийн хувьд үзэж байна.

Тиймээс хууль зүйн баталгаа, тэр дундаа цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааны нэр томъёоны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, хэлэлцүүлэн нэгдсэн нэг ойлголт хүрэх шаардлага бий болжээ.

Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал

Өнөөдөр нийгмийн хөгжилтэй уялдан цагдаад итгэж, хүндэтгэлтэй хандаж ирсэн нийгмийн сэтгэл зүй өөрчлөгдсөн,

цагдаагийн алба хаагчийн нийгмийн болон бусад баталгаа бэхжээгүй, цагдаагийн алба мэргэшлийн болж хөгжиж чадахгүй байна.

УИХ-д 2013 оны 4 сард Цагдаагийн албаны тухай хууль, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг өргөн мэдүүлж, 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Цагдаагийн албаны тухай хуулийг баталсан билээ.

Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн алба хаагчийн хууль зүйн баталгааг цогц байдлаар оруулж ирээгүй нь дараах учир шалтгаантай байна.

Энэ нь Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх баталгаатай холбоотой зохицуулалтыг эхлээд Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд оруулахаар төлөвлөж байгаад өөрчилж Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуульд оруулахаар тусгасан байсан боловч УИХ-ын Чуулганаар хэлэлцэгдэн батлагдаж чадаагүй улмаас баталгааны зохицуулалт орхигдсон.

Үүний улмаас цагдаагийн албан хаагчийн үйлдэл, шийдвэрийг эсэргүүцэх, улмаар амь нас, эрүүл мэндийг хохироох явдал өсч байгаа нь хувь хүний мэргэжлийн чадвартай холбоотой ч тэдний аюулгүй байдал, эрх зүйн хамгаалал, баталгаа бүрдээгүйтэй мөн холбоотой юм.

Тиймээс цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой харилцааг тусдаа хуулиар зохицуулах боломжгүй болсон тул алба хаагчийн эрх зүйн байдал, баталгаатай холбоотой асуудлыг зохицуулах хэрэгтэй болсон.

2011-2014, 2015 оны эхний 8 сарын байдлаар цагдаагийн алба хаагчид нийтдээ 603 гэмт хэрэг, 1292 зөрчлийн хохирогчоор бүртгэгдснийг нийт алба хаагчдын тоотой харьцуулбал 2011 онд 103 алба хаагч тутмын нэг нь гэмт хэргийн хохирогч болж байсан бол 2014 онд 52 алба хаагч тутмын нэг нь хохирогч болсон нь даруй 2 дахин өссөн үзүүлэлт юм.<sup>5</sup>

Түүнчлэн захиргааны зөрчлийн улмаас хохирсон алба хаагчид гэмт хэрэгт хохирсон алба хаагчдаас 0,5-3 дахин их байх бөгөөд цаашид өсөх хандлагатай байгаа нь гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон цагдаагийн алба хаагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах эрх зүйн баталгааг хууль тогтоомжид тусгах, улмаар хохирогч болохоос урьдчилан сэргийлэх ажлыг шинэтгэх шаардлага бий болж байна.

Цагдаагийн алба хаагч албан үүргээ

<sup>5</sup>Мэдээлэл технологийн төв 2015 оны 9 сарын 1-ний өдрийн мэдээ





гүйцэтгэж байхдаа гэмтэх, амь насаа алдах, дүрэмт хувцсаа уруулах зэргээр гэмт хэрэгт хохирсон тохиолдол бүрт дүн шинжилгээ хийн цагдаагийн алба хаагч халдашгүй байх үзлийг алба хаагч, иргэдэд төлөвшүүлэх нь цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болно.

2011-2014, 2015 оны эхний 8 сарын байдлаар албан үүргээ гүйцэтгэж байхдаа Эрүүгийн хуулийн 16 зүйлээр 433 гэмт хэрэгт хохирсон буюу 4 өдөр тутам нэг цагдаагийн алба хаагч гэмт хэргийн хохирогч болж байна.

Эрүүгийн хуулийн 230-р зүйлд (төрийн албан хаагч..., -ийг эсэргүүцэх) зааснаар 261 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 43,3 хувийг, албан үүрэгтэй холбоотой нийт гэмт хэргийн 60.3 хувийг эзэлж буй нь онцгой анхаарал татаж байна.

Тэр дундаа Эрүүгийн хуулийн 230 дугаар зүйлд заасан гэмт хэргийг нийт өдөрт хуваавал 6 хоног тутам нэг цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмт халдлагад өртөн хохирч байна.

**Албан үүргээ гүйцэтгэж байх үедээ**




Энэ нь Цагдаагийн албаны тухай хуульд үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааг бүрэн тусгаж чадаагүй, орхигдуулсантай салшгүй холбоотой юм.

2010 онд 161 алба хаагч хохирсон бол 2014 онд 312 болж өссөн нь ойролцоогоор 2 дахин их байна.

Дээрх графикаас үзэхэд нийт хохирсон алба хаагчдын 49,5 хувийг ЗХТХ-ийн 25-р зүйл "Хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих" хэсэгт зааснаар, 30-р зүйл 30<sup>2</sup> дахь

хэсэг "Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэх, өгөх" заалтаар 29.6%, 21 дүгээр зүйл "Танхайрах" 19.4%, 36 дугаар зүйл "Бусдын

**Албан үүргээ гүйцэтгэж байхдаа дарамт, шахалтанд өртөж байсан уу**



эд хөрөнгө ашиглан шамшигдуулах" заалтыг үндэслэн 1,3 хувь нь байна.

2014, 2015 оны цагдаагийн байгууллагын эрсдлийн үнэлгээний тайланд цагдаагийн алба хаагч албан үүрэг гүйцэтгэж байхдаа гүтгүүлэх, доромжлуулах, хүчирхийлэл, заналхийлэлд өртөх эрсдэл "5" буюу өндөр үнэлгээтэй гарч цагдаагийн байгууллага дахь эрсдэл бүхий ажлын байрны жагсаалтыг НХХЯ-нд хүргүүлсэн байна.

Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн мэдлэг дутмагаас гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирох, хууль ёсны эрх ашиг, сонирхлоо хамгаалуулахад нөлөөлж буй нь цагдаагийн алба хаагч гэмт хэрэг, захирааны зөрчлийн улмаас хохирох явдлаас урьдчилан сэргийлэх, тэдний эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байгаатай салшгүй холбоотой гэж судлаачийн хувьд үзэж байна.

Судалгаанд оролцогчдоос 828 буюу 33% нь албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирч байсан бол энэ талаараа эрх бүхий байгууллагад хандаагүй, шийдвэрлүүлээгүй буюу хууль ёсны эрх ашгаа хамгаалуулаагүй гэж 1950 буюу 78 хувь нь хариулжээ.

Цагдаагийн алба хаагчийг гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болох эрсдлийг бууруулах нэн шаардлагатай арга хэмжээнд "хууль, эрх зүйн хамгааллыг боловсронгуй болгох" нь зүйтэй гэсэн хариултыг судалгаанд оролцогчдын 57.0 хувь нь сонгосон зэрэг үр дүнгээс үзэхэд алба хаагчид ажил үүргээ гүйцэтгэж байхдаа хохирсон тохиолдолд хаана, хэнд хандах, нэхэмжлэх зэрэг эрх зүйн мэдлэг дутмаг байдалтай холбоотой гэж үзлээ.

Тухайлбал, санал асуулгад алба хаагчид гэмт хэрэг, зөрчлийн эрсдлийн түвшингээ

тодорхойлохдоо гэмтэл учруулахыг гэмт хэрэг, алба хаагчийн биед гэмтэл учруулахгүйгээр хүч хэрэглэх явдлыг зөрчилд хамааруулж ойлгох нийтлэг сэтгэлгээ төлөвшсөн байна.

Цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааны хэрэгжилтийг “Хөдөлмөрлөх”, “Ажлын ачаалал, цалин хөлс”, “Ахуй хангамж”, “Агсамж, тусгай хэрэгсэл”, “Эрүүл мэнд” гэсэн чиглэлийн хүрээнд хийсэн судалгааны үр дүнд цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгаа бүрэн хангагдаж чадаагүй байна гэж үзэж байна. Энэ нь цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх хууль зүйн баталгаа нь эрх зүйн зохицуулалтын хувьд учир дутагдалтай, хууль тогтоомжид бүрэн тусгагдаж чадаагүй байгаатай салшгүй холбоотой гэж үзэж байна. Учир нь одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомжоор алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгааг бүрэн тусгаж, эрх зүйн

зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг судалж, цаашид шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор судлаач миний бие Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл<sup>6</sup>-д цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх баталгаатай холбогдуулан Наймдугаар бүлэгт Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлыг тусгайлан тусгасан. Уг бүлгээр цагдаагийн албан тушаалд тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт, туршилтын хугацаа, үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх, цагдаагийн цол, түүнийг олгох болзол, сул орон тоог нөхөх, түр хавсран гүйцэтгэх, хүний нөөцийн жагсаалт гаргах, өөр албан тушаалд шилжүүлэх, ёс зүйн хороо, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, албанаас халах, чөлөөлөх, бүрэн эрхийг түдгэлзүүлэх, сахилга, ёс зүйн хариуцлага, алба хаагчийн баталгаа, улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засаг, бусад баталгаа болон ээлжийн амралт, алба хаах нас, эрх үүрэг, хориглох зүйл зэргийг тусгуулсан 52 зүйлийг оруулснаар цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгаа хангагдах боломж бүрдэж, цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлэх нөхцөл бий болно.

Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг хууль тогтоомжид тусгах явдал гэж үзэн цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх хууль зүйн баталгаатай холбоотой.

-Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа гэсэн 6 дугаар бүлэгт 24 зүйлийг,

-Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал гэсэн 8 дугаар бүлэгт 28 зүйлийг шинээр боловсруулан төсөлд тусгууллаа. Үүнд:


1. Үндсэн буюу эдийн засаг, улс төр, албан үүрэг гүйцэтгэх нөхцөлийн баталгаа:

Цагдаагийн албаны хуулийн төслийг боловсруулахдаа алба хаагчийн баталгаатай холбогдуулан дараах үндсэн зохицуулалтыг оруулаад байна. Үүнд:


-Цагдаагийн алба хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан баталгаагаар хангагдахын зэрэгцээ Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авна.

-Цагдаагийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэж байхдаа нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон зардлыг тогтоосон журмын дагуу байгууллагаас нөхөн авна.

**Гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон талаараа эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлж хууль ёсны эрх ашгаа хамгаалуулж байсан эсэх**



**Албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмт хэрэг, захиргааны зөрчлийн хохирогч болж байсан эсэх**



зохицуулалтаар баталгаажуулж чадаагүй байгааг судалгааны дүн харуулж байна.

Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь

Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааны эрх

<sup>6</sup> Төрийн мэдээлэл. 2013. №29



-Гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба хаагчийг албаны орон сууцаар хангах асуудлыг цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар, мөн нийтийн хэв журам хамгаалах алба хаагчийг албаны орон сууцаар хангах асуудлыг тухайн нутаг дэвсгэрийн Засаг дарга тус тус шийдвэрлэнэ.

-Цагдаагийн алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд хуульд заасан албан үүргээс нь гадуур дайчлах, оролцуулахыг хориглоно. Хэрэв эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас цагдаагийн алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг шаардсан бол татгалзах үүрэгтэй болохыг оруулсан.

-Цагдаагийн алба хаагчийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан шаардлагыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, заавал биелүүлэх ба биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

-Иргэн, албан тушаалтан хэн боловч цагдаагийн алба хаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хуулиар хүлээсэн үүрэгт үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардахыг хориглоно.

-Цагдаагийн алба хаагч албан үүргээ хууль ёсоор гүйцэтгэснээс үүссэн хохирлыг хариуцахгүй.

-Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ гүйцэтгэх явцад гаргасан алдааны улмаас учирсан хохирлыг Засгийн газар хариуцна.

-Цагдаагийн алба хаагч ажлын бус цагаар хууль ёсны үйл ажиллагаа явуулсан, түүнчлэн ажилдаа ирэх, буцах замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нэгэн адил тооцно.

-Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан цагдаагийн алба хаагч болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн амь нас, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг цагдаагийн байгууллага хариуцна.

-Цагдаагийн алба хаагчийг албан үүрэг биелүүлсэнтэй холбогдуулан төрийн эрх бүхий байгууллагаас шалгах тохиолдолд шууд удирдах даргад нь урьдчилан мэдэгдэнэ зэрэг зохицуулалтуудыг тус тус саналдаа тусгалаа.

Цагдаагийн албаны тухай хуулийн төслийн 85.1-д "Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд тухайн алба хаагчийн

гэр бүлийн нэг гишүүнд түүний сүүлд авч байсан нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг 120 сарын цалинтай тэмцэх хэмжээний тэтгэмжийг 1 удаа олгоно" гэж өөрчлөн саналаа хүргүүлэн тусгасан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 38.6-д "Цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон эргүүл, харуул, жижүүрээр ажилласан нэг жилийг нэг жил гурван сараар" гэж байсныг шинээр нэмж "техникийн болон ажиглалтын албанд ажилласан нэг жилийг нэг жил дөрвөн сараар тус тус тооцно"<sup>7</sup> гэж нэмж тусгууллаа.

Түүнчлэн цагдаагийн алба хаагчийн албан үүргээ гүйцэтгэх явцад хохирсон тохиолдолд авах тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг шинээр оруулбал тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжтой болно. Тухайлбал:

-Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмжээс гадна Засгийн газар дараах нөхөх олговор, тусламж олгоно:

-Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнээс шалтгаалан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор;

-Хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг;

-Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид авч байсан цалингийн зөрүү.

-Цагдаагийн алба хаагчийн авч байсан цалингийн хэмжээ нэмэгдэх бүрт энэ хуулийн дээрх цалингийн зөрүүг нэмэгдсэн цалингаас шинэчлэн тооцож олгоно.

-Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тусламж олгоно.

-Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь гэмтэл учирснаас нас барсан, албанаас чөлөөлөгдсөн иргэнийг урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан эрүүл мэнд, амь насанд нь хохирол учруулсан бол Цагдаагийн албаны хуулийн дээрх баталгаа нэгэн адил хамаарна.

Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг сайжруулахтай холбоотой саналыг

<sup>7</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн төслийн 85.4 дэх хэсэг



хуулийн төсөлд тусгуулбал энэ чиглэлээр үүссэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжтой болно. Тухайлбал:

-Цагдаагийн алба хаагчид эмнэлгийн тусламж үзүүлэх үүрэг бүхий тусгай зориулалтын эмнэлэг нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, өндөржүүлсэн бэлэн байдал, онц байдал зарласан, хээрийн сургууль, дадлагын үеэр эмнэлгийн баг ажиллуулна.

-Цагдаагийн төв байгууллага нь цагдаагийн алба хаагчийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулна.

-Цагдаагийн алба хаагчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулахтай холбогдон гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

-Цагдаагийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэнд нь хохирсон бол эмнэлгийн байгууллагаар үнэ төлбөргүй эмчлүүлнэ.

-Албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирснаас тахир дутуу болсон цагдаагийн алба хаагч, эдгээр үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэнд амралт сувилалын болон нөхөн сэргээх эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхээр очих ба буцах замын зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу жилд нэг удаа олгоно.

-Гэмт хэрэгтэй тэмцэх, дайны болон онц байдал, олон улсын болон энхийг дэмжих ажиллагаа, гамшиг, түүний үр дагаврыг арилгах зэрэг цагдаагийн алба хаагчийн эрүүл мэнд, амь насанд өндөр эрсдэлтэй онцгой нөхцөлд алба хаасантай холбоотойгоор сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээ шаардлагатай бол гурван сар хүртэл хугацаагаар сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулна гэх мэт заалтуудыг нэмж тусгуулахаар боловсруулан хүргүүлээ.

Цагдаагийн албаны тухай хуулийн шинэ төсөл батлагдвал Засгийн газар цагдаагийн алба хаагчийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүргийг хүлээх болно.

Түүнчлэн төсөлд “Цагдаагийн алба хаагч ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож хоёр жилд нэг удаа олгоно.

Цагдаагийн алба хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалан түүний эхнэр /нөхөр/ нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүний гэр бүлийг тэргүүн ээлжинд түүний

мэргэжлийн болон түүнтэй дүйцэхүйц ажлаар хангах, ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байгаа хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тусламжийг сар бүр нэг жилийн турш олгох бөгөөд эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн хүн өөрөө хариуцна” гэж төслийн 86.2—д тусгуулахаар санал хүргүүлээ.

Энэ нь цагдаагийн алба хаагчийн ажил үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөл боломжийг хангасан баталгааны нэг заалт болно.

Төслийн 86 дугаар зүйлд:

-Бусдын амь нас, эрүүл мэндийг аюултай нөхцөл байдлаас аврах, хамгаалах, эрсдэлтэй, онцгой нөхцөлд тусгай үүрэг гүйцэтгэсэн, эмх замбараагүй байдал болон онц байдлын үед ажилласан цагдаагийн алба хаагчийн албан тушаалын цалинг ажилласан цаг тутамд хоёр дахин нэмэгдүүлж олгоно.

-Цагдаагийн байгууллага алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжинд, хээрийн сургууль, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно. Цагдаагийн алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг Засгийн газар тогтоохоор оруулж өгсөн.

-Гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор цагдаагийн байгууллагад ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст уналга, ачаа тээшийн зардлыг тухайн үед мөрдөж байгаа онгоц, автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож олгоно.

-Цагдаагийн алба хаагч нь цагдаагийн төв байгууллагаас олгосон албаны үнэмлэх, хувийн дугаар бүхий таних тэмдэгтэй байна.

-Цагдаагийн алба хаагчид дүрэмт хувцас, эсхүл хувцасны мөнгөн хангамжийг олгоно.

-Цагдаагийн алба хаагчийн дүрэмт хувцас нь алба хаагчийн хүйс, гүйцэтгэх үүргийн онцлогт тохирсон, иргэдэд бүрэн танигдахаар байна.

-Цагдаагийн алба хаагчийн дүрэмт хувцас, үнэмлэх, таних тэмдэгтэй ижил загварын дүрэмт хувцас, үнэмлэх, таних тэмдэг дууриалган хийх, хэрэглэхийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хориглоно.

-Цагдаагийн алба хаагч бэлтгэх үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагын



алба хаагч цагдаагийн дүрэмт хувцастай байна.

-Аймгийн төвөөс бусад суманд томилогдсон цагдаагийн алба хаагчийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, албаны орон сууц, уналга, холбооны хэрэгслээр хангах үүргийг цагдаагийн байгууллага хүлээнэ.

-Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг таван жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшил олгох журмыг Засгийн газар батална.

Түүнчлэн хөдөлмөрийн хуульд заасан хэм хэмжээнээс ажлын онцлогийг харгалзан дэвшилт бүхий дараах зохицуулалтыг оруулсан. Тухайлбал:

-Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цагдаагийн алба хаагчид алба хаасан 2 жил тутам ажлын 3 өдрийн, цагдаагийн бусад алба хаагчид алба хаасан 5 жил тутам ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт олгоно.

-Ажлын зайлшгүй шаардлагаар нэмэгдэл амралтаа биеэр бүрэн эдэлж чадаагүй цагдаагийн алба хаагчид түүний зөвшөөрснөөр эдлээгүй хоног тутамд үндсэн цалинг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшил олгоно.

Үүнээс гадна цол, тухайн ажилтны ажлын чадварыг харгалзан өөрийнх нь хүсэлтээр ажиллуулах баталгааг бүрдүүлэхээр хуулийн төсөлд тусгаад байна. Үүнд:

-Цагдаагийн алба хаагчийн алба хаах насны дээд хязгаар нь цагдаагийн бага цолтой алба хаагч 45 нас; цагдаагийн дунд цолтой алба хаагч 50 нас; цагдаагийн ахлах цолтой алба хаагч 55 нас; цагдаагийн дээд цолтой алба хаагч 60 нас; эмэгтэй алба хаагч цагдаагийн цол харгалзахгүйгээр 45 нас байна.

-**Түүнчлэн** насны дээд хязгаарт хүрсэн алба хаагчийн алба хаах хугацааг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 5 хүртэл жилээр сунгаж, насны дээд хязгаарт хүрч албанаас чөлөөлөгдсөн иргэнийг цагдаагийн албаны үйл ажиллагаанд туслах үүрэг бүхий ажилд гэрээгээр ажиллуулж болно гэх мэт.

-Цагдаагийн алба хаагч үүргээ үр дүнтэй гүйцэтгэж, онцгой гавьяа гаргасан бол гавьяа зүтгэлийг нь үнэлж, түүнийг байгууллагын шагналаар шагнан урамшуулж болно;

-Цагдаагийн алба хаагчийг албан үүргээ

гүйцэтгэхдээ гаргасан онцгой гавьяаг үндэслэн “Цагдаагийн гавьяа” тэмдэг, ажилласан жилийг харгалзан “Цагдаагийн албаны төлөө 1”, “Цагдаагийн албаны төлөө 2”, “Цагдаагийн албаны төлөө 3” зэргийн тэмдгээр тус тус шагнана;

-Онцгой гавьяа байгуулж, “Цагдаагийн гавьяа” тэмдгээр шагнуулсан цагдаагийн алба хаагчид сарын үндсэн цалинг 5 хувьтай тэнцэх нэмэгдлийг олгох бөгөөд уг тэмдгээр шагнагдах тухай бүрд нь цалингийн хувийг нэмэгдүүлэн тооцож олгоно.

-Цагдаагийн алба хаагчийг “Цагдаагийн албаны төлөө 1”, “Цагдаагийн албаны төлөө 2”, “Цагдаагийн албаны төлөө 3” зэргийн тэмдгээр доор дурдсан үндэслэлээр шагнаж, цалингийн нэмэгдэл олгоно;

-Цагдаагийн байгууллагад 5-аас доошгүй жил алба хаасан бол “Цагдаагийн албаны төлөө 3” дугаар зэргийн тэмдгээр шагнаж, сарын үндсэн цалинг 10 хувь;

-Цагдаагийн байгууллагад 11-ээс доошгүй жил алба хаасан бол “Цагдаагийн албаны төлөө 2” дугаар зэргийн тэмдгээр шагнаж, сарын үндсэн цалинг 15 хувь;

-Цагдаагийн байгууллагад 17-оос доошгүй жил алба хаасан бол “Цагдаагийн албаны төлөө 1” дүгээр зэргийн тэмдгээр шагнаж, сарын үндсэн цалинг 20 хувь;

Судалгааны ажлын хүрээнд Цагдаагийн албаны тухай хуулийн төсөлд хуулиар хүлээлгэсэн эрх, үүргийн хүрээнд дараах баталгааны саналыг хүргүүлэн тусгаад байна. Тухайлбал:

Цагдаагийн алба хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ гүйцэтгэхдээ холбогдох хуульд заасан эрх хэмжээг хэрэгжүүлнэ.

-Цагдаагийн алба хаагч үйл ажиллагаандаа тэмдэглэл, илтгэх хуудас бичих, гар зураг үйлдэх, фото зураг авах, дүрс, дууны бичлэг хийх болон бусад арга хэрэглэнэ. Цагдаагийн байгууллага, алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэнэ.

-Цагдаагийн алба хаагч, ажилтан нь амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлаа аливаа халдлагаас хамгаалах, өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалуулах, зөрчигдсэн тохиолдолд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.



Цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгааны чиглэлээр дараах саналыг боловсруулан төсөлд тусгалаа. Тухайлбал:

Бусад буюу ажил үүрэг гүйцэтгэх эрх хэмжээ, хөдөлмөр хамгааллын баталгааны чиглэлээр:

Шаардлага тавих:

-Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчлийг арилгуулах, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх зорилгоор шаардлага тавина.

-Нийтийн хэв журмыг зөрчсөн, зөрчиж болзошгүй согтуурсан, мансуурсан хүнд олон нийтийн газрыг орхин явах, согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн нөлөөлөл арилах хүртэлх хугацаанд ирэхгүй байхыг шаардаж болно.

-Цагдаагийн алба хаагчийн шаардлагыг тухайн хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй. Цагдаагийн алба хаагчийн шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн, ажиллагаанд нь саад учруулсан бол албадан гүйцэтгэж, хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэх мэт.

Баримт бичиг шалгах:

-Цагдаагийн алба хаагч хүний нэр, хаяг, тодорхой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг тодруулах зорилгоор баримт бичгийг шалгана.

-Цагдаагийн алба хаагч хүний баримт бичгийг шалгахдаа нүүрээ хаасан зүйлийг авах, нүүрээ халхлах аливаа үйлдэл хийхгүй байхыг шаардах, нэр, хаяг, зөвшөөрлийн бүртгэлийг шалгах, эд зүйл, баримт бичиг нь зөрчил, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, эсхүл үйлдэх замаар олж авсан, эрэн сурвалжлагдаж байгаа эсэхийг тодруулах ажиллагааг явуулна.

-Цагдаагийн алба хаагч хүний баримт бичгийг шалгахдаа 1-2 алхамын зайтай зогсоож, ажиллагааг дуустал түүнийг тухайн газраас явахыг хориглох, эсхүл эрх бүхий байгууллагад очиж шалгуулах шаардлага тавьж болно. Цагдаагийн алба хаагч шаардсан бол тухайн хүн баримт бичгээ шалгуулах үүрэгтэй. Баримт бичиг шалгах ажиллагаа явуулсан нь нэгжлэг хийсэнд тооцогдохгүй.

Хуулийн этгээдийн баримт бичиг шалгах:

-Хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаа гэх үндэслэл бүхий сэжиг байгаа, хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаа талаар гомдол,

мэдээлэл хүлээн авсан бол цагдаагийн алба хаагч хуулийн этгээдийн бүртгэл, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, холбогдох бусад баримт бичгийг шалгана. Баримт бичиг нь хууль ёсны эсэхийг шалгах шаардлагатай бол баримт бичгийг 72 цаг хүртэлх хугацаанд түр хураан авч болно.

Тээврийн хэрэгслийг зогсоож шалгах:

Цагдаагийн алба хаагч хуульд заасан үндэслэлийн дагуу тээврийн хэрэгслийг зогсоон шалгана.<sup>8</sup>

-Эдгээрээс гадна согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн эсэхийг шалгах, саатуулах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, түр саатуулах, тээврийн хэрэгслийг шилжүүлэн байрлуулах, согтуурсан, мансуурсан хүнтэй холбогдуулан авах арга хэмжээ, орон байр, бусад газарт нэвтрэн орох, гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, зорчих хөдөлгөөнийг хязгаарлах, зам чөлөөлөх, хөдөлгөөний чиглэлийг түр өөрчлөх, хаах, биечилсэн судалгаа хийх, эрэн сурвалжлах ажиллагаа, мэдээллийг төлбөртэй авах, нийтийн эмх замбараагүй байдлын үед авах арга хэмжээ, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох, хүн, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, эд зүйл, баримт бичгийг хураан авах, бүлэг хүмүүсийг тараах, жагсаал, цуглааныг албадан тараах зэрэг үйл ажиллагаа явуулах хууль зүйн бусад баталгааг тусгасан байна.

Цагдаагийн алба хаагч хуульд заасан үүргээ биелүүлэхийн тулд албадлагын арга хэмжээ хэрэглэх баталгааны чиглэлээр Цагдаагийн албаны тухай хуулийн төсөлд дараах саналыг боловсруулан тусгууллаа. Үүнд:

-Цагдаагийн алба хаагч Цагдаагийн албаны хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэж болно.

-Цагдаагийн алба хаагч цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр албан хэрэгцээнд хүлээн авч бүртгэсэн тусгай хэрэгсэл, галт зэвсэг, сум, бусад хэрэгслийг хэрэглэнэ.

-Цагдаагийн байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэснээс үүссэн үр дагаврын

<sup>8</sup>Цагдаагийн албаны тухай хуулийн төсөл, 33 дугаар зүйлийн 33.1





төлөө хариуцлага хүлээхгүй.

-Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх явцад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол эмнэлгийн байгууллагад даруй мэдэгдэн, эрүүл мэндийн анхны тусламж үзүүлж, улмаар шууд захирах даргадаа, шууд захирах дарга нь прокурорт даруй мэдэгдэнэ.

-Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн, баривчлах, эрүүл мэндийн болон бусад эрх бүхий байгууллагад албадан хүргэх үед эсэргүүцэл үзүүлсэн, нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх зэрэг үндэслэл бүхий бүх тохиолдолд Цагдаагийн алба хаагч биеийн хүчийг хэрэглэнэ.

### **ДҮГНЭЛТ**

Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааны чиглэлээр судалгааны ажил хийгээд дараах дүгнэлтэнд хүрч байна. Үүнд:

1.Хууль зүйн баталгааны нэгдсэн нэр томъёоны ойлголтод хүрч чадаагүй байна.

-Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын 31 хуульд баталгааны талаар тусгайлсан зохицуулалт орсон байна;

-Баталгаануудын агуулгын хүрээнд харахад байгууллага, алба хаагч гэсэн 2 үндсэн чиглэлд хуваан авч үзсэн байна;

-Баталгаануудын нэршил тогтсон нэр томъёололгүйгээр тухайн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан харилцан адилгүй байдлаар тодорхойлогдсон

-Баталгаануудын агуулгыг харахад нийгмийн баталгаа, үүргээ биелүүлэх баталгаа гэсэн 2 чиглэл байна.

2.Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааны чиглэлээр 1911-2013 оны хоорон дахь 12 хууль, дүрэмд тусгагдсан байдлыг авч үзэхэд цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааг тухайн цаг үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байсан хууль тогтоомжиндоо нийгмийн тогтолцооны онцлогоос хамааран их, бага хэмжээгээр заавал оруулж байсан нь харагдаж байна. Цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааг сайтар хангах нь цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх эх үндэс болно гэдгийг тухайн цаг үеийн төр, засаг онцгойлон анхаарч байжээ.

3.Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх баталгааны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох хүрээнд хөдөлмөрлөх, ажлын ачаалал, цалин

хөлс, ахуй хангамж, агсамж, тусгай хэрэгсэл, эрүүл мэнд гэсэн 5 чиглэлийн хүрээнд хийсэн судалгааны үр дүнд цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх хууль зүйн баталгаа бүрэн хангагдаж чадаагүй байна гэж үзэж байна. Энэ нь цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх хууль зүйн баталгаа нь эрх зүйн зохицуулалтын хувьд учир дутагдалтай, хууль тогтоомжид бүрэн тусгагдаж чадаагүй байгаатай салшгүй холбоотой гэж үзэж байна.

Учир нь одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомжоор алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгааг бүрэн тусгаж, эрх зүйн зохицуулалтаар баталгаажуулж чадаагүй байгаа нь судалгааны дүнд харагдлаа.

Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааны чиглэлээр Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиудад тодорхой хэмжээгээр тусгагдсан байна.

4.Гадаадын улс орнуудад цагдаагийн алба хаагчид эрсдэлтэй, хүнд нөхцөлд ажилладгийг анхаарч, тэднийг төрөөс амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах асуудлыг анхаардаг ба энэ нь эрсдэл бий болсон үед үзүүлэх тусламж, үйлчилгээ нь өргөн хүрээтэй байдаг байна. Дээрхээс үзэхэд цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх баталгааг хангахад цалин хөлс, тэдэнд үзүүлэх тусламж, дэмжлэг, нөхөн олговор чухалчладаг нь нэг талаас алба хаагч албан үүргээ урам зоригтой биелүүлэх, нөгөө талаасаа цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн хууль сахиулах ажлыг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэхэд боломжийг олгож байна.

5.Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгаа өнөөгийн хууль тогтоомжид бүрэн тусгагдаагүй, тулгамдсан асуудал багагүй байна гэж үзлээ. Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг хууль тогтоомжид тусгах явдал гэж үзэн цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх хууль зүйн баталгаатай холбоотой 52 зүйлийг оруулж, цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгаа хангагдах боломж бүрдэж, улмаар цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлэх нөхцөл бий болно гэж дүгнэлээ.



Цаашид цагдаагийн алба хаагчийн баталгааны зохицуулалтыг ажил үүргийн онцлог, орчин үеийн жишигт нийцүүлэн эдийн засаг, улс төр, хөдөлмөр хамгаалал, халамж, үйл ажиллагааны зэрэг өргөн хүрээнд хуульчлах шаардлагатай байна. Тухайлбал, цагдаагийн алба хаагчийн баталгаа иж бүрэн хангагдаагүйн улмаас алба хаагч үүргээ гүйцэтгэх дур сонирхол буурах, итгэлгүй болох, тэдний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, тусламж, дэмжлэг орхигдох эрсдэл учирч болзошгүй байна. Тиймээс цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгааг хууль тогтоомжид сайн тусгаж, эрх зүйн хамгааллыг бүрдүүлэх нь чухал гэдэг нь харагдаж байна.

### **САНАЛ**

Цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааг бүрдүүлэхийн тулд дараах саналыг дэвшүүлж байна.

1.Хууль зүйн баталгааны нэр томъёоны тодорхойлолтыг онолын түвшинд эрдэмтэн судлаачдын дунд хэлэлцүүлэн нэгдсэн нэг ойлголтод хүрэх ажлыг зохион байгуулах

2.Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах чиглэлээр боловсруулсан саналыг хүргүүлэн тусгуулах

•Төслийн 6 дугаар бүлэг /Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа/-т

- Шаардлага тавих;
- Баримт бичиг шалгах;
- Хуулийн этгээдийн баримт бичиг шалгах;
- Тээврийн хэрэгслийг зогсоож шалгах;
- Согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэсэн эсэхийг шалгах, авах арга хэмжээ;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хязгаарлах, түр саатуулах, шилжүүлэн байрлуулах;
- Согтуурсан, мансуурсан хүнтэй холбогдуулан авах арга хэмжээ;
- Орон байр, бусад газарт нэвтрэн орох;
- Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох;
- Замын хөдөлгөөнийг хязгаарлах, зам чөлөөлөх, хөдөлгөөний чиглэлийг түр өөрчлөх, хаах;
- Биечилсэн судалгаа хийх;
- Эрэн сурвалжлах ажиллагаа;
- Мэдээллийг төлбөртэй авах;
- Нийтийн эмх замбараагүй байдлын үед авах арга хэмжээ;
- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох;
- Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох;
- Хүн тээврийн хэрэгсэлд үзлэг хийх;
- Эд зүйл, баримт бичиг хураан авах;

- Бүлэг хүмүүсийг тараах;
- Жагсаал, цуглааныг албадан тараах;
- Гамшгийн үеийн болон хорио цээрийн дэглэм сахиулах;
- Наймдугаар бүлэг /Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал/-т
- Цагдаагийн албан тушаалд тавигдах шаардлага;
- Сонгон шалгаруулалт, туршилтын хугацаа тогтоох;
- Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааг мөргөшлийн түвшинг үнэлэх;
- Цагдаагийн цол, олгох, болзол,;
- Цол, дүрэмт хувцас, үнэмлэх, таних тэмдгийг хураан авах;
- Албан тушаалын орон дээр ажиллах, хавсран гүйцэтгэх, шилжүүлэх, дэвшүүлэх, албанаас халах, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх;
- Хүний нөөцийн бодлого;
- Ёс зүйн хороо;
- Сахилга, ёс зүйн хариуцлага;
- Алба хаагчийн баталгаа;
- Хууль зүйн баталгаа;
- Улс төрийн баталгаа;
- Нийгмийн баталгаа;
- Эдийн засгийн баталгаа;
- Бусад баталгаа;
- Ээжлийн амралт;
- Алба хаах нас;
- Шагнал урамшил;
- Цагдаагийн алба хаагчийн эрх, үүрэг, хориглох зүйл зэрэг зүйлүүдийг тусгах.
- 3.Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсан тохиолдолд түүнийг хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох дүрэм, журмыг шинэчлэн боловсруулахад эрдэмтэн, судлаачдыг татан оролцуулах;
- 4.Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсан тохиолдолд олон нийт болон алба хаагчдад хууль сурталчилах ажлыг нэн даруй зохион байгуулах.



## ОСОБЕННОСТИ ИНДИВИДУАЛЬНОЙ ВОСПИТАТЕЛЬНОЙ РАБОТЫ С ОСУЖДЕННЫМИ

Преподаватель кафедры УИП  
БЮИ ФСИН России  
кандидат юридических наук  
Мазалева Людмила Валерьевна

Проблема воспитательной работы с осужденными к лишению свободы в науке уголовно-исполнительного права в настоящее время представляет определенную сложность и носит дискуссионный характер.

Воспитательную работу с осужденными к лишению свободы законодатель включил в перечень основных средств исправления осужденных; это нашло отражение в ст. 9 УИК, а также в ряде его глав.

Воспитательная работа - это система педагогически обоснованных мер, способствующих преодолению личностных деформаций осужденных, росту их интеллектуального, духовного и физического развития, правопослушного поведения, обеспечивающих успешность социальной адаптации после освобождения. Иными словами, речь идет о таком воздействии на осужденных, которое обеспечивает определенный уровень нравственного исправления, необходимый для успешной социальной адаптации осужденного после освобождения. Задаче исправления осужденных подчинены все остальные задачи, на ее достижение работают все средства воспитательного воздействия, в том числе и привлечение осужденных к труду<sup>1</sup>.

Характерной особенностью организации воспитательной работы в местах лишения свободы является то обстоятельство, что, с одной стороны, она осуществляется в условиях исполнения наказания, т.е. реализации карательной политики государства, затрагивающей систему взаимоотношений осужденных, существенно ущемляющей их свободу и интересы, а с другой стороны, проводится в весьма неблагоприятных условиях повышенной концентрации криминогенной среды, оказывающей активное противодействие: значительная часть осужденных в силу своей криминальной, воровской ориентации принципиально не приемлет

меры воспитательного воздействия.

При организации и проведении воспитательной работы необходим учет индивидуальных особенностей личности осужденного, характера совершенного им преступления, степени разорванности социально-полезных и родственных связей и др.

Индивидуальная воспитательная работа включает в себя систему целенаправленных психолого-педагогических и режимно-правовых воздействий, применяемых с учетом индивидуальных особенностей личности. Индивидуальную воспитательную работу в ФГУИК организует начальник отряда. Для правильной организации и проведения индивидуальной воспитательной работы необходимо предварительное изучение личного дела осужденного, выявление особенностей личности осужденного, в том числе – с помощью психологических тестов.

Индивидуально-воспитательная работа предполагает организацию педагогического воздействия на конкретного осужденного, основанного на знании его черт личности и условий жизни<sup>2</sup>.

Изучение личности осужденного – сложный и длительный процесс, требующий соблюдения следующих педагогических принципов:

- взаимосвязь изучения и воспитания;
- плановость изучения (изучать личность не от случая к случаю, а постоянно по специальной программе);
- целенаправленность изучения (почему один испытывает напряженность, другой не хочет учиться и т.д.)
- непрерывность и преемственность изучения;
- всесторонность изучения;
- изучение личности в развитии;
- взаимопроверка сведений о конкретной личности.

Содержание воспитательной работы в отряде зависит от того, на каком этапе отбывания наказания находится осужденный. Условно можно выделить этапы:

- адаптация к условиям ФКУ ИК (начальный этап);
- реализация комплекса средств исправления (основной этап);
- подготовка к освобождению (заключительный этап).

Исходя из этого, планирование индивидуально-воспитательной работы с осужденным так же условно можно

<sup>2</sup> Методические рекомендации по организации планирования индивидуально-воспитательной работы с осужденными. УФСИН России по Владимирской области

<sup>1</sup> Стурова М.П., Тюгаева Н.А. Пенитенциарная педагогика: Курс лекций. – Рязань: Академия ФСИН России, 2008. – 428 стр.



разделить на три этапа:

- период адаптации (до 6 мес.);
- основной этап (план составляется на каждый год);
- период подготовки к освобождению (за 6 мес. до освобождения).

На начальном этапе проводится углубленное ознакомление с личным делом осужденного и психолого-педагогическое изучение личности с выявлением отношения к совершенному преступлению и назначенному наказанию, установлением степени криминальной зараженности и педагогической запущенности. По тому, как проходит процесс социально-психологической адаптации к условиям ФКУ ИК, определяется степень восприятия осужденным условий отбывания наказания и оказываемого на него исправительного воздействия. Результатом первичного изучения личности осужденного должен стать индивидуальный социально-психологический портрет (характеристика), включающий в качестве разделов уголовно-правовую, социально-демографическую, психолого-педагогическую и иную информацию. Такую работу проводит начальник отряда во взаимодействии с сотрудниками психологической, режимной и оперативной служб, медсанчасти. Результаты отражаются в дневнике индивидуально-воспитательной работы с осужденным.

В целом на начальном этапе с каждым осужденным проводятся:

- ознакомительно-ориентационные беседы начальника отряда, в ходе которых выявляются личностные установки по отбытию наказания, круг общения, социальный статус среди осужденных, социально-полезные связи на свободе, отношение к факту совершенного преступления и наказания, степень осознания вины, личные перспективы, согласование вопросов трудоустройства в колонии и разъяснение требований правил внутреннего распорядка;
- наблюдение и контроль со стороны начальника отряда, членов совета воспитателей, а также общественных формирований за его поведением, трудовой деятельностью, кругом общения, взаимоотношениями с другими осужденными и представителями администрации, участием в проводимых мероприятиях;
- контроль за выполнением различных поручений администрации, постепенное приобщение к жизни отряда;
- в случае необходимости, корректировка его поведения с помощью бесед и мер общественного и дисциплинарного воздействия;
- составление плана индивидуально-воспитательной работы на период адаптации

и перспективного плана работы с осужденным на весь период отбывания наказания

После этого начальник отряда с помощью психолога и социального работника составляет комплексную программу исправления осужденного, результаты которого отражаются в дневнике индивидуальной воспитательной работы.

На основном этапе проводится целенаправленная дифференцированная воспитательная работа с учетом индивидуальных особенностей каждого осужденного, выявленных на начальном этапе, по составленной комплексной программе исправления.

Осужденные, находящиеся на основном этапе отбывания наказания, привлекаются ко всем групповым и массовым мероприятиям, проводимым на уровне отряда и колонии в целом. С каждым осужденным проводится углубленная индивидуальная воспитательная работа.

На основном этапе может быть осуществлен перевод осужденного, в соответствии с установленными законом требованиями и достигнутыми результатами исправления, в облегченных условиях отбывания наказания. Такой перевод может быть осуществлен как внутри одного и того же отряда, так и сопровождаться переводом в другой отряд.

План организации ИВР с осужденным составляет на год начальник отряда совместно с психологом на основе психолого-педагогической характеристики и заносится в дневник ИВР, план индивидуальной воспитательной работы.

На заключительном этапе проводится целенаправленная работа по подготовке к освобождению. При реализации данного этапа начальник отряда наиболее тесно взаимодействует со службой социальной работы ИК. Целесообразно также привлекать к работе психолога для проведения психологических тренингов, воспроизводящих вхождение в реальную жизнь после освобождения с выработкой соответствующих психологических установок.

В целом на заключительном этапе осуществляется:

- организация работы школы по подготовке осужденного к освобождению;
- рассмотрение вопросов трудового, бытового устройства после освобождения путем проведения бесед с осужденными и рассылкой запросов по будущему месту жительства и работы;
- проведение социально-психологических тренингов;
- предоставление краткосрочных отпусков за пределы учреждения для решения вопросов трудового и бытового устройства.



**ХУУЛИЙН ХЭЛЛЭГТ ТАСЛАЛ  
ХЭРЭГЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН  
ЗАРИМ ЛОГИК АСУУДАЛД  
(МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН  
ЖИШЭЭН ДЭЭР)**

**Х.Оюунбаатар**

ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн  
Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, цагдаагийн  
ахмад

Таслал бол нэг талаас хэл зүйн, нөгөө талаас логикийн судлагдахуун болдог хэлний бүрэлдэхүүн юм. Энэ үгүүлэлд ойлголт ба хэллэгийн бүтцэд таслалын гүйцэтгэх үүрэг, логик утгын талаар цухас авч үзэв.

Ойлголт бол нэг юмуу бүлэг юм, үзэгдлийн хамгийн гол чухал шинжийг тэмдэглэн, илэрхийлдэг сэтгэхүйн хэлбэр юм. Түүнийг агуулга ба багтаамжаар нь уламжлалт байдлаар ангилгахын зэрэгцээ, бүтцээр нь энгийн ба нийлмэл гэж ангилж болно.

Нийлмэл ойлголт нь хоёр ба хэд хэдэн ойлголтын багтаамж дээр тодорхой логик үйлдлүүд хийсний үр дагавар байдаг бол энгийн ойлголт тийм биш, цөм бүтэцтэй байдаг. Нийлмэл ойлголтыг хэлээр илэрхийлэх нэг арга бол таслал хэрэглэх явдал юм.

Жишээ №1:

*“Хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэн”*

*“Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр”*

ойлголт багтаамжийн хувьд огтлолцох харилцаанд орших “Хууль зүйн өндөр мэргэшилтэй хүн”, “Улс төрийн өндөр мэргэшилтэй хүн”, “Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэн” гэсэн ойлголтуудыг үржүүлсний үр дүн болсон нийлмэл ойлголт байна. Харин ойлголт бол дээрх ойлголт шиг хэд хэдэн ойлголтын багтаамжаас хамаарсан биш, цөм ойлголт байна.

Ойлголттой харьцуулахад сэтгэлгээний илүү дээд эрэмбийн хэлбэр болох хэллэг (буюу бодомж) бол юм, үзэгдэл ба түүний шинжийн хоорондын,

эсвэл юм, үзэгдлүүдийн хоорондын харилцааг нотлох юмуу няцаах аргаар илэрхийлдэг сэтгэхүйн хэлбэр юм. Хэллэг хамгийн багадаа хоёр ойлголтын хоорондын харилцааг илэрхийлдэг.

Энгийн хэллэг нэг субъект, нэг предикаттай байдаг бөгөөд логик схем нь байна.

Харин нийлмэл хэллэг нэг юмуу хэд хэдэн субъект ба предикаттай байж болдог. Иймд, нийлмэл хэллэгийн логик схемийг дараах байдлаар төсөөлж болно:

- 1)  $S_{(1+n)}-P$
- 2)  $S-P_{(1+n)}$
- 3)  $S_{(1+n)}-P_{(1+n)}$

Энд байна.

Таслалыг энгийн болон нийлмэл хэллэгийн аль алинд нь хэрэглэдэг тул нийлмэл хэллэг үүсгэдэггүй таслалыг нийлмэл хэллэг үүсгэдэг таслалаас ялгах шаардлагатай байдаг.

Жишээ №2:

*“Төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна.”*

Энэ хэллэгт “Төр” ба “Сүм хийд” гэсэн нэрээр нэрлэгдэх тусгаар зүйлсийн талаар биш, харин тэдгээрийн хоорондын харилцааг илэрхийлсэн “Төр, сүм хийдийн хоорондын харилцаа” гэсэн ойлголтын тухай ярьж байна. Энэ бол энгийн хэллэг бөгөөд энд хэрэглэсэн таслал нийлмэл хэллэг үүсгэхгүй. Учир нь энэхүү хэллэгийн бүтцийг задлахад утгат хэсэг буюу хэллэг үүсэхгүй.

Жишээ №3:

*“Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.”*

Энэ хэллэгт хэрэглэсэн таслал бол “Засгийн газар” гэдэг нэрээр нэрлэгдэх нэгэн бүхэл зүйлийг “Ерөнхий сайд” ба “Засгийн газрын гишүүн” гэдэг зүйлс (хэсгүүд) бүрдүүлдэг болохыг тоочин илэрхийлж байна. Уг хэллэгийг “Засгийн газар Ерөнхий сайдаас бүрдэнэ”, “Засгийн газар гишүүдээс бүрдэнэ” гэж задлаж болохгүй. Учир нь эдгээр хэллэгүүд тус бүртээ үнэн утгатай байж чадахгүй. Иймд, энэ бол энгийн хэллэг бөгөөд субъект нь “Засгийн газар”, предикат нь “Ерөнхий сайд, гишүүдээс бүрддэг байгууллага” гэдэг ойлголтууд байна.

Нийлмэл хэллэг нь түүнийг үүсгэж буй логик холбоосын үнэний утгаас хамааран хэд хэдэн төрөл байх боловч энэ үгүүлэлд таслалаар холбогдож үүсдэг хэллэгүүдийг зөвхөн авч үзэв.

1.Ерийн нийлмэл (конъюнктив) хэллэг

Бүрдүүлж байгаа энгийн хэллэгүүд нь нэгэн зэрэг үнэн байх зөвхөн тэр тохиолдолд л үнэн байдаг, бусад тохиолдолд, өөрөөр хэлбэл, бүрэлдэхүүнд нь ядаж нэг худал хэллэг оролцсон тохиолдолд худал утгатай байдаг нийлмэл хэллэг юм. Монгол хэлний “ба”, “бөгөөд” зэрэг холбоос үгээр ихэвчлэн




холбогдож үүсдэг. Зарим тохиолдолд таслалаар холбогдсон байх нь бий. Ийм нийлмэл хэллэгийн логик томъёо байна. Энд нь “бөгөөд” гэсэн холбоосыг тэмдэглэж байна.

Жишээ №4:

“Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.”

Энэ хэллэгт хэрэглэсэн таслал бол “Улсын



Зураг №1

Их Хурлын гишүүнээр сонгох иргэн” гэдэг ойлголтын багтаамж нь “хорин таван нас хүрсэн Монгол Улсын иргэн” ба “сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн” гэдэг ойлголтуудын үржвэр болохыг зааж байна. Өөрөөр хэлбэл, “хорин таван нас хүрсэн боловч сонгуулийн эрхгүй Монгол Улсын иргэн” болон “хорин таван нас хүрээгүй боловч сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн”-ийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгохгүй, зөвхөн “хорин таван нас хүрсэн бөгөөд сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн”-ийг л Улсын Их Хурлын гишүүнээр сонгоно гэсэн утгатай байна.

Ойлголтын багтаамж дээр суурилан хийх үржүүлэх үйлдэл нь тухайн ойлголтуудын аль альных нь шинжийг өөртөө нэгэн зэрэг агуулдаг олонлог (Зураг №1-ийн будсан хэсэг) үүсгэх зорилготой байдаг.


Үржүүлэх үйлдлийг гэж буюу гэж тэмдэглэж болно. Энд бол

ба ойлголтуудын багтаамжийн нэгдлийг тэмдэглэж байна.

Жишээ №5:

“Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.”

Энд “Монгол Улс дагаж мөрдөхгүй



Зураг №2

баримт бичиг” гэдэг ойлголтын багтаамжид таксономи хуваарь хийсэн байна. Таксономи хуваарь бол төрөл-дүрсийн харилцаанд суурилан хийх хуваах үйлдэл бөгөөд “Үндсэн

хуульд харшилсан олон улсын гэрээ” ба “Үндсэн хуульдаа харшилсан бусад баримт бичиг” гэдэг ойлголтууд “Монгол Улс дагаж мөрдөхгүй баримт бичиг” гэдэг төрөл ойлголтын зөрчилт харилцаатай дүрсүүд болохыг тоочин илэрхийлж байна(Зураг №2).

Нийлмэл хэллэгийг задлавал “Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээг дагаж мөрдөхгүй”, “Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй” гэсэн хэллэгүүд үүсэх бөгөөд нэгэн зэрэг үнэн байх боломжтой учир энэ бол ерийн нийлмэл хэллэг юм.

Жишээ №6:

“Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ.”

Энэ жишээнд ойлголтын багтаамжийн хамтран захирагдах харилцаанд суурилан хийсэн хуваарийн гишүүдийг тоочсон байна. Энэ бол ойлголтын багтаамжийн таксономи хуваарийн нэгэн төрөл бөгөөд хуваагдагч ойлголт нь “хууль санаачлах эрх эдлэх субъект”, хуваарийн гишүүд нь “Ерөнхийлөгч”, “Улсын Их Хурлын гишүүн”, “Засгийн газар” гэдэг ойлголтууд байна. Уг нийлмэл хэллэгийг бүрдүүлж буй “Ерөнхийлөгч хууль санаачлах эрх эдэлнэ”, “Улсын Их Хурлын гишүүн хууль санаачлах эрх эдэлнэ”, “Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ” гэсэн хэллэгүүд нэгэн зэрэг үнэн утгатай байж гэмээнэ хэллэг бүхэлдээ үнэн байх учир энд хэрэглэсэн таслал бол конъюнкци мөн бөгөөд ерийн нийлмэл хэллэг үүсгэж байна.

2.Эрс биш заагт (нэгдмэл заагт) хэллэг

Аливаа юмс үзэгдлийн сэтгэгдэж буй боллоцоотой шинж тэмдэгүүд нь харилцан бие биеэ тусгаарлаагүй заагт хэллэгийг эрс биш (буюу нэгдмэл) заагт хэллэг гэдэг<sup>1</sup>. Бүрдүүлж байгаа энгийн хэллэгүүд нь нэгэн зэрэг худал байхад л зөвхөн худал байдаг, бусад тохиолдолд, өөрөөр хэлбэл, бүрэлдэхүүнд нь ядаж нэг үнэн хэллэг оролцсон тохиолдолд үнэн утгатай байдаг нийлмэл хэллэг юм. Монгол хэлний “буюу” гэдэг холбоос үгээр ихэвчлэн холбогдож үүсдэг. Зарим тохиолдолд таслалаар холбогдсон байх нь бий. Ийм нийлмэл хэллэгийн логик томъёо байна. Энд нь “буюу” гэсэн холбоосыг тэмдэглэж байна.

Жишээ №7:

“Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах тухай өөрөө санаачилсан болон Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн авснаас хойш арван тав хоногийн дотор Засгийн газрыг огцруулах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ.”

<sup>1</sup> Норовсамбуу С. Логик. 1977. Т. 93.



Энэ хэллэгт “болон”, “,-”-аар “Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах тухай өөрөө санаачилсан”, “Ерөнхийлөгчийн саналыг хүлээн авсан”, “Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн авсан” гэсэн тохиолдлуудыг нэмж нэгтгэсэн байна. Энэ хэллэг эдгээр тохиолдлуудын ядаж нэг нь үнэн үед Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах эсэхийг арван тав хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ гэсэн утгатай байна. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн аваагүй боловч Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах тухай өөрөө санаачилсан тохиолдолд Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах эсэхийг арван тав хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ. Бусад бүх тохиолдолд мөн адил байна.

Таслал хэрэглэсэн нэгдмэл заагт хэллэгт нэмэх үйлдлийн үр дүнд үүссэн нийлмэл ойлголтыг ашигладаг. Ойлголтын багтаамж дээр суурилан хийх нэмэх үйлдэл нь тухайн ойлголтуудын бүх элементийг багтаасан олонлог үүсгэх зорилготой байдаг. Ойлголтуудын хоорондын огтлолцох, хамтран захирагдах, эсрэг, зөрчил харилцаанд суурилан энэ үйлдлийг хийж болно.

Хуулийн хэллэгт таслал хэрэглэсэн зарим тохиолдол дээр дурьдсанаас ч илүү ээдрээтэй асуудлыг үүсгэдэг. Таслалаар холбогдсон нийлмэл хэллэгийг ерийн нийлмэл үү, нэгдмэл заагт хэллэг үү гэдгийг эх хэлний болон логикийн үүднээс ялгахад төвөгтэй байдгаас эрх зүйн олон төрлийн маргаан үүддэг.

Жишээ болгон, Монгол Улсын Үндсэн хуулийн жаран тавдугаар зүйлийн 4-т “Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн хууль зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно” гэсэн заалтад анализ хийж үзье.

Энэ хэллэг бол ерөнхий бүтцийн хувьд имплицитив буюу нөхцөлт нийлмэл хэллэг байна. Ийм нийлмэл хэллэг үндэслэгээ (антецедент) ба мөрдлөгөө (консеквент) гэсэн логик бүтэцтэй байх бөгөөд логик томъёо нь болно. Энэ тохиолдолд, хэллэгийн “Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн хууль зөрчсөн” гэсэн хэллэг нь үндэслэгээ, “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно” гэсэн хэллэг нь мөрдлөгөө байна. Үндэслэгээ ба мөрдлөгөө нь мөн тус бүр нийлмэл хэллэгээр илэрхийлэгдсэн байна.

Уг нийлмэл хэллэгийн үндэслэгээ болж буй “Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн хууль зөрчсөн” гэсэн хэллэгт хэрэглэсэн

таслал бол “Үндсэн хуулийн цэцийн дарга хууль зөрчсөн” ба “Үндсэн хуулийн цэцийн гишүүн хууль зөрчсөн” гэсэн хэллэгүүдийн ядаж нэг нь үнэн байхыг шаардаж байна. Учир нь, Монгол Улсын Үндсэн хуулийн жаран тавдугаар зүйлийн 3-т “Үндсэн хуулийн цэцийн даргаар есөн гишүүний аль нэгийг гурван жилийн хугацаагаар гишүүдийн олонхийн саналаар сонгоно” гэж заасан учир “Үндсэн хуулийн цэцийн дарга” гэдэг бол “Үндсэн хуулийн цэцийн гишүүн” гэдэг төрөл ойлголтын дүрс мөн гэж тооцож болно. Иймд, “Үндсэн хуулийн цэцийн гишүүн хууль зөрчсөн” гэсэн хэллэг дангаараа ч энэ хэллэгийн үндэслэгээ болж чадна.

Тийм учраас, энэ (үндэслэгээ) бол нэгдмэл заагт хэллэг бөгөөд логик томъёо нь болно.

Харин дээрх нийлмэл хэллэгийн мөрдлөгөө болж буй “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно” гэдэг хэллэгт хэрэглэсэн таслал бол Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл болох “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр” ба “анх илгээсэн байгууллагын санал” гэдэг ойлголтоор нэрлэгдэж буй юмсын олонлогийг нэмэх аргаар нэгтгэж байна. Учир нь, эдгээр ойлголтууд багтаамжийн хувьд үл тохирох харилцаатай тул үржүүлэх үйлдэл хийх боломжгүй, харин нэмэх үйлдэл хийж болно.

Эдгээр ойлголтыг модаль хэллэгт таслалаар нэгтгэсэн учир “...-ийг Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно”, “...-ийг анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно” гэсэн хэллэгүүд нэгэн зэрэг үнэн байх зөвхөн тэр тохиолдолд л нийлмэл хэллэг бүхэлдээ үнэн байна гэж гарцаагүй нотлох аргагүй юм. Учир нь, монгол хэлэнд таслалаар “бөгөөд”(конъюнкци), “буюу”(эрс биш дизъюнкци) холбоосын аль алиныг нь орлуулж болдог.

Албан ёсны эсх нь мадаггүй биш боловч, олон нийтэд нээлттэй болсон нэгэн нийтлэлд УИХ-ийн гишүүн Х.Тэмүүжин: “1992 оны тавдугаар сарын 6-ны Улсын Бага Хурлын тэмдэглэл. Өөрөөр хэлбэл Үндсэн хууль 1992 оны нэгдүгээр сарын 13-нд баталсан. Батлагдсанаас хойш гурван сар хүрээгүй байхад Улсын бага хурал Цэцийн тухай хуулийг батласан. Тэр үед гишүүд ямар байр суурьтай байсан бэ гэдгийг бичсэн тэмдэглэл байна. Энэ тэмдэглэлийн 22 дугаар хуудсанд “эсвэл Цэц өөрөө шийдвэр гаргана. Эсвэл энэ талаар илгээсэн байгууллага нь санал болгосон бол гэсэн хоёр эх үүсвэрийг ойлгож



байгаа шүү. Энэ хоёр бол нэг холбоосоор биш эсвэл гэдгээр холбогдож байгаа шүү” гэсэн байгаа юм”<sup>2</sup> гэжээ.

Монгол хэлний “эсвэл”, “эсхүл”, “эсвээс” гэдэг холбоос бол тусгаарламал заагт (эрс дизьюнктив) хэллэгийн холбоос бөгөөд “аль нэг нь” гэсэн утгатай.

Тусгаарламал заагт хэллэгийг гэж тэмдэглэх ба энд бол холбоосын гишүүний тоо бөгөөд байна. Тусгаарламал заагт хэллэг бол бүрдүүлж байгаа энгийн хэллэгүүдийнх нь, өөрөөр хэлбэл, -ийн зөвхөн, аль нэг нь үнэн байхад л үнэн байдаг нийлмэл хэллэг юм<sup>3</sup>. Ийм учраас, тусгаарламал заагт хэллэгийн логик холбоос болох “эсвэл”, “эсхүл”, “эсвээс” гэдэг холбоосыг таслалаар орлуулах боломжгүй.

Дээрх нөхцлүүдийг харгалзан үзэж, энэ хэллэгийг нэгдмэл заагт(эрс биш дизьюнктив) хэллэг гэж тооцохоос өөр аргагүй бөгөөд логик томъёо нь болно.

Ингэвэл, Үндсэн хуулийн жарантандугаар зүйлийн 4 дэх заалтын логик томъёо бүхэлдээ болно.

Нийлмэл хэллэгийн логик холбоос бүр үнэний тогтсон утгатай байдаг. Логик холбоос байх ёстой газраа байхгүй бол, эсвэл, байх ёсгүй газраа байгаад байвал хэллэгийн утга алдагддагийг дараах жишээнээс харж болно: Жишээ №8:

“Энэ хуулийн 81.1-д заасан зорилгоор төр, нийгмийн зүтгэлтнийг алсан бол арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.”

Эрүүгийн хууль дахь энэ хэллэгээс “эсхүл” холбоосыг авч хаяад, зөвхөн таслалаар холбочихвол хорих ба цаазаар авах ялын аль нэгийг биш, харин аль алиныг нь хэрэглэх ёстой болно.

Жишээ №9:

“Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргана.”

Үндсэн хууль дахь энэ хэллэгт хэрэглэсэн “буюу эсхүл” гэсэн “марзан” холбоос логикийн хувьд буруу бөгөөд хуулийн энэ заалтыг яв цав, нэгэн утгатайгаар ойлгох боломжийг эрс үгүйсгэж байна<sup>4</sup>.

Цэцийн тухай хуулийг анх батлаж байх

<sup>2</sup> <http://politik.mn/post/6324> 3-р сарын 13-нд үзсэн.

<sup>3</sup> Ивлев Ю.В. Логика для юристов. М.: “Дело”, 2000. С. 51-52.

<sup>4</sup> Энэ үгүүлийн сэдэвт холбогдолгүй боловч Үндсэн хуульд “Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол...” гэсэн имплицитив(нөхцөлт) нийлмэл хэллэг оршин байх боломжгүй. Учир нь, хэрвээ Үндсэн хуульд өөрөөр заасан бол тэр нь логик зөрчилд хүргэнэ.

үед бичсэн гэх дээрх тэмдэглэлд байгаа мэдээлэл үнэн бол заавал хэрэглэх ёстой логик холбоосыг хэрэгтэй тохиолдолд нь хэрэглээгүй хэрнээ хэрэглэх шаардлагагүй, хэрэглэх боломжгүй тохиолдолд “тун хайхрамжгүйгээр” Үндсэн хуульд хэрэглэсэн болж таарч байна.

### Дүгнэлт, санал

Хуульд таслал болон бусад логик холбоосыг хэрэглэхэд тухайн холбоосын үнэний логик утгыг нягт нямбай харгалзан үзээгүйгээс шалтгаалан эрх зүйн олон төрлийн маргаан, хийдэл үүсдэг байна. Иймд, хэллэгт логик холбоосын үүрэг гүйцэтгэдэг эх хэлний холбох үгсийг, зөвхөн хуульд ч биш, ерөөс эрх зүйн хэлэнд оновчтой хэрэглэж хэвших хэрэгтэй, шаардлагатай байна. Ялангуяа, тусгаарламал болон нэгдмэл заагт хэллэгийн логик холбоосыг таслалаар орлуулах нь шийдвэрлэхэд төвөгтэй эрх зүйн маргаан, эргэлзээ дагуулдаг.

Ийм, үнэний утгыг нь тогтооход төвөгтэй нөхцөлд байн байн орохгүйн тулд, хууль хүн бүрт тэгш үйлчлэх боломжийг бүрдүүлэхийн тулд, хуулийг олон янзаар тайлбарлах, олон утгаар хэрэглэх боломжийг хязгаарлахын тулд, ядаж, Үндсэн хуульд:

\*Тусгаарлан зааглах “эсвэл”, түүнтэй ижил төрлийн холбоосыг таслалаар огт орлуулахгүй байх;

\*Нэгтгэн зааглах “буюу” холбоосыг таслалаар боломжтой бүх тохиолдолд орлуулахгүй байх;

\*Тусгаарлан зааглах “эсвэл”, нэгтгэн зааглах “буюу” холбоосыг нэгэн зэрэг (хамтад нь) огт хэрэглэхгүй байх шаардлагатай байна.

### Ном зүй

1.Ивлев Ю.В. Логика для юристов. М.: “Дело”, 2000.

2.Норовсамбуу С. Логик. 1977.

3.Оюунбаатар Х. Логик. Бүдүүвч, дасгал. УБ., 2011.

4.Сальников В.П., Назаренко А.Ф., Караваев Э.Ф. Логика. Учебник для юридических вузов. СПб.: Фонд “Университет”, 2003.

5.Монгол Улсын Үндсэн хууль

6.Монгол Улсын Эрүүгийн хууль

7.<http://politik.mn/post/6324>



## МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТОГТОЛЦООТОЙ ХОЛБООТОЙ ҮҮССЭН ҮНДСЭН ХУУЛИЙН МАРГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

**Т.Азжаргал**

ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн  
эрх зүйн онолын тэнхимийн багш, ахлах дэслэгч

Түлхүүр үг: Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаан- Үндсэн хуулийн эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх шүүхийн практик, үндсэн хуулийн зөрчил, Үндсэн хуулийн хяналт, Үндсэн хуулийн эрх зүйн зөрчил, Үндсэн хуулийн шүүх, шүүх эрх мэдэл, шүүх, шүүхийн тогтолцоо, шүүх

Шүүхийн мөн чанар, шүүхийн шинэтгэлийн явц үр дүн нь төрийн эрх мэдлийн (“хууль тогтоох”, “гүйцэтгэх”, “шүүх” гэсэн) гурван салаанд шүүх эрх мэдлийн эзлэх байр, статусыг хэрхэн тодорхойлсоноор буюу засаг төрийн байгууллагын тогтолцоонд шүүх эрх мэдлийн эзлэх байр сууриар тодорхойлогдоно.<sup>1</sup>

Түүний эрх зүйн үндсийг Үндсэн хуулийн “Төрийн байгуулал” гэсэн III бүлгийн 4 дэх хэсэг (дэд бүлэг) (47-56), түүнчлэн Үндсэн хуулийн хяналтын шүүх болох Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн эрх зүйн байдлыг “Үндсэн хуулийн Цэц” гэсэн V бүлэг мөн холбогдох бусад зүйл 8; (14-ийн 1, 16-ийн 1-ийн 14 дэх) хэсэгт тус тус тодорхойлжээ. Эдгээр үндэслэл, заалтыг бүхэлд нь шүүх эрх мэдлийн Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл гэж ойлгож болно.

Шүүх эрх мэдлийн талаарх Үндсэн хуулийн нэг дэх заалт нь “Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” (47,1) гэсэн томъёололтой. Үүнээс л бусад бүх заалтын утга агуулга эх ундаргатай.

Тэгэхээр Монгол Улсын түүхэнд шүүхийн тогтолцоотой холоотой үндсэн гурван төрлийн маргаан гарж байсан бөгөөд тэдгээрийг авч үзвэл 1994.04.15 [Дүгнэлт

№05], 1994.11.09 [Тогтоол №02], 2014.12.10 [Дүгнэлт №07], 2015.01.30 [Тогтоол №01], 2015.11.11 [Дүгнэлт №14], 2016.01.28 [Тогтоол №01] зэргийг дурдаж болно. Тухайлбал эдгээр маргаан чухам юунаас болов гэхээр “Шүүхийн тогтолцоо” тэр дундаа Монгол Улсын “шүүхийн үндсэн тогтолцоо”, “шүүхийн шатлал” хэмээх нэр томъёог Үндсэн хуульд хэрхэн тусгасан Үндсэн хуулийн өөрийнх нь мөн чанар үзэл баримтлал юу байв гэдэг дээр маргасан байна.

Тэгэхээр шүүийн тогтолцоо гэж юу вэ?, тэр дундаа үндсэн шүүхийн тогтолцоо? дагнасан шүүхийн тогтолцоо зэрэг асуултанд онолын хариулт өгөх шаардлага гарч байна.

Тийм болохоор Шүүх эрх мэдэл гэж юу вэ? Тэр нь төрийн эрх мэдлийн тогтолцоонд ямар байр суурь эзэлдэг вэ? гэдгийг анхлан авч үзэхээс өөр аргагүй. Тэгэхдээ өмнөх үетэй нь жишихгүйгээр үзэл баримтлалын шинэ, хуучныг ялгах дөт боломж мөхөс. Социалист тогтолцоон дахь “шүүн таслах ажил”, ардчилсан тогтолцоон дахь “шүүх эрх мэдэл” гэсэн хоёр үзэгдэл адил төстэй зүйл нэлээд бий ч, мөн чанар, үүрэг ач холбогдлоороо эрс ялгаатай.

Монгол Улс 1960-аад оноос “Социализм байгуулж дуусгах үедээ орсноос хойшхи 30 жилд зарим өөрчлөлт хийж байсан ч БНМАУ-ын шүүхийн систем нь: а) ардын шүүх<sup>2</sup>, б) аймаг, хотын шүүх<sup>3</sup>, в) тусгай

<sup>2</sup> **Ардын (хэсгийн) шүүх** бол БНМАУ-ын шүүхийн системийн үндсэн салаа байсан. Аймгуудад нэг чиглэлийн хэд хэдэн сумыг харьяалсан хэсгийн шүүх, орон нутгийн хотын шүүх, Улаанбаатарт районы шүүх, Дархан, Эрдэнэт хотод хэсгийн шүүх ажиллаж байжээ. Ардын шүүх нь шүүгч, ардын төлөөлөгчдөөс бүрэлдэж байв. Харин районых нь хэд хэдэн шүүгчтэй тул шүүхийн даргатай байна. Дарга нь шүүгчдийн бүрэлдэхүүнд орж шүүн таслах ажлын зэрэгцээ шүүхийн удирдлагын буюу захиргааны үүрэг биелүүлж байв. Хэсгийн болон хотын ардын шүүхэд орон тооны биш нарийн бичгийн дарга, районы ардын шүүхэд орон тооны нарийн бичгийн дарга, тогтоол гүйцэтгэгч нар ажилладаг байжээ.

<sup>3</sup> БНМАУ-ын шүүх, социалист ололтыг хамгаалах манаанд. ред. Р.Гүнсэн. УХГ., УБ., 1977. 93-97 дахь тал “...**Аймаг, хотын шүүх**. Тухайн үед БНМАУ-д 18 аймаг, улсын харьяалалтай (Улаанбаатар, Дархан, Эрдэнэт) 3 хотын шүүх ажиллаж байв. Эдгээр шүүх бол тус улсын шүүхийн системийн хоёр дахь салаа нь байсан юм. Аймаг, хотын шүүх нь шүүн таслах бүрэн эрхийн хувьд анхан шатны төдийгүй давж заалдах (хоёрдугаар) болон хяналтын шатны шүүх байв. Тэдгээр нь а) хуулиар харьяалуулсан эрүү иргэний хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэх, б) ардын шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болоогүй тогтоол, шийдвэр, магадлалтай хэргийг давж заалдах (хоёрдугаар) шатны журмаар шийдвэрлэх, в) мөн ардын шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр, тогтоол, магадлалтай хэргийг шүүх прокурорын эрх бүхий албан тушаалтны эсэргүүцлийн үндсэн дээр хяналтын шатны журмаар шийдвэрлэх эрх, үүрэгтэй байв. Аймаг, хотын шүүх нь өөрийн харьяа ардын шүүхийн шүүн таслах ажилд хяналт тавьж, ялын нэгдсэн бодлогыг хангуулахад чухал үүрэг гүйцэтгэж байв. Шүүхийн хяналтын энэхүү үүргээ ардын шүүхийн таслан шийдвэрлэх хэргийг нь

<sup>1</sup> Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008. 302 дахь тал.



шүүх<sup>4</sup>, г) Улсын Дээд шүүх<sup>5</sup> гэсэн дөрвөн салаа мөчрөөс бүрэлдэж байв. Энэхүү уламжлалтай холбоотой МУ-ын шинэ Үндсэн хуулийн 48-р зүйлд "...Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно." гэж заажээ. Энэ өгүүлбэрийг хэрхэн ойлгохоос хамаарч Үндсэн хуулийн дээрхи гурван төрлийн маргаан гарсан байна.

Ном зохиолд шүүхүүдийг нийгэм-эрх зүйн үүднээс нь "ерөнхий шүүх", "тусгай шүүх" гэж 2 ангилдаг байсан бөгөөд энэ жишгийг харгалзахын хамт төрийн эрх мэдлийн "хууль тогтоох", "гүйцэтгэх" хоёр салаатай шүүхийн тэнцвэрт байдлыг хангахын тулд Монгол Улсын шүүхийн тогтолцоог "үндсэн", "дагнасан" болон бие даасан төрөлжсөн шүүхээс бүрдэхээр тодорхойлж, уялдаа холбоог нь тогтоосон ба харин ямар нэг тусгай шүүх байгуулахыг хориглосон ажээ.<sup>6</sup> Төрөлжсөн шүүх нь Үндсэн хуулийн шүүх юм.

Энэ утгаар эрүүгийн болон иргэний хэргийн шүүхийг дагнасан шүүхээс ялгахын тулд ерөнхий шүүх гэж нэрлэх заншил байжээ. Шүүхийн тухай 1993 оны хуулиар шүүхийн тогтолцоог анхан шатны буюу сум, сум дундын, дүүргийн шүүх; давж заалдах, хяналтын шатны буюу аймаг, нийслэлийн

хоёрдугаар болон хяналтын шатны журмаар хянаж үзэх замаар хэрэгжүүлдэг байв. Хоёрдугаар болон хяналтын шатны үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд аймаг, хотын шүүхийн хяналтын коллеги байгуулагдан ажиллаж байв. Түүнчлэн аймаг, хотын шүүхийн дарга нь тус шүүхийн ажлын аппаратыг удирдахын гадна аймаг, хотын хэмжээн дэх ардын шүүхийг зохион байгуулалтын талаар жолоодох үүрэг биелүүлдэг байсан.

<sup>4</sup> Хилийн ба дотоодын цэргийн, төмөр замын зэрэг тусгай шүүхүүд ажиллаж байсан бөгөөд БНМАУ-ын шүүхийн системд Улсын Дээд шүүх онцгой байр эзэлж байв.

<sup>5</sup> БНМАУ-ын Дээд шүүх бол шүүн таслах дээд байгууллага мөн гэж Үндсэн хуульд заажээ. Ийнхүү Дээд шүүх тус улсын шүүхийн дээд байгууллага болох нь түүний чиг үүрэг эрх хэмжээгээр юуны өмнө илэрч байв. БНМАУ-ын Шүүх явдлын яам шүүхүүд байгуулагдсан үеэс тэдгээр шүүхийг зохион байгуулалтын талаар удирдах үүргийг 1959 оны эцэс хүртэл гүйцэтгэж байгаад татан буугдаж түүний үүрэг УДШ-ийн Тэргүүлэгчдэд шилжсэн байна. 1973 онд тус яам сэргээн байгуулагдсан боловч уг үүргийг эгүүлэн шилжүүлээгүй шинэ цаг үетэй золгосон юм. Харин Шүүх яам Хууль зүйн яам болж хууль тогтоомжийн төсөл боловсруулах энэ талаар дүгнэлт өгөх, хууль системчилэх, өмгөөлөх болон хууль зүйн зөвлөгөө өгөх газар, гэр бүлийн бүртгэл, нотариатын байгууллагыг зохион байгуулалтын талаар удирдах, хүн амын эрх зүйн хүмүүжлийн ажлыг улсын хэмжээгээр зохицуулах гол үүрэгтэй байв.

<sup>6</sup> Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008. 311-316 дахь тал.

шүүх; давж заалдах, хяналтын шатны буюу Улсын Дээд шүүх гэсэн хэлбэртэй байсныг 2002 оны хуулиар анхан шатны буюу сум, сум дундын, дүүргийн шүүх; давж заалдах шатны буюу аймаг, нийслэлийн шүүх; хяналтын шатны буюу Улсын Дээд шүүхээс бүрдэхээр, 2013 оны шүүх байгуулах тухай хуулиар аймаг дундын, дүүрэг дундын шүүхийг байгуулж, эрүү, иргэн, захиргааны хэргийн төрлөөр шүүхүүдийг дагнан байгуулсан бол 2015 оны шүүх байгуулах тухай хуулиар Үндсэн хуулийн зөрчлийг арилгах үүднээс шүүхүүдийн байршлыг хүн ам, шийдвэрлэсэн хэрэг маргааны тоо зэргийг харгалзан байгуулсан шүүхийн дугаарыг өөрчилж, дүүргийн нэрээр нэрлэж шүүхийүүдийг тойргийн журмаар өөрчлөн байгуулжээ. Энэхүү өөрчлөлтүүдийн үр дүнд тус тус Үндсэн хуулийн маргаан үүсч байсан бөгөөд маргааны гол агуулга нь шүүхийн тогтолцоо, шүүхийн шатлал гэсэн нэр томъёон дээр талууд маргалдаж байв.

Шүүхийн бүрэн эрхтэй холбогдсон шатлал гэж нэг ойлголт бий. Шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа нь гомдол, нэхэмжлэлийг аль шатанд хянаж байгаагаар:

- Анхан шатны шүүхийн ажиллагаа;
- Давж заалдах шатны шүүхийн ажиллагаа;
- Хяналтын шатны шүүхийн ажиллагаа гэж гурав дарааллан хувааж журамласан байна.

Дээрхи онолын ойлголтыг хууль тогтоогч хуульчлахдаа хэрхэн ойлгож хуульчилсан, иргэд хэрхэн ойлгосон, Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийг юу гэж тайлбарлаж, маргааныг шийдвэрлэсэн эсэхэд анализ хийе.

### Маргааны тойм ба Үндсэн хуулийн хяналтын хэлбэр

Нэг дэх маргаан буюу 1994.04.15 [Дүгнэлт №05], 1994.11.09 [Тогтоол №02]-ын оролцогчдын байр суурийг авч үзвэл Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгүүдэд «Шүүхийн үндсэн тогтолцоо нь Монгол Улсын Дээд шүүх, аймаг, нийслэл, сум буюу сум дундын дүүргийн шүүхүүдээс бүрдэнэ» гэж заасан. Гэтэл Улсын Их Хурлын 1993 оны 6 дугаар сарын 14-ний хуулиар нийслэлд 12 дүүрэг буюу захиргааны нэгж байхад 8 дүүргийн шүүх байгуулж 4-ийг нь дүүрэг дундын /Хан-Уул дүүргийн, Баянзүрх-Гачуурт дүүргийн, Сонгинохайрхан-Жаргалант дүүргийн, Багануур-Багахангай дүүргийн/ болгон байгуулжээ. Эдгээр шүүхүүдийн тамга, тэмдэг, хаяг, албан бичгийн маягт нь дүүрэг дундын хэлбэрээр хийгджээ. Эдгээр байдлуудаас үндэслэн үзэхэд Шүүх байгуулах тухай Монгол Улсын 1993 оны хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1, 3, 5, 7 дахь заалтууд Монгол





Улсын Үндсэн хуультай зөрчилдөж байна гэж үзжээ.<sup>7</sup> Онцлоо нь Үндсэн хуулийн цэц хяналтыг хэрэгжүүлэхдээ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тайлбар авч шийдвэр гаргахдаа харгалзан үзсэн байдаг.<sup>8</sup>

Хоёр дахь маргаан буюу 2014.12.10 [Дүгнэлт №07], 2015.01.30 [Тогтоол №01]-ын оролцогчдын байр суурийг авч үзвэл өмнөх маргаанаас илүү Үндсэн хуулийн зүйл заалтыг хэл зүйн үүднээс тайлбарлаж өөр өөрийн байр суурийг хамгаалсан бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулиар шүүхийн тогтолцоог хэрхэн тодорхойлсон талаар онолын маргаан өрнүүлсэн.

Дурдвал, Монгол Улсын Их Хурлаас 2013 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр баталсан “Шүүх байгуулах тухай” хуулийн /шинэчилсэн найруулга/ 1 дүгээр зүйлд аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүхийг иргэний, эрүүгийн болон захиргааны шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоохдоо 2-3 аймгийн нутаг дэвсгэрийг харьяалуулан дунд нь давж заалдах шатны нэг шүүх байхаар; Нийслэлийн

<sup>7</sup>Иргэн: Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд «дүүргийн шүүх» гэж заасан байтал Шүүх байгуулах тухай хуулиар «дүүрэг дундын шүүх» байгуулан Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн байна. Үнэхээр “дүүрэг дундын” шүүх байгуулах шаардлагатай байсан юм бол Үндсэн хуулийн заалтыг өөрчилж дээрх дүүргүүдийн Засаг дарга нарыг “дүүрэг дундын” Засаг дарга болгон томилох шаардлага гарах ёстой... гэж үзсэн бөгөөд, УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч хариу тайлбартаа “Улсын Их Хурлын дүүрэг дундын шүүх байгуулаагүй бөгөөд хуучин ажиллаж байсан хэсэг, район /нийслэлийн/, орон нутгийн хотын шүүхийг сум болон сум дундын, дүүргийн шүүх болгон өөрчлөн байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоосон юм. Ингэхдээ хоёр дүүргийг нэг шүүхэд /анхан шатны шүүхийн эрхтэй/ харьяалуулж, тэдгээрийг «Багануур, Багахангай дүүргийн шүүх» гэх мэтээр нэрлэсэн болно. Үүнийг өргөдөл гаргагч дүүрэг дундын шүүх байгуулсан гэж буруу ойлгосон бололтой. Шүүхийн харьяалал нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарьт захирагдах ёсгүй бөгөөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг дагуулан шүүх байгуулах тухай хуулийн заалт байхгүйг дурьдах нь зүйтэй. Сум дүүрэг хоёр нь ижил засаг захиргааны нэгж” юм. Шүүх байгуулах нэгэн үндэслэл бол тойргийн зарчим болно. Энэ зарчмын дагуу Улсын Их Хурал шүүх байгуулах хуульд өөрчлөлт оруулан нийслэлийн дүүргийн шүүхүүдийг тойргийн системээр байгуулсан гэж үзсэн.

<sup>8</sup>Шүүхийн ерөнхий зөвлөл: “... Нийслэлийн зарим шүүхийг хоёр дүүргийн шүүх байхаар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс боловсруулж Монгол Улсын Их Хуралд оруулахдаа Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүх байгуулахдаа түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтрал, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хэрэг, маргааны гаралтын түвшинг харгалзан үзнэ” гэж заасныг удирдлага болгосон юм. Нийслэлийн дүүргийн зарим шүүхийг хоёр дүүрэгт байгуулснаар Үндсэн хууль, Шүүхийн тухай хуулийг зөрчөөгүй гэж үзэж байна...” гэжээ.

шүүхийн оронд Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх гэж нэрлэн Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж болон Төв, Хэнтий аймгийн зарим сумын нутаг дэвсгэрийг харьяалуулсан<sup>9</sup>; мөн хуулийн 2 дугаар зүйлд анхан шатны шүүхийн байршил, тэдгээрийн нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоохдоо Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1, 2, 3, 4 дүгээр шүүх, Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1, 2, 3, 4 дүгээр шүүх гэж нэрлэн хэд хэдэн дүүргийг нэг шүүхэд; мөн нийслэлийн зарим дүүрэг болон Төв, Хэнтий аймгийн зарим сумыг нэг шүүхэд харьяалуулан дүүргийн иргэний хэргийн анхан шатны 4, эрүүгийн хэргийн анхан шатны 4 шүүх байгуулж Улаанбаатар хотод зүүн, баруун бүс, Багануур, Налайх дүүрэгт байршуулсан; Захиргааны хэргийн анхан шатны 6, 11 дүгээр шүүхийг байгуулахдаа тус бүр 2 аймгийн нутаг дэвсгэрийг нэг шүүхэд харьяалуулсан нь шүүхийн үндсэн тогтолцоог үгүйсгэж, иргэний үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах Үндсэн хуулийн суурь зарчим, шүүхийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлсэн Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй харагдана.

Гэвч Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын дээд шүүхээс бусад шүүхийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр нэрлэсэн хэдий ч мөн чанараар нь авч үзвэл аливаа этгээдийг шүүхээр хэрэг, маргаанаа эцэслэн

<sup>9</sup>Шигтгээ: Эрүүгийн хэргийн гэрчээр шүүх, цагдаад дуудагдаад жил орчим болж байна. Өнгөрсөн хугацаанд олон удаа дуудагдлаа, их хэцүү. Анх шүүхэд дуудагдсаныхаа дараа л Хархорин шүүхэд харьяалагдаж байгаагаа мэдсэн. Өмнө нь Зуунмодод очдог байсан нь илүү амар байсан. Эндээс 10,000 төгрөгөөр хот хоорондын унаанд суугаад хот ордог, хотоос 2,000 төгрөгөөр аймаг ордог. Аймаг орох шаардлага хүн бүхэнд байна. Очоод ажлаа бүтээхээс гадна амьтан ах дүүтэйгээ уулзах, буцахдаа хотоос хэрэгтэй зүйлээ худалдаж авах гээд хэд хэдэн ажил амжуулаад ирдэг байсан бол одоо Өвөрхангайд хүн танихгүй, очих айлгүй болохоор гудамжинд суугаад л шүүгч, цагдаа нь хэзээ дуудахыг хүлээгээд суух нь үнэхээр хүнд байна. Хөдөөний бид мөнгө төгрөг муутай. Танилгүй газар чинь аяга цай хүртэл мөнгөөр авдаг. Хоол, буудал гэвэл бүр ч барахгүй. Гэхдээ гэрээсээ авч явсан хүнс дуусвал хоол авч идэхээс явахав. Хоолны зардалаас илүү замын зардал их хүндрэлтэй. Манай эндээс Хархорин явдаг унаа байхгүй. Шүүх явах гээд унаа хайна, хамт яваад зардал хуваалцах хүн хайна. Бөөн ажил. Хүмүүст тийшээ явах шаардлага ер алга. Ганцаараа явахаар шатахууны зардал талдаа 20 гаруй мянга болно, дээрээс нь жолоочдоо жаал жуул юм өгнө. Сүүлдээ бүр цагаандаа гарсан. Мөнгөгүй үедээ мөрдөн байцаагчийнхаа унаанд дайгдах болсон. Ингээд бодохоор шүүх хэдий ойртсон ч гэлээ хүрч очиход улам хэцүү болсон. Шүүх шилжсэнээр иргэнээс гарах зардал ер нь хамгийн багадаа 2 дахин их болсон.



шийдвэрлүүлэх, давж заалдах гомдол гаргах эрхийг баталгаажуулсан шүүхийн тогтолцоог шатлан байгуулсан гэж үзэх үндэслэлтэй.

... Монгол Улсын Үндсэн хуульд иргэн сум дундын шүүхийн шийдвэрт гомдож аймгийн шүүхэд гомдол гаргах эрхтэй гэж заагаагүй. Харин анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүхэд, давж заалдах буюу хоёрдугаар шатны шүүхийн шийдвэрийг хяналтын буюу гуравдугаар шатны шүүхэд тус тус давж заалдах эрхтэй гэдгийг заажээ.

“Шүүхийн тогтолцоо”, “Шүүхийн харьяалал” гэсэн ойлголтыг ялгах нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тайлбарлан хэрэглэх гол сэжиг мөн бөгөөд “Шүүхийн харьяалал” нь шүүхийн хэрэг, маргаан харьяалан шийдвэрлэх нутаг дэвсгэрийн цар хүрээг илэрхийлдэг бөгөөд иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаатай эдлүүлэхийн тулд шүүхийн үр нөлөөтэй, хүртээмжтэй байдал зэрэг хүчин зүйлсийг харгалзан хууль тогтоогч түүнийг тогтоож байх учиртай.

Гэвч маргааны гол агуулга нь МУ-ын Үндсэн хуулиар тодорхойлсон шүүхийн Үндсэн тогтолцоог улсын дээд шүүх, аймаг нийслэлийн шүүх, сум буюу сум дундын дүүргийн шүүх гэж тодорхойлсоныг УИХ-аас Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд шүүхийн тогтолцоог Шүүхийн тухай хууль болон Шүүх байгуулах тухай хуулиар анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүх, хяналтын шатны шүүх гэж тодорхойлсон бөгөөд иргэн шүүхийн шатлалыг шүүхийн тогтолцоо гэж буруу тайлбарлаж байна гэх мэтээр маргаснаас үзэхэд Үндсэн хуулиар тодорхойлсон шүүхийн тогтолцоог хэрхэн ойлгох талаар онолын маргаан өрнүүлсэн.

Шүүх байгуулах хуультай холбогдуулан Нийслэл, дүүргийн прокурорын газруудын ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын чиглэлээр хариуцах газруудыг шинэчлэн тогтоожээ.<sup>10</sup> Түүнчлэн дээрх тушаалд заасны дагуу эрүүгийн хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрууд эрүүгийн гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн харьяаллыг харгалзан хяналт тавихаар болсон. Жишээлбэл, Дүүргийн I прокурорын газар нь Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэйн, II прокурорын газар Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол дүүргийн нутагт гарсан хэрэгт хяналт тавьж ажиллах<sup>11</sup>

<sup>10</sup> Улсын Ерөнхий прокурорын 2014 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн А/09 тоот “Аймаг, Нийслэл, дүүргийн прокурорын газрын бүтцийг шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу Нийслэлийн прокурор 2014 оны 2 дугаар сарын 25-ны өдөр А/04 тоот тушаал 11

болсон.

Дээрхи асуудлаар улсын ерөнхий прокурор<sup>12</sup>, шүүхийн ерөнхий зөвлөлөөс<sup>13</sup> тайлбар авсан байв.

Шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлд “Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх<sup>14</sup>, аймаг, нийслэлийн шүүх<sup>15</sup>, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс<sup>16</sup> бүрдэх бөгөөд ердийн болон дагнасан төрөлтэй буюу шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно” гэж зохицуулсан нь ҮХ-ийн дээр дурдсан заалтуудыг улам нарийвчилж өгсөн юм<sup>17</sup>. Дээрх эрх зүйн актуудын дагуу давж заалдах шатны шүүх болон сум дундын 29, Захиргааны хэргийн анхан шатны 22, дүүргийн эрүүгийн 4, иргэний 4 нийт 59 шүүх тойргийн зарчмаар байгуулагдан ажиллаж байна.

Ийнхүү шүүхийг тойргийн зарчмаар байгуулсан явдал нь онолын болон практикийн хувьд багагүй маргаан үүсгэсэн. Дээрхээс харахад ҮХ-ийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлээр зохицуулж буй асуудлыг хэрхэн нэг мөр ойлгох тухай тайлбар гаргах зайлшгүй шаардлага гарч байгааг илэрхийлж байна. Тухайлбал хуулийн дээрх заалтуудад “хотын шүүх” гэсэн хэсэг байхгүй, гэтэл сүүлийн үед Налайх, Багануур зэрэг дүүргүүдийг хотын статустай болгох, хот болгож бие даасан үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Иймд хот болж

<sup>12</sup> Монгол Улсын Ерөнхий прокурор: “...Иргэний Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээлэл болон мэдээллийн үндэслэгээнээс үзэхэд “Шүүх байгуулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлүүд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн” гэсэн нь үндэслэлтэй байна.

<sup>13</sup> Шүүхийн ерөнхий зөвлөл: “...Шүүх байгуулах тухай 2013 оны хуулиар Нийслэл дэх анхан шатны шүүхийг нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, хэргийн ачааллыг харгалзан шүүн таслах ажлын төрлөөр нь төрөлжүүлсэн. Ийнхүү дагнасан шүүх байгуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт, Үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлалтай нийцэж байна.” гэсэн болно.

<sup>14</sup> Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйл. Улсын дээд шүүх.

<sup>15</sup> Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүх.

<sup>16</sup> Шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйл. Анхан шатны шүүх.

<sup>17</sup> Шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйл. Шүүхийн тогтолцоо 10.1. Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх /хяналтын шатны шүүх/, аймаг, нийслэлийн шүүх /давж заалдах шатны шүүх/, сум буюу сум дундын, дүүргийн шүүх /анхан шатны шүүх/-ээс бүрдэнэ.

10.2. Улсын дээд шүүхээс бусад шүүхийг нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны тоог харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулна.



тэлсэн дүүргүүдийн хувьд шүүхтэй байх эсэх нь мөн л ҮХ зөрчих, маргаан дагуулах боломж бүрдүүлж байгаа харагдаж байна.<sup>18</sup>

Хүснэгт 1.4: Төв аймгийн шүүх болон Сум дундын 23-р шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг маргааны тоо /2010-2014 он/373839

Он	Төв /2013 оны 4 дүгээр сарын 15-аас Сум дундын 23-р шүүх/			Сэлэнгэ / Сум дундын 21-р шүүх/ <sup>1</sup>			Өвөрхангай /Сум дундын 18-р шүүх <sup>2</sup>		
	Эрүү	Иргэн	Захиргаа	Эрүү	Иргэн	Захиргаа	Эрүү	Иргэн	Захиргаа
2010	170	1404	31	284	1520	21	164	1768	38
2011	213	1494	11	279	1426	8	182	1066	22
2012	245	1423	18	337	1056	33	194	923	22
2013	270	1618	29	292	1156	31	167	1407	27
2014 <sup>3</sup>	168	533	24	146	364		60	89	

Дээрх хүснэгтээс харвал шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнөөр Төв аймгийн шүүх нь Сум дундын 23-р шүүх болж шийдвэрлэсэн хэрэг маргааны тоо 2014 онд өмнөх оноос Иргэний хэргийн хувьд 3 дахин, Эрүүгийн хэргийн хувьд 1.6 дахин буурсан байна. Энэ нь Төв аймгийн 10 сум өөр шүүхүүдэд харьяалагдах болж, шүүгч нарын тоог хоёроор цөөлсний дараах үр дүн юм.

Шүүхийн тогтолцоонд өөрчлөлт орсон нь нэг талдаа шүүх, шүүгчийн ачаалал буурсан эерэг үзүүлэлт гарч байгаа боловч нөгөө талдаа мөрдөн байцаагч, прокуроруудын ажлын ачаалал нэмэгдүүлсэн сөрөг үр дагавар бий болгосон тухай орон нутгийн судалгааны үеэр ярилцлагын судалгаанд хамрагдсан цагдаа, прокурорууд шүүмжтэй ханджээ.<sup>19</sup>

Шүүхийн тогтолцооны өмнөх болон одоогийн хэлбэрийн алийг нь илүүд үзэх вэ? Гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн 50% нь шүүхийн өмнөх тогтолцоог илүүд үзэж буй бол үлдсэн 50% нь шүүхийн одоогийн тогтолцоог илүүд үзэж байна. Иргэдийн хувьд шүүхийн тогтолцоонд орсон өөрчлөлтүүдийг мэдэхгүй, шүүхийн шинэчлэлийн талаар мэдээлэлгүй байсан нь ийм үр дүн гарахад нөлөөлсөн гэж үзэж байна. Энэ нь иргэдэд шүүхийн тогтолцооны өөрчлөлт, өөрчилсний ач холбогдол, үр өгөөжийн талаар мэдээллийг хүргэх хэрэгцээ шаардлагатайг харуулж байлаа.<sup>20</sup>

Өмнөх тогтолцоо болон одоогийн тогтолцоог илүүд үзэж буй шалтгаан гэсэн асуултанд

Өмнөх тогтолцоог илүүд үзэж буй шалтгаан	Одоогийн тогтолцоог илүүд үзэж буй шалтгаан
Анхан болон давж заалдах шатны шүүх нь тухайн аймагтаа, Төв аймагтаа байвал дээр.	Чиглэл нь өөр болохдоо иргэндээ ойр шүүх рүү явуулж байна.
Удаашралтай боловч чанартай байсан.	Хурдан шуурхай байгаа учраас.
Хуучнаараа байхыг хүсэж байна. Газар нь хол ч бусад бүх ажлаа амжуулдаг. Багийн ахлагч нар бөөгнүүлээд аваад явдаг, холбож өгдөг. Гэрчийг байнга дууддаггүй, хайрцагт нь хийж авчирдаг байсан.	Үйлчилгээ, хүртээмж өмнөхөөсөө сайжирсан хүмүүсийн ам сайн байгаа.
Аймаг унаа элбэг, зардал бага. Таних хүн элбэг. Ажлаар явах унаа нь элбэг учир дайгддаг, зам нэг зардал бага, танил олонтой, шүүх илүү ойр байсан нутаг орондоо байсан, таньдаг айлтай, цаг бага шаардана.	Төрөлжсөн болохоор арай хурдан болсон.
Өмнөх тогтолцооны хүнд үйлчлэх хүрээ нь илүү.	Шүүгчийн орон тоог нэмсэн.
	Уг нь их зүгээр, ядаж 4 жил үүнийг туршиж үзэх хэрэгтэй. Улам боловсруулах хэрэгтэй, нэлээн түүхий.
	Шүүгч тухайн чиглэлээр мэргэших бололцоо олгосон.
	Шүүх хаана байх нь хамаагүй. Тэгш үйлчилдэг байх хэрэгтэй. Тахар их далайлган сүрдүүлдэг.

Шүүх байгуулах тухай хуулийн 2.1 болон 2.4 дэх заалтын хүрээнд бий болсон ачаалал: Төв аймаг

Хуулийн өөрчлөлтийн хүрээнд Төв аймгийн иргэдэд учирч буй зардлын ачаалал, Иргэний

<sup>18</sup>Судалгааны багийн ахлагч: Ж.Бариаширсүрэн, Судлаачид: Ж.Ариунцэцэг, Б.Доржпагма "Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилт" \Төв аймгийн жишээн дээр\ УБ., 2015 он, 20-р тал

<sup>19</sup> Судалгааны багийн ахлагч: Ж.Бариаширсүрэн, Судлаачид: Ж.Ариунцэцэг, Б.Доржпагма "Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилт" \Төв аймгийн жишээн дээр\ УБ., 2015 он, 30-р тал

<sup>20</sup>Судалгааны багийн ахлагч: Ж.Бариаширсүрэн, Судлаачид: Ж.Ариунцэцэг, Б.Доржпагма "Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилт" \Төв аймгийн жишээн дээр\ УБ., 2015 он, 40-р тал

хэрэг маргаан<sup>21</sup>

Зардал нэмэгдсэн утга	Нэг иргэний	Жаргалант сумын хүрээн	Төв аймгийн хүрээнд <sup>4</sup>	Тайлбар
		Хоёр жилийн хугацаанд		
Замын зардлын өөрчлөлт	16 000 төг	73x2x16_000 <b>2 336 000 төг</b>	365x2x16 000 <b>11 680 000 төг</b>	Тогтолцоо өөрчлөгдсөнөөр бий зардлын ачаалал хамгийн багаар <sup>5</sup>
Хоёр чиглэлд явах болсноор бий болсон нэмэлт зардал	50 000 төг	73x2x50 000 <b>7 300 000 төг</b>	365x2x50 000 <b>36 500 000 төг</b>	Тогтолцоо өөрчлөгдсөнөөр бий болсон зардлын ачааллыг ойролцоогоор авч үзвэл <sup>6</sup>
Хонох тохиолдолд гарах зардлын өөрчлөлт	26 000 төг	73x2x26 000 <b>3 796 000 төг</b>	365x2x26 000 <b>18 980 000 төг</b>	-
Нийт зардлын өөрчлөлт	92 000 төг	13 493 000 төг	67 160 000 төг	-

Шүүхийн тогтолцоонд өөрчлөлт орсноор иргэдэд үүсэх ачаалал буюу зардлын үр нөлөөг Төв аймгийн жишээн дээр тооцож үзэхэд хууль санаачлагчийн “шүүхийг иргэдэд ойр сум, дүүрэгт харьяалуулан, тойргийн журмаар байгуулах нь шүүхийн үйлчилгээг иргэдэд аль болох ойртуулах” гэсэн санаатай нийцүүлэн шүүхийг орон зайн хувьд ойртуулсан мэт боловч бодит байдалд нийтийн тээвэр, зам харилцаанаас үүдэн хүндрэл үүсгэж, хэргийн онцлогоос хамааран зарим тохиолдолд зардал даруй хоёроос дөрөв дахин өссөн судалгааны дүн гарч байна. Шүүхийн байршил өөрчлөгдсөнөөр иргэн, айл өрхөд эдийн засгийн нэмэлт ачаалал бий болсон гэж дүгнэж болохоор байна

Энэхүү маргаантай асуудлыг Үндсэн хуулийн цэц дараах байдлаар шийджээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын шүүхийн нэгдсэн тогтолцоог “үндсэн” ба “дагнасан” гэсэн хоёр дэд хэсэгтэй байхаар тодорхойлж, шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс, түүнчлэн дагнасан шүүхийн тогтолцоо нь эрх зүйн маргаан, шүүн таслах ажлын төрлөөр мэргэшүүлэн байгуулсан шүүхээс бүрдэхээр байна.

Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Нэг. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Хоёр. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх; мөн хуулийн 2 дугаар зүйлийн Нэг. Дүүргийн Иргэний хэргийн

анхан шатны шүүх, Хоёр. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, түүнчлэн Гурав. Захиргааны хэргийн анхан шатны шүүх гэсний 6, 11 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн үндсэн тогтолцоо ... аймаг, нийслэлийн шүүх, ... дүүргийн шүүхээс бүрдэх ...” гэсэн заалтыг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

Энэхүү тогтоолын “Тогтоох” хэсгийн 1 дэх заалтыг 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэжээ.

Энэхүү Үндсэн хуулийн цэцийн тогтоолтой холбогдуулан УИХ-аас Шүүх байгуулах тухай хуулийг шинэчлэн батласан бөгөөд Үндсэн хуулийн зөрчил арилаагүй байна гэж үзэж Үндсэн хуулийн цэцээс 2015.11.11 [Дүгнэлт №14], 2016.01.28 [Тогтоол №01]-ийг гаргасан.

Маргааны гол онцлог нь: Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалт Үндсэн хууль зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолд заасан Үндсэн хуулийн зөрчил арилаагүй байна. Учир нь УИХ-аас 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлээр иргэний болон эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийг, 2 дугаар зүйлээр дүүргийн иргэний болон эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийг байгуулахдаа нэрийн хувьд “аймгийн” болон “дүүргийн” гэж томьёолсон боловч энэ нь 2-3 аймгийн дунд давж заалдах шатны нэг шүүх, 2-3 дүүргийн дунд анхан шатны нэг шүүхтэй байх агуулгыг илэрхийлж байгаа бөгөөд Үндсэн хуульд бэхжүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяаллын зарчмаар зохион байгуулагдах

<sup>21</sup>Нэг хүн нэг л удаа шүүхийн байгууллагад очих шаардлагатай болсон гэсэн хамгийн доод хэмжээгээр тооцоолсон болно.



Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоог үгүйсгэсэн байна.4. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Нэг.Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх гэсэн хэсгийн 1-8 дахь заалт, Хоёр.Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх гэсэн хэсгийн 1-8 дахь заалт; 2 дугаар зүйлийн Нэг.Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх гэсэн хэсгийн 1, 2, 4 дэх заалт, Хоёр.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх гэсэн хэсгийн 1, 2, 4 дэх заалт нь иргэний үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах Үндсэн хуулийн суурь зарчмыг алдагдуулж, шүүхийн нэгдсэн тогтолцоог тодорхойлсон Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна” гэж үзсэн.

УИХ Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 14 дүгээр дүгнэлтийн тухай” 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 94 дүгээр тогтоолоороо цэцийн 2015 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 14 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, Улсын Их Хурлын 2015 оны 94 дүгээр тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Е/23 тоот хориг тавьсан<sup>22</sup> бөгөөд уг хоригийг Улсын Их Хурал 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” 106 дугаар тогтоолоороо хүлээн авсан зэргийг үндэслэн Үндсэн хуулийн цэцээс Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Нэг. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх гэсэн хэсгийн 1-8 дахь заалт, Хоёр. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх гэсэн хэсгийн 1-8 дахь заалт, 2 дугаар зүйлийн Нэг. Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх гэсэн хэсгийн 1, 2, 4 дэх заалт, Хоёр. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх гэсэн хэсгийн 1, 2, 4 дэх заалт нь тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн үндсэн тогтолцоо ... аймаг ... дүүргийн шүүхээс бүрдэх ...” гэснийг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай. Энэ хүү тогтоолын “Тогтоох” хэсгийн 1 дэх заалтыг 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэжээ.

Үндсэн хуулийн цэцийн хяналтыг тодорхойлбол, эрх зүйн акт Үндсэн хуульд

<sup>22</sup>Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 14 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрч 2015 оны 94 дүгээр тогтоолыг баталсан ба Монгол Улсын Ерөнхийлөгч уг тогтоолд хориг тавихдаа Үндсэн хууль зөрчсөн тухай дүгнэлтийг хөндөөгүй, зөвхөн эдийн засаг, төсвийн хүндрэлтэй байдлыг дурдсан байна.

нийцэц байгаа эсэхийг шийдвэрлэсэн бөгөөд үүнийг Үндсэн хуулийн хэм хэмжээний хяналт гэдэг. Хяналтын энэхүү хэлбэр нь тодорхой нэг зөрчил буюу маргаанаас ангид байдлаар \тийм учраас хийсвэр гэж нэрлэдэг\ хэрэгждэг. Шүүхийн тогтолцоотой холбоотой маргаанд иргэн өргөдөл, мэдээлэл гаргасан бөгөөд агуулгаас хархад өргөдөл гаргасан иргэний үндсэн эрх зөрчигдөөгүй бөгөөд Үндсэн хуулийн өөрийн бичвэрт үндэслэн Шүүх байгуулах тухай хуулийг хянуулахаар хандсан нь ажиглагдаж байна.

МУ-ын Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаанд Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлж буй Үндсэн хуулийн цэцийн холбогдох хууль тогтоомж, Үндсэн хуульд тодорхойлсон эрх зүйн байдлаас хархад Үндсэн хуулийн хяналтын хэлбэрт тулгамдаж буй олон асуудал байгаа нь харагдаж байна.

Иргэн өргөдөл мэдээлэл гаргаж буй энэ эрх зүйн зохицуулалт хэм хэмжээний хяналтыг хэрэгжүүлдэг бусад улс оронд байдаггүй туршлага бөгөөд энэ нь цаашид дурын сонирхогч иргэн Үндсэн хуулийн цэцэд хандах явдал нь парламентын сөрөг хүчин эсрэг ашиг сонирхолтой субъект хэн хэгнээр Үндсэн хуулийн шүүхэд хандуулж эрх зүйн актыг хүчингүй болгох гэж тогтолцооруу шилждэг сул талтай болох бусад улсын туршлагаар нотлогдсон байдаг.

Үндсэн хуулийн шүүх 1994 онд МУ-ын шүүхийн тогтолцоотой холбоотой маргаан шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн хяналтыг зөвхөн Үндсэн хуулийн өөрийнх нь бичвэрийн хүрээнд хянах практикийг бий болгожээ. Энэ нь УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.Тэмүүжин гишүүний ... “Шүүхийн тогтолцоо” болон “шүүхийн харьяалал” гэсэн энэ хоёр ойлголт нь онолын өөр ухагдахуунууд юм. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн аль нэгжид шүүх байгуулах асуудал нь шүүхийн тогтолцоонд огт хамааралгүй, харин шүүхийн харьяалал, хүртээмжийн тухай асуудал бөгөөд “шүүхийн тогтолцоо”, “шүүхийн харьяалал” гэсэн ойлголтыг зааглан ойлгох нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тайлбарлан хэрэглэх гол сэжиг юм. Үндсэн хуулийн дээрх заалтаар шүүхийн тогтолцоог “үндсэн” ба “дагнасан” гэсэн хоёр хэлбэрээр тодорхойлж, шүүхийн үндсэн тогтолцоонд Улсын дээд шүүхээс бусад анхан болон давж заалдах шатны шүүхийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр нэрлэсэн хэдий ч мөн чанараар нь авч үзвэл анхан болон давж заалдах, хяналтын гэсэн гурван шатлалаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхээр тусгасан. Иргэн шүүхийн шийдвэрийг “давж заалдах эрхтэй”, улмаар анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн





хэргийг “давж заалдах” болон “хяналтын журмаар хянан үзэх”, “бүх шатны шүүх”, “анхан шатны шүүх” гэсэн ойлголт, нэр томъёоноос шүүхийн тогтолцооны үндсэн мөн чанар нь харагдаж байгаа юм... гэжээ. Тэгэхээр маргагч, маргалдагч талууд шүүхийн үндсэн тогтолцоо, шүүхийн шатлал гэсэн нэр томъёог өөр өөрийнхөөр тайлбарлаж онолын үндэслэлийг гаргасан бөгөөд Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн үндсэн бичвэрийн хүрээнд хэм хэмжээний хяналтыг хэрэгжүүлжээ.

### **Үнэлгээ ба шүүмж**

Шүүхүүд эрүү, иргэний, захиргааны шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулагдсан. \сум буюу сум дундын шүүхээс бусад\ Үүний үр дүнд МУ-д давж заалдах шатны 21, анхан шатны 57 шүх шинэчлэгдэн байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж байна. Шүүхүүдийг тойргийн журмаар байгуулсанаар шүүхэд харьяалагдах нутаг пэвсгэрт өөрчлөлт орсоноор шүүхийн төсөв багассан. \Жишээ нь төв аймгийн шүүх\<sup>23</sup> Шүүхийн харьяаллыг дагаад прокурорын байгууллага мөн тойргийн системд шилжиж харьяалах нутаг дэвсгэрт өөрчлөлт орсон. Шүүгчийн ажлын ачаалал буурч тодорхой чиглэлээр мэргэших, хэргийн материалтай бүрэн танилцаж, оновчтой шийдвэр гарах нөхцөл бүрдсэн. Шүүхүүд төвлөрсөн бие даасан төсөвтэй болж, захиран зарцуулах эрх эдэлдэг болсон.

Цахимаар мэдээлэл тараах, шүүх хуралдааныг онлайнаар хийхэд хүн амын талаас илүү хувь нь төвөөс алс суудаг интернэтэд холбогдох боломжгүй. Шүүхүүдийг иргэдэд орон зайн хувьд ойртуулсан мэт боловч нийтийн тээвэр, зам харилцаанаас үүдэн хэргийн оролцогчдод учрах хүндрэл, зардал 2-4 дахин өссөн.

Иргэдийн шүүхийн шийдвэрт давж заалдах үндсэн эрхэд шууд байдлаар нөлөөлсөн.

### **Дүгнэлт, санал**

2016.01.28 [Тогтоол №01]-ийн дагуу 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн шүүхийн тогтолцоог үндсэн ба дагнасан хэлбэрээр байгуулж Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1-д заасны дагуу ...аймаг, нийслэл, дүүрэг бүр шүүхтэй байх зохицуулалтыг тогтоожээ. Иймээс иргэдэд одоогийн тогтолцооны давуу талыг танилцуулж мэдээлэл хүргэх, мэдээ мэдээллийн төрөл хэлбэр, хүргэх арга замыг

<sup>23</sup>Төв аймгийн 10 сум өөр аймгийн шүүхэд харьяалагдах болсоноор төсөв 50 гаруй хувиар багассан. Тухайн шүүхийн 2012-2015 оны төсвийн мэдээллийг харахад бензин шатахууны томилолтын зардал 2 дахин багассан. \шуудангийн зардал багассанаар ДЗШШ-д хэргийг хүргүүлэхдээ багцлан илгээдэг болсон бөгөөд хугацаа хойшлох сул тал ажиглагдсан.\

сайжруулах нь нэн тулгамдсан асуудал байна.

1. Аливаа хуулийн төсөл санаачлах, түүнийг батлахдаа урьд өмнө үүнтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гарсан эсэхийг нягтлан шалгаж байж аливаа шийдвэрийг гаргаж байх шаардлагатай бөгөөд урь хянасан асуудлаа цэц дахин хянахгүй, бүтцийн өөрчлөлтэй холбоотой үргүй зардал гаргахгүй байх зэрэг сайн талтай юм. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр нь өөрөө Үндсэн хуулийн дэг журмыг тогтоож байдаг бөгөөд Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т “...Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” 70 дугаар зүйлийн 1-т “...Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” зэрэг заалтыг санах хэрэгтэй болов уу.

2. Хүн ам олноороо суурьших хот суурин газарт цахим хуудас, телевизээр дамжуулан мэдээлэл хүргэж байгаа нь хүн бүрт мэдээлэл түгээх, тэгш хүргэх шаардлагыг хангахгүй байна. Интернет сүлжээ бүх газарт байдаггүй, өрхийн мэршин суугаа газар, амьжиргааны түвшнээс хамааран компьютер, ухаалаг гар утас айл бүрт байхгүй учир иргэдийнхээ амьдралын хэв маяг, нөхцөл байдалд тохируулан мэдээлэл хүргэх арга замыг боловсруулах шаардлагатай байна.

3. Шүүхийн тойргийн хилийг тогтоохдоо тухайн орон нутгийн иргэдээс судалгаа авах, хэрэгцээ шаардлагыг бодит байдалд нийцүүлэн тодорхойлох зэрэг урьдчилсан тандалт, нөхцөл байдлыг үнэлсэн судалгаа хийж, үр дүнг нь олон нийтэд нээлттэй болгох;

4. Шүүхийн үйл ажиллагаанд учирч буй хүндрэлийг арилгах:

- Засаг, захиргааны тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулах эрх бүхий удирдлагын “босоо” тогтолцоотой цагдаа, прокурор, бусад төрийн байгууллага өөр аймагт байрлах шүүхэд шийдвэрлэгдэж буй хэрэгт холбогдох нотлох баримт бүрдүүлэх, мэдүүлэг авах асуудлаар харилцахад хүндрэлтэй байгаа тул шүүхийн шинэтгэлийг хууль сахиулах байгууллагын шинэтгэлтэй уялдуулан үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны харилцан уялдааг сайжруулах;

- Цаашид шүүх байгууллагын бүтэц, тогтолцоонд өөрчлөлт, шинэчлэл хийхдээ харилцан уялдаатай ажилладаг байгууллагуудаас санал авч, тухайн шийдвэр хэрхэн нөлөөлөх талаар тэдний саналыг харгалзан үзэх, хэлэлцүүлэг зохион



байгуулах, хамтарсан ажлын хэсэг байгуулах зэргээр арга хэмжээ авч байх;

- Шүүхийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, хийгдэж буй шинэлэг үйл ажиллагааны талаар шүүгч, шүүхийн захиргааны ажилтан болон тахарын албаны албан хаагчид мэдээлэл муутай байгааг анхаарч тэдэнд шүүхийн шинэтгэлийн агуулга, ач холбогдлыг таниулах, сургалт, хэлэлцүүлэг тогтмол явуулах; улмаар шүүхийн шинэчлэлийг хэрэгжүүлэх үйл явцад шүүгч болон шүүхийн захиргааны ажилтнуудын саналыг тусгаж ажиллах;

3. Шүүхийн төсвийг бодит хэрэгцээнд тулгуурлан тооцож, шүүхийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах боломжоор хангах;

- Шүүхийн захиргааны зардлыг бодитоор тооцох, зохих судалгаа хийдэг байх шаардлагатай байна.

#### *(Footnotes)*

<sup>1</sup> Шүүх байгуулах тухай хуулиар Сэлэнгэ аймгийг Сум дундын 3 шүүхэд хуваасан бөгөөд Сум дундын 21-р шүүхэд Төв аймгийн Сүмбэр, Жаргалант, Борнуур, Батсүмбэр сумдыг харьяалуулсан.

<sup>2</sup> Шүүх байгуулах тухай хуулиар Өвөрхангай аймгийг Сум дундын 2 шүүхэд хуваасан бөгөөд Сум дундын 18-р шүүхэд Төв аймгийн Эрдэнэсант сумыг харьяалуулсан.

<sup>3</sup> Шүүх байгуулах тухай хуулиар Захиргааны хэргийн анхан шатны 15-р шүүхэд Төв аймгийн нутаг дэвсгэрийн бүх сумд харьяалагдана.

<sup>4</sup> Шүүхийн байгууллага үйлчлүүлсэн иргэдийн тоог 2012 оноос хойш сум тус бүрээр мэдээлэхгүй байгаа тул сумаар нарийвчлан гаргах боломжгүй байна. Иймд дараах байдлаар төсөөлөн авч үзлээ. Мандал сумын Сум дундын 21 дүгээр шүүхийн 2014 оны 4 дүгээр улирлын тайлангаас үзэхэд тус шүүхээр нэг улиралд нийт 364 иргэний хэрэг шийдвэрлэсэн байна. Иймд Төв аймгаас үйлчлүүлж буй 4 сум, Мандал сум нийт 5 сумын хэмжээнд дундачлан авч үзвэл 73 хэрэг болж байна. Ингээд Жаргалант сумаас нэг жилд нийт 73 иргэний хэрэг шийдвэрлүүлсэн гэж үзье.

<sup>5</sup> Нэг ч иргэн хэрэг шийдвэрлүүлэхдээ Зуунмод орох шаардлагагүй байсан гэж үзэх тохиолдлоор авч үзвэл гэсэн утга бүхий юм.



## ХАРЬЯАЛАЛГҮЙ ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

**О.Хишигмөнх**

Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш

Дэлхийн улсуудын эдийн засгийн чадавх, улс төрийн байдал, хувь хүний хүсэл сонирхол, эрх зүйн зохицуулалт зэрэг хүчин зүйлүүдээс хамаарч орчин үед хүн амын шилжилт хөдөлгөөн ихсэх хандлагатай болсон нь иргэний харьяалалын асуудлыг хөндөх шалтгаан юм. Аль ч улсад байгаа харьяалалгүй иргэд нийгмийн харилцаанд оролцоход эрх нь зөрчигддөг тул харьяалалтай болох зайлшгүй шаардлагатай. Цаашид дэлхийн хүн амын хөдөлгөөн ихсэх төлөвтэй байгаа өнөө үед өөрийн улсын төдийгүй гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйн зарчим, үзэл баримтлалд нийцсэн үйл ажиллагаа явуулах, олон улсын гэрээ, хэм хэмжээг судлах хэрэгцээ байна.

Харьяалалгүй иргэний эрх зүйн байдлыг тодорхойлохын тулд юуны өмнө үндсэн асуудал болох харьяалалын асуудлыг авч үзэх нь зүйтэй. Иргэний харьяалалын асуудал нь улсын аюулгүй байдал, тусгаар тогтнол, хүн ам зүйн бодлоготой салшгүй холбоотой. Иргэний харьяалал гэж төр, иргэн хоорондын харилцан эрх, үүргээр нөхцөлдсөн тогтвортой холбоог ойлгодог бөгөөд иргэний харьяалал нь ард түмний аж байдлыг тодорхойлж, улс төрийн харилцаанд төрийг бүтээх, нийгэмд угсаатныг бүтээх үүрэг гүйцэтгэдэг.<sup>1</sup> Иргэний харьяалал нь орон зай, цаг хугацаанаас үл хамаарч тасралтгүй тогтвортой үргэжилдэг шинжтэйгээрээ онцлогтой. Эрх зүйн харилцаанд төр ганц өөрийн улсын иргэнтэй бус өөрийн нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэд болон харьяалал нь тодорхойгүй иргэнтэй оролцдог. Улсууд түгээмэл байдлаар

<sup>1</sup>Х.Гэрэлчулуун “Иргэний харьяалал ба шилжилт хөдөлгөөн” гарын авлага 2013 он 17 дахь тал

эрх зүйн харилцаанд оролцогч иргэн хэмээх ойлголтондоо өөрийн улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй иргэнийг хамааруулдаг. Иргэний харьяалалын асуудал нь онолын хувьд олон улсын эрх зүйн, практикийн хувьд үндэсний эрх зүйн чухал асуудал юм.

Харьяалалгүй хүн гэж аль ч улсын харьяалалгүй хэн нэгнийг хэлэх бөгөөд Монгол Улсын гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7-т зааснаар “Харьяалалгүй иргэн гэж “аль ч улсын харьяат бус хүнийг” хэлнэ хэмээн заасан. Олон улсын эрх зүйд харьяалалгүй иргэнийг апатрид гэж нэрлэдэг.<sup>2</sup> Улсуудын иргэний харьяалал олгох эрх зүйн зохицуулалтын зөрчилдөөнөөс болж аль ч улсын харьяалалгүй болдог бөгөөд ихэвчлэн иргэний харьяалалаа алдаж, өөр улсын харьяат болж чадаагүйгээс үүсдэг. Иргэн харьяалалаа алдах нийтлэг дараах үндэслэлүүд байдаг. Үүнд:

1.Хуучин харьяалалаа алдаж шинэ харьяалалтай болоогүй

2.Цусны зарчим бүхий улсад харьяалалгүй хүнээс хүүхэд төрвөл

3.Гадаадын иргэнтэй гэрлэснээс харьяалалаа алддаг улсын харьяат эмэгтэй, гадаадын иргэнд харьяалал олгодоггүй улсын иргэнтэй гэрлэвэл

4.Цусны зарчим бүхий улсын нутаг дэвсгэр дээр хөрсний зарчим баримталдаг улсын иргэдээс хүүхэд төрвөл

5.Маш цөөн тохиолдолд “дэлхийн иргэн” буюу өөрөө харьяалалаасаа татгалзаж аль ч улсын харьяалалгүй болдог байна.

Дэлхийн улс орнууд харьяалалын хөрсний болон цусны гэсэн хоёр зарчмыг баримталдаг. Хаана төрснөөс үл хамааран эцэг, эхийн харьяалалыг авдаг бол цусны зарчим. Энэ зарчмаар харьяалалтай болдог Монгол, Афганистан, Дани, Орос, Хятад, Солонгос, Япон г.м улсууд байдаг. Хэнээс төрснөөс үл хамаарч төрсөн улсын харьяалалыг авдаг бол хөрсний зарчим юм. Энэ зарчмыг Латин-Америкийн улсууд баримталдаг бол дээрх хоёр зарчмыг хослуулан хэрэглэдэг улсууд ч байдаг. Харьяалалгүй иргэд нь өөрийгөө аль улсын иргэн гэдгээ тодорхойлох баримт бичиггүй, төртэй тогтвортой харилцаагүй байдгаас өмч эзэмших, үл хөдлөх хөрөнгөтэй болох, өөрийн нэр дээр данс нээлгэх, гэр бүлээ батлуулах, хүүхдээ бүртгүүлэх, нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээ авах, хөдөлмөрлөж цалин хөлс авах зэрэг эрхүүд нь зөрчигддөг.

Монгол Улс нь харьяалалгүй иргэний эрх зүйн байдлыг дотоодын болоод нэгдэн

<sup>2</sup> О.Хосбаяр, М.Дүгэрсүрэн. “Олон улсын эрх зүй” УБ., 1999 он 88 дахь тал



орсон олон улсын хэмжээгээр тодорхойлсон. Иргэний харьяалалыг Монгол Улсын Үндсэн хууль, Харьяатын тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Иргэний хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, ажиллах хүч гадаадад гаргах, гадаадад ажиллах хүч, Мэргэжилтэн авах тухай хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Монгол улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам, Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол улсад оршин суух, харьяалалгүй хүнд зорчих үнэмлэх олгох, эзэмших, ашиглах, хадгалах, ашиглах журам зэрэг хууль, хуульчилан актууд болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хэм хэмжээнүүд болох хүний эрхийн түгээмэл тунхаглал, иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт зэрэг хэм хэмжээнүүдээр зохицуулж байна.

Монгол Улсад 2016 оны 5 дугаар сарын байдлаар 35 харьяалалгүй хүн бүртгэгдснээс цагаачлалаар 13, шашны шугамаар 8, суралцагч 5, төрийн бус байгууллага болон олон улсын хүмүүнлэгийн байгууллагын шугамаар 1, түр ирэгч 2, хөдөлмөр эрхлэгч 1, хувийн бусад зорилгоор 2, Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон 2 иргэн байна.<sup>3</sup> Харьяалалгүй иргэний насны хувьд 1924-2007 оны хооронд төрсөн иргэд байгаа бол тэдгээрийн 33 нь эрэгтэй, 2 эмэгтэй иргэн байна. Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмын дагуу Монгол Улс харьяалалгүй иргэдэд эрх, эрх чөлөөг эдлүүлэх ёстой. Монгол Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд "Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтооно", "Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно", Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно хэмээн заасан. Харьяатын тухай хуульд эцэг, эхийн аль нэг нь Монгол Улсын харьяат, нөгөө нь харьяалалгүй хүн байхад тэдний дундаас төрсөн хүүхэд хаана төрснөөс

хамаарахгүйгээр Монгол Улсын харьяат байна. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа бөгөөд эцэг, эх нь хоёулаа тогтоогдоогүй хүүхэд Монгол Улсын харьяат байна. Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа харьяалалгүй эцэг, эх хоёрын дундаас Монгол Улсад төрсөн хүүхэд 16 нас хүрсний дараа өөрөө хүсвэл Монгол Улсын харьяат болж болно. Харьяалалгүй хүний үрчлэн авсан Монгол Улсын харьяат 16 нас хүрээгүй хүүхэд Монгол Улсын харьяат хэвээр байна.<sup>4</sup> Гадаадын иргэн буюу харьяалалгүй хүн хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын харьяат болж болох бөгөөд Монгол Улсын харьяат болгохоос татгалзах үндэслэлүүдийг тодорхойлон заасан.<sup>5</sup> Үүнд:

-Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд заасан хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон

-Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, язгуур эрх ашгийн эсрэг үйл ажиллагаа явуулж байсан буюу явуулж байгаа бол

-Олон улсын алаг хядах байгууллагын гишүүн гэж зарлагдсан хүн

-Шүүхээр онц аюултай гэмт хэрэгтэн нь нотлогдсон бол иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаадын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсын харьяат болох хүсэлтийг хүлээн авахаас түдгэлзүүлж байгаа тухай албан ёсоор мэдэгдэж Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд харьяалалгүй хүнийг Монгол Улсын харьяат болгох асуудлыг шийдвэрлэдэг.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т Хуульд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэнд хамаарах энэ хуулийн зохицуулалт нь харьяалалгүй хүнд нэгэн адил үйлчилнэ хэмээн заасны дагуу Монгол Улсын бусад холбогдох хуулиудад харьяалалгүй хүний эрх зүйн байдлыг гадаадын иргэний нэгэн адил зохицуулсан. Тухайлбал, Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгох, зорчих үнэмлэх олгох, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох г.м асуудлуудад гадаадын иргэнтэй ижил байхаар хуульчилсан. Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад уг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд харьяалалгүй этгээд хамаарч байгаа бөгөөд тодорхой эрхүүдийг эдлэх зохицуулалт бий боловч практикт харьяалалгүй иргэд эрхээ эдлэх боломж хязгаарлагдмал юм. Харьяалалгүй этгээдтэй эрх зүйн харилцаанд оролцогч эрх бүхий этгээдүүд нь өөрийгөө нотлох баримт бичиг, хэн гэдгээ батлах эрх бүхий байгууллагын холбогдох үнэмлэхийг шаарддаг тул төрийн үйлчилгээг хүртэх,

<sup>3</sup>Иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын холбогдох мэргэжилтнээс уг судалгааг авсан болно.

<sup>4</sup> Монгол Улсын Харьяатын хуулийн 7 дугаар зүйл.

<sup>5</sup>Мөн хуулийн 10 дугаар зүйл.



нийгмийн хамгаалалд хамрагдах, сурч боловсрох, өөрийн гэсэн хөрөнгөтэй болоход бэрхшээл үүсдэг төдийгүй гэмт хэргийн золиос болох эрсдэлтэй. Иймд харьяалалгүй иргэд оршин суугаа улсынхаа эрх бүхий байгууллагад хандан харьяалалтай болох зайлшгүй шаардлагатай юм.

Монгол Улсын Иргэний хуулийн 543 дугаар зүйлийн 543-т “Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний нэгэн адил иргэний эрх зүйн чадвартай байна. Харьяалалгүй хүний иргэний эрх зүйн чадамжийг түүний байнга оршин суугаа улсын хуулиар тодорхойлно. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хийсэн хэлцэл, гэм хор учруулснаас үүсэх үүргийн талаархи гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний иргэний эрх зүйн чадамжийг Монгол Улсын хуулиар тодорхойлно гэж тус тус заасны дагуу өөрийн нутаг дэвсгэр дээр байгаа харьяалалгүй хүний эрх зүйн байдлыг хуулиараа тодорхойлохоор заасан. Мөн харьяалалгүй хүнийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлахад тухайн этгээдийн байнга оршин суудаг газрын хуулиар, хэрэв байнгын оршин суух газар байхгүй бол Монгол Улсын хуулиар зохицуулна.”<sup>6</sup> Монгол Улсын шүүхээр гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнтэй холбогдолтой иргэний хэргийг хянан шийдвэрлэхэд тэдгээр нь хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн адил эрхтэй байна”<sup>7</sup> гэж харьяалалгүй хүнийн эрх зүйн байдлыг тусгасан.

Хүний эрхийн хамгийн наад захын эрх нь иргэний харьяалалтай байх эрх гэдгийг олон улсын хүний эрх, эрх чөлөөний тухай баримт бичгүүдээр баталгаажуулсан. Хүн төрөлхтөний хүний эрхийн суурь хэм хэмжээ болох “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”<sup>8</sup>-ын 15 дугаар зүйлд “Хүн бүр иргэний харьяалалтай байх эрхтэй, аливаа хүний иргэний харьяалал болон харьяаллаа өөрчлөх эрхийг дур мэдэн цуцлах ёсгүй” гэж заасан Монгол улс Үндсэн хуулиндаа энэ заалтыг баталгаажуулан Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл журмыг гагцхүү хуулиар тогтооно. Монгол улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно<sup>9</sup> гэж иргэнийг өөрийг хүсээгүй байхад харьяалалаас хасахыг хориглосон. Монгол Улсад хэдийгээр ийм эрх зүйн зохицуулалт

байгаа боловч өөр улсын харьяалалтай болсон /хоёрдмол харьяалалтай/ иргэдийн харьяалалыг ерөнхийлөгч хүчингүй болгож хассан тохиолдол гарсан дээрх заалттай зөрчилдөж байна. Мөн иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад хүүхэд бүр иргэний харьяалалтай болох эрхтэй<sup>10</sup> хэмээн заасан нь хүүхдийн эрхийг зөрчигдөхөөс сэргийлсэн зохицуулалт бөгөөд цусны зарчимтай улсад харьяалалгүй хүнээс төрсөн хүүхэд харьяалалгүй болох тохиолдол байдагтай холбоотой. Хүүхдийн эрхийн тухай тунхаглалын 8.1-д “Оролцогч улсууд хуульд заасан иргэний харьяалалтай байх, нэр авах, гэр бүлийн холбоогоо хадгалах зэргээр хувийн онцлог байдлаа хадгалах, хүүхдийн эрхийг хүндэтгэх, хууль бусаар оролцохгүй байх үүрэг хүлээнэ” хэмээн иргэний харьяаллын талаар тус тус зохицуулжээ.

Дэлхийн нэгдүгээр дайны дараа үед харьяалалгүй иргэдийн тоо огцом өссөн бөгөөд энэ үеэс зохицуулалт шаардлагатай болж анх 1930 онд Нидерландын Гааг хотноо болсон олон улсын бага хурлын үр дүнд “Харьяатын тухай хуулийн зөрчилдөөнийг арилгах тухай конвенцийг баталсан. Дэлхийн хоёрдугаар дайны дараа Нэгдсэн Үндэстний Байгууллага байгуулагдан харьяалалын асуудлыг анхааралдаа авч Харьяалалгүй байдлыг багасгах тухай конвенц, Харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай конвенц, Гэр бүлтэй эмэгтэйчүүдийн иргэний харьяалалын тухай конвенц зэрэг конвенциудыг баталсан. Гадаадын зарим улсууд харьяалалгүй иргэдийг үүсгэхгүй байх, тоог бууруулах, өөрийн иргэдээ татах, гадаад улсын иргэдийг татах зорилгоор Герман, Унгар, Казахстан зэрэг улсууд иргэншил олгох шалгууруудыг хөнгөвчилж өөрийн иргэн биш боловч хилийн чанадад амьдарч буй нэг үндэстэндээ зориулж бусад улсын иргэдээс илүү хялбар нөхцөлөөр иргэншил олгодог байна. Оросын Холбооны Улс хилийн чанадад амьдарч буй “эх орон нэгтнүүд”-ээ өөрийн улс руу эгүүлэн татах, тэдгээр иргэдийг уугуул соёл, уламжлалаа өвлөн хадгалах, хөгжүүлэх төрийн бодлогыг баримталдаг байна. Мөн “Хилийн чанадад амьдарч буй эх орон нэгтнүүдийн талаар улсаас баримтлах бодлогын үндсэн чиглэлийн тухай” 1994.08.11-ний өдрийн 1681 тоот Оросын холбооны улсын Ерөнхийлөгчийн тушаалыг баталснаар хилийн чанадад амьдарч буй эх орон нэгтнүүдийн талаар төрөөс баримтлах бодлогын тухай хуулийн төсөл бэлтгэх, хилийн чанадад амьдарч буй эх орон

<sup>6</sup>Монгол Улсын Иргэний хуулийн 546.2 дугаар зүйл.

<sup>7</sup>Мөн хуулийн 189.1 дүгээр зүйл.

<sup>8</sup>Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь 1946 онд батлагдсан. Нэгдсэн Үндэстний байгууллагын бүх гишүүн улсууд дагаж мөрддөг.

<sup>9</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 15 дугаар зүйл.

<sup>10</sup> Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 24.3 дугаар зүйл.





нэгтнүүдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын хороо байгуулахаар болж гадаад улс дахь эх орон нэгтнүүдийн талаарх ОХУ-ын төрийн бодлогын тухай холбооны хуульд “хилийн чанадад буй эх орон нэгтнүүдтэй харилцах харилцаа нь төрийн гадаад болон дотоод гол бодлогуудын нэг юм”<sup>11</sup> хэмээн тусгажээ.

Нэгдсэн Үндэстний байгууллагын Дүрвэгсдийн асуудал хариуцсан дээд комиссарын газрын судалгаагаар дэлхий дээр нийтдээ арав орчим сая харьяалалгүй иргэд, үүний гуравны нэг нь хүүхдүүд бөгөөд судалгаанд хамрагдсан улсуудаас Оросын Холбооны Улс болон Ирак улс дахь харьяалалгүй иргэдийн тоо буурсан гэдгийг дурдаж улсууд харьяалалгүй хүний асуудлыг шийдвэрлэх нь чухал гэдгийг онцолжээ.<sup>12</sup> Тус байгууллага 1994 оноос эхлэн харьяалалгүй иргэд бий болохоос урьдчилан сэргийлэх, дэлхий даяар харьяалалгүй иргэдийг багасгах, тэдгээрийг эрхийг хамгаалах зорилгоор аян өрнүүлж гишүүн улсуудаа харьяалалгүй иргэдийг бууруулах тухай 1961 оны конвенц, харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай 1954 оны конвенцид нэгдэн орохыг уриалсан. Эдгээр олон улсын хэм хэмжээ нь улсуудын иргэний харьяалалын зөрчилдөөнийг багасгаж, харьяалалгүй иргэдийн асуудлыг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх юм.

Дэлхийн улс орнууд аль болох иргэний олон харьяалалтай /хоёр болон түүнээс дээш улсын иргэн/ байх асуудалд болгоомжтой хандаж бууруулах бодлогыг баримталж байгаа нь хүний хүсэл сонирхолыг хязгаарлаж буй мэт боловч ойлгомжгүй, төвөгтэй нөхцөл байдлуудыг багасгах, арилгах зорилготой. Зарим улсууд олон харьяалалтай байхыг хүлээн зөвшөөрч иргэний олгодог нь хүн амаа өсгөх бодлого, хөрөнгө мөнгө болон ухаантай тархыг татахтай холбоотой байдаг ч цэргийн алба хаах, татвар төлөх зэрэг үндсэн үүргүүдийг аль улсад биелүүлэх эсэх төвөгтэй байдлыг бий болгодог. Сүүлийн үед хил дамнанс гэмт хэргүүд үйлдэгдэгдэхэд олон харьяалалтай байдалтай ч нөлөөлж байгаа үгүйсгэж болохгүй. Нэгдсэн Үндэстний байгууллагын Дүрвэгсдийн асуудал хариуцсан Антонио Гутерреш 2011 онд Зүүн Өмнөд Ази, Төв Ази, Зүүн Европ, Ойрхи Дорнод болон Африкт иргэний харьяалалгүй иргэдийн ихэнх байгааг мэдэгдсэн. Шалтгаан энэ бүс нутаг дахь хил хязгаар, нутаг дэвсгэрийн өөрчлөлт, эрх зүйн ялгаатай зохицуулалт, ялгаварлан гадуурхалт юм. Тухайлбал эмэгтэйчүүдийн

харьяалалыг дагахыг үл зөвшөөрдөг байдал, шашнаар ялгаварлан гадуурхдаг байдал, улс задрах үйл явцуудтай холбоотой.

Нэгдсэн Үндэстний байгууллагын дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд хороо нь 1994 оноос хойш өрнүүлсэн аяныхаа дүнд 2006 онд “Харьяалалгүй хүмүүсийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, бууруулах тухай” дүгнэлт гаргасан бөгөөд дүгнэлтэндээ харьяалалгүйн иргэдийн мэдээлэлийг гаргах, шалтгааныг тогтоох, харьяалалгүй иргэд бий болохоос урьдчилан сэргийлэх, харьяалалгүй иргэдийг бууруулах тухай 1961 оны конвенцид нэгдэн орох, эрх зүйн орчиндоо өөрчлөлт хийх замаар тэдэнд туслах, харьяалалгүй иргэдийн эрхийг хамгаалах, харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай 1954 оны конвенцид нэгдэн орохыг зөвлөж эдгээрийг үр дүндтэй болгохын тулд засгийн газруудын оролцоо чухал юм гэдгийг онцолсон. Мөн 2003 оноос 2013 оны хооронд 10 жилийн хугацаанд 4 сая гаруй харьяалалгүй иргэд харьяалалтай болж, 12 орон үндэстний хуулиндаа байсан ялгаварлан гадуурхсан заалтуудаа өөрчилж, 2011-2014 оны хооронд 44 улс дээрх дээр дурьдсан хоёр конвенцид нэгдэн орсон.<sup>13</sup> Цаашид ч харьяалалгүй иргэдийг бууруулах, урьчилан сэргийлэх үйл ажиллагаагаа идэвхжүүлэх даян дэлхийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа бөгөөд гишүүн улсуудаа дараах зөвлөмжийг өгсөн. Үүнд:

-Харьяалалгүй байгаа шалтгааныг тодруулах

-Ямар ч хүүхэд төрсөн харьяалалтай эсэхийг шалгаж бүртгэж байх

-Иргэний харьяалалтай холбогдох хууль, эрх зүйн актууд нь ялгаварлан гадуурхалтаас ангид байх

-Шилжин суурьшигчидад харьяалалтай болох боломжийг олгох

-Төрийн зүгээс харьяалалгүй иргэд бий болохоос урьдчилан сэргийлэх бодлого баримтлах

-Харьяалалгүй иргэдийг бүртгэлжүүлж холбогдох шаардлагатай баримт бичгийг олгож байх

-НҮБ-ын харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай конвенц болон харьяалалгүй иргэдийг бууруулах тухай конвенцид нэгдэн орох.

-Харьяалалгүй хүн амын тоон болон чанарын мэдээллийг сайжруулах хэрэгтэй бөгөөд дээрх үйл ажиллагаануудыг дэмжснээр харьяалалгүй иргэдийг бууруулах, эрхийг нь хамгаалах механизм бүрдэнэ гэж үзсэн.

<sup>11</sup>“Федеральный Закон о государственной политике РФ в отношении соотечественников за рубежом”, 1999.

<sup>12</sup><http://www.unhcr.org/pages/49c3646c26.html>

<sup>13</sup><http://www.unhcr.org/pages/562df5ff6.html>



## Дүгнэлт

Монгол Улс нь цусны зарчмыг баримталдаг буюу эцэг, эхийн харьяалалыг дагадаг гэж үздэг ч эрх зүйн зохицуулалтуудаас харахад хөрсний зарчмыг ч баримталж болохоор заасан байна. Цөөн хүн амтай, газар нутаг томтой, эдийн засгийн өсөлт тогтворгүй, ажилгүйдэл ихтэй улсын хувьд хүн амын бодлогодоо маш нухацтай хандаж өөрийн иргэдээ тогтоон барих, гадаад иргэд Монгол Улсын харьяат болох, харьяалалгүй иргэдийг харьяалалтай болгох асуудалд бусад улсын туршлагад тулгуурлах нь зүйтэй. Монгол Улсад ч сүүлийн үед иргэд гадаадад хөдөлмөр эрхлэх, суралцах, гадаадын иргэнтэй гэр бүл болох болсноор харьяалалаа өөрчлөх хандлага нэмэгдэж байна. Ихэнх улсууд харьяалалгүй иргэний эрх зүйн байдлыг үндэсний эрх зүйн хэм хэмжээнд тулгуурлан шийдвэрлэдэг практик байна. Цаашид аль ч улс иргэдийн шилжилт хөдөлгөөний урсгалаас гадна үлдэх боломжгүй нь тодорхой. Улсуудын иргэний харьяалалын зарчим, шалгуур болон эрх зүйн зохицуулалтаас үүдэж харьяалалгүй болж байна. Монгол Улсад харьяалалгүй иргэний эрх зүйн байдлыг гадаадын иргэний нэгэн адил эдлүүлэхээр заасан боловч практикт өөрийгөө нотлох бичиг, баримтгүй, аль улсын иргэн нь тодорхойгүй этгээд хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэнтэй ижил хэмжээнд эрхүүдээ эдэлж чадахгүй байна. Монгол Улс хүний эрх, эрх чөлөөг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн баталгаажуулж харьяалалгүй иргэдийн эрхийг хамгаалах, тоог бууруулах, бий болгохгүй байх талаар тодорхой ажлуудыг хийх шаардлагатай. Үүнд:

- Нэгдсэн Үндэстний байгууллагын харьяалалгүй иргэдийг бууруулах тухай 1961 оны конвенц, харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай 1954 оны конвенцид нэгдэн орох, ингэснээр харьяалалгүй иргэдийн эрхийг хамгаалах, харьяалалтай болох бүхий л боломжийг бүрдүүлэх юм.

-Гадаадын иргэнтэй гэр бүл болсон, гадаад улсын харьяат болсон иргэдийг өөрөө харьяатаас гарах өргөдөлөө өгөөгүй бол тодорхой хугацаанд харьяаллаа хадгалж болдог зохицуулалтыг харьяатын тухай хуулийн төсөлдөө оруулах хэрэгтэй.

-Мөн харьяалалгүй иргэдэд зориулсан гарын авлагыг түгээмэл хэл дээр боловсруулан гаргаж хэвлэмэл болон цахим хэлбэрээр байршуулах, харьяалалтай болоход шаардагдах баримт бичиг, мэдээллийг богино хугацаанд гаргаж өгч эрх бүхий байгууллагууд шуурхай үйлчилж шийдвэрлэж өгөх нь хүний эрхийг баталгаажуулж олон улсын өмнө хүлээсэн

үүргээ биелүүлсэн явдал болох юм.

## Ном зүй

Нэг. Ном сурах бичиг, гарын авлага

-Ж.Амарсанаа “Хүний эрх. Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал. УБ.,2000 он

-Х.Гэрэлчулуун “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөн” гарын авлага УБ.,2013 он

-О.Хосбаяр, М.Дүгэрсүрэн. “Олон улсын эрх зүй” УБ., 1999 он

Хоёр. Хууль, хуульчилсан акт

-Монгол Улсын Үндсэн хууль 1992 он

-Иргэний хууль 2002 он

-Харьяатын тухай хууль 1995 он

-Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль 2010 он

-Иргэний бүртгэлийн тухай хууль 2003 он

-Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадад ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль 2001 он

-Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он

-“Монгол улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам” Засгийн газрын 62 дугаар тогтоол”-ын хавсралт 2003 он

-“Гадаадын иргэн, харьяалалгүй хүн монгол улсад оршин суух, харьяалалгүй хүнд зорчих үнэмлэх олгох, эзэмших, ашиглах, хадгалах, ашиглах журам” Хууль зүйн сайдын 2014 оны 187 дугаар тушаалын хавсралт

Гурав. Олон улсын хэм хэмжээ:

-Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 он

-Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966 он

-Харьяалалгүй байдлыг багасгах тухай конвенц 1954 он

-Харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай конвенц 1948



## НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ

**Э.Мөнхжаргал**

Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн  
Бизнесийн эрхзүйн тэнхимийн багш

Нийгэм, улс төр, эдийн засгийн харилцааг бүхэлд нь өөрчилж эхэлсэн 1990-ээд оноос Монгол Улсын өмнө тулгарсан нэг гол зорилт нь зах зээлийн эдийн засагт нийцсэн орчин үеийн татварын тогтолцоог цоо шинээр бүрдүүлэн бий болгох явдал байсан. Энэ асуудлыг Монгол Улсын Бага Хурлаас 1990 онд баталсан «БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль» болон «Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл»-ээр баталгаажуулан «...үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд орлогын албан татварын системд 1991 оноос шилжих..»-ээр заасан билээ.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн 5 зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.”, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-д «хуулиар ногдуулсан албан татвар төлөх» нь иргэний үндсэн үүрэг байхаар тус тус хуульчлан заасан нь татварын эрх зүйн суурь болдог.

Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж эхэлсэн үеэс эхлэн донор байгууллагуудаас байнгын тусламж дэмжлэг авч байсны нэг жишээ нь НӨАТ нэвтрүүлэх төсөл байв. Монгол улс 1993 онд худалдааны татварыг бий болгож, 1995 оноос хойш Монгол улсад ОУВС болон Дэлхийн банкнаас ирж ажилласан зөвлөхүүд “худалдааны татвар”-ыг НӨАТ-д шилжүүлэх талаар удаа дараа зөвлөж, энэ арга хэмжээ нь төсвийн алдагдлыг бууруулах, нийт татварын тогтолцоог бэхжүүлэх чухал арга хэмжээ болохыг тэмдэглэж байсан. Ийнхүү

1997 оноос НӨАТ нэвтрүүлэх төсвийг Дэлхийн банкнаас санхүүжүүлж, ОУВС-ын мэргэжилтнүүд хуулийн төсөл, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргажээ. Улмаар 1998 оны 1 сарын 6-нд НӨАТ-ын тухай хууль батлагдаж, мөн оны 7 сарын 1-ний өдрөөс хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж сүүлд үүссэн залуу татварын нэг болно. Иймд салбарын маш цөөн тооны мэргэжилтэнүүдийн судалгааны материалаас өөр судлагдсан зүйл тун ховор юм.

Нэмэгдсэн өртгийн албан татвар бол хувь хүнд шууд ногддоггүй харин тухайн хүнд үйлчилсэн үйлчилгээ ба бараанд ногдуулсан шууд бус хэлбэрийн татвар гэж олон улсын практикт өргөн хэрэглэгддэг. Өөрөөр хэлбэл эцсийн үр дүн гарахыг хүлээхгүйгээр борлуулалт, бараа, ажил үйлчилгээнд ногдуулан авдаг учраас төсвийн орлогын найдвартай эх үүсвэр болдог гэж үздэг. НӨАТ нь эрх зүйн орчны хувьд Монгол улсад хамгийн “тогтворгүй” татварын нэг юм. Шинээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш өнөөг хүртэл 31 удаа нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд эдгээр өөрчлөлтөөс гадна НӨАТ-аас чөлөөлөх тухай 27 бие даасан хууль гарч байжээ.<sup>1</sup>

Нэмэгдсэн өртгийн албан татвар<sup>2</sup> нь эцсийн дүндээ аливаа улс орны хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагуудыг үнэн зөв санхүүгийн тайлан мэдээлэл бэлтгэдэг болгох, татварын хөндлөнгийн мэдээллийг цуглуулах найдвартай хэрэгсэл, эх үүсвэр болох ингэснээр далд эдийн засаг буюу хар зах зээлийг багасгах, мөнгөний урсгалыг төр өөрийн хяналтад байлгаж, хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагыг санхүүгийн цэгцтэй тогтолцоонд оруулах ач холбогдол бүхий татвар юм.

Зах зээлийн эдийн засгийн харилцаа улам бүр гүнзгийрч буй өнөө үед үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үндэстний эрх ашигт хамаарах тодорхой зорилтуудыг шийдвэрлэхэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд татварын эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажил эрчимтэй явагдаж байна.Тухайлбал: Монгол улсад 1993 оноос Худалдааны татварыг нэвтрүүлж, 1998 оноос Нэмэгдсэн өртгийн албан татвар болгон өөрчлөн баталсан бөгөөд 2006 онд тус хуулийг шинэчилэн найруулсан байдаг. Төсвийн уян хатан санхүүгийн тогтвортой эх үүсвэр болдог нэмэгдсэн өртгийн албан

<sup>1</sup> Цогт.О “Монгол улсын нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, цаашдын чиг хандлага” УБ хот (2011) 3 дах тал

<sup>2</sup>Г.Гантулга, Ч.Өнөржаргал, НӨАТ-ын хуулийн хэрэгжилтэнд тулгамдаж буй зарим асуудлууд. УБ., 2010он, х.1 дэх тал



татварын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжиж, эцсийн хэрэглэгчдэд хуримтлал үүсгэх ач холбогдол бүхий Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 оны 07 сарын 09-ны өдөр Улсын их хурлаас соёрхон баталсан нь татварын эрх зүйн орчин төдийгүй татвар төлөгчдийн нийгмийн сэтгэл зүйд эерэгээр нөлөөлсөн шинэлэг өөрчлөлт болсон.

Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль, эрх зүйн орчин

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2016.01.01 нээс мөрдөгдөнө/

-Хуулийн зохицуулалтыг энгийн, ойлгомжтой болгож, хоёрдмол утга, тодорхой бус байдлыг арилгасан;

-НӨАТ төлөгч болон суутган төлөгчийг ойлгомжтой ангилсан;

-НӨАТ-ын босгыг 50 сая төгрөг болгон нэмэгдүүлж, сайн дураар бүртгүүлэх боломжийг нэмэгдүүлсэн;

-Эцсийн хэрэглэгчдэд олгох урамшуулалын тогтолцоог бий болгосон;

-НӨАТ-ын падааны цахим систем нэвтрүүлэх;

-Далд эдийн засгийн үзүүлэлтийг бууруулахад худалдан авагчдын оролцоо, хяналтыг дээшлүүлсэн;

Шинэчлэн найруулсан НӨАТ-ын тухай хууль батлагдсантай холбоотой бусад холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт орсон.

-Хувь хүний орлогыг албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйл "16.1.18.нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллаас орсон орлого."<sup>3</sup>

-Татварын ерөнхий хууль 18 дугаар зүйлийн "18.1.8.Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин "хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, тасалбарын цаас, пос терминал машин" хэрэглэх;<sup>4</sup>

-Татварын ерөнхий хууль 74 дүгээр зүйл "74.5.Нэмэгдсэн өртгийн албан татвар суутгагч бэлэн мөнгөний системийн хэрэглэгч гишүүнд бэлэн мөнгөний тасалбар олгоогүй, олгохоос татгалзсан, эсхүл үнийн дүнгээс зөрүүтэй дүнгээр олгосон бол хариуцлага хүлээлгэх

Улсын их хурлын тамгын газрын судалганы төвөөс<sup>5</sup> гаргасан "Бодлогын судлагаа, шинжилгээ" судалгааны эмхтгэлд нэмэгдсэн өртгийн албан татварын хувьд Засгийн газраас үзүүлдэг нийгмийн халамжийн зориулттай эрүүл мэнд,

<sup>3</sup>Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, 2006 он

<sup>4</sup>Татварын ерөнхий хууль, 2008 он

<sup>5</sup>Улсын их хурлын тамгын газрын судалгааны төв, "Бодлогын судлагаа, шинжилгээ" судалгааны эмхтгэл, УБ., 2011он, Монгол: Чулуун,Г 280 дэх тал

боловсрол, нийтийн тээврийн үйлчилгээ, мөн шашны үйлчилгээ, төрийн байгууллагын үйлчилгээ, орон сууцны түрээслэх үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэглээнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, жижиг дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж, батлан хамгаалахад зориулсан тоног төхөөрөмжийн импорт гэх мэт бараа ажил үйлчилгээнд татвар ногдуулах нь зохимжгүй юм.Төрөөс үзүүлэх үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах нь нийгмийн бодлогод үл нийцэх ба татварын нэмэлт дарамт бий болгож төсвийн зардлыг л нэмэгдүүлнэ гэж үздэг байна.

Хуучин хуулинд нотариатын үйлчилгээ болон өмгөөлөл, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох ажил, үйлчилгээнд хамааруулаагүй байсан бөгөөд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч мөн эсэх нотариатч, татварын алба хооронд маргаан үүсч байсан. Өөрөөр хэлбэл: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нотариатчийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх заалт байхгүй. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5. 1 дэх хэсэгт "Монгол улсын нутаг дэвсгэрт бараа импортлолсон болон экспортолсон этгээд, түүнчлэн бараа үйлдвэрлэсэн буюу борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн иргэн, хуулийн этгээд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байна" гэж заасан. Нотариатын үйлчилгээг иргэнээс иргэнд үзүүлж байгаа үйлчилгээ гэж үзэх үндэслэлтэй тул нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч мөн<sup>6</sup> гэж үзэн Хан-уул, Баянгол дүүргийн татварын албанаас нотариатын үйлчилгээ үзүүлэгч татвар төлөгчдөд татварын улсын байцаагчийн акт үйлдсэн байдаг.

Үүнтэй холбоотойгоор нотариатчдын танхимаас Нийслэлийн захиргааны хэргийн шүүх, Монгол Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүх, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүхэд дээрхи актыг хүчингүй болгуулах, нотариатч нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч биш болохыг тогтоолгохоор нэхэмжлэл гаргаж улмаар бүх шатны шүүхээс Нотариатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 23-р зүйл, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.4 дэх заалтуудын дагуу нотариат ч нь төрийн чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэж байгаа тул Нэмэгдсэн өртгийн

<sup>6</sup>Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, 2007.09.13 217 дугаар



албан татварын хуулийн 13 дугаар зүйлийн 13.6.12-т заасан “Засгийн газар, түүний харьяа болон төсөвт байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээ”-нд хамааруулан үзэж нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэнээр татварын алба хууль дээдлэх зарчмыг баримтлан Монгол Улсын шүүхийн шийдвэрийг баримтлан ажиллаж байсан байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай шинэчлэн найруулсан хуулийн 7 дугаар зүйл: Албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээ<sup>7</sup>

•7.2.3. Нотариатын үйлчилгээ

•7.2.17. Өмгөөлөл, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Нотариатын үйлчилгээ

-Нотариатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт “Нотариатч нь төрийн нэрийн өмнөөс хөндлөнгийн гэрчийн үүрэг гүйцэтгэж, эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус харилцаанд оролцож байгаа этгээдэд эрх зүйн зөвлөгөө өгөх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ”.<sup>8</sup>

Үндсэн хуулийн 1 дүгээр заалт – “шударга ёс нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчиж байна.

Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд заасан “тэгш байдал нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчиж байна.

-НӨАТ-ын хуулийн 7.2.3 дахь заалт нь тэгш байдлын зарчмыг зөрчсөн утгаараа Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн заалтыг агуулгын хувьд давхар зөрчиж байна.

-Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх заалтад хүн бүр “Хууль зүйн туслалцаа авах эрхтэй” гэж заасныг зөрчиж байна. / иргэдээс өөрийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах, хэрэгжүүлэхийн тулд хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах боломжийг нээж өгсөн

Өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээ

-Нэмэгдсэн өртөг нь онолын хувьд “хаана өртөг, үнэ нэмэгдэж байна, тэр тухай бүрд энэ татварыг ногдуулах ёстой” байдаг. Нэмэгдсэн өртөг нь хийсвэр хийгээд зохиомол, дур зоргын байх ёсгүй бөгөөд бодитойгоор шинээр өртөг бий болсон байх ёстой.

-Өөрөөр хэлбэл: үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны явцад тухайн бараа, үйлчилгээний, зардал бодитой нэмэгдэх бөгөөд энэ тохиолдолд нэмэгдсэн өртөг бий

<sup>7</sup> Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, 2015 он

<sup>8</sup> Нотариатын тухай хууль, 2011 он

болж, энэ нь аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд хийсэн бол НӨАТ ногдуулна.

-Өмгөөлөл нь аж ахуйн үйл ажиллагаанд хамаарахгүй. Эрх зүйн эх толь бичигт “аж ахуйн үйл ажиллагаа гэдгийг эд хөрөнгө ашиглах, бараа худалдах, ажил гүйцэтгэх ба үйлчилгээ үзүүлэх зэргээр ашиг байнга олоход чиглэгдсэн, хуульд тогтоосон журмаар бүртгүүлсэн үйл ажиллагааг өөрийн эрсдэл дээр бие даан хэрэгжүүлэх” гэж тайлбарласан байна.

-Аж ахуйн үйл ажиллагааны гол шалгуур нь ашиг байнга олох зорилго юм.

-Өмгөөлөл – хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгэмд шударга ёсыг тогтоох Өмгөөллийн үйл ажиллагаа нь ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨХ ҮЙЛС болох талаар доор баримт бичигт тусгаж өгсөн байдаг.

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)

-Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966)

-Хуульч мэргэжлийн бие даасан байдлын талаарх олон улсын БАР-ын холбооны стандарт

-Өмгөөлөгчийн үүргийн тухай НҮБ-ын үндсэн зарчим (1990)

Хууль зүйн туслалцаа мөн чанараараа төрийн үүргээс улбаатай, ямагт эрүүл мэнд, боловсрол, төрийн байгууллагын үйлчилгээтэй жишигдэн үзэгддэг. Тиймээс НӨАТ ногдуулах нь хууль зүйн туслалцаа авах эрхийг шууд зөрчихөд хүргэхээр байна.

НӨАТ-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.17 дахь заалтын дагуу “өмгөөлөл, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ”-г НӨАТ ногдох ажил, үйлчилгээнд хамааруулсан нь

- Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “шударга ёс нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

-16 дугаар зүйлийн 14 дэх заалтыг “хууль зүйн туслалцаа авах эрх”

-19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтыг зөрчиж байна.

Хэдийгээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 02 дугаар дүгнэлтээр Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3дахь заалтад “нотариатын үйлчилгээ;”, 7 дугаар зүйлийн 7.2.17 дахь заалтад “өмгөөлөл, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ;” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга





ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, .... гэснийг тус тус зөрчөөгүй байна гэсэн дүгнэлт гарсан боловч судлаачийн хувьд уг заалтуудыг зайлшгүй өөрчлөх шаардлагатай гэж дүгнэж байна. Нотариатын эрх зүйн үйлчилгээ нь тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэж байгаа төрийн гэрчлэх чиг үүрэг байх тул Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.12 дахь заалтын “Төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээ. Үүнд Засгийн газар, түүний агентлагууд, төсөвт байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээ хамаарна” гэсэнд хамааруулан үзэж нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх үндэслэлтэй гэж үзэж байна.

Дээрх байдлаас үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчиж, төр төсөвт байгууллагын иргэдэд үзүүлсэн үйлчилгээнээс нэмэгдсэн өртгийн албан татвар авдаггүй мөртлөө өөрийн гэрчлэх чиг үүргээ нотариатаар дамжуулан хэрэгжүүлсний төлөө иргэдээс ялгавартай байдлаар албан татвар авах нь төрийн үйлчилгээг тэгш хүргэх буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дах хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасан зарчмыг зөрчихөд хүргэж байна.<sup>9</sup>

Харин иргэдийн хувьд хуульд заавал нотариатаар гэрчлүүлэх үйлчилгээг авсаныхаа төлөө, төрийн чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлж буй нотариатын үйлчилгээг авсаныхаа төлөө нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх нь шударга ёсонд нийцэхгүй байхын зэрэгцээ 50 сая ба түүнээс дээш төгрөгийн үйл ажиллагааны борлуулалтын орлого олсон нотариатчаас үйлчилгээ авсан иргэд нотариатын үйлчилгээний хөлсөн дээр нэмж нэмэгдсэн өртгийн албан татварыг төлөх нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлд заасан “тэгш байдал нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг нэн илэрхий байдлаар зөрчсөн байна.

#### **Дүгнэлт**

Эрх зүйн орчны хувьд 2016 онд томоохон шинэчлэл хийгдэж далд эдийн засгийг бууруулах, эцсийн хэрэглэгч албан татвар төлөгчдийг урамшуулах ажил амжилттай хэрэгжиж байгаа нь судалгаанаас харагдаж

байна.

Энэхүү судалгааны ажлаар Монгол улсын нэмэгдсэн өртгийн албан татварын тогтолцоо, түүний хууль эрх зүйн орчны өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт дахь зэрэг болон сөрөг нөлөөллүүдийг бууруулах зорилгоор судалгааны ажлыг хийсэн бөгөөд дараах эрх зүйн өөрчлөлтийг хийх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

1. Монгол Улсын Үндсэн хуульд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлнэ.” гэж заасан. Гэтэл төр иргэнийхээ хууль ёсны эрх, ашгийг хамгаалах, эрх зүйн үйлчилгээг үзүүлснийхээ төлөө татвар авахаар хуульчилж Үндсэн хуульд заасан хууль ёсны эрхийг илт зөрчсөн заалт болох Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 7.2.3. нотариатын үйлчилгээ; 7.2.17. өмгөөлөл, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ; -дэх заалтуудыг хүчингүй болгох

2. Татварын урамшууллыг зөвхөн эцсийн хэрэглэгчид олгох зорилготой тул хувь хүнд олгоно гэсэн зохицуулалтыг нэмж хуулийн заалтыг нэг мөр ойлгомжтой болгох.

3. НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь хэсэгт “үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болсон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй” гэж зааж өгсөн нь татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр 2 дахин татвар ногдуулж, татвар төлөгч болон татвар суутган төлөгчдийн эрх зүйн байдлыг дордуулсан байна. Тиймээс уг заалтыг эргэн харах шаардлага бий болж байна.

#### **Ном зүй**

1. Ном, сурах бичиг, гарын авлага  
- УТЕГ, “Татварын тогтолцоо” II дэд дэвтэр, УБ., 2002 он  
- Г. Гантулга, Ч. Өнөржаргал, НӨАТ-ын хуулийн хэрэгжилтэнд тулгамдаж буй зарим асуудлууд. УБ., 2010 он  
- Цогт.О “Монгол улсын Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, цаашдын чиг хандлага” УБ., 2011  
- Улсын их хурлын тамгын газрын судалгааны төв, “Бодлогын судлагаа, шинжилгээ” судалгааны эмхтгэл, УБ., 2011 он,  
- Алтанзаяа.Г “Татварын бүртгэл”, УБ., 2012 он  
- Монгол улсын албан татварын эрх зүй, УБ., 2012 он  
- Монгол Улсын Үндсэн хуулийн 2016 оны 02 сарын 03-ны өдрийн 02 дугаар дүгнэлт  
2. Хууль тогтоомж  
- Монгол улсын Үндсэн хууль, УБ., 1992 он  
- Татварын ерөнхий хууль, УБ., 2008 он  
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, УБ., 2006, 2015 он  
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, УБ., 2006 он  
- Нотариатын тухай хууль, УБ., 2011 он

<sup>9</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 2016 оны 02 сарын 03-ны өдрийн 02 дугаар дүгнэлт



## МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ ҮРЧЛЭГДСЭН ХҮҮХДИЙН ИРГЭНИЙ ХАРЬАЛЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНУЙ БОЛГОХ АРГА ЗАМ

**Ц.Ундрах**

Отгонтэнгэр их сургуулийн Хуульзүйн сургуулийн багш, хууль зүйн магистр

Олон улсын эрх зүйн үндсэн субъект нь улс бөгөөд олон улсын эрх зүйн харилцаанд оролцохын тулд нутаг дэвсгэртэй, хүн амтай, засаглалтай, олон улсын харилцаа явуулах чадвартай байх гэсэн үндсэн дөрвөн шинжийг агуулсан байх шаардлагатай. Тухайн улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа бүх хүнийг тэр улсын хүн ам гэнэ.<sup>1</sup> Хүн амын эрх зүйн байдлыг улс бүр өөрсдөө тодорхойлдог. Өөрийн улстайгаа эрх зүйн тогтвортой холбоотой бие хүнийг тухайн улсын харьяат гэдэг бөгөөд эрх зүйн тогтвортой холбоо нь улсын бүрэн эрхтэй шууд хамааралтай тул өөрийн улсын нутаг дэвсгэр дээр мөн гадаад улсад оршин байгаагаас үл хамааран төрийн ивээлд багтаж, хамгаалагдаж байхыг ойлгоно. Иймээс Монгол Улсын харьяатын тухай хуулинд заасан үрчлэгдсэн хүүхдийн иргэний харьяаллыг шийдвэрлэх асуудал нь дан ганц иргэний харьяаллын асуудлыг хөндөж байгаа биш мөн төр иргэнээ хамгаалах ялангуяа хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол, аюулгүй байдал зэрэг олон үр дагавартай асуудлуудыг үүсгэдэг.

Үрчлэлт нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж буй хууль ёсны ажиллагаа<sup>2</sup> бөгөөд үүний үр дагавар бол үрчлэгдсэн хүүхэд болон үрчлэн авсан эцэг буюу эх хоёрын хооронд тухайн хүүхэд ба түүний төрсөн эцэг буюу эх хоёрын хооронд тухайн хүүхэд ба түүний төрсөн эцэг, эхээсээ өнчирсөн, эсвэл хүндэтгэн үзэх бусад

шалтгаанаар эцэг эхийн асран хүмүүжүүлэх үүрэг хэрэгжих боломжгүйн улмаас хүүхдийг өөр нэгэн гэр бүлд тэдний хууль ёсны гишүүнээр хүлээн авахыг хэлнэ.

Монгол Улсад 1999 оны Гэр бүлийн тухай хуульд гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авахыг хүсвэл үрчлүүлж болох зохицуулалт<sup>3</sup> шинээр тусгагдсан юм. Монгол Улс 1990, 1998 онуудад нэгдэн орсон Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенциудад нэгдэн орж мөн 17 улстай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хоёр талт гэрээний 8 улстай байгуулсан гэрээнүүдэд хүүхэд үрчлэлтийн талаархи харилцааг зохицуулсан байдаг.

Тухайлбал, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн<sup>4</sup> 21 дүгээр зүйлд үрчлэлтийн тогтолцоо бүхий болон түүнийг хүлээн зөвшөөрсөн оролцогч улсууд нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих бөгөөд тэдгээр нь:

(а) хүүхдийн эцэг эх, төрөл садан, хууль ёсны асран хамгаалагч нарын зүгээс хүүхэд үрчлүүлэхийг зөвшөөрсөн, эсхүл дээрх сонирхогч хүмүүс шаардлагатай зөвлөгөө авсны үндсэн дээр үрчлүүлэх зөвшөөрлөө тодорхой мэдээлэлтэйгээр өгсөн, үрчлэлтэд хамаарах болон найдвартай эх үүсвэрээс авсан бүх мэдээллийг үндэслэн дагаж мөрдөж байгаа хууль, журмын дагуу гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр хүүхдийг үрчлүүлнэ;

(б) хэрэв хүүхдийн хүмүүжил буюу үрчлэлтийг хангаж чадахуйц гэр бүлд байлгах буюу хүмүүжүүлэх зорилгоор шилжүүлэх, эсхүл тухайн хүүхдийн төрсөн оронд зохих ёсоор нь асрамжлах боломжгүй бөгөөд өөр оронд үрчлүүлэх нь хүүхдийг асарч хамгаалах боломжтой арга хэмээн авч үзэж, хүүхдийг асран хамгаалалтад түр шилжүүлэх, тохирох гэр бүлд үрчлүүлэх, эсхүл эх оронд нь зохих ёсоор асран халамжлах боломжгүй бол үндэстэн дамнан үрчлүүлэхийг хүлээн зөвшөөрнө;

(с) хүүхдийг улс хооронд үрчлүүлэх тохиолдолд тухайн улсад хүүхэд үрчлүүлэхэд дагаж мөрддөг баталгаа болон хэм хэмжээг адил хэмжээнд хангана;

(д) улс хооронд үрчлүүлэх хүүхдийг

<sup>3</sup>Д.Дугармаа “Монгол Улсын гэр бүлийн эрх зүй” УБ 2005 он., 95 дахь тал

<sup>4</sup>Хүүхдийн эрхийн тухай конвенц нь 1989 онд батлагдаж, 1990 онд хүчин төгөлдөр болсон бөгөөд Монгол улс 1990 оны 01.26-нд гарын үсэг зурж, 1990.07.05-нд соёрхон батласан.

<sup>1</sup>М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр “Олон улсын эрх зүй” УБ 1999 он., 83 дахь тал

<sup>2</sup>Ред. Д.Наранчимэг “Иргэн, бизнесийн эрх зүйн гарын авлага” УБ 2006 он., 173 дах тал



шилжүүлэн суурьшуулахад оролцсон хүмүүс энэхүү үйл ажиллагаанаас санхүүгийн ашиг хонжоо олохгүй байх шаардлагатай бүх арга хэмжээ авна;

(е) энэ зүйлийн зорилтыг хангах үүднээс шаардлагатай бол хоёр талт буюу олон талт хэлэлцээр байгуулах, тэрчлэн хүүхдийг өөр улсад шилжүүлэн суурьшуулах ажлыг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэхийг зорино.

Харин үрчлэгдсэн хүүхдийн иргэний харьяаллын асуудлын эрх зүйн зохицуулалтын үндэс нь Монгол Улсын Үндсэн хууль, Харьяатын тухай хуулийн<sup>5</sup> 13 дугаар зүйлд заасан байдаг:

13 дугаар зүйл. Үрчлэгдсэн хүүхдийн иргэний харьяаллыг шийдвэрлэх

1. Гадаадын иргэн эхнэр, нөхрийн үрчлэн авсан Монгол Улсын харьяат 16 нас хүрээгүй хүүхэд Монгол Улсын харьяат хэвээр байна.

2. Хэрэв гадаадын иргэн, эхнэр, нөхөр нь Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах үед түүний иргэний харьяаллыг өөрчлөх хүсэлт гаргавал үрчлүүлж буй эцэг эхийн саналыг харгалзан тухайн хүүхдийн иргэний харьяаллыг шийдвэрлэж болно.

3. Гадаадын иргэн эхнэр, нөхрийн үрчлэн авсан Монгол Улсын харьяат 16 насанд хүрсэн хүүхдийг тэдний хүсэлтээр Монгол Улсын харьяатаас гарахыг зөвшөөрч болно.

Хуулийн зүйл, заалтын логик дэс дараалал, хэм хэмжээний захирах захирагдах талаас авч үзвэл дээрх 3 хэсэг нь хоорондоо уялдаатай бөгөөд 13.1 дэх хэсгээс 13.2, 13.3 дахь хэсэг нь "эх" авах авснаар Харьяатын тухай хуулийн 13 дугаар зүйлийн агуулга нь үрчлэгдсэн хүүхдийн иргэний харьяалал нь өөрийн улстайгаа нягт уялдаа холбоотой бөгөөд манай улс иргэний харьяалал олж авах хөрсний болон цусны гэсэн үндсэн хоёр зарчмын цусны зарчмыг баримталдаг онцлогтой. Уг зарчмыг Оросын хувьсгалын өмнөх үеийн хуульч В.Н.Александренко "Энэ бол тодорхой хүний эрхийг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг юм", Английн хууль Дж.Уэстлейк "Энэ зарчим бол Европын эрх зүйд хүний эрхийг биш төрийн эрх мэдлийн хүрээг өргөтгөхөд чиглэгдсэн"<sup>6</sup> гэж тодорхойлсноос үзэхэд цусны зарчимтай улс орнууд иргэнийнхээ харьяаллыг хадгалах зорилготой байгаа нь харагдаж байна.

Харьяатын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасан "Гадаадын иргэн эхнэр, нөхрийн үрчлэн авсан Монгол

Улсын харьяат 16 нас хүрээгүй хүүхэд Монгол Улсын харьяат хэвээр байна" гэж заасан нь хүүхдийн насны хязгаар нь Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 1 дүгээр зүйлд заасан ". . . тэрээр 18 наснаас өмнө насанд хүрсэнд тооцогдоогүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ", Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлд зүйлд "Хүүхдийн эрхийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл хамгаалахад энэ хууль үйлчилнэ" гэж тус тус заасантай зөрчилдөж байна. Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журамд<sup>7</sup> зааснаар Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авагч гадаадын иргэний хүлээх үүрэгт "үрчлэн авсан хүүхдийн талаар 1 сартайгаас 3 нас хүртэл хагас жил тутам, 4-8 нас хүртэл жил тутам, 8-16 нас хүртэл хоёр жил тутам Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд мэдээлэл ирүүлэх" гэж заасан байдаг бөгөөд 16-18 насны хүүхдийн мэдээллийг ирүүлэх үүрэггүй байгаа учир дутагдалтай юм.

Харьяатын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.3 дахь хэсэгт гадаадын иргэн эхнэр, нөхрийн үрчлэн авсан хүүхдийн иргэний харьяаллыг өөрчлөх талаар зохицуулсан байдаг. Гэтэл Гэр бүлийн тухай хуулийн<sup>8</sup> 58 дугаар зүйлийн 58.9 дэх хэсэгт "Үрчлэгдсэн хүүхэд харьяатаа сонгох эрхийг Харьяатын тухай Монгол Улсын хуульд заасны дагуу эдэлнэ." гэж заасан нь үрчлэгдсэн хүүхдэд өөрт нь иргэний харьяаллаа сонгох эрх нь байгаа мэт боловч Харьяатын тухай хуулинд энэ эрх олгогдоогүй байгаа нь анхаарал татаж байна. Гэр бүлийн тухай хууль, Гадаадын иргэнд монгол улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журамаар үрчлэгч эцэг, эхэд тавигдах шаардлага, хүүхэд үрчлүүлэх процессийг нарийвчлан зохицуулдаг.

Дэлхийн улс орнуудад хүүхэд үрчлэлтийн асуудалд үүсэж байгаа зарим сөрөг нөлөөллийг дурьдвал<sup>9</sup>:

-Хүүхэд үрчилж авахыг ихэд сонирхож буй хүүхэдгүй гэр бүлийн тоо/ хэрэгцээ/ өсөн нэмэгдэж байгаа явдал

-Зарим гэр бүл, ялангуяа ганц бие ядуу эмэгтэй хангалуун амьдралаар тэжээн тэтгэж

<sup>7</sup>Гадаадын иргэнд монгол улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам нь 2001 оны Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2001 оны 100/32 дугаар тушаалаар батлагдсан.

<sup>8</sup> Гэр бүлийн тухай хууль 1999 онд батлагдаж 2002, 2010, 2011, 2012, 2016 онуудад тус тус нэмэлт өөрчлөлт орсон.

<sup>9</sup> УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс "Хүүхэд үрчлүүлэх болон хүүхэд үрчлэн авах талаар бусад орны туршлага, эрх зүйн зохицуулалт" УБ 2013 он., 11 дэхь тал

<sup>5</sup> Харьяатын тухай хууль 1995 онд батлагдаж 2000, 2002, 2008, 2013, 2015 онуудад нэмэлт өөрчлөлт орсон.

<sup>6</sup> О.Пунцагдаш "Иргэний харьяалал (Олон улсын эрх зүйн асуудал)" УБ 2002 он., 7 дахь тал



чадахгүй байгаа зовлонгоо гэтлэх цорын ганц арга бол бусдад хүүхдээ үрчлүүлэх нь асуудлыг шийдэх гарц гэж үзэх болсон,

-Дэлхийн зарим хэсэгт хүүхэд үрчлэх асуудалд уламжлалт ёс заншил саад болдог нь хүүхэд үрчилж авах гэр бүл олдохгүй цөөрөхөд хүргэдэг сөрөг нөлөөлөл

-Хүүхэд үрчлэн авах зорилго агуулга өөрчлөгдөж түүнийг өөр зорилгод ашиглах явдал нэмэгдэж байгаа зэрэг асуудлууд орж байна.

Эндээс үзэхэд хүүхэд үрчлэн авах зорилго агуулга өөрчлөгдөж түүнийг өөр зорилгод ашиглах явдал нэмэгдэж байгаагаас үүдэн үрчлэн авч байгаа гадаадын иргэдийн улс орны нөхцөл байдлыг харгалзан үзэх хэрэгтэй. Хүний эрхийн зөрчил өндөр, улс төрийн нөхцөл байдал тогтворгүй, хүн худалдаалах гэмт хэрэг их гардаг мөн монгол хүн амьдрахад тохиромжгүй зэрэг эрсдэл үүсч болох олон хүчин зүйлийг тооцоолон тодорхой тохиолдолд хязгаарлалт тавих эсхүл хүүхэд үрчлүүлэхийг хориглох нь зүйтэй. Тухайлбал, НҮБ-ын хар тамхи болон гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагаас (United Nations Office on Drugs and Crime) хийсэн 2014 оны судалгааны тайланд<sup>10</sup> хүн худалдах, худалдаалах гэмт хэрэгт эмэгтэй хүн 49%, эрэгтэй хүн 18%, эмэгтэй хүүхэд 21%, эрэгтэй хүүхэд 12% хувийг эзлэж, жил ирэх тусам насанд хүрсэн эмэгтэйчүүдийн тоо 2004 онд 74% байсан бол 2011 онд 49% болон буурахад харин насанд хүрээгүй эмэгтэй хүүхдийн тоо 2004 онд 10% байсан бол 2011 онд 21% болон өссөн үзүүлэлт гарсан байна. Гадны улс орнуудад үрчлүүлж байгаа хүүхдийн хүйсийн хувьд эрэгтэй хүүхдүүдээс илүү эмэгтэй хүүхдүүд үрчлэгддэг учраас энэ төрлийн гэмт хэрэгт өртөхгүй байх гэсэн магадлал тун тааруу байгаа нь харагдаж байна.

### Дүгнэлт

Үрчлэгдсэн хүүхдийн иргэний харьяаллын асуудал нь хүний эрх, эрх чөлөө, төрийн эрх мэдэлтэй шууд холбоотой асуудал юм. Олон улсын эрх зүйн харилцаанд улс олон улсын харилцаа явуулах чадварын гол илрэл бол өөрийн улсын иргэдийн хууль ёсны эрх, ашгийг хамгаалж чадахад оршдог.

Монгол Улсын нэгдэн орсон Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенцид<sup>11</sup> "Улс хооронд хүүхэд үрчлэхэд хүүхдийн дээд ашиг сонирхол болон түүний үндсэн эрх олон улсын эрх зүйд нийцэж байгаа талаар баталгаа бүрдүүлэх; хүүхэд хулгайлах, худалдах,

<sup>10</sup> UNODC "Global report on trafficking in person 2014". Дэлгэрэнгүйг [https://www.unodc.org/documents/data-and-analysis/glotip/GLOTIP\\_2014\\_full\\_report.pdf](https://www.unodc.org/documents/data-and-analysis/glotip/GLOTIP_2014_full_report.pdf)

<sup>11</sup> Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц нь 1993 онд батлагдаж, 1995 онд хүчин төгөлдөр болсон бөгөөд Монгол улс 1998 оны 01.16-нд нэгдэн орсон.

хил дамнан худалдахаас сэргийлж тэдгээр баталгааг хүндэтгэх үүднээс хэлэлцэн тохирогч улсууд хамтын ажиллагааны тогтолцоо бий болгох", Хүүхдийн эрхийн тухай конвенцид " Нийгмийн хамгааллын улсын буюу хувийн байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна" гэж тус тус зааснаас үзэхэд аливаа төрийн бодлого шийдвэр нь хүүхдийг эрх дээд зэргээр хангахад чиглэгдэх ёстой байна.

Иймээс Харьяатын тухай хуулинд заасан үрчлэгдсэн хүүхдийн иргэний харьяаллыг хэвээр хадгалах насыг 18 нас хүртэл болгон өөрчилснөөр хүүхдийн эрх, ашгийг хамгаалахад нөлөөлөх гол нөхцөл бүрдэж мөн үрчлэн авах гэж байгаа эцэг эхийн улс оронд тодорхой хэмжээний шаардлага тогтоож өгөх нь Монгол Улсын нэгдэж орсон олон улсын гэрээ, конвенцтэй зөрчилдөхгүй бөгөөд энэ асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгаж өгснөөр үрчлэгдсэн хүүхдийн иргэний харьяаллын асуудлыг боловсронгуй болгох нэг гарц болно гэж үзэж байна.

### Ном зүй


- 1.М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр "Олон улсын эрх зүй"УБ 1999 он.
- 2.О.Пунцагдаш "Иргэний харьяалал (Олон улсын эрх зүйн асуудал)" УБ 2002 он.
- 3.Д.Дугармаа "Монгол Улсын гэр бүлийн эрх зүй" УБ 2005 он.
- 4.Ред. Д.Наранчимэг "Иргэн, бизнесийн эрх зүйн гарын авлага" УБ 2006 он.
- 5.УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс "Хүүхэд үрчлүүлэх болон хүүхэд үрчлэн авах талаар бусад орны туршлага, эрх зүйн зохицуулалт" УБ 2013 он.
6. Харьяатын тухай хууль /1995/
- 7.Гэр бүлийн тухай хууль /1999/
- 8.Гадаадын иргэнд монгол улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам /2001/
- 9.Хүүхдийн эрхийн тухай конвенц /1989/
- 10.Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц /1993/
- 11.[www.unodc.org](http://www.unodc.org)
- 12.[www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)

## ОЛОН УЛСЫН ТЕРРОРИСТ БҮЛЭГЛЭЛ “ИСЛАМЫН УЛС /ISIS/-ЫН ТУХАЙ”

Д.Нямбат

Анх 2003 онд Жорданы армийн офицер Абу Мусаб Аль-Заргав (Abu Musab al-Zarqawi) гэгч этгээд Осам Бин Ладений Аль Кайда бүлэглэлийн салбарыг Иракт үүсгэж толгойлогч нь болсноор Исламын улс бүлэглэлийн суурь бий болсон байна. 2014 онд “Исламын улс” гэж өөрсдийгөө нэрлэн Аль Кайда бүлэглэлээс салан тусгаарласан. Дэлхий нийт “Исламын улс террорист бүлэглэл” хэмээн нэрлэж байна.

Аль Кайда бүлэглэлтэй ижил террорист халдлага үйлдэх, дайн самуун дэгдээх, энгийн иргэдийг үй олноор нь хөнөөх боловч тэднээс илүүтэй цэрэгжсэн, армийн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг<sup>1</sup>. Армийнхныг голчлон элсүүлдэг. 2014 оны 6 дугаар сард Ираны урд хилтэй залгаа оршдог Суннит үндэстний гол хот Иракийн 2 дахь том хот болох Мосул (Mosul), түүнээс бага зэрэг урагшаа орших Текрет (Tikrit) хотуудыг эзэлсний дараа Исламын улс бүлэглэл нь өөрийгөө Халифийн вант улс хэмээн нэрлэн дэлхийн лалын шашинтай бүх улс орон, иргэдийн улс төр, шашны эрх мэдлийг төвлөрүүлнэ хэмээн зарласан. Исламын улс бүлэглэл нийтдээ 30.000-100.000 гишүүнтэй.



Зурагт дүрсэлснээр<sup>2</sup> Исламын улс бүлэглэл нь Иракийн баруун хэсгийг бүхэлд нь, Сирийн зүүн хэсгийн олон арван хотуудыг эзэлсэн. Нийтдээ 6.5 сая оршин суугчтай. Цаашид газар нутгаа тэлсээр байх хүсэлтэй тул Египет, Ливи, Нигери, Пакистан, Афганистан зэрэг улс оронд гишүүд нь газар нутаг эзэмшихээр халдлага үйлдэх, дотоодын

дайн дэгдээж байдаг. Сүүлийн үед хэд хэдэн хотыг эзэлсэн байлдааны үйл ажиллагаа нь амжилттай явагдаж буй тул тус бүлэглэлд элсэн орох хүсэлтэй гадаадын иргэдийн тоо нэмэгдэх хандлагатай байна. Жишээ нь: 3400-20.000 орчим суннит шашинтай иргэд барууны орнуудаас хүрч ирч элссэн. Энэ нь барууны орнуудын тагнуулын албадыг улам бүр сонор сэрэмжтэй, хяналттай ажиллахыг шаардаж байна. Учир нь террорист халдлага үйлдэх ятгалгад автсан, тархиа угаалгасан иргэд өөрийн паспортаар буцаж эх орондоо ямар ч саадгүй ирч тэсрэх бөмбөг дэлбэлэх, амиа золиослон олон хүний амь насанд халдах эрсдэл үүсгэж байгаа.

АНУ-ын Тагнуулын ерөнхий газрын дарга Жамес Клаппер: 2015 оны 2 дугаар сарын байдлаар Исламын улс бүлэглэлд 15.000 гаран гадаадын иргэд гишүүнээр элссэн.

Тус гэмт бүлэглэлийн гишүүдийн сарын цалин 350 орчим ам доллар. Энэ нь барууд террорист бүлэглэл, орон нутгийн босогчдын авч буй хөлснөөс илүү гэсэн үг. Иракын засгийн газрын армийн алба хаагчдын цалингаас 5 дахин өндөр үнэ юм. Иймд Ирак, Сирийн олон жирийн иргэд Исламын улс бүлэглэлд элсэх хүсэлтэй байдаг.

Сирийн хойд зүгт орших Ракка (Raqqa) нь Исламын улс бүлэглэлийн нийслэл хот хэмээн нэрлэгддэг. Удирдлагыг тэнд төвлөрүүлж шүүх, цагдаа, санхүүгийн зэрэг төрийн байгууллагыг шинээр бий болгож эрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц хариуцсан байгууллагын удирдлагыг хянадаг болсон. Нийгмийн халамжийн үйлчилгээ бага зэрэг үзүүлдэг.

### САНХҮҮЖИЛТ

Аливаа террорист бүлэглэлүүд гэмт хэрэг, террорист халдлага үйлдэх бусад улс орон, байгууллагын хандив тусламжаар санхүүжиж байдаг бол Исламын улс бүлэглэл нь голчлон өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг шинжээрээ ялгаатай.

Тэдний санхүүжилтийн гол эх үүсвэр нь нефть юм. 2014 оны байдлаар нэг өдөрт дунджаар 44.000 баррель нефтийг Сири-ээс, 4000 баррель нефтийг Иракаас олборлон дундын зуучлагч нарт түүхийгээр нь борлуулан 1-3 сая ам долларын орлого төвлөрүүлдэг. Зуучлагч нар нэг баррелийг 20-35 ам доллараар худалдан авч цааш нь 60-100 ам доллараар борлуулна.

Исламын улс бүлэглэлийн гол дайснууд гэгдэх боловч нефтийн хомсдолтой шалтгаанаар Сирийн ерөнхийлөгч Башар

<sup>1</sup>Zachary Laub (2015), *The Islamic State Introduction in* <http://www.cfr.org/iraq/islamic-state/p14811>

<sup>2</sup> Исламын улсын эзэмшил газар нутаг (2015) the Economist in <http://www.theatlantic.com/international/archive/2014/08/the-many-ways-to-map-the-islamic-state/379196/>





Аль Ассад (Bashar al-Assad)-ын засгийн газар, Турк, Иракийн Курдуудад зах зээлийн ханшнаас бага үнээр бэлэн мөнгөөр төлбөр тооцоогоо хийн нефтэй зардаг. Татвар төлөх ойлголт байхгүй тул далд эдийн засаг үүссэн. Судалгаа, дүн шинжилгээний арга ашиглан нефтийн хэмжээ, мөнгөний урсгал, тоог таамаглахаас биш яг тэдэн ам долларыг олдог эсхүл олсон гэх тоо баримт байхгүй.

Гэхдээ агаарын дайралт, тусгай ажиллагаа, буудалцаан гээд зуучлагч нар маш олон эрсдэлтэй нүүр тулдаг тул нефтийн үнэ өсөх боломжгүй<sup>3</sup>.

Нефть бусад байгалийн нөөцнөөс гадна Исламын улс бүлэглэл нь айлган сүрдүүлэх гэмт хэргээс сард 8 сая ам долларын ашигтай ажилладаг гэсэн тооцоо байна. Мөн түүх дурсгалын эртний эд зүйлсийг хууль бусаар хил дамнуулан худалддаг. Тэдний эзэмшлийн хотуудад амьдарч буй Христийн шашинтай иргэдээс нэмэгдэл татвар авна. Зарим бизнес эрхлэгчид худалдаа наймаагаа хамгаалуулахаар татаас төлнө. Европ болон бусад тивээс ирсэн сэтгүүлч нарыг хулгайлан барьцааны мөнгө нэхнэ. Банк дээрэмдэнэ. Эмэгтэйчүүдийг секс боолчлолд оруулж худалдана. Мал, үр тариа хулгайлна. АНУ-ын Төрийн сангийнханы тодорхойлсноор Исламын улс бүлэглэлийн тогтмол бус үйл ажиллагааны жилийн орлого 20 сая ам доллараас давсан.<sup>4</sup>

2014-2016 онд Исламын улс бүлэглэл зохион байгуулсан, удирдан чиглүүлсэн террорист халдлагуудаас үзэхэд Бельги-2, Австрали-3, Афганистан-1, Канад-2, Франц-8, Саудын Араб-4, Ливи-5, Дани-1, Тунис-3, Йемен-3, АНУ-2, Турк-4, Кувейт-1, Египет-6, Ирак-1, ОХУ-1, Ливан-1, Сири-2, Индонез-1 удаа зэрэг 19 улс оронд 51 удаагийн халдлага үйлдэгдээд байна.

Үүнийг автомат бугаар олон зуун сумаар шүрших, гранат дэлбэлэх, олон хүн цугларсан сүм, жагсаал цуглаан, ресторанд амиа золиослогч тэсрэх бөмбөг дэлбэлэх, онгоц барьцаалж дэлбэлэх зэрэг аргууд ашигласан. Халдсаны улмаас 1281 иргэн амь насаа алдаж, 2932 иргэн гэмтэж шархадсан байна.

<sup>3</sup> FATF (P16 2015), Financing of the Terrorist Organization Islamic State in Iraq and the Levant in <http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/Financing-of-the-terrorist-organisation-ISIL.pdf>

<sup>4</sup> АНУ-ын Төрийн сангийн Хэвлэл мэдээллийн төв (2015) in <https://www.treasury.gov/press-center/press-releases/Pages/jl2672.aspx>

Үүнээс Тунис, Египет, Саудын Араб, Морокко, Йемен улсад хяналтаа тогтоох, газар нутаг эзэмших зорилготой халддаг<sup>5</sup>.

Халдлага үйлдэгдэх бас нэг ноцтой шалтгааныг тухайн улс орны эдийн засгийн уналт, ажилгүйдэл, нийгмийн халамж, үйлчилгээний хангалтгүй байдалтай холбоотой гэж үздэг. Тухайлбал, Морокко, Тунис, Йемен улсыг террорист халдлагад өртөх хамгийн өндөр эрсдэлтэй улс орон гэж үзэж байгаа бөгөөд учир нь дээрх үзүүлэлт сүүлийн 5-н жил сайжрахгүй байна.

Харин Саудын Араб, Алжир, Сири, Иракийг эрсдэлтэй, Египет, Туркийг бага эрсдэлтэй гэж тодорхойлсон байна.

### ИСЛАМЫН УЛС ТЕРРОРИСТ БҮЛЭГЛЭЛИЙН ГИШҮҮДИЙГ БЭЛТГЭХ

Цалин хөлсний боломж, албадлага, лалын шашны мөн чанарыг бүрэн гүйцэт ойлгоогүй, лалын шашин дотроо ондоо урсгал шүтдэг зэрэг шалтгаанаар иргэд, харин боловсролгүй, амьдрахын эрхээр, өөрийн гэсэн үзэл бодол төлөвшиж амжаагүй шалтгаанаар хүүхдүүд уг гэмт бүлэглэлийн гишүүнээр элсэж байна. Насанд хүрсэн террорист гишүүд, хүүхдүүдийг аль алиныг нь цэргийн баазд бэлтгэнэ. Нууц байдлаар Хойд Америк, Европийн холбооны зарим улс болон манай улстай хамгийн ойрхон нь Казакстан улсад дадлагажуулж бэлддэг баазууд байна<sup>6</sup>.

Хүүхдүүдийг террорист халдлага үйлдэх хойч үеэ болгон бэлтгэх ийм газрыг "Исламын улсын гавар (үнэгний)" бааз хэмээн нэрлэнэ. Сирид гэхэд багадаа 3-н хүүхдийн цэргийн бааз байна. Тэнд хүйс, насны хэмжээ заахгүй. АК47 маркын бууг задлах, буцааж угсрах, буудах, Коран судрыг судлуулах, Араб хэл заах, хүний толгойг авч байхыг харах, айдсаа дарж сургахын тулд хүний толгойг өөрөөр нь тасдуулах, амиа золиослогч болгон тархийг нь угаах, тэр ч бүү хэл эцэг эхээ хэрхэн алахыг зааж өгч байна<sup>7</sup>. Хэрвээ татгалзвал хөл гараа хугалуулах эсхүл амиа алдана<sup>8</sup>.

<sup>5</sup> Legatum Institute (P 34, 2015). How vulnerable are societies to Islamic State?

<sup>6</sup> Tom Whitehead (2016), Islamic State setting up terror training camps in Europe, police agency warns in <http://www.telegraph.co.uk/news/worldnews/islamic-state/12120636/Islamic-State-setting-up-terror-training-camps-in-Europe-police-agency-warns.html>

<sup>7</sup> Tom Wyke (2015) ISIS release shocking new video of child soldiers from Kazakhstan being trained with AK47s in <http://www.dailymail.co.uk/news/article-2845531/ISIS-release-shocking-new-video-child-soldiers-Kazakhstan-trained-AK47s.html>

<sup>8</sup> Robert Spencer (2016) Islamic State training kidnapped children to kill their parents in <http://www.jihadwatch.org/2016/01/islamic-state-train->

**ТӨГСГӨЛД НЬ**

Манай улсын хувьд эдийн засгийн өсөлт, нийгмийн халамж үйлчилгээгээ сайжруулах, ажилгүйдлийн түвшинг багасгах, Исламын улс бүлэглэлтэй тэмцэх олон улсын эвсэлд нэгдэх, тусламж дэмжлэг үзүүлэхдээ болгоомжтой хандах байдлаар террорист халдлагад өртөх эрсдлийг бууруулах боломжтой. Мөн иргэдийн шашны боловсролыг дээшлүүлэх тухайлбал, лалын шашинтай иргэдэд лалын шашны үзэл санаа, агуулгыг бүрэн дүүрэн ойлгуулах сургалт явуулах, Коран судрын үг сургаалийн ойлголтын зөрүү бий эсэх тандалт судалгаа хийх зэрэг арга хэмжээ авах нь зүйтэй.

Жишээ нь: Коран судрын 4:3 хэсэгт лалын шашинт эрэгтэй хүн 4 хүртэл эхнэр авахыг зөвшөөрсөн боловч бүгдэд нь эрх тэгш, шударга хандаж чадахгүй бол зөвхөн нэгтэй л гэрлэ гэсэн утгатай сургааль бий<sup>9</sup>. Мөн хүнлэг энэрэнгүй байхыг сургаан олон заалтууд бий. Гэвч олон эхнэртэй болвол, лалын бус шашинтай хүнийг хороовол диваажинд очно гэж Коран судрыг гуйвуулж ойлгуулснаар террорист бүлэглэлд элсэх тохиолдлууд гардаг байна. Түүнчлэн Исламын улс бүлэглэл нь онгоцны жолоочийг бэлтгэн ирээдүйд үйлдэх халдлагыг хэдэн арван жилийн өмнөөс эхлүүлж буйгаас үзвэл манай улсын лалын шашинтай иргэд, алба хаагчдыг элсүүлэх, хахуульдах, тархийг нь угаахыг үгүйсгэхгүй юм.

Мөн хөрш зэргэлдээх улсуудтай терроризмтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах, хүний нөөцийг сургах, туршлага судлах шаардлагатай байгаа. Террорист бүлэглэлийн санхүүжилтийг илрүүлэх, мөнгөний гүйлгээг таслан зогсоох нь терроризмтэй тэмцэх хамгийн үр дүнтэй аргад тооцогдож байгаа тул манай улсад орж, гарч буй мөнгөний урсгалыг хянах, олон улсын банк санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох зэргээр эрсдлийг бууруулж чадна.

хавсралт. “Исламын улс бүлэглэлийн үйлдсэн террорист халдлагууд

Хаана	Хэзээ	Халдлага <sup>1</sup>	Нас барсан хүний тоо	Шархадсан хүний тоо
Бельги	2014/5	Бельгийн нийслэл Брюссель хотын Еврейн музейн дэргэд Исламын улс гэсэн бичигтэй цамцтай этгээд хүмүүс руу гал нээсэн. Гэмт этгээдийг баривчилсан.	4	0
Австрали	2014/9	Терроризмтэй тэмцэх албаны цагдаагийн 2 офицер шархадсан. Гэмт этгээд буудалцааны үеэр алагдсан.	0	2
Австрали	2014/9	Сидней хотод 15 хүнийг барьцаалахаар төлөвлөж байсан 2 этгээдийг илрүүлэн баривчилсан. Ял шийтгэгдсэн. Өвч зэвсэглэсэн 800 цагдаагийн алба хаагчид ажилласан.	0	0
Канад	2014/10	Канадын Куебик мужид ганцаардсан чоно (lone wolf) гэж нэрлэдэг террорист этгээд машинтай 2 цагдаагийн алба хаагч руу бөмбөг дэлбэлж нэг нь газар дээрээ нас барж, нэг нь амьд үлдсэн.	1	1
Канад	2014/10	Канадын Парламентийн байшингийн дэргэд Үндэсний дайны дурсгал үзүүлэнг хамгаалж байсан цэргийг буудаж хөнөөсөн. Бүүг нь салгахаар ноцолдож байсан тусгай хамгаалалтын офицер хөлөндөө буудуулсан. Гэмт этгээд газар дээрээ буудуулж нас барсан.	1	3
Австрали	2014/12	Исламын улс бүлэглэлийг дэмжигч этгээд Сидней хотын Линди кафе д үйлчлүүлж байсан 17 иргэнийг барьцаалсан. Буутай этгээдийг орж ирэх үед 11 иргэн зугатаж амжсан. Цагдаагийнхан байшин руу буудаж эхлэх үед террорист этгээд болон нэг иргэн цагдаагийн суманд өртөж нас барсан.	2	4

ing-kidnapped-children-to-kill-their-parents

<sup>9</sup> Dr. Gamal A. Badawi (2012) What Is The Legal Status Of Polygamy In Islam? in Polygamy In Islamic Law book, chapter 3 [http://www.muslimmah.org/books/books\\_detail.php?chapter\\_no=3&chapter\\_sub=What%20Is%20The%20Legal%20Status%20Of%20Polygamy%20In%20Islam?&title\\_id=17](http://www.muslimmah.org/books/books_detail.php?chapter_no=3&chapter_sub=What%20Is%20The%20Legal%20Status%20Of%20Polygamy%20In%20Islam?&title_id=17)



Франц	2014/12	Исламын улс бүлэглэлийг дэмжигч этгээд цагдаагийн хэсэг рүү орж Аллах Акбар гэж хашгиран 3 алба хаагчийг буудаж шархдуулсан. Гэмт этгээдийг буудаж хөнөөсөн.	0	3
Франц	2014/12	Исламын улс бүлэглэлийг дэмжигч этгээд гудамжинд явган зорчигч олонтой хэсэгт машинаа дэлбэлж 11 иргэнийг шархдуулсан. Тухайн үедээ Аллах Акбар гэж хашгирч байсан. Гэмт этгээдийг баривчилсан.	0	11
Франц	2014/12	Исламын улс бүлэглэлийг дэмжигч этгээд гудамжинд явган зорчигч олонтой хэсэгт Хрисмасын бэлгийн дэлгүүрийн гадаа машинаа дэлбэлж 10 иргэнийг шархдуулж, 1 иргэн нас барсан. Тухайн үедээ Аллах Акбар гэж хашгирч байсан. Гэмт этгээдийг баривчилсан.	1	10
Саудын Араб	2015/01	2 этгээд хил хамгаалахын алба хаагчид руу гал нээсэн. Нэг нь өөрийгөө дэлбэлж амиа золиослосон. Үлдсэнийг нь буудаж хөнөөсөн.	3	1
Франц	2015/01	3 хоногийн үргэлжилсэн халдлага, барьцаалах гэмт хэргийн улмаас иргэд, цагдаагийн алба хаагчид алагдсан.	5	11
Египет	2015/01	Цэргийн бааз болон зочид буудал руу халдсан.	27	
Бельги	2015/01	Террорист халдлага үйлдэхээр бэлтгэж байсан 2 этгээдийг илрүүлэн баривчлах ажиллагааны үед хөнөөсөн.	2	0
Ливи	2015/01	Голдуу гадаад улсын төлөөлөгчид байрладаг зочид буудлын дэргэд машин дэлбэлсэн, нэг амиа золиослогч өөрийгөө дэлбэлсэн. Гадны 5, хамгаалалтын 5 ажилтан нас барсан.	10	0
Дани	2015/02	Данид төрсөн боловч Палестаний иргэн Копенгагенд болсон илтгэлийн үеэр гал нээсэн. Халдлага үйлдэхээс хэдхэн хоногийн өмнө Исламын улс бүлэглэлийн удирдагч Абу Бакраас зааварчилгаа авсан нь тогтоогдсон.	2	5
Ливи	2015/02	Христийн сүм рүү халдсан.	21	
Тунис	2015/03	Үндэсний музейд байсан хүмүүс рүү автоматаар шүршиж гадны жуулчид голдуу өртөж нас барсан. 2 гэмт этгээдийг цагдаа нар буудаж хөнөөсөн. Нэг нь зугатсан.	22	50
Йемен	2015/03	Лалын 2 сүмд тус бүр 2 амиа золиослогч өдрийн цагаар мөргөл үйлдэж байсан иргэдийн дунд өөрсдийгөө дэлбэлсэн. Йеменийн түүхэнд үйлдэгдсэн хамгийн том террорист халдлагад тооцогдож байна.	137	351
Египет	2015/04	Цэргийн бааз руу халдаж 15 цэрэг, 2 энгийн иргэн алагдсан.	17	
Ливи	2015/04	Өмнөд Солонгосын ЭСЯ-ны хамгаалалтын 2 ажилтанг буудсан.	2	
Афганистан	2015/04	Төрийн алба хаагчид цалингаа авахаар банкны гадаа зогсож байхад амиа золиослогч тэсрэг бөмбөг дэлбэлсэн.	34	125
АНУ	2015/05	Техас мужид Мухаммедийн тухай хүүхэлдэйн киноны нээлтийн үеэр 2 террорист этгээд цагдаа нар руу гал нээж нэгийг шархдуулсан. Буудалцааны үеэр 2 гэмт этгээдийг буудаж хөнөөсөн.	0	1
Ливи	2015/05	Цэргийн бааз руу халдсан. 21 террористийг устгасан. Хэдэн цэргийн алба хаагч амь үрэгдсэн нь тодорхойгүй.	21	
Саудын Араб	2015/05	Шийт үндэстний сүм руу халдсан.	21	123
Турк	2015/06	Бүгд найрамдах ардчилсан намын сонгуулийн үеэр 2 удаа бөмбөг дэлбэрсэн. Сонгуулиас 2 өдрийн өмнө тэсрэх бөмбөгийг байршуулсан байв. Бөмбөг дэлбэлсэн гэмт этгээдийг баривчилсан.	4	100-200



Франц	2015/06	Францад төрсөн лалын шашинтай этгээд үйлдвэрийнхээ эзний толгойг тасдаж, үйлдвэрийн гадаа машинаа дэлбэлсэн. Гэмт этгээдийг баривчилсан боловч 6 сарын дараа шоронд байхдаа өөрийгөө боомилж нас барсан.	1	2
Кувейт	2015/06	Кувейт хотын лалын сүмд мөргөл үйлдэж байсан иргэдийн дунд бөмбөг дэлбэлсэн. Гэмт этгээд дэлбэрэлтэнд өртөж нас барсан. 15 хүнийг террорист ажиллагаанд оролцсон үндэслэлээр баривчилсан.	27	227
Тунис	2015/06	Тунисийн зүүн хэсэгт далайн эргийн хот Соуссе хотын барууны орны иргэд голчлон буудалладаг зочид буудал руу автоматаар шүршиж жуулчид өртсөн. Гэмт этгээдийг цагдаа нар буудаж хөнөөсөн.	38	39
Иемен	2015/06	Рамадан сарын үеэр машинтай амиа золиослогч сүм руу халдсан.	4	12
Иемен	2015/06	Машинтай амиа золиослогч Шийтийн сүм руу халдсан.	2	6
Египет	2015/07	Синай мужид орших Исламын улс бүлэглэлийн армийн 300 гаран гишүүд цагдаагийн хэлтэс рүү дайрсан. 100 гаран гэмт этгээдийн хөнөөж, 20 орчим цэргийн зориулалттай машиныг устгасан. Бусад нь зугатаж амжсан.	21+	9
Египет	2015/07	Кайр дахь Италийн консулын газрын дэргэд тэсрэх бөмбөгтэй машин дэлбэлсэн.	1	9
Ирак	2015/07	Хан бани Сад хотын супермаркет руу машинтай амиа золиослогч халдаж өөрийгөө дэлбэлсэн.	125	130+
Турк	2015/07	Социалист намын залуучуудын цуглааны үеэр амиа золиослогч өөрийгөө дэлбэлсэн.	33	104
Саудын Араб	2015/08	АНУ болон бусад улсын холбоотон болж Исламын улс бүлэглэлийн эсрэг хориг арга хэмжээ авсан үндэслэлээр 21 настай амиа золиослогч сүмд өөрийгөө дэлбэлсэн.	21	
Франц	2015/08	Амстердамаас Парисаас руу явж байсан хурдны галт тэргэнд гал нээсэн. Гэмт этгээдийг баривчилсан.	0	3
Турк	2015/10	Анкарагийн төмөр замын төв буудлын урд болсон жагсаал, цуглааны үеэр амиа золиослогч 2 этгээд тэсрэх бөмбөг дэлбэлсэн.	102	400+
Египет / ОХУ	2015/10	Египетээс ОХУ-ын Санкт Петербург руу нисч байсан 217 зорчигчтой, 7 нисэх багийн гишүүдтэй онгоцыг дэлбэлсэн. Шинжээчийн дүгнэлт гарахаас өмнө Англи, АНУ-ыг сөнөөсөн гэж буруутгаж байсан.	224	0
Ливан	2015/11	Шийт үндэстний мөргөлийн үед амиа золиослогч бөмбөг дэлбэлсэн.	43	300+
Франц	2015/11	Гудамж талбай, цэнгэлдэх хүрээлэн, бар, ресторан, концертийн танхим зэрэг олон хүн цугласан газарт 3-н хэсэг болж хуваагдсан террористууд буудах, гранат дэлбэлэх, өөрийгөө дэлбэлэх зэргээр цуврал халдлага үйлдсэн.	130	368
Франц	2015/11	Дээрх халдлагыг зохион байгуулсан гэх сэжигтнийг баривчлах явцад 6 хүн шархадсан. Гэмт этгээдийг бусад 2 хамтрагчтай нь буудаж хөнөөсөн.		6
Тунис	2015/11	Тунисийн ерөнхийлөгчийн бие хамгаалагчдын автобус руу амиа золиослогч халдсан. Гэмт этгээд бөмбөгт өртөж амь насаа алдсан.	13	16
АНУ	2015/12	Лалын шашинт эхнэр, нөхөр 2 баярын өдөр олон хүн цугласан төв дотор гал нээсэн. Тухайн өдрийн өглөө эхнэр нь халдлага үйлдэх тангараг өргөсөн тухайгаа фейсбүүкт нийтэлсэн байсан. Цагдаа нартай буудалцах явцад гэмт этгээдүүдийг буудаж хөнөөсөн.	14	24



Сири	2015/12	Курдишийн армийн эмнэлэг, дэлгүүрт тэсрэг бөмбөгтэй ачааны тэрэгтэй халдаж дэлбэлсэн.	60	80
Сири	2015/12	Курдууд, Сирийн христийн шашинтай иргэд голдуу үйлчлүүлдэг 3-н ресторан руу амиа золиослогч халдсан. Гэмт этгээд бөмбөг дэлбэлэхдээ нас барсан.	16	35
Ливи	2016/01	Цагдаагийн алба хаагчдыг дадлагажуулах төв рүү тэсрэг бөмбөгтэй ачааны тэрэгтэй халдаж дэлбэлсэн.	60	200+
Египет	2016/01	Гадаадын жуулчид ихтэй зочид буудал руу халдсан. 3 жуулчин өртсөн. Цагдаа нар гэмт этгээдийг буудаж хөнөөсөн.		2
Турк	2016/01	Истанбулын төв талбайд амиа золиослогч гадаадын жуулчид руу халдсан.	12	14
Индонез	2016/01	НҮБ болон хэд хэдэн улсын ЭСЯ-тай зэргэлдээ орших Жакартагийн цагдаагийн газар болон Старбакс кофе шоп руу амиа золиослогч халдсан. 4-н гэмт этгээдийг буудаж хөнөөсөн боловч бусад нь зугатаж амжсан.	4	24
Саудын Араб	2016/01	Шийт үндэстэний лалын сүм руу амиа золиослогч халдсан.	4	18
1281 2932				

Мэдээлэл бэлтгэсэн: ЦЕГ-ын Судалгаа, дүн шинжилгээний төвийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Д.Нямбат

<sup>1</sup>Lazaro Gamio, [Bonnie Berkowitz](#), and [Denise Lu](#) (2015) What a year of Islamic State terror looks like in <https://www.washingtonpost.com/graphics/world/islamic-state-attacks/>